



*МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН*  
**2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

*2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 09-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ*

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

## НЭГДСЭН ХУРАЛДААН

**ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС**

---

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр, Пүрэв гараг

|   |                |
|---|----------------|
| <b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>  | <b>1</b>       |
| <b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>   | <b>2-27</b>    |
| <b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>  | <b>28-123</b>  |
| <i>1.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>  | <b>31-45</b>   |
| <i>2.Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>  | <b>9-48</b>    |
| <i>3.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i> | <b>48-53</b>   |
| <i>4.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>  | <b>53-120</b>  |
| <i>5.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/</i>   | <b>120-123</b> |

**11 дүгээр сарын 09-ний өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 11 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Д.Өнөрболор, Ч.Ундрэм;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Б.Баярсайхан, Л.Оюун-Эрдэнэ, Н.Энхболд;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Сүхбаатар;

Тасалсан: С.Ганбаатар, Ц.Туваан;

Хоцорсон: С.Амарсайхан-3 цаг 40 минут, С.Батболд-1 цаг 54 минут, Д.Батлут-03 минут, Ж.Батсуурь-07 минут, Х.Булгантуяа-04 минут, Д.Ганбат-11 минут, Н.Ганибал-06 минут, Т.Доржханд-02 минут, Ц.Мөнх-Оргил-33 минут, Н.Наранбаатар-13 минут, С.Одонтуяа-07 минут, Ц.Сэргэлэн-18 минут, Н.Учрал-41 минут, Ч.Хүрэлбаатар-02 минут, Б.Энх-Амгалан-04 минут, Ж.Эрдэнэбат-1 цаг 14 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Ш.Адьшаа, Б.Пүрэвдорж нараас албан бичиг ирүүлснийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Ш.Адьшаа, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Ц.Сандаг-Очир нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

**Нэг.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Цагдаагийн ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын дарга

Л.Нямдаваа, Тээврийн цагдаагийн албаны Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн дарга Ц.Чинзориг, мөн албаны Мөрдөн шалгах хэлтсийн дарга В.Хосбаяр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хууль, тогтоомжийн хэлтсийн дарга Э.Бадамсамбуу, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор С.Гантулга, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, шинжээч Т.Нарантунгалаг, мэргэжилтэн Ц.Лхагвацэнд, Эрүүгийн хууль, тогтоомжийн уялдаа холбоог хангах, боловсронгуй болгох чиг үүрэг бүхий байнгын ажлын хэсгийн гишүүн Б.Гантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн газрын Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

*НЭГ. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

### **Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Ш.Адъяаа, Г.Амартүвшин, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар, Б.Энх-Амгалан /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 1.10 дугаар зүйлийн 10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“10.Энэ хуулийн 12.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12.3 дугаар зүйлийн 2.1, 3.2 дахь заалт, 13.1 дүгээр зүйлийн 2.1-д заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоож, хохирогчийг арван найман насанд хүрсний дараа тоолж эхэлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 37 |
| Татгалзсан: | 18 |
| Бүгд:       | 55 |

67.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 6.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “12.1 дүгээр зүйлийн 5 дахь” гэснийг “12.1 дүгээр зүйлийн 4 дэх” гэж, мөн зүйлийн 6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “22 дугаар бүлэгт” гэснийг “22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34  
Татгалзсан: 20  
Бүгд: 54  
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 3 дахь заалтын 6.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “10.1 дүгээр зүйлийн 2, 3” гэснийг “10.1 дүгээр зүйлийн 3” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38  
Татгалзсан: 16  
Бүгд: 54  
70.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 5.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн ““мэргэжлийн үйл ажиллагаа явуулах,” гэсний дараа “тээврийн хэрэгслийг жолоодох” гэж, мөн хэсгийн “нийтийн албанд ажиллах” гэсний дараа “, тээврийн хэрэгслийг жолоодох”” гэснийг ““тохиолдолд” гэсний дараа “тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс арван хоёр жил хүртэл, эсхүл”” гэж өөрчилж, мөн зүйлийн “гэж, 12.3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтын “арван зургаан насанд” гэсний дараа “хүрсэн арван найман насанд”” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35  
Татгалзсан: 19  
Бүгд: 54  
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтыг хасаж, Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “хорин” гэснийг “хорин таван” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35  
Татгалзсан: 19  
Бүгд: 54  
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

**“27.10 дугаар зүйл.Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих**

1.Ажлын хэсгийн гаргасан, Тээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж

хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.согтуурсан, мансуурсан үедээ;  
2.2.тээврийн хэрэгслийг жолоодох эрхгүй хүн;  
2.3.хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулж үйлдсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг гурван жилээс дээш таван жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг таван жилээс дээш найман жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг:

4.1.согтуурсан, мансуурсан үедээ үйлдсэн;  
4.2.энэ гэмт хэргийн улмаас хоёр, түүнээс олон хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг найман жилээс дээш арван хоёр жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

5.Тээврийн хэрэгслийг жолоодох эрхээ хасуулсан хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгслийг жолоодсон, эсхүл согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Энэ зүйлд заасан “согтуурсан” гэж шалгаж, тогтоох ажиллагааны үр дүнд шалгуулагчийн амьсгал дахь спиртийн агууламж 0.20, түүнээс дээш промилль (%), эсхүл цусан дахь спиртийн агууламж 0.5, түүнээс дээш промилль (%) илэрснийг ойлгоно.

-“Тээврийн хэрэгслийн жолооч” гэж тээврийн хэрэгсэл жолоодож яваа тээврийн хэрэгслийг жолоодох эрхтэй, эсхүл эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүнийг ойлгоно.

-“Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн” гэдэгт согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн үйлдлийн улмаас тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүнийг ойлгоно.

-“Тээврийн хэрэгсэл” гэж механикжсан тээврийн хэрэгслийг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37  
Татгалзсан: 18  
Бүгд: 55

67.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Тээврийн цагдаагийн албаны Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн Мөрдөн шалгах хэлтсийн дарга В.Хосбаяр нар хариулж, тайлбар хийв.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн ““10.1 дүгээр зүйлийн Тайлбарын “арван дөрвөн” гэснийг “арван зургаан” гэж, “12.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг,” гэснийг, мөн зүйлийн “2.1 дэх заалтын “арван дөрвөөс” гэснийг “арван зургаагаас” гэж, мөн зүйлийн”” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36  
Татгалзсан: 19  
Бүгд: 55

65.5 хувийн саналаар дэмжигдлээ.

*ХОЁР.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“8.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөнтэй холбогдуулан эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах, сунгах, ангилал нэмэх, өөрчлөх, шинээр авах, тээврийн хэрэгслийн эзэмшлийн шилжилт, хөдөлгөөн хийх эрхийг хязгаарлана.” гэсэн саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар үг хэлэв.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэх үндэслэл нь энэ хуулийн 5.2, 5.3, 5.4, 5.5, 5.6, 5.7, 5.8, 5.10, 5.11, 5.12, 5.13, 5.14, 5.15, 5.18, 5.20, 6.4, 6.5, 6.6, 6.7, 6.8, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.17, 6.18, 6.20, 6.22, 6.23, 6.26, 6.27 дугаар зүйл, Долоодугаар бүлэг, 8.1, 8.6, 8.7, 8.8, 8.9, 9.7, 10.3, 10.7, 10.15, 10.25

дугаар зүйл, Арван нэгдүгээр бүлэг, 12.1, 12.2, 12.3, 12.4, 12.5, 12.6, 12.8, 12.9, 12.10, 12.11, 13.1, 13.2, 13.4, 13.5, 13.6, 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.8, 14.9, 14.10, 14.11, 14.12, 14.13 дугаар зүйл, Арван тав, Арван зургаадугаар бүлэг, 17.1 дүгээр зүйлд тус тус заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 25  
Бүгд: 55  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 41  
Бүгд: 55  
25.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35  
Татгалзсан: 20  
Бүгд: 55  
63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэх үндэслэл нь энэ хуулийн 5.2, 5.3, 5.4, 5.5, 5.6, 5.7, 5.8, 5.10, 5.11, 5.12, 5.13, 5.14, 5.15, 5.18, 5.20, 6.4, 6.5, 6.6, 6.7, 6.8, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.17, 6.18, 6.20, 6.22, 6.23, 6.26, 6.27 дугаар зүйл, Долоодугаар бүлэг, 8.1, 8.6, 8.7, 8.8, 8.9, 9.7, 10.3, 10.7, 10.15, 10.25 дугаар зүйл, Арван нэгдүгээр бүлэг, 12.1, 12.2, 12.3, 12.4, 12.5, 12.6, 12.8, 12.9, 12.10, 12.11, 13.1, 13.2, 13.4, 13.5, 13.6, 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.8, 14.9, 14.10, 14.11, 14.12, 14.13 дугаар зүйл, Арван тав, Арван зургаадугаар бүлэг, 17.1 дүгээр зүйлд тус тус заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 37  
Татгалзсан: 18  
Бүгд: 55  
67.3 хувийн саналаар дэмжигдлээ.



4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг өөрчлөн найруулж 3 дугаар зүйл болгон шилжүүлэх.

**“3 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“5.Жолооч:

5.1.согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;

5.2.тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;

5.3.согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 17

Бүгд: 55

69.1 хувийн саналаар дэмжигдлээ.

*ГУРАВ.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх найруулгын саналаар санал хураалт явуулав.*

*Нэг.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх найруулгын санал:*

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн ““1.2, 1.3, 1.4 дэх заалтын дугаарыг “1.3, 1.4, 1.5;” гэснийг “1.2., 1.3. дахь заалтын дугаарыг “1.3., 1.4.”” гэж өөрчилж, мөн зүйлийн “3.5-3.8 дугаар зүйлийн дугаарыг “3.7-3.10” гэж,” гэснийг “14.7 дугаар” гэсний өмнө шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 17

Бүгд: 55

69.1 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хоёр.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх найруулгын санал:*

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “агуулга бүхий зүйл, хэсэг” гэснийг “агуулгатай дараах зүйл, хэсэг” гэж өөрчилж, 3 дахь заалтын 3 дахь хэсгийн “саналаа” гэсний дараа “оршин суугаа /оршин байгаа/ газар, эсхүл тухайн

зөрчил гаргасан харьяаллын” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37  
Татгалзсан: 18  
Бүгд: 55  
67.3 хувийн саналаар дэмжигдлээ.

*Гурав.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх найруулгын санал:*

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 41.2 дахь хэсгийн “10.1 дүгээр зүйлийн” гэсний дараах “2,” гэснийг хасаж, мөн зүйлийн 12.1 дүгээр зүйлийн “5 дахь” гэснийг “4 дэх” гэж, 4 дүгээр зүйлийн “2024 оны ... дүгээр/дугаар сарын ...-ны” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 35  
Татгалзсан: 20  
Бүгд: 55  
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

*Дөрөв.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулав:*

**Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй санал:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 22  
Бүгд: 49  
55.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Б.Пүрэвдорж, Д.Ганбат, Б.Энх-Амгалан, Б.Энхбаяр нар үг хэлэв.

*Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 11 цаг 20 минутаас хуралдааныг даргалав.*

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 11 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоо, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Жамъянхүү, мөн хэлтсийн шинжээч М.Цолмон, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга И.Батчулуун, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Дэд дарга бөгөөд Шийдвэр гүйцэтгэх албаны дарга Ч.Оюунцэцэг, мөн газрын харьяа Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны дэд дарга Б.Базарсад, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын дарга Т.Төгөлдөр, мөн газрын мэргэжилтэн Н.Наранцэцэг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Н.Өлзийхутаг, Олон улсын Улаанбаатар их сургуулийн Монгол-Солонгосын эрх зүйн хүрээлэнгийн захирал, хууль зүйн доктор О.Амарсанаа, Гадаадын иргэн, харьяатын газрын Иргэний харьяаллын газрын мэргэжилтэн Б.Бат-Ундрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Б.Баттөмөр, С.Одонтуяа, Н.Учрал, Б.Бат-Эрдэнэ, Г.Тэмүүлэн, Ж.Чинбүрэн, Б.Жаргалмаа, Л.Энх-Амгалан, Ц.Мөнхцэцэг, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Х.Булгантуяа, Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн, Д.Сарангэрэл, П.Анужин нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоо, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын ахлах мэргэжилтэн Н.Наранцэцэг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Н.Өлзийхутаг, Олон улсын Улаанбаатар их сургуулийн Монгол-Солонгосын эрх зүйн хүрээлэнгийн захирал, хууль зүйн доктор О.Амарсанаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн үг хэлэв.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны саналаар Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 21  
Бүгд: 50  
58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 14 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Мал эмнэлгийн бодлогын асуудал эрхэлсэн ахлах шинжээч Х.Алтангэрэл, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, мөн газрын Хяналт, баталгаажуулалтын газрын дарга Б.Батсүх, Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсийн дарга Г.Батмөнх, мөн хэлтсийн гаалийн улсын байцаагч Г.Шүрэнчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Ж.Чинбүрэн, Н.Ганибал, О.Цогтгэрэл, Г.Мөнхцэцэг нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал эмнэлгийн бодлогын асуудал эрхэлсэн ахлах шинжээч Х.Алтангэрэл, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсийн дарга Г.Батмөнх нар хариулж, тайлбар хийв.

***Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт***

*оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:**

*Нэг.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав:*

**Л.Мөнхбаатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Т.Аубакир, Б.Бейсен, Ц.Идэрбат, Ц.Туваан /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 14.9, 14.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 14.9, 14.10, 14.11 дэх хэсэг болгох:

“14.9.Энэ хуулийн 11.1.1-д заасан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалттай аж ахуйд мөрдөх био хамгааллын нийтлэг зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга өвчин тус бүрээр баталж хэрэгжилтэд хяналт тавина.

14.10.Хамгаалалттай аж ахуй нь энэ хуулийн 14.9-д заасан нийтлэг зааварт нийцүүлэн өөрийн үйл ажиллагаанд мөрдөх био хамгааллын зааврыг баталж мөрдүүлнэ.

14.11.Энэ хуулийн 14.2, 14.9, 14.10-т заасан журам, био хамгааллын зааврын хэрэгжилтэд үнэлгээ хийх үйл ажиллагааг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцан хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20  
Татгалзсан: 21  
Бүгд: 41  
48.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 21  
Бүгд: 42  
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 19

Бүгд: 42

54.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 14.9, 14.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 14.9, 14.10, 14.11 дэх хэсэг болгох:

“14.9.Энэ хуулийн 11.1.1-д заасан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалттай аж ахуйд мөрдөх био хамгааллын нийтлэг зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга өвчин тус бүрээр баталж хэрэгжилтэд хяналт тавина.

14.10.Хамгаалалттай аж ахуй нь энэ хуулийн 14.9-д заасан нийтлэг зааварт нийцүүлэн өөрийн үйл ажиллагаанд мөрдөх био хамгааллын зааврыг баталж мөрдүүлнэ.

14.11.Энэ хуулийн 14.2, 14.9, 14.10-т заасан журам, био хамгааллын зааврын хэрэгжилтэд үнэлгээ хийх үйл ажиллагааг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцан хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 19

Бүгд: 42

54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 4.1.18 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4.1.20 дахь заалтын “эсхүл үе хөлтний шимэгчлэл” гэснийг хасах:

“4.1.18.“хамгаалалттай аж ахуй” гэж олон улсын худалдааны чөлөөт байдлыг дэмжих болон улс, бүс, нутагт тархсан өвчнөөс хамгаалах, тэмцэх зорилгоор тандалт, хяналт, эрсдэлийн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ, био хамгааллын нийтлэг зааврыг хэрэгжүүлэхээр бусад мал, амьтнаас тусгаарлан маллаж байгаа эрүүл мал, амьтан бүхий байгууламжийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 19

Бүгд: 44

56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “7.4.2 дахь заалт” гэснийг “7.4.2 дахь заалтын “улсын байцаагчаас” гэсний өмнө” гэж, “9.7 дахь хэсэг” гэснийг “9.7 дахь хэсгийн “улсын байцаагч,” гэсний өмнө” гэж өөрчилж, “34 дүгээр зүйлийн 34.2.4, 34.3.3 дахь заалтын “дэвсгэрийн” гэсний дараа “мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, төрийн өмчийн мал эмнэлгийн лабораторийн оношилгоо, хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулах,” гэж” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 19  
Бүгд: 45  
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.4.2, 31.4.4, 31.4.5 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 22  
Бүгд: 44  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28  
Татгалзсан: 18  
Бүгд: 46  
60.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.4.2, 31.4.4, 31.4.5 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 19  
Бүгд: 46  
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.5.2 дахь заалтын “мал эмнэлгийн” гэснийг “мал эмнэлэг, эрүүл ахуй, ариун цэврийн” гэж, 31.5.4 дэх заалтын “худалдаа, үйлчилгээний” гэснийг “худалдаанд мөрдөх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26



Татгалзсан: 20  
Бүгд: 46  
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.6.4 дэх заалтын “таслан зогсоох” гэсний дараа “талаар хугацаатай үүрэг даалгавар өгөх, хэрэгжилтэд хяналт тавих” гэж нэмж, 31.6.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“31.6.1.мал, амьтан, тэдгээрийн хашаа, байр, ус, бэлчээр, өвс, тэжээлд болон мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэх, хадгалах, тээвэрлэх, худалдах явцад мал эмнэлэг, эрүүл ахуй, ариун цэврийн үзлэг, шинжилгээ хийлгэсэн эсэхэд хяналт тавих;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 19  
Бүгд: 46  
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.6.2, 31.6.3 дахь заалтыг нэгтгэж доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“31.6.2.мал, амьтны халдварт өвчин тараах, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах эрсдэлтэй мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхийг хориглох, шаардлагатай тохиолдолд устгах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 18  
Бүгд: 45  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.6.6 дахь заалтын “мал, амьтны тэжээлийн нэмэлтийг улсын бүртгэлд бүртгэх,” гэснийг хасаж, 31.6.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“31.6.7.Мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн сангийн хөтлөлтөд хяналт тавих;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 20  
Бүгд: 45  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 15.13 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:



“15.13.Энэ хуулийн 28.2-т зааснаас бусад албан тушаалтан мал, амьтны гоц халдварт өвчний талаарх баталгаажуулах мэдээллийг тараахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 21

Бүгд: 45

53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3, 4 дэх заалт буюу 34.2.4, 34.3.3 дахь заалтын “баталгаажуулах” гэсний дараах “, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 19

Бүгд: 45

57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “хамгаалалттай аж ахуйд мөрдөх био хамгааллын нийтлэг” гэснийг “хамгаалалттай аж ахуйг баталгаажуулах, хяналт тавих” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 19

Бүгд: 45

57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 21

Бүгд: 45

53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Найруулгын санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.5.2 дахь заалтын “тэдгээрийн гаралтай” гэсний дараа “түүхий эд,” гэж, 31.6.5 дахь заалтын “эмнэлгийн хэрэгсэл,” гэсний дараа “тэжээлийн нэмэлт,” гэж нэмэх.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 4.1.21 дэх заалтын “төлөвлөгөөтэйгөөр” гэснийг “төлөвлөгөөний дагуу” гэж, “шаардагдах арга хэмжээ” гэснийг “шаардлагатай арга хэмжээг” гэж өөрчилж, 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.5.4 дэх заалтын “амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус” гэснийг “амьтан, тэдгээрийн гаралтай” гэж, 31.6.4 дэх заалтын “борлуулах” гэснийг “худалдах” гэж, 31.6.5 дахь заалтын “гаралтай” гэсний өмнөх “амьтны” гэснийг “амьтан, тэдгээрийн” гэж, 31.6.6 дахь заалтын “малын” гэснийг “мал, амьтны” гэж өөрчлөх.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 4.1.20 дахь заалтын “бүлгийн” гэснийг, 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.6.4 дэх заалтын “хүнсний болон хүнсний бус” гэснийг, 31.6.5 дахь заалтын “тэжээл, тэжээлийн нэмэлт, мал” гэснийг, 31.5.4, 31.6.5, 31.6.12 дахь заалтын “мал эмнэлгийн” гэсний дараах “ажил,” гэснийг тус тус хасах.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг 1 дэх заалт, 4 дэх заалтыг 3 дахь заалт, 1 дэх заалтыг 4 дэх заалт, 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг 1 дэх заалт болгон өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 18  
Бүгд: 45  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хоёр.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав:*

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 5.4 дэх хэсгийн 5.4.2 дахь заалтын “гадаад орны” гэсний өмнө “хуульд өөрөөр заагаагүй бол” гэж, 5.4.3 дахь заалтын “экспортлох” гэсний өмнө “шаардлагатай бол” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28  
Татгалзсан: 18  
Бүгд: 46  
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 3.1.11 дэх заалтын “мал, амьтан,” гэсний дараа “ургамал,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28  
Татгалзсан: 19  
Бүгд: 47  
59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “26.1 дэх хэсэг,” гэснийг “26.1 дэх хэсгийн “эрүүл мэндийг хамгаалах” гэсний өмнө болон” гэж өөрчилж, “8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтын “байгууллагад” гэсний дараа “цахимаар” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 18  
Бүгд: 48

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.2 дахь хэсэг нэмж, төслийн 4 дүгээр зүйлийн “25.2,” гэснийг хасах:

“25.2.Хорио цээрийн хяналт, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүн, энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг харгалзан ургамлын хорио цээрийн гэрчилгээг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 19

Бүгд: 48

60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 27.1 дэх хэсгийн “мэргэжлийн баг” гэснийг “эрх бүхий албан тушаалтан” гэж, 27.2 дахь хэсгийн “мэргэжлийн багийн” гэснийг “эрх бүхий албан тушаалтны” гэж өөрчилж, төслийн 2 дахь заалт буюу 26.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 26.4, 26.5 дахь хэсэг болгох:

“26.4.Эрсдэлийн үнэлгээг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон эрх бүхий албан тушаалтан гүйцэтгэнэ.

26.5.Энэ хуулийн 26.4-т заасан эрсдэлийн үнэлгээ хийх журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 20

Бүгд: 48

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.7 дахь заалт нэмж, төслийн 6 дугаар зүйлийн “7.1.7,” гэснийг хасах:

“7.1.7.гадаад орны мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн байгууллагатай хяналт, шалгалтын ажлыг уялдуулан хамтран ажиллах, улсын хилээр нэвтрүүлсэн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний талаарх мэдээллийг тогтоосон хугацаанд хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар хүргүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 19

Бүгд: 48

60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “тус тус, 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтын” гэсний өмнө “, 25 дугаар зүйлийн гарчгийг “Импортын, олон улсын мал эмнэлгийн, ургамлын хорио цээрийн гэрчилгээ” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 19

Бүгд: 49

61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн ““мэдээг тогтоосон хугацаанд” гэснийг “тухай бүр”” гэснийг ““хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий” гэснийг “дээд шатны”” гэж өөрчилж, “, 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтын” гэснийг болон “27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 18

Бүгд: 49

63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл.Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 21

Бүгд: 49

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

### Найруулгын санал:

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 1.1 дэх хэсгийн “хангах, худалдааг хөнгөвчлөх” гэснийг “дэмжих” гэж өөрчлөх.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 5.4 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 27.2 дахь хэсэг болон 4 дүгээр зүйлийн “хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн” гэсний өмнө “хүнс,” гэж нэмэх.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг 1 дэх заалт болгон өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 20  
Бүгд: 49  
59.2 хувийн саналаар дэмжигдлээ.

*Гурав.Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:*

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28  
Татгалзсан: 21  
Бүгд: 49  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

*Дөрөв.Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав:*

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу “9.13, 9.14 дэх хэсэг” гэснийг “9.14, 9.15 дахь хэсэг” гэж, төслийн 3 дахь заалт буюу 9.2.3 дахь заалтын “3-аас” гэснийг “гурваас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28  
Татгалзсан: 19  
Бүгд: 47  
59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу “16 дугаар зүйлийн 16.12” гэсний дараа “, 16.13” гэж нэмж, 16.13.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.13.4.малын тэжээл, шимт чанар, хүрэлцээ, бэлчээрийн менежмент болон усан хангамж, аймаг дундын отрын бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, холбогдох журмын хэрэгжилт, малын гаралтай түүхий эд бэлтгэл,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 17  
Бүгд: 47  
63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“5 дугаар зүйл.**Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 29 |
| Татгалзсан: | 18 |
| Бүгд:       | 47 |

61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг 1 дэх заалт, 3 дугаар зүйлийн 3 дахь заалтыг 1 дэх заалт болгон өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 26 |
| Татгалзсан: | 21 |
| Бүгд:       | 47 |

55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

*Тав.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав:*

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 26 |
| Татгалзсан: | 21 |
| Бүгд:       | 47 |

55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зургаа.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав:*

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “6.63 дахь хэсэг” гэснийг “6.64 дэх хэсэг” гэж, “6.63.” гэснийг “6.64.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 23  
Бүгд: 47  
51.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “, 8, 9, 10, 11” гэсний дараа “, 12” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 18  
Бүгд: 47  
61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“5 дугаар зүйл.**Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 24  
Бүгд: 47  
48.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 20  
Бүгд: 49  
59.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“5 дугаар зүйл.**Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 20  
Бүгд: 50

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 24

Бүгд: 50

52.0 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 15 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан хариулж, тайлбар хийв.



*Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** Төслийн 2 дугаар зүйлийн 23.2.23 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.2.23.төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил, ашиглалтад байгаа газар дээр хууль бусаар барилга, байгууламж баригдсан талаар шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бол хураан авах ажлыг зохион байгуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 21

Бүгд: 48

56.2 хувийн саналаар дэмжигдлээ.

*“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Л.Мөнхбаатар:** Төслийн 4 дэх заалтыг 2 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/-д тус тус даалгасугай:

1/орон сууцны ипотекийн зээлийн эрэлт болон төвлөрлийг сааруулах бодлоготой уялдуулан ипотекийн хөтөлбөрийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, нийслэл, орон нутагт тэгш хүртээмжтэй хуваарилах;

2/агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах зорилгоор инженерийн дэд бүтцийн шийдэлтэй, нийт талбай нь 100 м<sup>2</sup>-аас ихгүй хэмжээтэй амины орон сууцыг орон сууцны ипотекийн зээлд хамруулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36

Татгалзсан: 14

Бүгд: 50

72.0 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 16 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.*

***Тав.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 16 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.*

***Бусад.*** Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэн, Д.Ганбат нарын урилгаар Баянхонгор аймгийн Галуут, Заг, Баянговь сумдын Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчид, Соёлын төвийн албан хаагчид, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн урилгаар Ховд аймгийн Үенч сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчид, Баянхонгор аймгийн Ерөнхий боловсролын “Эрдэм” сургуулийн багш, ажилчид, Нийслэлийн ерөнхий боловсролын “Шинэ эрин” сургуулийн 9<sup>о</sup> ангийн багш, сурагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

*Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.*

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 6 цаг 12 минут үргэлжилж, 72 гишүүнээс 62 гишүүн хүрэлцэн ирж, 86.1 хувийн ирцтэйгээр 16 цаг 23 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр,  
Пүрэв гараг Төрийн ордон “Их  
хуралдай” танхим 10 цаг 11 минут.

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Занданшатар:** 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 9-ний өдрийн нэгдсэн хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна. ирцээ бүрдүүлье дарга нар. Тэмүүлэн дарга Төсвийн байнгын хороо хуралдсан уу?

Гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Гишүүдийн ирц бүрдсэн тул 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 9-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх буюу хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн

даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд.

Монгол Улсын 2024 онд төсвийн тухай, нийгмийн даатгалын сангийн 2024 онд төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 онд төсвийн тухай хуулийн төслүүдийн 3 дахь хэлэлцүүлгийг явуулна аа.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 онд Төсвийн хүрээний мэдэгдэл 2025-аас 2026 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т заасны дагуу гишүүн энэ хуулийн 9.5-д заасан Улсын Их Хурлаар хэлэлцэхээр товлосон асуудлыг өөрчлөх, асуудал нэмэх, тов дараалал өөрчлөх асуудлын горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг, Ширнэнбандийн Адьяа, Бөхчулууны Пүрэвдорж нараас албан бичиг ирүүлсэн байна аа.

Норовын Алтанхуяг гишүүн үг хэлнэ.

**Н.Алтанхуяг:** Эрхэм гишүүддээ өглөөний амгаланг айлтгая.

Улсын төсөв ярьж байгаа. Улсын төсөв дээр би анх эхлэхэд нь хэлсэн. Энэ сонгуулийнхаа төсвийг буцааж авах ёстой. Улсыг өрөнд оруулсан ийм төсвийг бол баталж болохгүй Улсын Их Хурлын гишүүдийг 3 орчим тэрбум төгрөг тойрог дээр чинь тавина гэж авлигадах байдлаар улсын төсвийг баталж энэ Монголчуудын

Монгол Улсын хувь заяагаар тоглож болохгүй гэдгийг би хатуу хэлсэн. Тийм учраас та бүхэн энэ төсвөө буцааж аваад, засаж янзлаад, улсын төсвийг алдагдалгүйгээр ингээд батлах хэрэгтэй.

76 гишүүнийг 3-аар үржүүлэхээр 200 гаруй тэрбум төгрөгөөр жишээ нь нэмэгдээд л явна. Ингэж болохгүй. Би даирамд дурдчихъя. Би энэ 4 жил энэ Их Хурлын гишүүнээр суухад тойрог дээрээ нэг төгрөг тавиулаагүй. Хэдэн төгрөг тавьчихаад энэ Их Хурлын гишүүдийн амыг барих гэсэн, ийм хээл хахууль авлигын Улсын Их Хурлын гишүүдийг авлигадах гэсэн энэ үйлдлийг бол Жавхлан зогсоомоор байна. Ямар ч үнээр хамаагүй улсын төсвийг батална гэдэг ийм юм байж болохгүй. Тэгээд 1 зовлон байна. Би яах вэ энэ Занданшатар даргад хэлчихсэн байгаа. Тэр нүүрсний асуудлаар нэг юм хийе гэсэн. Дээр нь одоо би ер нь нэг тууштай явъя. Энэ улсын төсөв мөнгө юу болоод байгаа асуудлаар Улсын Их Хурал дээр асуулга тавьж хариулт авч олон нийтэд өгье.

Ингэхгүй болохоор хойноос нь энэ Жавхлан хэн 2 дандаа гүтгэлэг хийх юм. Би тэгээд энэ өрөн дээр ингээд би цаас үзүүлж ярья. Гадаад өрийн удирдлага ба цаашдын зорилт Монгол Улсын Сангийн яамны гаргасан цаас. Энэ дээр ингэж байгаа юм. 2022 оны байдлаар улсын гадаад нийт өр бол 33.8 тэрбум доллар байна гэж байгаа юм. 2014 онд 21 байсан юм байхгүй юу. Ингээд 12 тэрбум доллароор улсын чинь өр нэмэгдчихээд байна гэдгийг Сангийн яам өөрөө гаргасан. Одоо энийгээ арай үгүйсгэхгүй байлгүй. 2022 онд гаргасан Үндэсний аудитын газрын дүгнэлт байгаа. Энэ дээр юу гэж байгаа вэ гэхээр гадаад өрийн хэмжээ нэмэгдсээр байна. Та нар ер нь юм уншдаг юм уу, уншдаггүй юм уу? Ингээд өр чинь бол нэмэгдээд байгаа гэдгийг аудитын байгууллага энэ бүгдээрээ ингээд хэлчихсэн төсөв чинь болохгүй байна гэдгийг төсвийн шинэчлэлд анхаарах асуудлууд 2021 онд Дэлхийн банкны

хүмүүс Даваадалай, Бадамчимэг гэдэг хүмүүсийн дэлхийн банк л даа. Энэ дээр гаргасан юмнууд байна. Би энэнээс нь ураад авчихлаа л даа. Ураад харуулчихъя. Энэ дээр бас ингэж байгаа юм Засгийн газрын өр чинь өндөр хэвээрээ байна аа. Динамикаараа графикаараа үзүүлчихсэн.

Төсвийн зардал чинь хэтэрхий өндөр байгаагийн зэрэгцээ тогтворгүй байна энийгээ засаж янзал. Одоо та нарын би бид нарын яриад байгаа нэг баахан хөрөнгө оруулалтууд байгаа үр ашиггүй. Суманд аваачиж хэрэгтэй хэрэггүй юм босгоно. Тэрийг чинь бас хэлчихсэн. Хөрөнгийн зардлын үр ашигт анхаар. Монгол Улсын хөрөнгө оруулалтын үр ашиг тааруу байхаар байна. Дэлхийд одоо энэ Монгол ингээд Малайз, Хятад, Индонез гэж яваад Монгол хамгийн сүүлд нь, үгүй яагаад ийм юмыг ингээд засдаггүй юм бэ?

Алтанхуяг л худлаа хэлээд байгаа юм шиг хойноос нь тайлбарлах юм. Монгол Улсын төсвийн алдагдал 2016 онд хамгийн их байхаар баталсан. Сонгуулийн жил. 2020 онд хамгийн их байсан. Одоо 2024 онд хамгийн их байхаар баталж байна. Энийгээ боль оо. Энэ улс чинь цаашаагаа жаахан тогтвортой хөгжиж байна. Хүн ахуй хүмүүсийн ахуй амьдрал дээшлүүлмээр байх юм. Энэ нэг худлаа нэг элс хайрга нийлүүлж нэг байшин нэртэй юм барьдгаа боль л доо хөрөнгө оруулалт. Ийм байдлаар энэ олон улсын байгууллагууд энийг чинь хэлчхээд байна. Алтанхуяг хэлээд байгаа юм биш үү Жавхлан. Хүрэлбаатар та 2 нийлээд хэдэн тролд мөнгө тараачхаад ингэж юм хийгээд байж болох уу? Нэг өдөр гэмт хэрэгтэн болно шүү би хэлчихье. Монгол Улсын хувь заяагаар ингэж тоглож болдоггүй одоо та нар ингээд тойрог дээрээ нэг хөрөнгө оруулалт гээд тавьж байгаа юм. Тэрнээсээ мөнгө цавчиж байна, 2-ын хооронд. Тэгчхээд тэрүүгээрээ дандаа сошиал дээр ингээд баахан амьтан хөлсөлчихсэн ажиллуулж байна. Энэ бол түр зуурын юм шүү. Энэ

Монголчууд Монгол Улсын амьдрал ахуй эдийн засаг цаашаа явах ёстой шүү. Монголчуудын ахуй амьдралыг яаж дээшлүүлэх вэ гэдэг юм ерөөсөө яригдахгүй байна. Яаж мөнгө ч авчих тухай л ерөөсөө улсын төсөв хүртэл энэ рүү чиглүүлж байна. Би маш их харамсаж байна.

Тийм учраас та нар минь энэ алдаагаа ямааны нөгөө арай жаахан гарз багатай дээр нь татаж аваад ингээд засаад янзал.

**Г.Занданшатар:** Ширнэнбандийн Адьшаа гишүүн.

**Ш.Адьяа:** Өнөөдөр Улсын Их Хурал энэ улсын төсөв хэлэлцэж улс төрчид их халуун, их хайртай дуртай юм ярьж байна аа. Тэгэхлээр ард түмний элч төлөөлөгчийн хувьд энэ цаг уурын гамшигт үзэгдлээс болж олон хүний амь нас, түүний дотор эмэгтэйчүүд, хүүхдийн амь нас эрсэдсэн үнэн харамсаж байна. Энэ 2024 оны төсөв хэлэлцэж байгаа. Энэ дээр Монгол Улсын эдийн засгийн голлох салбар болсон Мал аж ахуйн түүний дотор малчдын, залуу малчдыг эдийн засгийн хөшүүргээр дамжуулж хөдөө орон нутагт ажиллах нөхцөлийг сайжруулах талаар энэ төсвийн хөрөнгө оруулалт дээр нэг ч хөрөнгө мөнгө тавьсангүй. Энд бид дүгнэлт хийх ёстой.

Бид өнөөдөр 70 сая малтай 80 сая малтай гэж их сайрхаж ярьдаг. Энэ 80 сая малыг чинь хэн маллаад байгаа юм. Ажиллах хүчин байна уу, байхгүй байна. Энэ Улсын Их Хурлын гишүүдийн 50-аас доошгүй нь орон нутгаас сонгогдсон гишүүд байгаа. Залуу малчид байхгүй байна. Мал маллах хүн байхгүй байна гэж ярьдаг.

Гэтэл бид нар бодлого боловсруулахдаа энэ талаар юу ч хийхгүй ийм харамсалтай цаг үетэйгээ тулгарч байна. Өнөөдөр мал маллаж байгаа

малчдын 50-аас дээш насны хүмүүс л эмэгтэйчүүд хүүхдүүд байна. Энэ саяын энэ байгалийн гамшигт үзэгдлээс болж олон эмэгтэйчүүд амь насаа алдсан. Энэ талаар өнөөдөр хэн ч дуугарахгүй байна. Энэ юунаас болоод байгаа юм. Цаашид яах юм? Цаг уурын энэ онцгой нөхцөл байдал энэ Мал аж ахуй, Монгол Улсын эдийн засгийн голлох салбар мөн юм бол Монгол хүн бүхэн хүнсний асуудлаа Мал аж ахуйгаас дамжуулж шийддэг нь үнэн юм бол залуу малчдын асуудал мал аж ахуйн асуудал дээр эдийн засгийн бодлогоор дамжуулсан тогтолцооны өөрчлөлт хийх цаг болсон байна. Бид өнөөдөр малчид байхгүй бол хэдхэн жилийн дараа бид яах юм. Гаднаас ажиллах хүч авах уу? Малчдын асуудал эдийн засгийн голлох хөшүүрэг болсны мал аж ахуйн асуудал чинь сүйрлийн ирмэг дээр тулсан. Бид сайхан өнөөдөр малчдаа залуучуудаа орон нутагт ажилла гэж уриа лоозон яриад ямар ч үр дүнгүй болсон. 30 жилийн өмнөх яриа хэлэлцээр бодлого энд явагдахгүй. Байгаль цаг уурын өөрчлөлтийн улмаас малчдын асуудал хүнд байдалд орсон. Түүнчлэн сэтгэлгээний, хандлагын өөрчлөлтөөс бид энэ малчдын асуудлыг эдийн засгийн бодлогоор дамжуулж тогтолцооны өөрчлөлт хийх болсон гэдгийг дахин хэлье.

Би олон Их Хурлын гишүүдтэй санал солилцоод байгаа. Даваасүрэн гишүүн миний саналыг их дэмжиж байгаа. Та бүхэн өнөөдөр эдийн засгийн хөшүүргээр дэмжсэн төрийн тогтвортой бодлого тогтолцооны өөрчлөлт хийх хууль эрх зүйн орчныг энэ парламент баталъя. Энийг та бүхэн энэ миний энэ санал санаачилгыг дэмжиж хамтран ажиллахыг Монгол Улсын ирээдүй болсон эдийн засгийн бодлогын чиглэл болох мал аж ахуй, залуу малчдын асуудлыг тогтолцооны өөрчлөлт хийхэд та бүгд надтай хамтарч ажиллахыг би уриалж байна.

Энэ бол Монгол Улсын эдийн засаг, улс орны ирээдүйн асуудал. Монгол Улсын



үндэсний аюулгүй байдлын асуудал шүү гэдгийг дахин хэлье.

**Г.Занданшатар:** Бөхчулууны  
Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Сая амралтын хагас сайн бүтэн сайн өдөр Дорнод аймгийн Цагаан-Овоо, Сэргэлэн сумаар явж иргэдтэй уулзаад ирсэн. Тэгээд иргэдийн үгийг төрд хүргэх нь Их Хурлын гишүүдийн үндсэн үүрэг. Тэгээд Цагаан-Овоо сумын Төмөрбатаа ах ер нь залуу ээж нар 2-оос 3 жил хүүхэд төрүүлээд гэртээ сууж байна. Залуу ээж нар тэгээд ясли сумдуудад байгуулж өгмөөр байна аа. Тэгээд залуу хүмүүсийг ажил хийлгэмээр байна. 6 сартай хүүхэд болонгуут нь яслид явуулаад тэр хүн залуучууд ажил хиймээр байна. Тэгэхгүй бол дараалаад дараалаад хүүхэд гардаг. Ер нь сайхан ид боловсрол эзэмисэн мэдлэг эзэмисэн тэр үедээ мэдлэгээ ашиглаж ажиллаж чадахгүй байна.

Тийм учраас энэ яслыг сумдуудад байгуулах асуудлыг шийдвэрлэж өгөх хэрэгтэй.

Дээрээс нь бага насны хүүхдүүд гэртээ байхдаа нөгөө эцэг эхчүүд яг яаж хүмүүжүүлэх бас тэр юм хумаа зарим чадахгүй тэгээд утсаар тоглуулаад л тэгээд муу зан сурч байна. Энэ хүмүүжлийн доголдол их гарч байна л гэж хэлж байна. Бат-Эрдэнэ гишүүн энэ дээр дургүйцэж байгаа бол өөр сумаас чинь очиж асуулгана аа.

Цагаан-Овоогийн Цагааны Наранбаатар өрнөөс өрний хооронд амьдарч байна. Банкны мал л маллаж байна. Тэгээд ийм учраас энэ улс орноо хөгжүүлээд эдийн засгаа сайжруулаад малын түүхий эдээ сайжруулбал бид нарын амьдрал гайгүй болох юм гэж ярьж байна. Мөнхтуяа багш хүүхдийн хоолны мөнгө 2650 төгрөг байна. Тэр нь хэтэрхий чанар муутай гэдэс дүүргэсэн ийм хоол өгч байна. Тийм учраас хоолны мөнгө

нэмээч. Тэр нэмэх санаачилгад оролцооч гэж сая улсын төсөв дээр тодорхой хэмжээгээр нэмж байгаа гэдгийг хэлье.

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Тулгаа бэлчээрийн асуудал их тулгамдсан асуудал болоод байна аа, иргэд хооронд, баг хооронд, сум хооронд, аймаг хооронд бэлчээрийн асуудал маш их гарч байна гэж. Тэгэхээр би хариулсан. Үгүй ийм сайхан нутагтай энд бэлчээрийн асуудал гарч байгаа юм чинь. Манай тэр баруун аймагт бэлчээр маш тийм хомсдолтой байдаг. Тэгээд хаяа багтахаараа бууж, хазаар багтахаараа сайхан идээд амьдарцгаа л гэж хэллээ.

Тэгээд хамгийн сүүлд нь яг өнөөдрийн байдлаар Ховд аймагт баруун аймгуудад нэг шуудай гурил 120 мянган төгрөг байгаа. Тэгээд өчигдөр би Новосибирскт суудаг нэг бизнесменээр дамжуулаад гурилын үнийг бүгдийг нь судлаад Ховд аймагт ирэх бүх зардлыг гаргасан. Тэгээд 58 мянган төгрөгөөр Орос 1 дүгээр гурил ирж байна 58 мянган төгрөгөөр. Тэгээд Орос гурилаар, гадаад гурилаа импортыг нь хаачхаад зөвхөн дотоодын гурил ид гэж хэлдэг. Тэгээд ийм юм байж болохгүй шүү дээ. Өөрөөр хэлбэл ард иргэд 60 мянган төгрөгөөр жоохон ашиг нэмээд 60 мянган төгрөгөөр гурил идэх боломжтой байж байхад 120 мянган төгрөгөөр гурил ид гээд ингээд дарамтлаад байдаг төр байж болохгүй шүү дээ. Та нар ингээд тэтгэвэр 2022 оны 2 сарын 1-нд тэтгэвэр 500 мянга болоход 10 шуудай гурил авч байсан шүү дээ. Одоо 4 шуудай хагас болчхоод байна шүү дээ. Энэ хүмүүсийн ингээд тэтгэврийг нэг талаараа нэмчхээд нөгөө талаараа гурилыг нь хямдхан бараа бүтээгдэхүүн хэрэглэх тэр боломжийг нь бүгдийг нь хаагаад тэгээд тэр ард иргэдийнхээ ахмадуудынхаа карманаас мөнгийг нь суульдаг энэ зүйлээ боль л доо.

Тэр гурилынх нь зөвшөөрлийг нь өгчих л дөө. Тэгээд баахан татаас энэ тэр авна, тэгээд татаас авчхаад тэгээд

хямдхан гурил үйлдвэрлэж чадахгүй. Тэгээд ард иргэд тэр өндөр үнэтэй хэдхэн үйлдвэрийн захирлуудын кармаг түнтийлгэдэг, зовоон зовоон түнтийлгэдэг ийм байж болохгүй шүү дээ. Тэр буудайны компаниудын. Зах зээлийн журмаар өрсөлдөөд л яв л даа.

Хэрвээ тэр ингээд 50, 60 мянган төгрөгөөр гурил ирэх боломжтой байж байхад 120 мянгаар зараад байх юм бол тэр салбар чинь тэр чигээрээ дампуурна ирээдүйд. Энэ татаасны энэ систем чинь ерөөсөө энэ үйлдвэр ААН-ийг улам дампууруулдаг ийм зүйл байхгүй юу даа.

Хэрвээ одоо зах зээлийн зарчмаар өрсөлдөөд явах юм бол тэр компаниуд чинь илүү хямдхан бүтээгдэхүүн хэрэглэх тэр зүг рүү маш их зүтгэнэ шүү дээ. Ингэхгүй тэгээд ард иргэдийнхээ карманаас тэгээд л баруун аймгийнхан бүгдээрээ 60 мянган төгрөгөөр гурил хэрэглэх боломжтой байж байхад 120 мянган төгрөгөөр хэрэглээд л одоо ингээд 2 дахин илүү мөнгө төлөөд хамгийн гол хэрэгцээ шүү дээ. Засгийн газрын гишүүд анхаараарай.

**Г.Занданшатар:** Гишүүд үг хэлж дууслаа хэлэлцэх асуудалтай холбогдуулаад. Ер нь тэгээд Ховд аймагт манай Ховд аймгийн гишүүд гэхэд жишээлбэл ХАА-н зардлаар тэр ногоон байгууламж бүхий сумын төвийн тохижилт гэж байгаа юм. Сумын тохижилт 6 тэрбум төгрөгийн өртөгтэй 3 тэрбумаар 9 сумд сумын төвийн тохижилт Мөнххайрхан сум руу 70 тэрбум төгрөгөөр, 8 тэрбум 500 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зам барина. Сумын төвийн зам. Улаанбаатарын замын түгжрэлээ хийж байхад чинь энийгээ хөдөө ахуй энэ тэр дээрээ тавиад шийдэхгүй энэ чинь гэх мэтчилэн ингээд шүүгээд үзэх юм бол өчигдөр төсвийн шинжилгээний нэгж Төсвийн хууль зөрчиж байна зарим заалтууд гээд тэгчихсэн учраас тэгээд багцаар нь хураалгах гээд байсан учраас зарим заалт

нь төсвийн алдагдал бууруулж байгаа бас зөв зүйтэй зүйл хийж байгаа маш сайн заалтууд байна. Зарим нь болохоор зөрчилтэй гээд тэгээд байгаа учраас зарчмын хувьд хураалгахад хэцүү байна гэдэг ийм санал хэлсэн шүү би. Өчигдөр түүнээс биш тэрийг сая гишүүд нь гуйвуулаад байх шиг байна. Тэгээд энийгээ гишүүд Байнгын хороон дээрээ сайн нягталж үзэх хэрэгтэй.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Ганбаатар сайд 5 дахь өдрийн нөгөө асуулгын хариуг юу хойшлуулаад Адышаа гишүүн ч гэсэн тэгээд хойшлуулаад агаарын бохирдол Цогтгэрэл гишүүн, гишүүдийн тавьсан 1 асуудал нүүрстэй холбоотой асуудлаар асуулгын хариуг сонсох уу, яах вэ гэдгийг маргааш шийдэх ёстой байдаг. Тамгын газар суугаад байдаг. Нөгөө мэдээ мэдээлэл нь болоод асуулга тавьсан гишүүд нь зөвшөөрч байвал 7 хоногийн өмнө тараачихсан байна уу, материал нь ирчихсэн байна уу? Тэрийг өнөөдөр шийдэж өгвөл сайн байна.

Ингээд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна аа.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг



2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

ХЗБХ-ны 2023 оны 12 дугаар сарын 12 дугаар тогтоолоор хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаа, Г.Амартүвшин, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар, Б.Энх-Амгалан нар болон холбогдох бусад албан тушаалтнууд ажиллалаа.

Хуулийн төслийг D-parliament.mn цахим хуудаст байршуулан олон нийтийн саналыг авсан бөгөөд иргэдээс хуулийн төслийн 6 зүйлтэй холбоотой давхардсан тоогоор 43 санал ирүүлснээс бага насны хүүхдийг хүчиндэх алах гэмт хэргийг ялын бодлогыг чангалж хорих ялыг 25-аас 30 жил, эсхүл бүх насаар хорих талаар санал зонхилж байсныг ажлын хэсэг нэг бүрчлэн хэлэлцсэн болно.

Хууль зүйн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулж зарчмын шинжтэй зарим асуудлыг ажлын хэсэг нягталж үзэж, нарийвчлан зохицуулах шаардлагатай гэж үзээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.8-д заасны дагуу горимын санал гаргасныг

хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Хууль зүйн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг дэг зүйл бүрээр хэлэлцсэн. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Д.Ганбат, С.Бямбацогт, Д.Цогтбаатар, Г.Амартүвшин, Ц.Сэргэлэн нар хуулийн төсөл болон зарчмын зөрөөтэй саналын томъёололтой холбогдуулан асуулт асууж хариулт авсан болно.

ХЗБХ-ны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Үүнд:

Насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоож хохирогчийг 18 насанд хүрсний дараа тоолж эхлэхээр, Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах, сунгах, ангилал нэмэх, өөрчлөх, шинээр авах, тээврийн хэрэгслийн эзэмшлийн шилжилт хөдөлгөөн хийх эрхийг хязгаарлах зэрэг болно оо.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

**Г.Занданшатар:** Энэ 7 хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа. Улсын Их Хурлын гишүүдэд мэндчилгээ дэвшүүлье.

11 дүгээр сарын 9-нд Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир Чойгийн Цэнд Нагваансамбуугийн Янжмаа нарын 8 дахь хүүхэд болж эхээс мэндэлжээ.

11 дүгээр сарын 11-нд Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар, Рагчаагийн Нанзад, Халтарын Оюунцэцэг нарын ууган хүүхэд болж эхээс мэндэлжээ.

Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир, Нанзадын Наранбаатарт төрсөн өдрийн мэнд хүргэж Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний илч болсон та бүхэнд болон гэр бүлийнхэнд нь Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх аз жаргал сайн сайхныг хүсэн ерөөе.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулна.

Дэмбэрэлцэрэнгийн Мөнх-Эрдэнэ Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх, Максимын Чинбат УЕП-ын орлогч Төрийн хууль цаазын шадар зөвлөх, Отгонбаярын Мөнхбаатар УЕП-ын таслах туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга, Лхамдоржийн Нямдаваа ЦЕГ-ын Захиргаа удирдлагын газрын дарга, Цолмонгийн Чинзориг Тээврийн цагдаагийн албаны Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн дарга,

Ванчигсүрэнгийн Хосбаяр Тээврийн цагдаагийн албаны Мөрдөн шалгах хэлтсийн дарга, Энэбишийн Бадамсамбуу ШШГЕГ-ын Хууль, тогтоомжийн хэлтсийн дарга, Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Сэнгээгийн Гантулга дотоод хэргийн их сургуулийн эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор. Базаргүрийн Гантуяа Эрүүгийн хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах боловсронгуй болгох чиг үүрэг бүхий байнгын ажлын хэсгийн гишүүн. Шагдарсүрэнгийн Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч, Төмөрчөдөрийн Нарантунгалаг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч, Цэрэнсүрэнгийн Лхагвацэнд Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Асуулт алга байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Зарчмын зөрүүтэй 15 санал байгаа.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 1.10 дугаар зүйлийн 10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“10.Энэ хуулийн 12.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12.3 дугаар зүйлийн 2.1, 3.2 дахь заалт, 13.1 дүгээр зүйлийн 2.1-д заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоож, хохирогчийг арван найман насанд хүрсний дараа тоолж эхэлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир, Ширнэнбандийн Адъяаа, Ганибалын Амартүвшин, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Бөхчулууны Пүрэвдорж, Жамъянхорлоогийн Сүхбаатар, Бямбасүрэнгийн Энх-Амгалан, Цаашид ажлын хэсэг гэнэ.

Санал хураалт явуулна.

Бүлгийн дарга, сайдууд санал хураалт явуулна. Суудалдаа сууцгаа санал хураалт явуулна. Жавхлан сайд нааш ир санал хураалт явуулъя.

Санал хураалт.

67.3 хувийн саналаар санал дэмжигдсэн.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 6.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “12.1 дүгээр зүйлийн 5 дахь” гэснийг “12.1 дүгээр зүйлийн 4 дэх” гэж, мөн зүйлийн 6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “22 дугаар бүлэгт” гэснийг “22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт” гэж тус тус өөрчлөх

Санал гаргасан. Ажлын хэсэг санал хураалт 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 3 дахь заалтын 6.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “10.1 дүгээр зүйлийн 2, 3” гэснийг “10.1 дүгээр зүйлийн 3” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт 70.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5 Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтыг хасаж, Эрүүгийн хуулийн 12.1

дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “хорин” гэснийг “хорин таван” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт 64.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар зүйлийн 5.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн ““мэргэжлийн үйл ажиллагаа явуулах,” гэсний дараа “тээврийн хэрэгслийг жолоодох” гэж, мөн хэсгийн “нийтийн албанд ажиллах” гэсний дараа “, тээврийн хэрэгслийг жолоодох”” гэснийг ““тохиолдолд” гэсний дараа “тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс арван хоёр жил хүртэл, эсхүл”” гэж өөрчилж, мөн зүйлийн “гэж, 12.3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтын “арван зургаан насанд” гэсний дараа “хүрсэн арван найман насанд”” гэснийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

64.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

**“27.10 дугаар зүйл.Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих**

1.Ажлын хэсгийн гаргасан, Тээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас

долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг:

2.1. согтуурсан, мансуурсан үедээ;

2.2. тээврийн хэрэгслийг жолоодох эрхгүй хүн;

2.3. хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулж үйлдсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг гурван жилээс дээш таван жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг таван жилээс дээш найман жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг:

4.1. согтуурсан, мансуурсан үедээ үйлдсэн;

4.2. энэ гэмт хэргийн улмаас хоёр, түүнээс олон хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг найман жилээс дээш арван хоёр жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

5. Тээврийн хэрэгслийг жолоодох эрхээ хасуулсан хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгслийг жолоодсон, эсхүл согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил

хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Энэ зүйлд заасан “согтуурсан” гэж шалгаж, тогтоох ажиллагааны үр дүнд шалгуулагчийн амьсгал дахь спиртийн агууламж 0.20, түүнээс дээш промилль (%), эсхүл цусан дахь спиртийн агууламж 0.5, түүнээс дээш промилль (%) илэрснийг ойлгоно.

-“Тээврийн хэрэгслийн жолооч” гэж тээврийн хэрэгсэл жолоодож яваа тээврийн хэрэгслийг жолоодох эрхтэй, эсхүл эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүнийг ойлгоно.

-“Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн” гэдэгт согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн үйлдлийн улмаас тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүнийг ойлгоно.

-“Тээврийн хэрэгсэл” гэж механикжсан тээврийн хэрэгслийг ойлгоно.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Асуулт гэж байхгүй дэмжсэн дэмжээгүй гээд л хэлж болно.

Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн. Жолоодох эрхгүй хүнийг жолооч гэж нэрлэх юм байна.

**Ц.Даваасүрэн:** Би 2 зүйлийг тодруулъя. Тэгэхдээ ер нь яах вэ энэ Эрүүгийн хуулийн асуудал дээр би та



бүгдийг нэлээн сайн нягталж үзсэн байх гэж найдаж байна шүү. Сүүлийн үед бас манай залуучууд түргэдэх бас дутуу харах ийм юмнууд бол хуулиуд дээр гаргаад байна шүү. Тийм учраас ялангуяа Эрүүгийн хуулийн асуудал хүний хувь заяатай холбогдолтой учраас маш сайн нарийн нягтлах хэрэгтэй гэдгийг бас хэлэх нь илүүдэхгүй байх.

Энэ гадуур нэг ийм яриа яваад байна шүү дээ. Айраг уучихсан байвал ийм ял авчих гээд байна гээд байх юм. Тэр талаар надад нэг тодруулж өгөөч. Тэр спиртийн хэмжээ чинь энэ айргийн юунд хүрэх үү үгүй юу? Айраг уучихсан яваад нэг ийм санамсаргүй алдаанаас болоод хүн шоронд орох тохиолдол гарах ийм хууль болчихлоо гэдэг талаараа асууя 2 дугаарт ер нь энэ тээврийн хэрэгсэл гээд байгаа дотор одоо энэ нэг гадуур хавтгай байгаад байгаа энэ нэг хөх моторт дугуй шиг юм байна шүү дээ. Ийм юм айраг уучихсан давхиж яваад хүн мөргөөд хаячихвал яах вэ, бас орох уу? Энэ орж байгаа юм уу гэдгийг би нэг асууя.

Энэ тэгэхдээ гадаад улс орнуудад Европт бол энийг гарсны дараа нь хууль гаргасан шүү энэ бүүр тусгайлсан хууль гаргасан юм. Гэтэл манайх бол ингээд л хэрэглээд л байж л байдаг. Тэгээд л задгай. Тэгээд 1 юм болохоо болингуут араас нь л нөгөө ниргэсэн хойно нь хаширдаг гэдэг шиг болохоо болингуут л хаширдаг тэгээд л сүржигнэдэг. Урьдчилж ерөөсөө арга хэмжээ авдаггүй.

Нэг ийм том дутагдал манайханд байна аа. Тийм учраас би энэ тээврийн хэрэгсэл гэдэг дотор тэр орж байна уу гэдгийг энэ нэг мотортой дугуй шиг нэг унадаг дугуй орж байна уу үгүй юу гэж. Нөгөө талаараа ер нь бол ингээд тээврийн хэрэгсэл жолоодож байгаа асуудлыг бид нар нэлээн анхааралтай хандахгүй бол тээврийн хэрэгслийн энэ нэг соёлгүй харилцаа энэ замын түгжрэлд их нөлөөлж байгаа шүү.

Манайхан бол өөрөө машинаа тавиад явчихаараа тоохгүй байна зам дээр. Хэлэхээр урдаас юу гэж байна гээд тэгэхээр юун сүртэй юм гээд байгаа байхгүй юу. Чи битгий машинаа тавь л даа гэхээр юун сүртэй юм гээд байгаа юм. Тэгсэн мөртөө хүн машин тавьсныг харчихаараа үгүй новш чинь машинаа тавиад явчхаж гээд ингээд байгаа байхгүй юу. Өөрөө тавьж болдог бусад нь тавьж болдоггүй энэ нэг монгол ёс зүйн төлөвшилийг хэдүүлээ арилгахгүй бол энэ нэг тээврийн хэрэгслийг хэрэглэж байгаа маань бүр бидэнд маш хүнд чирэгдлийг авчирч байна аа. Соёлтой харьцааг бий болгох чиглэлд бас бид нар энэ хуулиас гадна анхаарах ийм цаг бас болчихсон байна шүү гэдгийг бас хэлэхэд илүүдэхгүй хэлье.

Тэгээд миний саяын асуусан 2 зүйлийг анхаараарай. Хэлэлцүүлгийн явцад.

**Г.Занданшатар:** Цэндийн Сандаг-Очир гишүүн гаргасан саналаа тайлбарлаж үг хэлж болно. Тэр цусан дахь спиртийн агууламж 0.5, амьсгал дахь агууламж 0.2 гэдэг чинь айраг пиво хэдэн ямар хэмжээтэй таардаг юм гэдэг тодорхойлолт байгаа байлгүй. Тэрнийгээ хэлчих.

Цэндийн Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Даваасүрэн гишүүний саналтай холбогдуулж бас хариулт хэлье, тайлбар хэлье. Согтуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодож яваа асуудал байгаа. Одоогийн хуулиараа Зөрчлийн хуулиар хариуцлага оногдуулж байгаа. Засгийн газраас өргөн барьсан хуульд бол ялын бодлогыг чангалъя аа. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож яваад хүний амь нас, эд хөрөнгө хохирох, эрүүл мэндээрээ хохирох асуудал гэмт хэрэг зөрчил ерөөсөө огт буурахгүй байна аа. Тэр дундаа бага насны хүүхэд бас тээврийн хэрэгсэл согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоны улмаас амь насаа

алдах тохиолдол гэмт хэрэг зөрчлүүд буурахгүй байна гэдэг үүднээс энэ чиглэлийн бас хариуцлагыг чангатгахаар оруулж ирсэн.

Одоогийн Зөрчлийн хуулийг шууд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож яваад зөрчил гэмт хэрэг гаргасан тохиолдолд Эрүүгийн хуулиар хорих шийтгэл оногдуулахаар өргөн барьсан хуульдаа орж ирсэн. Хэлэлцүүлгийг Байнгын хороо, ажлын хэсэг дээр энэ асуудлыг яриад яах вэ бас хэт чангаруулсан байна аа.

Тийм учраас эхний удаа зөрчил гаргасан тохиолдолд эрхийг нь 6-аас 1 жилээр хасаад торгох торгуулийн хэмжээг нэмэгдүүлж байгаа. Аль эсвэл 7-гоос 30 хоног баривчлъя гэж байгаа эхний удаа бол.

2 дахь удаа бол тэр Эрүүгийн хуулиар хорих энэ шийтгэлийг оногдуулдаг байж гэж байгаа. Согтуугаар гэдгийг бол архи уугаад согтсон байна уу, айраг уугаад согтсон байна уу гэдэг бол тэр биш. Ерөөсөө л согтуурсан үе. Тэрнээс тэрийг ялгах бололцоо байхгүй. Та бол айраг ууж явж байгаад зөрчил гаргасан гэмт хэрэг үйлдсэн учраас энийг ялын бодлогоос хөнгөлөгдөнө гэдэг юм бол байхгүй юм байна.

Тийм учраас ерөөсөө та согтуурна гэдэг бол тухайн хүн өөрөө эрүүл мэндийн хувьд гэдэг юм уу анхаарал болгоомж сарних бүх л төрлийн юмаа алдсан байдаг. Тийм учраас айраг ууж согтсон байна уу, архи ууж согтсон байна уу гэдэг энд ялгах бололцоо байхгүй. Ерөөсөө согтуурсан бол. Тэр промилль гэдэг бол олон улсын стандарт дээр тогтоосон хэм хэмжээ. Цусан дахь спиртийн агууламж болоод амьсгал дахь спиртийн агууламжийг тогтоож байгаа. Энийг бол хуульд олон улсын стандартаар нь оруулж өгсөн гэдгийг хэлье. Тэгээд нэмэлт тайлбарыг манай тээврийн цагдаа болоод холбогдох улсууд бас хариулаад өгнө биз дээ?

**Г.Занданшатар:** Энэ тэгээд стандарт хэмжээ л дээ. Зүгээр энэ дээр хувь промилль 2-ыг хоёуланг нь тавьчихаар энэнээс болоод нэг хэмжих багажийн стандарт зөрөөгөөс шалтгаалаад хүн бас шалгаж байгаа хүмүүс мэддэггүй зөрөө гаргадаг асуудлууд гардаг. Энэ промилль хувь 2-ыг хоёуланг нь тавьчихаар энэ 2 чинь бас зөрөөтэй байдаг тохиолдол гардаг юм байна лээ. Дугуй, мопед, энэ тэр тээврийн хэрэгсэл, механикжсан тээврийн хэрэгслийг ойлгоно гээд бүгдийг нь заачихсан юм шиг байна.

Тэгээд энэ дээрээ ингээд асуулт хариулт байхгүй л дээ. Энэ дээр сайн тайлбар хийж тээврийн цагдаагаас. 88.

Тээврийн цагдаа нарт нийтдээ гардаг дутагдал байна шүү дээ хэмжих багаж нь промилль байна уу, хувиар байна уу гэдгээ ялгахгүйгээр энэ 2 чинь 2 өөр гарч болно шүү дээ бас.

Тэрнийг бас хэлээрэй. 86. Ажлын хэсэг 88.

Хууль дээрээ промилль, хувь хоёроо хоёуланг нь зэрэг тавьчихаар энэ 2 чинь 2 ялгаатай байдаг биз дээ, тэрнийг бас.

**В.Хосбаяр:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Тээврийн цагдаагийн албаны Мөрдөн шалгах хэлтсийн дарга дэд хурандаа Хосбаяр байна аа.

Даваасүрэн гишүүн гишүүний асуултад хариулъя аа.

Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм, Монгол Улсын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжид зааснаар тээврийн хэрэгсэл гэж хүн ачаа суурилагдсан тоног төхөөрөмжийг замаар тээвэрлэхэд зориулсан хэрэгслийг хэлж байгаа юм аа.

Ингээд тээврийн хэрэгслийг дотроо 2 ангилдаг. Нэг нь механикжсан тээврийн хэрэгсэл буюу замын хөдөлгөөний дүрэмд заасан тусгайлсан сургалтад хамрагдаж эрх авдаг тээврийн хэрэгсэл буюу орчиндоо аюултай тээврийн хэрэгсэл гэж үздэг. Автомашин мотоцикл 2 ордог байж байгаа.

Мөн насны ангиллаар жолооддог. Түрүүний гишүүний асуугаад байгаа унадаг дугуй скүүтер энэ мопед сороон зэрэг энэ хөдөлгүүрүүд орж байгаа юм аа. Тэгэхээр одоо өнөөдөр хэлэлцэж байгаа энэ хууль дээр болохоор механикжсан тээврийн хэрэгсэл гэдгийг тээврийн хэрэгсэл гэдэгт ойлгоно гэж байгаа. Тэгэхээр түрүүний тэр асуугаад байгаа энэ унадаг дугуй сороон бол орохгүй.

**Г.Занданшатар:** Энэ эцсийн хэлэлцүүлэг дээр тэр спиртийн агууламжийн промилль хувь хоёроо бас жоохон хэмжих багаж энэ тэрийнхээ стандартаа уялдуулж бас хянаж үзээрэй. Яг хууль дээр ингээд заачхаад сүүлд нь спиртийн агуулгад чинь Цагаан архи 38-аас 40 градус гэж үзэх юм бол нэг литрт шүү дээ тэ? Тэрнийг 0.5 руу шилжүүлээд л ямар хэмжээ зөвшөөрөгдөж байгааг айргийнх ч бай, шимийн архи 10-аас 12 градус энэ тэр гэх юм бол ингээд тэгээд 0.5 хоёр руугаа спиртийн агууламж 0.5 руугаа шилжүүлээд тооцно шүү дээ тиймээ. Тэгэхдээ тэр нь хүн болгоноос өөр байна.

Ингээд санал хураалт явуулъя. Энийгээ бас нарийвчлахгүй бол хэрэгжүүлэх явцад бас энэ чинь хүндрэл гарах вий. Энийгээ промилль, хувь 2 чинь 2 өөр байдаг гэдгийг та хэд.

Санал хураалт явуулъя.

67.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 4 дүгээр зүйлийн ““10.1 дүгээр зүйлийн Тайлбарын “арван дөрвөн”

гэснийг “арван зургаан” гэж, “12.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг,” гэснийг, мөн зүйлийн “2.1 дэх заалтын “арван дөрвөөс” гэснийг “арван зургаагаас” гэж, мөн зүйлийн”” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт 65.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Саяын тэр нөгөө багажууд нь промилль хувиар өөр өөр заадаг. Тэгээд нөгөө багажийн стандарт энэ тэр нь өөр өөр байдаг өөр өөр багаж авчхаад тэрэн дээрээ л будилаан үүсээд байдаг гэсэн ийм гомдол санал их гарч байсан юм байна лээ. Хүн ажлаас жишээлбэл тэрнээс болоод халагдчихлаа гэхэд тэрнийг бас нарийвчлан судалж байж энийг тэгэхдээ харгалзан үзэх эцсийн хэлэлцүүлэгт.

Санал хураалт явуулна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“8.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөнтэй холбогдуулан эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах, сунгах, ангилал нэмэх, өөрчлөх, шинээр авах, тээврийн хэрэгслийн эзэмшлийн шилжилт, хөдөлгөөн хийх эрхийг хязгаарлана.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал гэж байхгүй. Дэмжсэн дэмжээгүй үг байна. Пүрэвдорж гишүүн за тэгвэл Дамдины Цогтбаатар ХЗБХ-ны дарга.

**Д.Цогтбаатар:** Баярлалаа. Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Дарга аа энэ дээр гүйцээн боловсруулах чиглэл бид нар авмаар байгаа юм аа. Яагаад гэхлээр нөгөө бас зүй ёсны юмнууд яригдаж байсан л даа. Энэ гаргасан зөрчилтэй нь огт холбоогүй асуудлаар санкц тавиад, торгууль шийтгэл тавиад байна аа. Тэгэхлээр энэ дээр бас зөрчил гарч болзошгүй байна гээд тэр юмнуудыг нь авахлаар энэ арай зөөлдчихсөн болоод байгаа юм аа. Тэгээд яг Байнгын хорооны хурал дээрээ бид нар бас энийгээ ярьсан юм. Тэгэхлээр энэ дээр нөгөө цаанаасаа бол угаасаа бодлого маань бас хариуцлага шийтгэлийг илүү чангалах. Гэхдээ тэр яг гаргасан зөрчилтэй нь аль болох холбогдсон чиглэлээр тэр чангалах санкц хувилбаруудыг бодож гаргах хэрэгтэй байгаа юм аа. Тэгээд энэ дээр нэг гүйцээн боловсруулах чиглэл авмаар байна.

**Г.Занданшатар:** Энэ чинь машины худалдан борлуулах шилжилт хөдөлгөөн хийгдэхээр тэр үедээ л торгуулиа төлдөг бараг тэр үед торгууль нь мэдэгдэж байгаа шүү дээ. Хүмүүс мэдэхгүй явж байгаад л. Тэгсэн чинь энэ бүх хөдөлгөөнийх нь эрхийг нь хязгаарлачихна гэхээр чинь энэ чинь тэгээд бүүр нөгөө торгууль ч үгүй, борлуулах ч үгүй, ингээд нэг ийм асуудал үүсэхээр зохицуулалт хийчихсэн юм байна. Харин тэрний оронд тэр торгосон бол тэр хүнд мэдэгддэг байх хэрэгтэй шүү дээ. Хүмүүс чинь тэр машинаа зарах үед л торгуулсан гэдгээ мэдээд байна гэсэн асуудал гараад байгаа шүү дээ. Тэгээд энийгээ тэгээд яг унагаах юм уу? Гүйцээн боловсруулах юм уу?

Гүйцээн боловсруулах чиглэл өгье. Гүйцээн боловсруулах чиглэл өгчихсөн.

Байнгын хороон дээр ярь, гүйцээн боловсруулах чиглэл өгчихсөн тийм дэг байгаа.

2. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэх үндэслэл нь энэ хуулийн 5.2, 5.3, 5.4, 5.5, 5.6, 5.7, 5.8, 5.10, 5.11, 5.12, 5.13, 5.14, 5.15, 5.18, 5.20, 6.4, 6.5, 6.6, 6.7, 6.8, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.17, 6.18, 6.20, 6.22, 6.23, 6.26, 6.27 дугаар зүйл, Долоодугаар бүлэг, 8.1, 8.6, 8.7, 8.8, 8.9, 9.7, 10.3, 10.7, 10.15, 10.25 дугаар зүйл, Арван нэгдүгээр бүлэг, 12.1, 12.2, 12.3, 12.4, 12.5, 12.6, 12.8, 12.9, 12.10, 12.11, 13.1, 13.2, 13.4, 13.5, 13.6, 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.8, 14.9, 14.10, 14.11, 14.12, 14.13 дугаар зүйл, Арван тав, Арван зургаадугаар бүлэг, 17.1 дүгээр зүйлд тус тус заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хамаарахгүй.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр торгуулсан хүмүүс нь торгуулиа төлөөгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхийг авах, сунгах, ангилал нэмэх, өөрчлөх, шинээр авах тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн хийх эрхийг хязгаарлана гэж байгаа юм. Тэгэхээр энэ нь бүүр урьд нь бүүр ил өөр юмнуудыг жишээ нь, гадаад паспорт олгохгүй, төрийн албаны шалгалт өгүүлэхгүй, тендер шалгаруулалтад оролцуулахгүй, тусгай зөвшөөрөл энэ тэрээ өгүүлэхгүй гэдэг ийм зүйл байсныг нь ажлын хэсэг дээр хассан байгаа.

Тэгэхээр ер нь энэ тэгэхгүй бол ингэхгүй гэдэг энэ зүйл хуульд орж ирэх их буруу юм байгаа юм. Ер нь иргэнээ барьцаалдаг төр ерөөсөө байж болохгүй байхгүй юу даа. Тэгэхээр ер нь бол энэ



торгуулийг төлүүлэх олон арга хэрэгсэл байдаг. Өөрөөр хэлбэл 50 мянган төгрөгөөр торгуулсан тэрийг хугацаандаа төлөхгүй бол тодорхой хугацаа.

**Г.Занданшатар:** Энэ санал хураалттай хамааралгүй бөгөөд түрүүн өнгөрсөн асуудлаар нэг гүйцээн боловсруулах чиглэл өгсөн. ХЗБХ-н дээрээ ярь.

Санал хураалт явуулна.

Санал хураалт. Онооны төлөө биш хүний төлөө амьдрах хэрэгтэй.

54.5 хувийн саналаар санал дэмжигдсэн.

3.Төслийн 4 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. Энэ санал дэмжигдсэнгүй, Бүх техник гацаагүй.

Та нар мэдэн будилж эсрэг санал өгсөн. Энхбаяр дарга аа, Энхбаяр сайд аа. Энэ чинь ямар заалт нь билээ. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн.

**Б.Энх-Амгалан:** Сая энэ техникийн саатал гараад бүх юмнууд ингээд гацчихлаа. Тэгээд санал өгч чадсангүй. Тийм учраас энэ саналыг хүчингүй болгох горимын санал гаргаж байна.

**Г.Занданшатар:** Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

63.6 хувийн саналаар саяын саналыг хүчингүйд тооцлоо. Тийм учраас төслийн 4 дүгээр зүйлийг хасах саналыг дахиж хураалгая.

Санал хураалт.

Бат-Эрдэнэ аварга хүн зодохгүй, суудалдаа сууж санал хураалт өгье. Учрал гишүүн суудалдаа суу.

Санал хураалт.

67.3 хувийн саналаар санал дэмжигдэж төслийн 4 дүгээр зүйлийг хаслаа.

4. Төслийн 5 дугаар зүйлийн 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг өөрчлөн найруулж 3 дугаар зүйл болгон шилжүүлэх.

“3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“5.Жолооч:

5.1.согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;

5.2.тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;

5.3.согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж, дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

69.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нэг зүйл бас мартчихаж. Тэр зөвхөн спиртийн агууламж амьсгал болон цусан дахиар шинжилнэ гэж байгаа шүү

дээ. 3 дахь нь бас нөгөө шээс шээсний спиртийн агууламжаар тодорхойлдог нэг ийм аргачлалтай бас шүүхээр юм явлаа хорих шийтгэх ялтай болж байгаа үед.

Тийм учраас цус өгөх боломжгүй хүн байж болно согтуу байж болно. Тийм учраас тэр юмаа оруулахгүй зөвхөн энэ 2-оор гээд хязгаарлах нь буруу байж магадгүй шүү. Олон улсын стандарт нь 3 төрлөөр авдаг юм байна лээ.

2.Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх найруулгын саналаар санал хураалт явуулъя.

1.Төслийн 3 дугаар зүйлийн ““1.2, 1.3, 1.4 дэх заалтын дугаарыг “1.3, 1.4, 1.5;” гэснийг “1.2., 1.3. дахь заалтын дугаарыг “1.3., 1.4.” гэж өөрчилж, мөн зүйлийн “3.5-3.8 дугаар зүйлийн дугаарыг “3.7-3.10” гэж,” гэснийг “14.7 дугаар” гэсний өмнө шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Үгүй энэ нөгөө 12 жил болоод хугацаа нь дуусчихсан юм техникийн. Шинэчлэх гэсэн чинь Сангийн яам л болохгүй гээд энэ төсвөөс хас гээд хасуулчихсан байгаа. Энэ нөгөө гаднын тусламжаар энийг 12 жилийн өмнө аваад тэгээд энэ үйлдвэрлэхээ больчихсон юм байна лээ. Зах зээлгүй болчихсон.

Ингээд 63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Миний төсөв биш шүү наадах чинь. Би гэртээ юм авч тавих гээгүй.

7.Төслийн 4 дүгээр зүйлийн 10.1 дүгээр зүйлийн тайлбар 14 гэснийг 16 гэж 10.2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг гэснийг мөн зүйлийн 2.1 дэх заалтын 14-өөс

гэснийг 16-аас гэж мөн зүйлийн гэснийг тус тус хасах санал гаргасан ажлын хэсэг

Санал хураалт.

Энийг санал хураалт явуулчихсан.

Одоо Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх найруулгын саналаар санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “агуулга бүхий зүйл, хэсэг” гэснийг “агуулгатай дараах зүйл, хэсэг” гэж өөрчилж, 3 дахь заалтын 3 дахь хэсгийн “саналаа” гэсний дараа “оршин суугаа /оршин байгаа/ газар, эсхүл тухайн зөрчил гаргасан харьяаллын” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

67.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх найруулгын санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 41.2 дахь хэсгийн “10.1 дүгээр зүйлийн” гэсний дараах “2,” гэснийг хасаж, мөн зүйлийн 12.1 дүгээр зүйлийн “5 дахь” гэснийг “4 дэх” гэж, 4 дүгээр зүйлийн “2024 оны ... дүгээр/дугаар сарын ...-ны” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний” гэж тус тус өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66 хувийн саналаар санал дэмжигдэж байна.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх

зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй санал.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг хасах.

Үг хэлэх хүмүүсийг авъя. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж, Дашдондогийн Ганбат, Бямбасүрэнгийн Энх-Амгалан өөр гишүүн байхгүй юу? Баттөмөрийн Энхбаяр сайдаар тасаллаа.

29.1-ийг хэлээд байгаа юу? Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Энэ мөрдөн байцаалтын нууц задруулах Эрүүгийн хуулийн 21.9 дэх заалт байгаа энэ. Хууль санаачлагч оруулж ирэхдээ Эрүүгийн хуулийн 21.9 буюу мөрдөн байцаалтын нууц задруулах эрүүгийн гэмт хэргийн ялын бодлогыг чангатгая гэдэг ийм зүйл оруулж ирсэн. Энэ асуудалтай холбогдуулаад бас манай хэвлэл мэдээллийнхэн эсэргүүцэл яаж үзүүлж байсныг ч манай гишүүд санаж байгаа байх. Энэ асуудлаар одоо мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуульд бол энэ мөрдөн байцаалтын нууц задруулах асуудлыг бол Эрүүгийн хуулийн тодорхой хариуцлага хүлээхээр байгаа. Тэгээд энэ асуудлыг Улсын Их Хурал дахь МАН-ын бүлэг энэ асуудлыг авч хэлэлцээд мөрдөн байцаалтын нууц задруулахад хүлээлгэх хариуцлагыг чангатгах энэ 21.9 гэдэг заалтыг хасах нь зүйтэй гэж Улсын Их Хурал дахь МАН-ын бүлэг тогтсон юм аа.

Тэгээд Байнгын хороон дээр хуралдаад ирцийн бас байдлаас шалтгаалаад энэ дэмжигдээгүй юм байна лээ. Тийм учраас би одоо гишүүдийг кнопоо дарахгүй байж байгаад энэ заалтыг босгож өгөхийг хүсье баярлалаа.

**Г.Занданшатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах энэ асуудал дээр гол асуудал нь хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан болон иргэнийг энэ асуудлаар хариуцлага тооцох тухай асуудал өнгөрсөн хугацаанд бол яг энэ Эрүүгийн хуулиар бол шийдэгдээгүй юм байна лээ. Тэгээд би тэгэхээр энэ протоколд тэмдэглүүлэх гэж оруулж байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ заалт энэ 21.9 дүгээр заалт дэмжигдэх юм бол цаашидаа ер нь протоколд тэмдэглүүлсэн тохиолдолд энэ протоколын дагуу хууль хэрэглэх явцад Дээд шүүхийн тайлбар гардаг.

Дээд шүүхийн тайлбарыг бас тодорхой хэмжээгээр хууль хэрэглэх явцаа бас ашиглах ийм тохиолдлууд байгаа. Тийм учраас энэ дээр бол зориуд нэг зүйлийг хэлэхэд энэ хуулийн заалтын дагуу аливаа нэг иргэн хүн, хэвлэл мэдээллийн ажилтан энэ 21.9 дүгээр зүйлийн заалтын дагуу ямарваа нэгэн байдлаар эрүүгийн хариуцлага хүлээхгүй байх ёстой шүү гэдэг энэ зарчим дээр энэ Их Хурлын гишүүд хэрвээ дэмжсэн тохиолдолд энэ зарчим дээр л энэ асуудлыг дэмжиж байгаа шүү гэдгийг тэмдэглэж протоколд тэмдэглүүлэхийн тулд энэ үгийг хэлж байгаа.

Тийм учраас энэ мөрдөн байцаалтын нууцыг задруулчхаад хүмүүсийг мэдээллийнхнийг ашигладаг. Тэгэхдээ хэвлэл мэдээллийнхнийг нь буцаад хэрэгтэн болгох ийм зүйл рүү бид нар ерөөсөө яагаад ч оруулж болохгүй. Энийг нууцыг нь задруулж байгаа тэр нөхдүүдэд зайлшгүй хариуцлага тооцох ёстой гэдэг энэ зарчим дээр л энэ протоколд тэмдэглэхийн тулд энэ үгийг хэлж байгаа гэдгээ хэлье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Дашдондогийн Ганбат гишүүн.

**Д.Ганбат:** Та 2 ажлын энэ мөрдөн байцаалтын явцын талаар мөрдөн байцаалтын үед олж авсан албаныхаа мэдээллийг ингээд задруулж байгаа нь болохгүй л дээ. Олон хүний амь настай холбогдсон олон хүний амьдралтай холбогдсон ийм зүйл. Тэгээд нөгөө яг өнөөдрийн байдлаар тэр хууль нь үйлчлэхгүй байна шүү дээ. Ер нь мөрдөн байцаалтын нууцыг задалсан хүн ямар ч арга хэмжээ авагддаггүй. Авч байгаа арга хэмжээ нь хуулийнхаа зүйл заалтаараа бол торгох байдаг юм шиг байна. Энэ нь үйлчлэхгүй байна л даа. Тэгэхээр олон хүний амь амьдрал хохирсон. Энэ дээр цэг тавих цаг болсон. Би тэр Засгийн газраас оруулж ирсэн тэр санал бол зөв байна. Засгийн газраас гаргасан саналыг би тэр болгон дэмжээд байдаггүй. Гэхдээ энэ дээр бол овоо нэг зөв юм оруулаад ирсэн байна. Энийг нь дэмжих хэрэгтэй. Манай МАН-ын бүлэг яагаад ийм угаасаа л сонин зантай л даа энэ бүлэг чинь тэгээд. Дандаа л ингээд л хачин хачин юм гаргаж байдаг тийм.

Тэгэхээр энэ МАН-ын бүлгийн гаргасан энэ юмыг дэмжиж болохгүй тийм. Энийг бол ерөөсөө нөгөө сэтгүүлч хэвлэл мэдээллийнхэн маань 4 дэх засаглал болохынхоо хооронд нөгөө гүйцэтгэх ажлынх нь нэг хэсэг болоод ингээд явчхаад байна. Ингээд ашиглаад байна тэр хэдийг. Тэгэхээр болохгүй л дээ. Тэр нь яах вэ мэдээлэл олж авах эрх нь эх сурвалжаа нуух эрх нь хэвлэлийнхний бүрэн эрх. Тэр талаар бол албаны үүрэг хүлээгээгүй энгийн иргэд сэтгүүлчид энэ хүмүүс ямар нэгэн хариуцлага хүлээх ёсгүй. Тэр тухайн мөрдөн байцаалтыг явуулж байгаа албан тушаалтан тэрийг хариуцаж байгаа цагдаа, тагнуул, Авлигатай тэмцэх газар хариуцлага хүлээх ёстой. Энүүгээрээ бол торгуулна барина гэсэн тийм юм байдаг тэр нь хэрэгждэггүй. Энэ явдал маш удаан ужиг болтлоо үргэлжиллээ. Энэ дээр цэг тавих цаг болсон.

Гэтэл МАН-ын бүлэг одоо яагаад ийм юмыг бүлгээрээ эсэргүүцээд байдаг юм бэ? Энэ чинь одоо жинхэнэ хуулийн, хуулийнхны, жинхэнэ мэргэжлийн, хүмүүсийн л хийдэг ажил шүү дээ. Битгий тийм юманд оролц л доо та нар. Тэр улс төрөө л хийдэг юм байгаа биз айн. Тэр хууль нь хуулиараа яваад цаана нь хүний амьдрал байдаг. Хэчнээн хүн хохирлоо. Тэгээд хэвлэл мэдээллийнхнийг худалдаад аваад сурчихсан та нар, энэ юмаа боль л доо. Ажлын цаг тарчихсан байхад л өрөөний гадаа нэг өрвийсөн нөхөр микрофон бариад л зогсож байдаг юм. Үгүй ямар хэрэгтэй юм бэ тэр чинь. Энэ чинь ажлын цаг дууссаны дараа тэр чинь миний цаг юм байгаа биз дээ хаана юу хийх юм?

Баярлалаа. МАН-ын бүлэг бас ч гэж юм ойлгохоор хүмүүс байна л даа. Тийм энэ Тогтохсүрэн дарга бүрэн ойлгох л хүн. Яачхаад ингээд МАН-ынх болчихоороо л ийм болчих юм. Нээрээ ёстой зовлонтой болсон юм та нар. Ойлгомжтой болох шиг боллоо.

**Г.Занданшатар:** Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн.

**Б.Энх-Амгалан:** Энэ 21.9 дүгээр зүйлийн 2, 3 ийм л юм байгаа шүү дээ. Мөрдөн шалгах ажиллагааны талаар албан үүргийн дагуу олж мэдсэн албан хаагч буюу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор энэ хүмүүс байхгүй юу. Тэр хэргийг мөрдөж байгаа нөхдүүд. Энэ нөхдүүд олж авсан тэр мэдээллээ нууцалсан баримтуудаа ил болгоод, тэр нууцалсан гэрчүүдээ ил болгоод тэгээд хэрэг хянан шийдвэрлэхэд саад учруулаад хэргийн үнэн мөнгийг тогтооход саад учруулаад, мөрдөн байцаах ажиллагаанд саад учруулаад ингээд хэвлэл мэдээллийнхэнд аваачаад мэдээллээ өгчихсөн бол энэ чинь Эрүүгийн хуулиар шийдэгдэх ёстой байхгүй юу. Одоо та нар харж байгаа. Ингээд шууд хэвлэл дээр гарч ирээд өөрсдөө гарч ирээд хэргээ яриада унадаг ийм хууль хяналтын



байгууллага байгаа шүү дээ гээд хэрэг яриад сууж байдаг. Шалгаж байгаа хэргээ яриад сууж байдаг. Тэгээд гарч ирчхээд тэрэн дээрээ зохиол биччихээд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараачхаад одоо яахыг нь харна, шүүхийг яахыг харна гээд ингээд шүүхэд нөлөөлөх гээд байдаг ийм нөхцөл байдлууд байгаа шүү дээ.

Тийм учраас энэ хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын нууцыг задалдаг. Уул нь нэг талдаа ялладаг, нөгөө талдаа цай цагаатгадаг ийм 2 талын үйл ажиллагаатай хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтыг явуулах ёстой байтал зөвхөн яллах талаа барьж үзчихээд тэрийгээ бүр хүчээр ингэж олон нийтэд үзэн ядуулж байж шүүхэд нөлөөлөх гэсэн ийм оролдлогуудыг таслан зогсоох ёстой байхгүй юу? Таслан зогсоох ёстой. Энэ чинь өөрөө цаашдаа хэлмэгдүүлэлт болно шүү дээ.

Тэгэхээр энийг бол яг энэ үндсэн заалт нь үлдэх ёстой. Харин тэр мэдээллийг олж авсан иргэн ч байдаг юм уу хэвлэлийн ажилтан бол тэр чинь бол хардах эрхтэй хүмүүс байхгүй юу. Тэд нар болж байна. Яг үндсэн үүрэг хүлээсэн тангараг өргөсөн тэр төрийн албан хаагч, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч тэр прокурор, тэр хуулийн байгууллагын албан хаагчид шийдэгдэх ёстой гэдэг зарчим дээр бол санал нэг байгаа юм аа.

**Г.Занданшатар:** Энэ тэгэхдээ нөгөө гүйцэтгэх ажлын шугамаар ч юм уу задрах тохиолдолд прокурорын зөвшөөрөлтэйгөөр задалж болж байгаа шүү дээ тийм ээ.

Тийм Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Энэ заалт дээр ерөөсөө анхнаасаа эхлээд нэг тийм буруу ойлголт явчихсан юм аа. Энэ бол санаатай үйлдэл. Хэвлэл мэдээллийн байгууллагын эрх чөлөөнд халдлаа. Иргэдийн мэдэх эрхэд халдлаа.

Сэтгүүлчийг яллах гэж байна энэ тэр гэсэн ийм улс төр зориуд хийсэн. Энэний цаана манай энэ нууц мэдээллийг задалдаг хуулийн байгууллагынхан өөрсдөө байгаа. Өөрсдөө өөрсдөө ийм захиалгаар ийм юм хийсэн. Одоо энэ асуудал дээр прокурорын байгууллагаас тодорхой хэрэг бүртгэлтийн хэрэг үүсгээд шалгаж байгаа асуудлууд бий. Энэ жирийн албан хаагчдаас мэдээлэл задрахгүй байгаа. Жирийн ажлаа хийж байгаа мөрдөгч эрүүгийн төлөөлөгчөөс энэ мэдээлэл задраагүй. Сүлжээ үүссэн байгаа. Шантааж хийж байна. Энэний цаана хээл хахууль авах гэмт хэргийн том сүлжээ байна. Мөнгө угааж байна. Улс төрд нөлөөлж байна.

Алтанхуяг гэдэг Ерөнхий сайдыг одоо урьд өдөр нь хуулийн байгууллагад гарч ирээд яг ар гэрт нь хэрэг үүсгэж шалгаж байгаа гэж байгаад огируулж байсан.

Төрийн эрх мэдэл ард түмний гарт байх ёстой болохоос хонгилынхны гарт байх ёсгүй. Хонгилынхны гарт. Энд хэвлэл мэдээллийн байгууллагад ямар ч хамаатай заалт биш. Өнгөрсөн 100 жилийн хугацаанд энэ заалт байсан. Эрүүгийн хуульд. Энд иргэдийг энэ зүйл заалтаар яллаж байгаагүй. Хэвлэл мэдээллийн байгууллагынхныг энэ зүйл заалтаар яллаж байгаагүй. Зориуд мушигад ийм одоо энэ нөгөө нууц задалдаг сүлжээ нь илрэх гээд, дэлбэрэх гээд сандраад ийм акцыг энэ танхимд хийсэн юм шүү.

Тийм учраас би зориуд мэдээллийн ийм одоо энийг залруулах ёстой гэж үзэж байгаа юм. Тийм учраас манай Байнгын хороо мэргэжлийн Байнгын хороо энэ саналыг дэмжээгүй. Хасах саналыг.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд үг хэллээ. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа.

Санал хураалт явуулъя.

Санал хураалт.

52.1 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

#### 14.13 цагт

Дараагийнхаа асуудалд оръё.

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр танилцуулна.

Энхбаяр сайдыг индэрт урьж байна.

**Б.Энхбаяр:** Улсын Их Хурлын эрхэм дэд дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлүүлэхээр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна аа.

Гэр бүлийн тухай хууль нь хувийн эрх зүйн асуудлыг зохицуулж байгаа иргэний эрх зүйн суурь хуулийн нэг бөгөөд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль 1999 онд батлагдсан. Монгол Улсын хувьд хууль батлагдаж байсан үе буюу 1999 оноос хойш гэрлэх, гэрлэлт цуцлах, хүүхдийн эрх, хууль ёсны эрх ашиг хөндөгдөх, зөрчигдөх, сэргээх зэрэг харилцаа ихсэж байна аа.

Тухайлбал шүүхийн шийдвэрийн тоо баримтаас дурдвал Гэр бүлийн тухай хуулиар 2020 онд 4732, 2021 оны эхний хагаст 2085 хэрэг шийдвэрлэсэн нь нийт хэргийн 10.1 хувийг эзэлж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд энэ төрлийн маргааны тоо ихсэх хандлагатай байна. Мөн олон улсын чиг хандлагаас үзэхэд шинэ төрлийн гэр бүлийн харилцаа нэмэгдэж байна.

Иймээс Гэр бүлийн тухай хуулийг олон улсын жишигт нийцүүлэх, шинээр үүсэж байгаа харилцааг зохицуулах, хийдлийг арилгах зорилгоор тус хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Ингэхдээ хүүхэд жирэмсэн болон хөхүүл эмэгтэй эс үгүй бол бага насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх, хөгжлийн бэрхшээлтэй ахмад настан, хөдөлмөрийн чадваргүй гэр бүлийн гишүүний эрх, хууль, ёсны ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах зарчмыг баримтлалаа.

Түүнчлэн хуулийн төсөлд эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалахад илүүтэй анхаарч боловсруулсан.

Төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгалаа.

Үүнд:

Улсын Их Хурлын 2022 оны 1 дүгээр тогтоолтой уялдуулж Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах цус ойртолтоос урьдчилан сэргийлэх зорилгоор ДНК-ийн шинжилгээнд хамрагдах боломжийг төсөлд тусгалаа.

2014-өөс 2022 оны хооронд гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг эхээс 22924 хүүхэд шинээр мэндэлсэн байна. Манай улсын хувьд гэрлэлтээ бүртгүүлээгүй

боловч хамтран амьдарч байгаа хүмүүсийн эрх үүргийг тодорхойлох цаашлаад эд хөрөнгө хуваах хүүхэд тэжээн тэтгэх асрамжлалын маргааныг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Иймд хуулийн төсөлд хамтран амьдрагчийг тодорхойлж тэдгээрийн хамтын амьдралын явцад хамтын амьдрал дуусгавар болох тохиолдолд эдлэх эрх хүлээх үүрэг мөн ийм харилцаанаас төрсөн хүүхдийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зохицуулалтыг тусгалаа.

Шүүхийн шийдвэрийн цахим сангаас 2022 оны гэрлэлт цуцалсан Шүүхийн шийдвэрүүдээс түүвэрлэн авч үзэхэд гэрлэлт цуцлах болсон шалтгаан таарамжгүй харилцаа 76 хувь, архидалт 12 хувь, тусдаа амьдарч байгаа 8 хувь, гэр бүлээс гадуурх харилцаа 2 хувь, Гэр бүлийн хүчирхийлэл 2 хувьтай байна аа.

Тодруулбал гэрлэлт цуцлах шалтгааны дийлэнх хувийг гэрлэгчид хоорондын таагүй харилцаа эзэлж байна.

Хуулийн төслөөр гэрлэгчдийн эрх үүргийг нарийвчилсан бөгөөд үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө талын эрх, нэр төр, алдар хүндэд хохирол учруулсан тохиолдолд иргэний хуульд заасны дагуу гэм хорын хохирол төлүүлэх боломжийг бүрдүүллээ. Хуулийн төсөлд гэр бүлийн харилцаанд болон дуусгавар болох тохиолдолд гэрлэгчдийн эд хөрөнгийн эрхийг хамгаалах зорилгоор гэрлэлтийн гэрээ байгуулах зохицуулалтыг тусгалаа.

Гэрлэгчид гэрлэлтийн гэрээгээр эд хөрөнгийн эрх үүсгэх, шилжүүлэх, дуусгавар болгох, хязгаарлахаар зохицуулсан бол хөрөнгийн төрлөөс хамаарч бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гэрээгээ бүртгүүлэх зохицуулалтыг нэмж тусгалаа.

Хуулийн төсөлд хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг эхийн үүрэг

хариуцлагыг нэмэгдүүлж хүүхдийн өмнө хамтран үүрэг, хариуцлага хүлээх зарчмыг тусгалаа.

Мөн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийн эд хөрөнгийг хүүхдийн хэрэгцээнд зарцуулах зохицуулалтыг тусгаад байна аа. Түүнчлэн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг гэр бүлдээ авч, асран хүмүүжүүлэх, асралт гэр бүлийн харилцааг шинээр зохицууллаа. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Гэр бүлийн тухай хуулиар хүүхдийн амьдарч байгаа бус нутагт тогтоосон амьжиргааны доод түвшний хэмжээний тодорхой хувиар тооцох нь тэтгэлгийн хэмжээг тогтоож байна аа.

Иргэд олон нийтийн зүгээс хүүхдийн тэтгэлгийн хэмжээ нь хүүхдийн хэрэгцээнд хүрэлцэхгүй нөгөө талаас тэтгэлэг төлөгчийн орлоготой уялдахгүй байна гэсэн шүүмж гарсан. Иймд тэтгэлгийн хэмжээг тэтгэлэг, авагчийн нас, амьжиргааны өртөг зардал зэрэг хэд хэдэн хүчин зүйлсийг харгалзан тэтгэлэг төлөгчийн орлого, нөхцөл байдалтай уялдуулж эрх бүхий байгууллагаас батлах аргачлалын дагуу шүүх шийдвэрлэхээр шинэ зохицуулалтыг тусгалаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн мэдээллээс үзэхэд хүүхдийн тэтгэлгийн 50 гаруй хувь огт төлөгддөггүй байна. 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тэтгэлэг авагч нийт 13866 хүүхэд байгаагаас 9739 хүүхэд тэтгэлгээ авч чадаагүй байгаа.

Тэтгэлгийн хэмжээгээр нь тооцвол 6.6 тэрбум төгрөг төлөгдөөгүй байна. 2017-гоос 2022 онд 7596 хүүхэд дотоодод үрчлүүлсэн бол Монгол Улсын харьяат нийт 274 хүүхэд гадаадын иргэдэд үрчлэгджээ. Хүүхэд үрчлүүлснийг хүчингүйд тооцсон 2017-2021 оны шүүхийн шийдвэрүүдийг авч үзэхэд 2017 онд 97 шүүхийн шийдвэр, 2018 онд 12 шүүхийн шийдвэр, 2019 онд 11 шүүхийн шийдвэр, 2020 онд 12 шүүхийн шийдвэр, 2021 онд 9 шүүхийн шийдвэр байна аа.



Иймд хуулийн төсөлд хүүхдийн эрх, хууль, ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор үрчлүүлэх эсэх асуудлыг шүүх шийдвэрлэх шинэ зохицуулалтыг тусгалаа. Хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийн төслийг хэлэлцэж эсэх асуудлыг шийдвэрлэж өгөхийг эрхэм гишүүдээсээ хүсье.

Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Энхбаяр сайдад баярлалаа.

Төслийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин танилцуулна аа.

Таныг индэрт урьж байна.

**Г.Амартүвшин:** Улсын Их Хурлын дэд дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, гэр бүлийн гишүүний эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус амины эрх үүрэг тэжээн тэтгэх асран хамгаалах, харгалзан дэмжих, хүүхэд үрчлэхтэй холбоотой харилцаа түүнээс үүсэх үр дагавар, тэдгээрийн эрх, хууль, ёсны ашиг сонирхлын хамгаалах харилцааг нарийвчлан зохицуулах хүүхдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор хуульд заасан зарим тохиолдолд эрх хязгаарлах зохицуулалтыг тусгах, үүнээс үүсэх үр дагаврыг тооцож оролцогчдын эрх ашгийг аль болох хөндөхгүй байх хамгаалах зохицуулалтыг тусган хуулийн төслийг боловсруулсан бөгөөд хуулийн

төсөл батлагдсанаар төрийн байгууллага болон иргэнд тодорхой хэмжээний зардал үүсэх тул хууль санаачлагч холбогдох хууль тогтоомжийн дагуу зардлын тооцооны талаарх судалгааг хийсэн байна.

Хуулийн төслийн *D-parliament.mn* цахим хуудаст байршуулан олон нийтийн саналыг авч байгаа болно оо.

Байнгын хороон хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин 2 тал харилцан тохиролцсон эд хөрөнгийн маргаангүй хүүхдийн тэтгэмжийн асуудлыг шийдвэрлэсэн тохиолдолд шүүхэд хандалгүй хялбаршуулсан журмаар, эс үгүй бол бусад захиргааны хэм хэмжээний актаар гэрлэлт цуцлах боломж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэг хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж байгаагаа илэрхийлээд гэр бүлээс гадуур харилцааны улмаас гэрлэлтээ цуцалж байгаа тохиолдолд буруутай этгээдэд мөнгөн төлбөр оногдуулах асуудал тусгасан эсэх, гэрлэлт бүртгүүлэх үед садан төрлийн гэрлэлт цус ойртолтоос сэргийлэх талаарх зохицуулалт туссан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Учрал ургийн бичиг хөтлөх асуудлыг сүүлийн үеийн дэвшилтэт технологи ашиглахыг хуульд тодорхой тусгах шаардлагатай талаар дурдаад хүн амын удмын сангийн аюулгүй байдлыг хангахад угийн бичиг хөтлөх талаар тусгасан үр дүнтэй хэрэгжиж үр дүнтэй хэрэгжих боломж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Адьшаа гэр бүлээ цуцлуулсны дараа хүүхдийн тэтгэлэг төлүүлэх үүрэг хариуцлагыг биелүүлэх талаар шинэ зохицуулалт туссан эсэх, гадаад улсын иргэдэд хүүхэд үрчлэх асуудал цаашид гарах үр дагаврыг хэрхэн зохицуулсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж байгаагаа илэрхийлээд садан төрлийн хүмүүс

хоорондоо гэрлэж байгааг хэрхэн тогтоож, урьдчилан сэргийлэх, мөн ижил хүйсийн хүмүүс гэр бүл болон хамт амьдрах талаарх зохицуулалт байгаа эсэх талаар асуулт асууж хариулт авсан болно оо.

Гэр бүлийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 76.9 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсан баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Амартүвшин гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн

хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Баярсайханы Солонго, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Нармандахын Жамьяанхүү, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Нарантуяагийн Баярмаа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн шинжээч Мөнхдэлгэрийн Цолмон, ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга цагдаагийн хурандаа Идэрийн Батчулуун, ШШГЕГ-ын дэд дарга бөгөөд Шийдвэр гүйцэтгэх албаны дарга хурандаа Чойжамцын Оюунцэцэг, Шүүх шинжилгээний ерөнхий газрын тэргүүн дэд дарга хурандаа Базарсадын Даваа ирсэн үү? УБЕГ-ын Иргэний бүртгэлийн газрын дарга Туулын Төгөлдөр, ШШГЕГ-ын харьяа Банк, хадгаламж зээлийн хоршоодын Төлбөр барагдуулах ажлын албаны дэд дарга хошууч Батхүүгийн Базарсад, УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газрын ахлах мэргэжилтэн Няндагийн Наранцэцэг, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга Начиндагвын Өлзийхутаг, олон улсын Улаанбаатар их сургуулийн Монгол Солонгосын эрх зүйн хүрээлэнгийн захирал хууль зүйн доктор Очирбатын Амарсанаа, Гадаад иргэн харьяатын газрын Иргэний харьяатын газрын мэргэжилтэн Батсуурийн Бат-Ундрах, Монголын хуульчдын холбооны гишүүн хуульч Цэнд-Аюушийн хуралдаанд оролцож байна аа.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Нэрсээ өгье.

Сандаг-Очир, Бөхчулууны Пүрэвдорж гишүүнээр, Дуламдоржийн

*Тогтохсүрэн гишүүнээр тасаллаа.  
Сарангэрэл гишүүн орж байгаа юм уу?*

*Даваажанцангийн Сарангэрэл  
гишүүн.*

*Анужин Цогтбаатар юм уу?  
Анужин гишүүнийг оруулчих, нэмчих  
Анужин гишүүнээр тасаллаа.*

*Улсын Их Хурлын гишүүн  
Цэрэнпилийн Даваасүрэн асуултаа асууя.*

**Ц.Даваасүрэн:** Сүүлийн үед энэ хүүхэд гэр бүлийн асуудалд анхаарч эхэлж байгаа нь сайн. Яах вэ бид бол нэг одоо юу гэмээр юм дээ нэг тэнэгийн ухаан хойно гэдэг шиг л ингээд л юм болоод л өнгөрсөн хойно нь л хаширдаг болчихоод байгаа юм даа. Уг нь бол урьдчилан сэргийлэх чиглэл рүү нь л анхаарах ёстой. Тэгээд би энэ дээр нэг тодорхой санал хэлье гэж бодож байгаа юм. Зүгээр ер нь бол ялангуяа энэ гэр бүлийн асуудлаас болж хүүхэд ер нь хохирч хэлмэгдэхгүй байх ёстой.

*ОХУ-д бол хэрвээ гэр бүл салаад тэгээд нөгөө этгээд тэтгэмжээ өгөхгүй бол ял эдлүүлдэг хатуу. Тэгээд тэрэн шиг ер нь нэлээн хатууруулсан ийм заалтуудыг бол бид нар бас оруулж өгөхөд гэмгүй. Тэр хүүхдийн тодорхой наад захын хэрэгцээг нь хангах тэр тэтгэмжийг нь төлүүлэх асуудал дээр бид анхаарах ёстой. Бас нэг ийм зүйлийг бид нар ер нь цаашидаа би энэ хууль санаачилж орж ирж байгаа улсууд энэ холбогдох байгууллагыг анхаараач гээд байгаа юм.*

*Энэ Орост ялангуяа энэ өнчин хүүхдүүдэд бол яг энэ асрамжийн газар хүмүүжээд сургуулиа төгссөний дараа дээд сургууль төгссөний дараа бол иүүд байр өгдөг, байр өгдөг. Тэд нар чинь байр олоход хэцүү шүү дээ. Тийм учраас бол энийг нэг бид нар анхаараад ийм хуулийн заалт оруулж ирэхэд бас та нар нэг судлаад анхаараач. Яг бүтэн өнчин ийм хүүхдүүдэд бол байр олгодог. Байр өгдөг*

*ийм л болмоор байгаа юм. Ямар ч асран хамгаалах ч үгүй ийм улсууд бол хэцүү шүү дээ. Тийм учраас энэ чиглэлд манай төрийн холбогдох байгууллагууд анхаараад дараагийн хууль дээр бол энэ бүтэн өнчин хүүхдүүдийн асуудал дээр энэ заалтыг оруулж ирээч гэж байр аль нэгэнд нь байр өгдөг болгоё гэж гудамжинд хаяад хэрэггүй шүү дээ хүнийг ер нь. Тийм учраас ямар нэг халамж асран хамгаалагчгүй, ивээн тэтгэгчгүй, боломжгүй ийм хүүхдүүдийг бол бүтэн өнчин хүүхдүүдэд бол ийм арга хэмжээг цаашидаа авмаар байна аа.*

**Л.Мөнхбаатар:** Даваасүрэн гишүүн та санал хэлчэв үү, хариулт авах юм уу та. Даваасүрэн гишүүний саналыг ажлын хэсэг шинэчилсэн найруулга учраас ажлын хэсгийнхээ хэлэлцүүлгийн явцдаа анхаарна биз.

*Байнгын хорооны дарга  
Баагаагийн Баттөмөр асуултаа асууя.*

**Б.Баттөмөр:** Гэр бүлийн тухай хууль ингэж орж ирж байна аа. Энэ 11 сарын 3-нд өргөн баригдаад өнөөдөр 9-нд ингээд хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж байгаа гээд их хурдтай явж байна аа. Удирдахуйн шинжлэх ухаанд бол аливаа асуудлыг шийдэхэд хурд хэрэгтэй, чанар бас хэрэгтэй, хамгийн чухал. Тэгээд энэ чанар талаасаа ямархуу байгаа юм. Шинэ сайд нэлээн хурдтай явуулж байх шиг байна. Энэ хувийн эрх зүйн харилцааг зохицуулж байгаа гол хууль бол гэр бүлийн хууль. 1999 онд батлагдаад л тэрнээс хойш яг дорвитой шинэчлэл хийгдээгүй ингээд явчихсан. Гэр бүлд бол асар их хэмжээний асуудлууд тулгарч ирсэн 20 хэдэн жилийн хугацаанд. Тэр болгоныг тухайн үед шийдээгүй нөгөө л хагархай цонхны онол тухайн тухайн үед нь асуудлуудаа шийдээгүй дандаа хойноос нь хөөцөлдөж явдаг. Ингээд орж ирж байгаа нь бол зүйтэй байна гэж ингэж үзэж байгаа юм аа.

Энэ Улсын Их Хурлаас төрийн албаны ёс зүйн тухай хуулийг баталсан. Одоо ингээд хэрэгжээд явж байгаа. Энэ хууль дотор бол төрийн албан хаагчийг соён гэгээрүүлэх, үндэсний хөтөлбөр батлах үүргийг бид нар авчихсан байгаа. Энэ хүрээнд бол маш их олон судалгаануудын ажлыг хийж байгаа. Тэгээд энэ судалгааны ажлыг ингээд хийгээд хийх явц дунд юу харагдаж байна гэхээр зэрэг ерөөсөө энэ гэр бүлийн харилцаан дээр гол асуудлууд байна гэсэн. Ийм юм гарч ирж байгаа юм л даа. Манай бол салалт байнга гэр бүл салалт байнга нэмэгдэж байгаа, гэр бүл бүртгэлт бол байнга багасаж байгаа. Тэгээд гэр бүл салалтын золиос нь хүүхэд болдог. Яагаад салж байна гээд судлаад үзэхээр зэрэг л ерөөсөө таарамжгүй харилцаа. Архи гэсэн ийм 2 үндсэн гол үзүүлэлт л голлож нөлөөлөөд байгаа юм.

Тэгээд хамтран амьдрагч гээд нэг юм гарч ирсэн байгаа. Энэ чинь бараг 30 гаруй мянган хүүхэд байдаг гэсэн судалгаа бидэн дээр байгаа юм. Тэгээд тэдний эрх ашиг байнга зөрчигдөж байдаг. Тэгээд гадаадад их олон хүмүүс гэр бүл болдог амьдралын шаардлагаар гаднын улсуудтай гэр бүл болдог сайн сайхан хүмүүстэй гэр бүл болоод сайхан амьдарч байгаа хүмүүс байна.

Тухайн нийгмийнхээ шаар болчихсон хар тамхи хэрэглэдэг элдэв бусын тийм хүмүүстэй гэр бүл болоод хохирч байгаа эмэгтэйчүүд их олон байгаа. Ийм судалгааны дүн бас манай дээр гарч ирсэн байгаа. Тэгээд эцэг эх байх эрхээ хасуулчихсан 120-оод хүн байна гэсэн бидэн дээр судалгаа байгаа. 1300 гаруй хүүхэд асрамжид байна гэж байгаа. Ингэхээр чинь энэ юу болж байгаа юм бэ? Нэг гурав арваны дөрөвхөн сая хүнтэй юунд энэ тоо бол үнэхээр аймшигтай тоо шүү дээ. Эрсдэлтэй нөхцөлд 20 гаруй мянган хүүхэд амьдарч байгаа гэсэн судалгаа бас бидэнд ирсэн байгаа.

Тийм учраас эндээс дүгнэлт хийгээд бид юу вэ гэхээр ерөөсөө энэ Монгол улсын хэмжээнд энэ үндэсний соён гэгээрүүлэх хөтөлбөрийг баталж хийх зайлшгүй нийгмийн шаардлага бий болчихжээ гэсэн ийм дүгнэлтэд хүрч байгаа юм аа.

Тэгээд 2 асуулт байна.

Нэгдүгээрт нь энэ цус ойртолтын асуудал байгаа юм. Энэ дээр эрдэмтэд хэд хэдэн эрдэмтэд 6.1 хувь байна, 7.3 хувь байна. Монголын хүн амын гэж. Энэ бол үнэхээр үндэсний аюулгүй байдлын аймаар том сэдэв шүү. Тэгэхээр энэ дээр үед чинь би чинь ургийн бичгээ хөтөлдөг байсан. Одоо шинжлэх ухаан хөгжжөөд энэ хиймэл оюун ухаан гээд хүн өөрийнхөө 3, 4 дэх үеэ ингээд биччихэд бол тэр хиймэл оюун ухаан мэдээллийн технологийн ололт амжилтыг ашиглаад энийг тэр ургийн бичгийг өөрөөр хэлбэл тэр нэг генетик генологи гэж хэлж байгаа шүү дээ. Тийм тэрийг бий болгочих ийм боломж байна энэ учир.

**Л.Мөнхбаатар:** Асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Солонгоо сайд хэд билээ? Наадах чинь 81 үү? Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье. Албан тушаал нэрээ хэлээд асуултад хариулаарай.

**Б.Солонгоо:** Баярлалаа. Баттөмөр гишүүний асуултад хариулъя, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Солонгоо.

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга бас нэлээн хүлээлт үүсгэсэн бас 1999 оноос хойш томоохон нэмэлт, өөрчлөлт ороогүй. Гэр бүлийн тухай хууль өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Тэгээд Гэр бүлийн тухай хуульд бас гэр бүл болоход гэрлэлт бүртгүүлэхэд харшлах шалтгааны нэг нь бол төрөл садангийн холбоотой бол бас гэр гэрлэлт бүртгүүлэх боломжгүй. Энэ



нь бас гэрлэлт хүчингүй байх шалтгаануудын нэг байдаг.

Тэгээд Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд бас энэ цус ойртолтоос урьдчилан сэргийлэх хүн амын удмын санг бас хамгаалах зорилгоор гэрлэгчид гэрлэлтээ бүртгүүлэхээс өмнө ДНК-ийн шинжилгээнд хамрагдаж болох боломжийг нээж байгаа. Гэхдээ нөгөө талаасаа бид нар бас энэ ДНК-ийн шинжилгээ бодитой байхын тулд бас тодорхой судалгаануудыг сайн хийх хэрэгтэй. Тэгээд манай бас Шүүх шинжилгээний ерөнхий газар дээр ДНК-ийн шинжилгээг авч эцэг эхийг тогтоох одоо шүүхийн практик хэрэгжээд багагүй хугацаа өнгөрсөн. Гэхдээ хамгийн гол нь бас төрөл садныг тогтооход ДНК-ийн шинжилгээнээс гадна бас мэдээллийн сангийн суурь судалгаа зайлиггүй хэрэгтэй байна гэдэг асуудлыг бас манай Шүүх шинжилгээний ерөнхий газраас өгч байгаа. Тэгээд энэ гол асуудал нь юу байна гэхлээрээ бас гэрлэгч хосуудад удам зүйн шинжилгээ хийхэд ураг төрлийн өвөг удмын 3 болон түүнээс дээш үеийн үеэл, хаяал, бүл, өвөг удмуудыг тодорхойлох шаардлагатай.

Тэгээд генетик генологийн харьцуулах өгөгдөл мэдээллийн сан зайлиггүй шаардлагатай байдаг гэсэн байна. Тэгэхлээр цаашидаа бид нар бас энэ генетик өгөгдлийн санг бүрдүүлэхэд хугацаа хэрэгтэй байгаа учраас бас энэ ДНК-ийн шинжилгээ бас авсны үндсэн дээр гэрлэгч хосууд гэрлэлтээ бүртгүүлдэг болох энэ хуулийн заалтыг 2028 оны 1 сарын 1-нээс хэрэгжүүлэхээр бас тусгасан.

Тэгээд Шүүх шинжилгээний ерөнхий газраас бас энэ суурь судалгааг доор хаяж хамгийн багадаа хүн амын нэгээс дээш хувьд хийх шаардлагатай гэсэн бас мэдээллийг өгсөн. Тэгээд дор хаяж суурь судалгаанд 30-аас 32 мянга орчим иргэдийг хамруулж удам зүйн мод буюу мод буюу харьцуулах өгөгдлийг бас

бий болгох шаардлага байна аа. Тэгээд үүн дээр бас бидний хувьд бас бэлтгэл шаардлагатай. Тэгээд Шүүх шинжилгээний ерөнхий газар дээр цаашидаа энэ төрлийн судалгаа шинжилгээг авахад Засгийн газрын зүгээс бас анхаарч ажиллахад Улсын Их Хурлын бас тогтоол гарсан байгаа.

Тэгэхлээр энэ Улсын Их Хурлын 2022 оны тогтоолын хэрэгжилт энэ асуудалтай үлдэж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Асуултад нэмж хариулъя.

Учрал сайд хариулъя.

**Н.Учрал:** Өнгөрсөн онд яг Их Хурлын тогтоол гарсан байгаа юм, Засгийн газарт өгсөн үүрэгт энэ хүн амын удмын сангийн аюулгүй байдалд анхаарч энэ угийн бичиг хөтлөх ийм нэгдсэн систем хийх гээд. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх гээд бас бид өнгөрсөн хугацаанд ажилласан. Энэ Архивын ерөнхий газартай бас хамтраад гэрээ байгуулаад ажиллаж байгаа юм. Архивын ерөнхий газарт байгаа нөгөө цаасан материалыг нөгөө цахимжуулах нэг ийм ажил үргэлжилсээр байна.

Ингээд энэ материалыг нэгтгээд тухайн хүний буюу хувь хүний мэдээлэл хамгаалах хуульд зааснаар тэр мэдээллийн эзний зөвшөөрлөөр мэдээллийг цуглуулаад түүнийг нь тэр архивын материалтай холбоод тэгээд нөгөө 2 хүн гэрлэх гээд ирэхэд нь тэр ДНК-ийн шинжилгээтэй нь харьцуулж түүн дээр нь нэг ийм үнэлэлт дүгнэлт гаргадаг болгохгүй л бол цаашидаа бид яг энэ хуульд заасан энэ заалтыг хэрэгжүүлэхэд маш их бэрхшээлтэй учраас л энэ 2028 он гэж тавиад байгаа юм л даа.

Тэгээд бид бол цаашидаа орчин үед бол нэг нэг хэритэйж гээд бүүр ийм дэлхийн хэмжээний бараг фэйсбүүк, твиттер энэ тэр шиг тийм бие даасан

платформ энэ тэр гарчихсан. Манай иргэд ч гэсэн өөрсдөө түүнд бүртгүүлээд ингээд угийн бичгээ өөрсдөө хөтлөөд тэгээд угийн бичгээрээ дамжуулаад тэр нөгөө хамаатан садан ах дүү нартайгаа холбогддог. Энэ ургийн баяр хийдэг ч гэсэн маш их учир шалтгаантай л байсан байна шүү дээ. Манай энэ өвөг дээдэс маань олон жил энэ ургийн баяр хийх ёстой гээд байгаа ч асар чухал байсан.

Тийм учраас үүнийг бол онлайн орчин цахим орчинд л ийм угийн бичиг хөтлөх үндэсний хэмжээний ийм аяныг санаачлах хэрэгтэй л гэж бид нар үзэж байгаа. Тэгээд ирэх жил бол энэ *idam.mn* гээд энэ ажлыг бол олон жил хийсэн бас нэг байгууллагадаа бол бид өнгөрсөн хугацаанд ажиллаж байгаа. Үүний бол гол нь Архив, Бүртгэл, Хууль зүйн яамтай л хамтарч байж л энэ асуудлыг шийдвэрлэнэ. Тэгэхээр ямар ч байсан ирэх онд бол энэ угийн бичиг хөтлөх системийг ашиглалтад оруулна. Тэгээд үүнд иргэн болгон идэвх зүтгэл гаргаж бас оролцох шаардлагатай байгаа юм аа. Хүн болгон төдийлөн ач холбогдлыг нь ойлгодоггүй. Гэхдээ яг энэ угийн бичиг хөтлөөд явж байгаа зарим би бас нэг гэр бүлүүдийг мэдэж байна. Тэгэхэд тэд нар бол ах дүү нараа мэддэг, зураг хөргөө тавьдаг, хоорондоо мэдээллээс солилцдог. Тэгээд ингээд маш тийм идэвхтэй группүүд байна.

Тийм учраас бүгдээрээ ямар ч байсан үндэсний хэмжээнд энэ аянаа өрнүүлбэ. Зүгээр Засгийн газрын зүгээс энэ системийг нь хувийн хэвшилтэйгээ хамтарч хөгжүүлээд хэрэгжүүлэх бүх механизмыг бол бүрдүүлэхэд анхааръя. Тэгээд Энхбаяр сайдтай энэ ажил дээр бас хамтарч ажиллана аа.

**Л.Мөнхбаатар:** Баттөмөр дарга тодруулж асууя.

**Б.Баттөмөр:** Цахим ургийн бичиг хөтлөх бий болгох бол тийм хүнд асуудал биш. Та нар бол программынхаа

даалгаврыг энэ яаманд гаргаад өгчих хэрэгтэй. Маш амархан энэ бол дор нь хийнэ. Энэ мэдээллийн технологийн энэ эрин зуунд амьдарч байгаа энэ үед бол нэг цахим ургийн бичиг байтугай нас барсан хүнийг гэртэй нь ар гэрийнхэнтэй нь уулзуулчихаж байна шүү дээ. Шинжлэх ухаан технологийн ололт. Тийм учраас энийг хийх ёстой энд сая цаг болоод нэг зүйл асууж чадсангүй. Энэ гэр бүлийн ёс зүй, эцэг эхийн ёс суртахуунтай холбоотой энэ асуудал энэ хуульд ямар заалтууд орж ирж байна аа? Энийг хариулж өгөөч. Хамгийн гол асуудал бол энэ ёс суртахууны ёс зүйн уналт доройтлын чинь гол эх үүсвэр хаана байгаа гэхээр гэр бүл дотор бас байна гэсэн ийм судалгааны дүн гарч ирж байгаа юм.

Тийм учраас Гэр бүлийн тухай хуульд энэ асуудлыг яаж оруулж ирж байна, түвшин ямар байна, яаж оруулж ирж байна.

**Л.Мөнхбаатар:** Баттөмөр гишүүний тодруулгад хариулъя ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье.

**Б.Солонгоо:** Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Тэгээд ер нь Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн маань бас гол үзэл баримтлал зарчим бол аль болох хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд хамгаалах гэр бүлийн гишүүд бас хүүхдийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа бас адил тэгш хүлээдэг болох дээр чиглэж байгаа. Тэгээд хамгийн гол нь бас хүүхдийг аль болох гэр бүлийн орчинд өсгөж хүмүүжүүлэх үүргийг эцэг эхэд ноогдуулах. Нөгөө талаасаа бас хүүхэд гэр бүлийн орчинд өсөж хүмүүжих бас эрхийг баталгаажуулах, хамгаалах дээр бас чиглэж байгаа.

Нөгөө талаасаа бас гэрлэгчдийн үүрэг хариуцлага эрхийг тодорхой тусгасан. Гэрлэгчид бие биеийнхээ өмнө

хүлээх үүрэг болон гэрлэгчид гэр бүлийн гишүүний өмнө ялангуяа хүүхдийн өмнө хүлээх үүрэг хариуцлагыг маш тодорхой тусгасан.

Нөгөө талаасаа Гэр бүлийн тухай хууль өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль дээр гэр бүлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй төрийн байгууллагуудын бас асуудлыг бас тусгаагүй байдаг. Тэгэхээр Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Гэр бүлийн хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй төрийн байгууллагуудтай ийм чиг үүрэгтэй холбоотой бас тусгайлсан бүлгийг нэмсэн. Тэгээд энэ бүлэгт гэр бүлийн ялангуяа залуу гэр бүлүүдэд сургалт зөвлөгөө өгөх бас тодорхой асуудлуудыг тусгасан байгаа.

Тэгэхлээр гэр бүл хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрийн захиргааны байгууллагууд Гэр бүлийн тухай хуулийг бас хэрэгжүүлэхэд сурталчилгаа хийх, иргэдэд бас зөвлөгөө зөвлөмж өгөх сургалтад хамруулах гээд бас цогц арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан.

Бидний хувьд хуулийн төслийг боловсруулах шатанд нийгмийн оролцогч талуудтай үе шаттайгаар хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан. Тэгээд залуу гэр бүлүүдэд тулгамдаж байгаа асуудал маань бас гэр бүлийн одоо сургалтад хамрагдах, гэр бүлийн маргаан шүүхийн шатад очлоо гэхэд бас эвлэрүүлэн зуучлалын үйлдэл үйлчилгээг мэргэжлийн түвшинд.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа асуултаа асууя.

**С.Одонтуяа:** Тэгэхээр энэ Гэр бүлийн тухай хууль ер нь их оройтож орж ирж байна л даа. Энэ чинь байгаа нь бараг мөрдөж байгаа нь 1999 оны ч хууль байна уу хэдэн оных байна? Тэгэхээр одоо

хэддүгээр зуун билээ? Энэ Гэр бүлийн хууль их олон парламент дамжсан, олон ч удаа буцсан байгаа. Тэгэхээр 2022 оны 3 дугаар сарын 8-нд манай Улсын Их Хурлын эмэгтэй гишүүд Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг өргөн барьсан.

Ингээд Засгийн газраас орж ирэх гэж байгаатай уялдуулаад бид бас энэ хуулиа хамтарч хэлэлцэхээр ингээд зөвшөөрсөн байгаа. Тэгэхээр энэ эмэгтэй гишүүдийн саналыг энэ ажлын хэсгийнхэн бас сайн оруулж өгөөрэй гэж хэлмээр байна. Миний хувьд бол би бас нэг зүйлийг хэлмээр байна аа.

Өнгөрсөн 3 жилд намайг бас энэ сошиалаар маш олон удаа гүтгэсэн. Юу гэж гүтгэсэн бэ гэхээр Одонтуяа 2 эхнэртэй хууль батлуулах гээд байна гэдэг ийм зүйлийг сошиалаар нэлээд гүтгэсэн. Тийм учраас иргэд маань бас очихоор асуудаг. Тэгэхээр миний хувьд ийм зүйл байхгүй шүү. Өнөөдөр бид бол Монгол Улс нэг эхнэртэй, нэг нөхөртэй байх энэ хуулийн үзэл баримтлал явж байгаа. Тэгээд яах вэ сошиалаар янз бүрийн ийм зүйл хэлээд байгаа нь ор үндэслэлгүй шүү гэдгийг би бас хэлчихмээр байна аа.

Хамгийн том тулгамдсан асуудал өнөөдөр Монголын гэр бүлд л байна өнөөдөр Монголын гэр бүлд гэр бүл болсноосоо эхлээд л маш олон төрлийн асуудлуудад тулгарч байгаа байхгүй юу. Тэгээд ийм цөөхөн хүн амтай газар гэхэд жилдээ 3-аас 4 мянган гэр бүл салж байна гэдэг маш өндөр үзүүлэлт.

Тийм учраас бид энэ Гэр бүлийн тухай хуулиараа яавал энэ гэр бүл салахгүй байх вэ гэдэг дээр урьдчилан сэргийлэх ийм дэмжсэн ийм заалтуудыг оруулж өгөх ёстой. Тэгээд өмнө нь нэг орж ирэхэд нь би ямар шалтгаанаар бас энэ буцах ёстой гэсэн бэ гэхээр төрөөс дэмжлэг үзүүлнэ л гэхчхэн байгаа. Монголын гэр бүлд. Тэгээд яг яаж дэмжих



юм гэдэг нь байхгүй. Тэгэхээр энэ удаа яг орж ирсэн үү ямар зүйл заалт орж ирсэн бэ? Бусад орны хуулийг судалж байхад тэдэн хүүхэдтэй бол ийм дэмжлэг үзүүлнэ. Орон сууцын нөхцөл сайжруулахад нь ингэж дэмжинэ гээд ингээд заачихсан. Тэгэхээр энэ Гэр бүлийн хуульд яг ямар дэмжлэг үзүүлнэ гэж бол орж ирсэн бэ гэдгийг 1 дүгээрт асуумаар байна аа.

Нөгөөтээгүүр энэ 2017 онд манай Ардчилсан эмэгтэйчүүдийн холбоо улс орон даяар энэ Гэр бүлийн тухай хуулиар нэг хэлэлцүүлэг хийсэн юм.

Тэгээд энэ саналаа манай эмэгтэй гишүүдэд бас хүлээлгэж өгсөн байгаа. Энэ дээр бол хамгийн том асуудал юу гэж яригдсан бэ гэхээр тэтгэмжийн асуудал байсан. Одоо сая Энхбаяр сайд уншиж байна л даа. 50 хувь л олгогдож байна гэж.

Тэгэхээр үлдсэн 50 хувь нь ер нь яаж амьдар гээд байгаа юм бол оо? Би энийг бас зүгээр Энхбаяр сайдыг эцэг хүнийх нь хувьд асуумаар байна. Энэ 50 хувиа авч чадахгүй гэр бүлүүд ер нь яаж аж амьдралаа залгуулдаг юм бол оо? Нөгөөтээгүүр эцэг нь ямар ч төлбөрийн чадваргүй архи дарс уугаад явчихсан тэр гэр бүлийг яах юм бэ? Тэр гэр бүл чинь хүүхдүүд нь хоол идэх ёстой, хувцас өмсөх ёстой. Энэ гэр бүлд тусгайлсан асуудлууд дэмжих зүйлүүд байна уу? Тэр иргэдтэй уулзаж байхад эрсдэлийн сан гэж юм байгуулаач. Тэр эрсдэлийн сангаасаа хамаагүй бага 1, 2 тэрбум төгрөг төсөвлөхөөд тэндээсээ үнэхээр хэцүү байгаа энэ гэр бүлүүдэд дэмжлэг үзүүлэх ёстой.

Дараа нь эргэн төлөгддөг гээд энэ зүйлийг бол ярьж байсан. Нөгөөтээгүүр энэ гэр бүлийн сэтгэл зүйчид маш их хэрэгтэй байна аа. Тэгэхээр Монголд Монгол хүмүүс ингээд өөрсдөө төлбөр төлөөд гэр бүлийн сэтгэл зүйчид хандах ийм хандлага бол бас их байхгүй байна.

Тэгэхээр энэ гэр бүлийн асуудлаар дагнасан сэтгэл зүйчдийг төрөөс ер нь яаж?

**Л.Мөнхбаатар:** Одонтуяа дарга нэг мэдэгдэл хийлээ. Нэлээн хэдэн асуултууд асуусан. Эхлээд Ажлын хэсэг хариулах юм уу? Энхбаяр сайд дараа нь хариулах юм уу? Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье. Солонгоо дэд сайд хариулъя.

**Б.Солонгоо:** Одонтуяа гишүүний асуултад хариулъя.

Тэгээд жил болгон шүүхэд гэр бүл цуцлуулах нэхэмжлэхийг 2700-аас 2800 гаруй нэхэмжлэл ирж байна. Тэгэхлээр гэр бүл салалтын яг шүүхэд бүртгэлтэй мэдээллээс харахад 10 жилийн өмнөхтэй харьцуулахад 10 хувиар нэмэгдсэн байдаг. Тэгээд гэр бүл цуцлахад бас яалт ч үг хүүхдийн эрх хамгийн ихээр зөрчигдөх бас эрсдэл үүсдэг. Тэгээд үүнтэй холбогдуулаад хүүхдийн тэтгэлгийн асуудал иргэдийн зүгээс их хүлээлт үүсгэсэн асуудал байгаа. Тэгээд яг хүүхдийн тэтгэлэгтэй холбогдуулаад 50 хувь төлөгдөхгүй байгаагийн цаана мэдээж төлбөрийн чадваргүй байх, бүртгэлтэй хаяг дээрээ төлбөр төлөгч байхгүй байх, эрэн сурвалжлагдаж байгаа, хорих ял эдэлж байгаа гээд бас олон шалтгаан байдаг.

Тэгэхээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд бас нэмэлт, өөрчлөлт оруулах саналын төсөл бас Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй дагаж өргөн мэдүүлсэн. Энэ төсөлд бас хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбогдуулаад тодорхой заалт тусгасан. Мөн бас Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл оруулсан. Гол асуудал нь бол эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг илүү мэргэшүүлэх сэтгэл зүйч болон нийгмийн ажилтны оролцоог хангах. Ингэснээрээ бас гэр бүлд үүсээд байгаа

маргаан зөрчлийг мэргэжлийн байгууллагыг оролцуулж бас шийдвэрлэхэд гэрлэгчдэд бас дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан байгаа. Тэгээд Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл бас гэр бүлийг ялангуяа гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих чиглэлээр яг суурь харил зарчимдаа тусгасан.

Тухайлбал гэр бүл нь нийгмийн үндсэн нэгж бөгөөд төрөөс гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжсэн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ гээд манай хуулийн маань үнэт үндсэн зарчим байна. Мөн төрөөс гэр бүлийг дэмжих хамгаалах төрийн байгууллагын чиг үүрэг тогтолцоо гэсэн 10 дугаар бүлэг дээр гэр бүлийг дэмжих талаар төрийн байгууллагуудын чиг үүргийг бүрэн эрхийг тусгасан.

Үүнд нэн ялангуяа бас Засгийн газар гэр бүлийг дэмжих талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн талаар тодорхой тусгасан. Гэр бүл цуцлах бас асуудал яагаад байна гээд бас судалгаа хийгээд судалгааны дүнг харахаар мэдээж тодорхой асуудлууд яалт ч үгүй санхүүгийн нөхцөл байдал орон сууц бас таарамжгүй байдал согтууруулах ундааны хэрэглээ гээд бас хэд хэдэн хүчин зүйлд хуваагдаж байгаа.

Тэгэхлээр бид нар цаашид бас гэр бүлийг дэмжих бодлогыг бас Засгийн газраас цогц байдлаар хэрэгжүүлэх нь бас гэр бүл тогтвортой байхад томоохон хүчин зүйл болно. Нөгөө талаасаа гэрлэгчид маань гэрлэх гэрлэлтээ бат бүртгүүлэхийн өмнө сургалтад хамрагддаг байх. Залуу гэр бүлүүд д бас зориулсан сургалт дэмжлэгийн үйл ажиллагааг хийх нь их цаг үеэ олсон нийгэмд хүлээлт үл үүсгэсэн асуудал байгааг оролцогч талууд хэлэлцүүлгийн явцад дурдаж байсан.

Хүүхдийн тэтгэлэгтэй холбогдуулаад тэтгэлэг төлж чадахгүй байгаа.

**Л.Мөнхбаатар:** Гэр бүлийн нөгөө сэтгэл зүйчтэй холбоотой асуулт асуусан тэ. Гүйцээгээд хариулчих уу? 81 дүгээр микрофон өгье.

Солонгоо дэд сайд гүйцээгээд хариулчихъя.

**Б.Солонгоо:** Шүүхийн шийдвэрээр жил болгон 14 мянга гаруй тэтгэлэг төлөгч бол хүүхдийн тэтгэлэг төлөх үүрэгтэй. Үүний 50-аас 60 хувь нь жил болгон хэрэгждэг. Харамсалтай нь бас 40 гаруй хувь хэрэгжихгүй байна. Тэгээд үүнтэй холбогдуулаад бас бид нарыг хуулийн төслийн хэлэлцүүлэг хийх явцад тэтгэлгийн сан бүрдүүлэх, эрсдэлийн сан бүрдүүлэх саналыг бол оролцогч талуудаас гаргаж байсан. Бидний хувьд бас энэ асуудлыг одоо судлаад цаашидаа бас энэ нийгмийн халамжийн бодлого нийгмийн бодлогын хүрээнд шийдэгдэж болох асуудал учраас тусдаа сан байгуулах нь сөрөг талууд үүсэх бас боломжтой гээд үүн дээр яг тэтгэлгийн сан байгуулах асуудал одоогийн хуулийн төсөлд тусгаагүй.

Гэхдээ шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг илүү сайн хэрэгжүүлэхэд дэмжлэг болгох зорилгоор шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах мөн энэ шүүхийн шийдвэр хэрэгждэг байх асуудал дээр анхаарч ажиллаж байгаа. Тухайлбал ШШГЕГ дээр бол хүүхдийн тэтгэлэг төлөхгүй байгаа тэтгэлэг төлөгч, хариуцагчид бас зорчих, эрх хязгаарлах бас албадлагын арга хэмжээг авч эхэлснээр хүүхдийн тэтгэлэг төлөх. Бас статистик хэмжээ маань бас 10 хувиар нэмэгдсэн. Тэгэхээр цаашидаа бас бид нар энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дээр сайн анхаарах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлдэг болох шаардлагатай. Зөрчлийн тухай

хууль дээр хүүхдийн тэтгэлэг төлөхгүй байгаа байгаа тохиолдолд зөрчлийн хариуцлага ноогдуулах жишиг хуулийн заалт бол байгаа. Энэ хуулийн заалтыг цаашид бас хэрэгжүүлэх боломжтой. Үүн дээр харин нэмэлт, өөрчлөлт бол оруулаагүй. Мэргэжлийн сэтгэл зүйч зайлиггүй шаардлагатай байна гэдэг асуудал бас оролцогч талуудын зүгээс өгч байгаа.

Нэн ялангуяа гэр бүл цуцлах маргаан шүүхэд очлоо гэхэд эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаатай хамтад нь сэтгэл зүйн зөвлөгөө дэмжлэг өгөх нь хэрэгцээтэй байна гэдэг асуудлыг бас манай шүүгчдийн зүгээс их гаргасан. Тэгэхлээр цаашидаа бас хүүхдийн эрхийг хамгаалах гэр бүлийн тогтвортой байдлыг хамгаалах мөн хүүхэд хамгааллын үйлчилгээнд ч гэсэн сэтгэл зүйн мэргэжлийн сэтгэл зүйчдийг оролцуулах нь бас бид нар хуулийг бодитойгоор хэрэгжүүлэхэд томоохон хувь нэмэр оруулна. Гэхдээ сэтгэл зүйчдийг бэлдэх шаардлага байна. Тэгэхлээр бас энэ төрлийн үйлчилгээний хүртээмжийг бол зайлиггүй шаардлагатай сайжруулах шаардлага бол үүсэж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Одонтуяа дарга тодруулах уу? Салдангийн Одонтуяа дарга тодруулж асууя. Одонтуяа даргын микрофоныг өгөөрэй.

**С.Одонтуяа:** Тэгэхээр хариултаас би ингэж ойлголоо. Ер нь гэр бүлийг төрөөс цогц бодлогоор дэмжинэ гэсэн үг л орсон юм байна. Яг тодорхой заалт ороогүй юм байна гэж ойлголоо. Яг гэр бүлийг жишээлэхэд 2 хүүхэдтэй бол, 3 хүүхэдтэй бол, 4 хүүхэдтэй бол гээд ингээд бусад орнуудад дэмждэг нь яг хуульдаа заачихсан байдаг гээд би тэгсэн. Тэгэхээр ингэж ороогүй зүгээр дахиад л нөгөө лоозонгоороо л орчихсон юм байна. Тэгэхээр энэ хуулийн яг гол шигтгээ гарч ирж чадах уу үгүй юу? Тодорхой хуульд л зааж өгөхгүй бол энэ хэрэгждэггүй юм.

Зүгээр төрөөс бодлогоор дэмжинэ гээд бид нар 30 жил ярилаа шүү дээ. Тэгээд бодлогоор харин яаж огт дэмжээгүй л байхгүй юу. Энэ дээр бол сэтгэл хангалуун биш байна аа. Тэгэхээр энэ хэлэлцүүлгийн явцад энэ дээрээ бодитой саналуудаа оруулах ёстой.

Хоёрдугаарт Энхбаяр сайдаа нэг ийм санал байна Байнгын хорооны дарга нь алга. Хүүхэд хамгаалал ерөөсөө гэр бүлийн асуудал гэдэг.

**Л.Мөнхбаатар:** Тодруулгад хариулах уу? Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр хариулъя.

**Б.Энхбаяр:** Энэ гэр бүлийн хуулийг Хууль зүй, дотоод хэргийн яам толгойлж санаачилж оруулж ирж байгаа. Хүүхэд хамгааллын хуулийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам оруулж ирж байгаа. Энэ гэр бүлийн хууль бол халамжийн хууль биш байгаа. Энэ гэр бүлийг төрөөс яаж хайрлах вэ тийм юм ерөөсөө байхгүй. Ер нь тийм төрөөр хайрлуулаад байдаг бас асуудал биш. Энэ байна шүү дээ анх гэр бүл яаж болохоос эхлээд цуцлах, тэр хүүхдийн өмнө хүлээх хариуцлага, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, үрчлэлт гэсэн цэвэр хууль зүйн асуудлуудыг зохицуулж байгаа хууль байгаад байгаа.

Тэрнээс биш гэр бүл хэдэн хүүхэдтэй бол яах вэ ийх вэ гэдэг бол энэ хүүхэд хамгааллын гэдэг юм уу энэ нөгөө бусад нийгмийн хамгааллын тэтгэвэр, тэтгэмжийн хуулиудаар зохицуулагддаг ийм харилцаа байгаа. Мөн энэ гэрлэлттэй холбоотой үүсэж байгаа энэ хууль зүйн үр дагаврууд дээр аль улсын хууль тогтоомжийг ямар тохиолдолд хэрэглэх вэ гэдэг зөрчилдөөний хэм хэмжээг нарийвчилж зохицуулж оруулж ирж байгаа юм. Яагаад гэхээр энэ 1999 онд батлагдсанаас хойш одоо манай улсын иргэд их олон 100 мянгаараа гадаадад амьдарч байна. Гадаадын иргэдтэй гэр бүл болж байна. Тэндээс хүүхдүүд гарч

байна гадаад улсад гэр бүлээ зохиож байна. Хүүхэд нь гадаад улсад төрж байна. Энэнтэй холбоотой аль улсын хуулиудыг ер нь энэ ялангуяа хөрөнгийн асуудал, халамжийн асуудал, тэтгэмжийн асуудлууд дээр хэрэглэж авах вэ гэдэг цэвэр ийм хууль зүйн үр дагавар, хэм хэмжээтэй холбоотой харилцаа зохицуулсан хууль байгаа юм шүү гэдгийг би бас гишүүдийн анхааралд хүргэж байна аа.

**Л.Мөнхбаатар:** Цахим хөгжил харилцаа холбооны сайд Ням-Осорын Учрал асуултаа асууя.

**Н.Учрал:** Энхбаяр сайд сая бас хуулийнхаа концепцыг хэллээ. Тэгээд Энхбаяр сайдаас бас нэг хүсэлт байна. Тэгээд би 2019 оны 4 дүгээр сард Гэр бүлийн тухай хуулийн төслийг санаачилж Их Хуралд өргөн мэдүүлж байсан. Тэрнээс хойш хаа ч юм нэг газар энэ хууль дарагдсан. Дараа нь харин Одонтуяа гишүүн энэ эмэгтэй гишүүд нийлээд бас энэ хуулийн концепцыг яриад оруулж ирж байсан. Энэ бол нөгөө Гэр бүлийн хуульд хүүхдийн тэтгэмжийн асуудлыг хуульчилъя гэдэг санаачилга л даа.

Өнөөдөр яг энэ судалгаанаас чинь харахад бараг 72 мянган өрх толгойлсон эхчүүд 19 мянган эцэг байна гэж. Тэгээд эмэгтэйчүүд л байна л даа, хэдэн өрх толгойлсон. Тэгээд нөгөө айл гэр болж тоглоно тэгээд дараа нь сална, сарнина, тэгчхээд хүүхэддээ тэгээд тэр нэг хэдэн төгрөгийн тэтгэмжээ нэг авгайдаа өгч байна л гэж бодоод байдаг юм шиг байгаа юм энэ эрчүүд. Тэр чинь хүүхдэдээ өгч байгаа гэдгийг нь уг нь ойлгуулмаар байгаа юм. Тэгээд өнөөдрийн хуулиар чинь энэ ерөөсөө гэр бүлийн хуулиар өнөөдөр гэр бүл цуцлуулсан тохиолдолд амьжиргааны доод түвшний 50 хувиар буюу 100 орчим мянган төгрөгийн л тэтгэмж тогтоож байна шүү дээ тухайн бүс нутгийнхаа. Тэгэхээр энэ юу юм бэ гэхээр тэрбум төгрөгийг төгрөгийн орлоготой хүн ч бай сая

төгрөгийн орлоготой хүн ч бай хүүхдэдээ яг л тэр мөнгийг өгдөг байхгүй юу.

Амьдрал нь боломжийн 10 жил, 20 жил ингээд амьдраад ирчихсэн. Тэгээд гэр бүл сална. Түүнийхээ дараа амьжиргааны доод түвшний 50 хувь гээд 50 мянган төгрөг өгдөг. Тэгэхдээ 50 хувь нь бас төлдөггүй. Тэгээд түүнийгээ тэр нэг салчихсан эхнэртээ өгч байна гэж л ингээд бодоод байдаг нэг ийм арчаагүй л эрчүүдийн байдлаас болоод л энэ олон мянган эхчүүд, эмэгтэйчүүд ингээд өрх толгойлоод ар нуруун дээрээ Монголын амьдралыг авч явж байгаа шүү дээ. Та нар ч гэсэн иргэдтэй уулзах уулзалтад хэн ирж байна. 2, 3 хүүхдээ дагуулчихсан эхчүүд, эмэгтэйчүүд л ирж байна шүү дээ.

Тэгэхээр би ямар Солонгоо сайд, энэ Булгантуяа сайд 2-оос ийм юм асуугаад байлтай биш. Энхбаяр сайд нэг хэлчих хэрэгтэй энэ тэтгэмжийг орлоготой нь дүйцүүлж нэмээд өгөөч. Ерөөсөө энэ бүс нутаг биш тэр хүн тэрбум төгрөгийн орлоготой 500 сая төгрөгийн орлоготой орлоготой нь дүйцүүлж хүүхдийн тэтгэмжийг хүүхдийн тооноос хамааруулна гэж олгомоор байна.

Хэрвээ тэр нутаг дэвсгэрт нь тэр нөгөө амьжиргааны одоогийн энэ амьжиргааны доод түвшний 50 хувиар тооцдог нь магадгүй байна гэвэл тэр чинь мэдээж тухайн бүс нутаг нь тэр амьжиргааны түвшин нь тэр зуугаасаа доош байх юм бол тэгээд л явдаг юм байгаа биз. Үнэхээр дээш байвал хүүхдийнх нь тооноос хамааруулаад л орлоготой нь дүйцүүлээд л энэ тэтгэмжийг өгчих л дөө. Тэгээд энэ айл гэр болж тогложоод дараа нь ингээд тэр хүүхдэдээ нэг хэдэн төгрөг өгч чадахгүй байгаа энэ эрчүүдээс энэ банк санхүүгийнх нь салбарынхантай ярьж байгаад тэр картаас нь мөнгийг нь татаж авах хэрэгтэй шүү дээ. Тэгэхгүй дандаа ингээд хүүхэд хохироодог. Одоо



ерөөсөө тэгээд л ерөөсөө л нэг хэдхэн эмэгтэйчүүдийн ар нуруун дээр л Монголын амьдрал яваад байгаа байхгүй юу. Яг бодит нөхцөл байдал энэ.

Тэгэхээр магадгүй энэ хуулийн хамгийн том зарчим тэгээд Энхбаяр сайд энэ дээр нэг тодорхой хэлчхээч. Энэ ажлын хэсэг дээр та бас хугацаа байгаагүй учраас энэ хууль дээр нэг их сайн ажиллаагүй байх. Та согтуу жолоочийг нөгөө эрүүгийн хариуцлага хүлээлгэх гээд байгаа хууль оруулж ирээд зоригтой золбоотой байгаа шигээ энэ нэг авгай хүүхдээ хаяхчаад тэтгэмжийг нь өгч чаддаггүй нэг эрчүүдэд орлоготой нь дүйцүүлж тэтгэмжийг нь нэмээд өгөөч ээ. Та бүүр энийг ингээд нэг зоригтой хэлээч.

Би Булгаа сайд, Солонгоо сайд 2-оос ингэж асуухгүйгээр Энхбаяр сайдаас л асууж байна.

**Л.Мөнхбаатар:** Учрал сайд Энхбаяр сайдад хаяглаж асуусан учраас Энхбаяр сайд хариулна аа.

**Б.Энхбаяр:** Учрал сайдтай бол санал нэг байна тийм. Би бол хууль санаачлагчийн хувьд бүүр чангалчихъя гэсэн бодол байсан. Тийм. Тэгэхдээ Хууль зүйн сайд хамгийн дээд талд нь бас нэг Үндсэн хууль гэж нэг юм байгаад байдаг. Үндсэн хуулийн суурь зарчимд бас хүрээнд яригдах ёстой бусад улс орны туршилагыг бас Солонгоо сайд хэлэх байх. Энэ чиглэлийн асуудлыг. Би бол Засгийн газрын хуралдаанаар Гэр бүлийн хуулийг хэлэлцүүлнэ гэдэг анх асуудлаа ярихдаа бол бас энэ зарчмаар оруулсан. Орлоготой нь уялдуулж тэтгэмжийг нь авъя гэдэг зарчмыг би олон нийтэд бас зарласан байгаа. Таны ярьж байсан асуудлыг. Одоо манай хууль зүйн яг энэ зөвшөөрөл олох дээр энэ бас Үндсэн хуулийн асуудал үүсэх нь ээ. Өөрөөр хэлбэл хүнийг хөрөнгө чинээ нэг ийм байдлаар нь хууль зүйн хувьд ялгавартай дэглэм үйлчлүүлж болохгүй

байна гэдэг ийм Үндсэн хуулийн зарчимтай тулсан юм.

Тийм учраас энэ хүрээндээ асуудал яригдаж байгаа. Улсын Их Хурал мэдээж хууль тогтоогч бас энэ асуудлыг дахиж ярих эрх нээлттэй байгаа. Миний хувьд бол Учрал сайдтай бол зүрх сэтгэл адилхан байгаа тийм.

**Л.Мөнхбаатар:** Учрал сайд тодруулах юм уу? Ням-Осорын Учрал сайд тодруулж асууя.

**Н.Учрал:** Тэгэхдээ энэ чинь 79 мянган өрх толгойлсон эхчүүд байна. Бас нэг 20 мянган эрчүүд бас байна шүү дээ. Тэгэхээр энэ чинь эрчүүд, эмэгтэйчүүд гэж ялгахгүй өрх толгойлсон тэр эхчүүд байна уу эрчүүд байна уу аль алинд нь одоогийн хуулийн эцэг эхийн амьдарч байгаа бүс нутаг дахь амьжиргааны доод түвшинээс бага орлоготой бол 50 хувиар тооцогдож болно, одоогийнхоор. Тэгэхээр, тэгэхдээ амьдарч байгаа бүс нутаг нь амьжиргааны түвшинээс 50 хувиас дээш орлоготой бол орлоготой нь дүйцүүлэх л ёстой байхгүй юу. Тэгэхгүй бол тэр 7 буудлын Дорж ч адилхан, Баянхошууны хэн ч адилхан, Зайсангийн хэн ч адилхан тэгээд л нэг зарим хүнд нь тэр амьжиргааны доод түвшинд 50 хувь нь их сүртэй мөнгө биш байгаад байдаг. Заримд нь ачаалал үүсгээд байдаг. Тэгээд орлого илүү олоход хүүхдэдээ нэг орлогоосоо нэг хэдэн төгрөг өгөхөд энэ чинь яачих вэ дээ салж сарнисан л юм байгаа биз.

**Л.Мөнхбаатар:** Яах юм нэмж хариулах юм уу? Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье. Тодруулгад нэмж хариулъя.

**Б.Солонгоо:** Учрал гишүүний асуултад хариулъя.

Тэгээд бид нар бас хүүхдийн тэтгэлгийн хэмжээтэй холбогдуулаад бас олон нийтийн зүгээс бас саналууд

хүлээж авсан. Тэгээд үүнтэй уялдуулаад бас хүүхдийн тэтгэлэг маань хүрэлцэхүйц байх зарчмыг баримталж байгаа. Тэгэхлээр бас тухайн тэтгэлэг төлөгчийн эд хөрөнгө орлогоос хамааруулж тэтгэлэг авагчийн бас хэрэгцээ шаардлага зэрэг нөхцөл байдлыг харгалзаад тусгай аргачлалын дагуу шүүхээс хүүхдийн гэр бүл цуцлахаас өмнөх амьдарч байсан нөхцөл байдал дордохгүй байх гэсэн үндсэн зарчмын дагуу бас шүүх тухай бүр шийдэхээр оруулсан. Тэгээд энэ аргачлалын дагуу бас орлогоос хамааруулж тэтгэлэг тогтоодог жишиг дэлхийн олон улс оронд байдаг. Тэгээд бид нар энэ бусад улсуудын асуудлуудыг судлаад хууль тогтоомж бас шүүхийн практик судалсан. Тэгээд мэдээж бас бид нар хамгийн бага хэмжээг хуульдаа тусгах шаардлагатай. Тэгээд тэтгэлэг авах хэмжээ маань орлоготой уялдах хэдий ч тэтгэлэг авагчийн оршин суугаа бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшний хэмжээнээс багагүй байна гэсэн баталгааг оруулсан. Тэгээд цаашидаа тэтгэлэг төлөлтийг бас сайжруулах нэг арга хэмжээ бол яалт ч үгүй гэр бүл цуцалсан ч гэсэн гэр хүүхэдтэйгээ хамт амьдрахгүй байгаа эцэг эх хүүхэдтэйгээ байнгын харилцаатай байх асуудлыг хуулийн төсөлд тусгасан байгаа. Тэгэхлээр байнгын харилцаатай байснаар тусдаа амьдарч байгаа ч гэсэн хүүхдэдээ тэтгэлэг өгөх бас хүсэл эрмэлзэл нэмэгдэнэ. Энэ дээр бас шүүхийн зүгээс ч гэсэн бас тодорхой саналуудыг өгсөн. Яг хүүхдийн тэтгэлэг төлөх төлүүлэхтэй холбоотой Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас бас авч хэрэгжүүлж байгаа албадлагын арга хэмжээний талаар бас мэдээллийг ШШГЕГ-аас бас өгөх боломжтой. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Тодруулах юм уу? Ням-Осорын Учрал гишүүн тодруулж асууя.

**Н.Учрал:** Тэгээд Солонгоо сайд өөрөө мэдэж байгаа байх аа. Энэ хуульд яг энэ тэтгэмжийн асуудлыг дэвшилтэт

зохицуулалт хийгдээгүй хууль шүү. Тэгэхээр ажлын хэсэг ажиллахдаа анхаараарай. Яг одоо бол тухайн эцэг эх хаана амьдарч байна түүний амьжиргааны доод түвшний 50 хувиар тооцож тэтгэмж өгдөг. Тэгэхээр өөр газар амьдарч байсан, аль газар амьдарч байх ёстойгоос үл хамаараад амьжиргааны түвшин нь бага газар юм байна аа.

Ингээд 50 хувиар тооцъё гээд. Миний яриад байгаа юм юу юм бэ гэхээр тухайн хүүхдийг амьдарч байсан нөхцөл байдлыг нь дордуулахгүй байх ёстой шүү дээ. Эцэг эх нь салж сарничихаар хүүхэд чинь амьдралын түвшин дордолгүй байх вэ дээ. Гэтэл тухайн тэр салж сарнисан эцэг эх нь илүү орлого олоод байдаг. Тэгээд л нэг хуучин бүртгэлтэй нэг гэрийнхээ хаягаар нэг орлогын дундаж түвшний 50 хувийг нь хэдэн төгрөг төлсөн болоод байгаад байдаг. Тэр шүүх шийднэ гэж нэг ийм үг бичээд наадах чинь явахгүй л дээ.

Орлоготой нь дүйцүүлж нэмнэ гээд л хийчих хэрэг.

**Л.Мөнхбаатар:** Санал хэллээ гэж ойлголоо. Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ асуултаа асууя.

**Б.Бат-Эрдэнэ:** Байна уу? Баярлалаа. Энэ их чухал хууль орж ирж байгаа юм аа. Тэгээд энэ хуулийг бол тал талаас нь нэлээн сайн хэлэлцэж байгаад ингээд батлах нь зүйтэй гэж. Өнөөдөр гэр бүл гэдэг бол энэ Монголын нийгмийн хамгийн хамгийн анхан шатын нэгж шүү дээ. Их засаг хуульд тодорхой заачихсан. Хэн гэрийнхээ аж байдлыг сайн зохион байгуулж чадна тэр харьяа ардыг захирна. Түүнд аравт, зуутыг захируулж болно гэсэн. Бид нар Чингисийгээ их ярих дуртай шүү дээ. Их эзэн Богд Чингис хааны зарлиг цааз Их засаг хуульд тодорхой заачихсан. Тэгэхээр өнөөдөр яригдаж байгаа асуудлын гол юм бол энэ

гэр бүлийн нэг багана. Энэ гэр бүлийн ачааг үүрч явах ёстой эр хүний тухай асуудал өнөөдөр яригдаж байна шүү дээ.

Ингээд Монголчуудыг энэ хүчирхэг үндэстнийг доройтуулах олон зууны бодлого сайхан бодит биеллээ олоод тэгээд биднийг хүүхэд байх энэ хуучин тогтолцооны үед ч тийм л байсан. Үгүй энэ эрэгтэй юм яах вэ зайлуул энэ тэгээд нэг гачгаар, ачигч хийгээд ч гэсэн тэгээд л амьдраад явна. Үгүй энэ муу охиныг л үгүй энийг л нэг боловсролтой, энийг л нэг юм үзүүлэх юм сан тэр хот гэдэг газар л бараадуулах юм сан л гээд ингэсээр байгаад тэгээд өнөөдрийн ийм нөхцөл байдал бий болсон. Тэгээд шинэ нийгмийн харилцаанд шилжсэн.

Энэ 30 жилийн хугацаанд бол өгөө Монголчуудын уламжлалт эмэгтэй хүн ээжийг эмэгтэй хүнийг өргөдөг ижил тэнцвэр хэмжээнд авч явдаг тэр үзэл сэтгэлгээнээс шал өөр. Эмэгтэй хүн байнгын доорд дарангуйлалд байдаг. Магадгүй тийм бусад улс орнуудын жишиг маягаар. Ингээд жендерийн асуудал ингээд яриад тэгээд улс төрийн эрх мэдэл нь жендерт эмэгтэйчүүдийн эрх мэдэл нэмэгдээд ирж болно л доо.

Гэтэл эрчүүд нь иймэрхүү өнөөгийн түвшинд байх юм бол энэ Монголын нийгэм үнэхээр улам л хүнд байдал руугаа л яваад байх ийм л нөхцөл байдалтай байгаа юм шүү дээ. Тэгээд энэ дээр ямар бодлого барьж байдаг юм бол? Энэ хүүхэд залуучууд гэр бүлийн асуудал хариуцсан нэлээн ажил үзсэн бололтой ийм нас тогтсон хүн байна. Энэ дээр ямар дүгнэлт байдаг юм. Та нарын судалгаа юм гаргасан юм байна уу? Үгүй яав ч энэ байдлаараа цаашаа явах ер нь тийм боломж байхгүй л байна л даа. Энэ чинь Монголчууд хэлээд байгаа биш энэ Олон улсын байгууллага, судалгааны байгууллага чинь эр хүн нь доройтсон төдийгүй эр хүйстэн доройтсон амьтны төрөл зүйл энэ орчны ертөнцөөс чинь алга болчихоод байна гээд ингээд судалгаа

гаргаад байна шүү дээ. Гэтэл Монгол эр хүн эрчүүд ийм өнөөдрийнх шиг эрүүл мэнд наслалтынх нь байдлыг та нар аваад үз.

Өнөөдөр энэ нийгэмд гүйцэтгэж байгаа үүрэг гэр бүлдээ гүйцэтгэж байгаа байдлыг нь аваад үз. Өнөөдрийн аймшигтай хүчирхийлэл аллага ёс бус бүх юмны чинь л түрүүнд л эрчүүд байна шүү дээ. Тэгээд ийм байдлаараа байж болохгүй. Би яагаад эр хүний тухай асуудал яриад байна вэ гэхээр зэрэг өрх гэр дотор аав үүргээ биелүүлдэг, аав нь нэр хүндтэй байх юм бол тэрийг үнэлбэл гэр бүл ямар байх билээ дээ. Эх эцэг 2-оос л шалтгаална шүү дээ тэр айл.

Гэтэл энэ улс гэр чинь бас ялгаа байхгүй. Энэ улс гэрийн нөгөө эцэг болсон төрийг бүрдүүлж байгаа энэ өндөр албан тушаал хашиж байгаа манай Их Хурал парламентаас л энэ асуудал ярьж байна. Би олон удаа ярьсан учраас энэ хүмүүс сүүлийн 30 жилд энд ёс зүй муутай, ёс суртахуунгүй ийм нэг цөөхөн хэдэн хүмүүсийн энэ авлигал ашиг сонирхлын үйл ажиллагаанаас болоод Монголын төрийн буюу монголын ард түмний эцэг энэ төрийн чинь нэр хүнд ингээж шалдаа буучхаад байна.

**Л.Мөнхбаатар:** Асуултад хариулъя. Хэн хариулах вэ? 80 ажлын хэсгийн 89 дүгээр микрофоныг өгье. Албан тушаал нэрээ хэлээд асуултад хариулаарай.

Битгий дараарай цаанаасаа өгнө, ажлын хэсгийн 89 дүгээр микрофоныг өгье.

**Н.Баярмаа:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Эрэгтэйчүүдийн асуудалд бол бас төрийн зүгээс тодорхой анхаарал хандуулж ажиллаж байгаа. Судалгаагаар үзэхэд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрөө бол маш өндөр гарсан. Өөрөөр хэлэх юм бол 9 орчим насны дундаж наслалтын



зөрөө бол гарсан байгаа. Бид нар бас эрэгтэйчүүдийг дэмжих мөн эрэгтэйчүүдийн энэ аж байдлыг дээшлүүлэх мөн хүмүүсийн эрүүл одоо амьдрах ухаанд эрчүүдийг бас сургах чиглэлээр олон сургалтууд явж байгаа. Ер нь судалгаанаас харахад эрэгтэйчүүд маань өөрсдөө бас нэлээн эрүүл мэндийн хувьд бас асуудал олон байгаа. Тэгэхээр энэ бүхэнд чиглэсэн ажлуудыг хийж байна. Эрэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төвүүд бол байгуулагдсан эхний төвийг бид нар Чингэлтэй дүүрэг дээр бол эрэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төв байгуулаад сэтгэл зүйн болон бусад зөвлөгөөнүүдийг өгч байна. Орон нутгийн гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдээр эрэгтэйчүүдэд хандсан зөвлөгөөнүүд бол явагдаж байгаа. Мөн албан болон албан бус хэлбэрээр сургалтууд бол хийгдэж байгаа.

Ер нь цаашидаа бол бас эрэгтэйчүүдэд анхаарах чиглэлээр олон ажлуудыг хийхээр төлөвлөөд ингээд ажиллаж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Сая хэн гэж хүн хариулчав аа? Албан тушаал нэрээ хэлээрэй гэдэг нь Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан бүрэн протоколтой явдаг. Тийм учраас хэний асуултад хэн хариулж байгаа нь их тодорхой байх ёстой шүү гэдгийг ажлын хэсгийнхэнд сануулан хэлье. Бат-Эрдэнэ гишүүн яах юм тодруулж асуух уу? Тодруулж асууя.

**Л.Мөнхбаатар:** Тийм. Тэгэхээр зэрэг энэ удаагийн парламент, энэ Ерөнхий сайд, Оюун-Эрдэнийн тэргүүлсэн Засгийн газар бол миний түрүүний хэлээд байгаа энэ улс үндэстний энэ ард түмний гэр бүлээр бол аав нь болсон энэ Монголын төр энэ Монголын төрийг нэг аливаа ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх энэ хулгай луйвар, авлигал, энэ болохгүй, бүтэхгүй бүх зүйлийг арилгах. Энийг цэцэглүүлээд орж ирээд байдаг. Энэ чинь нэг үхрийн эвэр дорживол гэдэг шиг ингээд

нэг цөөхөн гарын 5 хуруунд багтахаар нэг хэдхэн этгээдүүдээс болоод л үе үеийн парламент ингээд Монголын төр нэр хүнд нь унаад ингээд яваад ирлээ шүү дээ.

Тэгэхээр энийг нэг цэгцлэх хууль эрх зүйн тодорхой ийм сайн шийдлүүдийг гаргасан. Энэ 2024 оноос бол ер нь Монголын төр рүү.

**Л.Мөнхбаатар:** Бат-Эрдэнэ сайд ерөнхийдөө санал хэлчихлээ. Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн асуултаа асууя.

**Г.Тэмүүлэн:** Та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе. Гэр бүлийн тухай хуульд тодорхой томоохон бас өөрчлөлтүүдийг оруулах хуулийн төсөл орж ирж байна. Энэ Гэр бүлийн тухай хууль дээр ерөөсөө Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах үүднээс Засгийн газарт бас нэг хэд хэдэн үүрэг чиглэлийг бол бид нар 2022 онд Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах хүн амын өсөлтийг дэмжих талаар гээд тогтоол бас хувь хүнийхээ үүднээс санаачлаад Улсын Их Хурлаар батлуулаад Засгийн газарт тодорхой чиглэлүүд өгсөн. Энэ чиглэлийн дагуу бол ямар ч бай төрөл садангийн хүмүүсийн хоорондын гэрлэлтийг тодорхой хэмжээнд хориглох түр зохицуулалтыг хийх улсын бүртгэлийн байгууллагаас лавлагаа авдаг байх ч гэдэг юм уу, хамааралтай эсэхээ тодруулдаг байх өөр өөрсдөө мэдэх эрхийг нь олгодог байх. Шаардлагатай бол энэ ДНК-ийн шинжилгээнд хамрагдаад өөрсдөө баталгаажуулдаг ч гэдэг юм уу. Энэ зохицуулалтыг бол бид нар бас холбогдох хуулийн хүрээнд хийгээрэй гэдэг чиглэлийг бол Засгийн газарт өгсөн. Энэ Засгийн газарт Улсын Их Хурлын тогтоолоор өгсөн чиглэлийн дагуу өнөөдөр бол Засгийн газар энэ хуулийн төслийг санаачлаад оруулж ирж байна гэж бол харж байгаа юм. Би нэг хэд хэдэн зүйлийг бол бас тодруулж асуух гээд байгаа юм. Мааш сайн Гэр бүлийн тухай хууль дээр та

бүхэн маань Монгол хүний удмын санг, аюулгүй байдлыг нь хамгаалах үүднээс тодорхой зохицуулалтуудыг хийж орж ирлээ. Бид нарын 2022 онд санаачилж батлуулсан Удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах тогтоол дээр хэд хэдэн чиглэлүүдийг өгсөн.

Нэгдүгээрт бол ерөөсөө цус ойртолтоос сэргийлэхийн тулд ерөөсөө л дэлхий нийтээр хэвшмэл болчихсон хоёр, гуравхан л арга байдаг.

Нэгдүгээрт ургийн бичиг хөтлөх, тодотгох,

Хоёрдугаарх нь овог нэршилээр бол зохицуулалтуудыг хийх овог нэршилээр овог, нэр, нэг овог удмынхан дотроо гэрлэдэггүй байх зохицуулалтын асуудал,

Гуравдугаарт яг шинжлэх ухааны техник технологийн дэвшилийг ашиглаад бол генетикийн лабораториор тодорхой юу гэдэг юм би энэ удмынхаа хамаатлыг өөрсдөө мэддэг хэрэгтэй байх энэ асуудал байгаад байгаа юм.

Дөрөвдүгээрх нь бол мэдээж энэ яах вэ төрийн бодлого зохицуулалтын асуудал. Дотоод шилжилт хөдөлгөөнөөрөө хязгаарлах зохицуулалт хийх энэ бодлогын асуудлууд байдаг. Тэгэхээр би тогтоолтой холбогдуулаад бид нар ингэж хэлсэн. Тогтоолын 2 дугаар заалт дээр монгол хүний удмын санг цус ойртол удмын удамилын өвчлөлөөс сэргийлэх үүднээс ургийн бичиг бүрийг айл өрх бүрд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөтлүүлэн хэвшүүлэх ажлыг орон даяар 2024 онд багтаан хэрэгжүүлэх, шаардлагатай бол ургийн бичгийн нэршилийг шинэчлэх ажлыг зохион байгуулах гэдэг чиглэлийг 1 дүгээрт өгсөн.

Энэ ажил маань ер нь ямар явцтай явж байгаа юм бэ?

Хоёрдугаарт та бүхэн Гэр бүлийнхээ тухай хууль дээр тухайн энэ

хүмүүс чинь төрөл садангийн хүмүүс юм уу хоорондоо гэрлэх гээд байгаа юм уу? Та ядаж гэрлэхээсээ өмнө бас энийгээ мэдэж аваад лавлагаа авдаг байгаа ч ээ. ДНК-ийн шинжилгээнд хамрагдаад энийгээ баталгаажуулчхаач гэдэг энэ зохицуулалт орж ирж байгаа юм.

Тэгэхээр энэ зохицуулалт энэ хуулийн хэрэгжилтийг чинь хангуулахын тулд бид нар яг энэ орчин үеийн дэвшилтэт технологи бүхий генетикийн лаборатори хэрэгтэй. Энэ гений сантай холбоотой генетик нөөцтэй холбоотой генетикийн лабораторитой холбоотой асуудал маань ер нь ямар түвшинд явж байгаа юм бэ? Хаана хэрэгжих гээд энэнийх нь талаарх тооцоо судалгаа ТЭЗҮ юуг нь хийгээд хэзээнээс хэрэгжүүлэхээр төлөвлөөд ингээд явж байгаа юм бэ гэдэг судалгаа энэ дэд бүтэц байхгүй бол энэ хуулийн гол удмын сангийн аюулгүй байдлаас хамгаалах энэ зохицуулалт маань бол амьгүй болох ийм асуудал байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр ер нь та хэд маань ямар бодолтой байна? Дотоод шилжилт хөдөлгөөнийг тэтгэх бодлого бол байх ёстой. Бид нар социализмын үед бол магадгүй юу гэдэг юм төгсөх 10 жилийг заавал ч үгүй аймгийн төв дээр эсвэл сум дундын сургууль дээр төгсгөдөг ч гэдэг юм уу төвлөрүүлж эсвэл тодорхой аймаг, дүүргүүдээс шилжилт хөдөлгөөнийг зохицуулж ажиллах хүчнийг авдаг арми эсвэл сувилагчийн дунд, Багийн коллежийг байгуулдаг ч гэдэг юм уу ийм зохицуулалтууд байсан. Одоо яг ямар бодлогыг ер нь та нар маань цус ойртолтоос сэргийлэх үүднээс хэрэгжүүлэх бодлого баримталж байгаа юм бэ? Ямар зохицуулалтуудыг хийж байгаа юм?

**Л.Мөнхбаатар:** Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье.

**Б.Солонгоо:** Хууль зүй, дотоод хэргийн яамны Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя.

Тэгээд яг Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Шүүх шинжилгээний ерөнхий газар үйл ажиллагаа явуулдаг тэгээд шүүх шинжилгээний байгууллагын ДНК-ийн шинжилгээний лабораторид 2004 оноос эхлэн бас эцэг эх тогтоох шинжилгээ хийж эхэлсэн. Тэгээд жилд дун дунджаар бас 500 орчим иргэний хэргийн 1500 орчим биологийн дээжит эцэг эх тогтоох шинжилгээг бас хийдэг. Цаашидаа бас энэ ДНК-ийн шинжилгээний лабораторийн маань бас хүчин чадлыг бас сайжруулах чиглэлээр бас төсөл хэрэгжээд 2023 онд бас лабораторийн бас тоног төхөөрөмжийг бүрэн шинэчилсэн. Тэгээд молекул биологич мэргэжилтэй 10 шинжээч бол өнөөдөр үйл ажиллагаа явуулж байна.

Гэхдээ бидний хувьд өнөөдрийн бас энэ ДНК-ийн шинжилгээг эцэг эх тогтоох шинжилгээг бол хүүхэдтэй ДНЗ-тай харьцуулж шинжилгээ хийж байна. Цаашидаа бас гэрлэгч хосууд яг ураг төрлийн ураг садан, төрөл садангийн хамааралтай эсэх дээр шинжилгээ хийхийн тулд яалт ч үгүй бас суурь судалгааг Монгол Улсын хэмжээнд хийх зайлиггүй шаардлагатай гэдэг асуудлыг Шүүх шинжилгээний ерөнхий газраас өгч байгаа. Тэгээд энэ суурь судалгаанд ямар мэдээлэл зайлиггүй байх шаардлагатай вэ гэхлээр Монгол Улсын хэмжээнд нийслэл, аймаг, сум, дүүрэг, багийн хүн амын төлөөллөөс биологийн дээж авч түүврийн судалгаа хийх мөн бас Монгол Улсад цус ойртолт өндөр байгаа гэгдэх аймаг сумдад цус ойртолтын түвшин хэр байгааг тогтоох судалгаа хийх. Мөн бас Монгол Улсын хэмжээнд удам зүйн шинжилгээг овог угсаагаар хийх. Энэ суурь судалгаанууд хийгдсэний дараа бас энэ ДНК-ийн шинжилгээ төрөл садангийн хамааралтай эсэхийг тогтооход илүү

бодитой гарах боломж бүрдэнэ гэж байгаа.

Тэгээд ингэж бас судалгаа суурь судалгаатай болсноор удам төрөл генетик зайн хувьд хэр ойр, хэр хол байна вэ? Цус ойртолт үүсэх магадлал хэдэн хувьтай байна уу? Аль овоо угсааны хүн байна вэ гэдэг бас асуултад бас хариулт өгөх боломж бүрдэнэ. Тэгэхдээ цаашидаа бас шүүх шинжилгээний байгууллагын хувьд энэ чиглэлээр бас судалгаа хийх хүчин чадал, чадавхыг сайжруулах шаардлагатай байгаа. Нөгөө талаасаа бас энэ ажлыг хийхэд бас доор хаяж хүн амын нэгээс доошгүй хувьд судалгаа хийх хэрэгтэй. Тэгэхлээр 30-аас 32 мянган иргэнийг бас хамруулах шаардлагатай. Ингэснээрээ бас тодорхой төсвийн хөрөнгө оруулалтууд шаардлагатай байгаа. Тэгээд өнөөдөр бас зардлыг нь аваад үзэхээр нэг хүнээс дээж авч шинжилгээ хийх бодит зардал нь нэг иргэний хувьд 120-оос 150 мянга орчим төгрөг байна. Тэгээд ургийн бичиг хөтлөхтэй холбоотой хуулийн заалт өнөөдрийн бас Гэр бүлийн тухай хуульд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд бас үүнтэй холбоотой бас тодорхой заалтуудыг тусгасан.

Мөн бас Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулаад Соёлын сайдаар ахлуулсан ажлын хэсэг бас энэ чиглэлээр бас ажиллаж байна аа.

**Л.Мөнхбаатар:** Тэмүүлэн дарга тодруулж асууя.

**Г.Тэмүүлэн:** Би ерөөсөө судалгаа асуугаагүй. Би лаборатори яг хэзээ байгуулагдах юм бэ? Бид нар чинь яг энэ хүний генетикийн шинжлэх ухааны энэ генетикийн лаборатори зайлиггүй шаардлагатай байгаад байдаг генетикийн оношилгоогоо хийдэг болчихоод байдаг удам угсааны хамаатлыг тогтоодог болох шаардлагатай болчихоод

байдаг. Өнөөдөр бид нар юу гэдэг юм яг энийг хийх лаборатори байхгүй байхгүй юу Монгол Улсад хүн дээрээ. Гэтэл юу гэдэг юм саяын тэр цус ойртолтын асуудал чинь ч гэдэг юм уу ургийн бичиг хөтөлдөггүй ч гэдэг юм уу одоо бид нар овог нэршлийн асуудлыг шинэчлэх шаардлагатай ч гэдэг юм уу эд нар чинь бүгд асуудал болчихсон байгаад байгаа. Бид нар 2022 онд баталсан энэ нэг дугаартай. Энэ тогтоол бол бүхэл бүтэн Очирбат гуайн Ерөнхийлөгч байж гаргасан тогтоолоос 30 жилийн дараа гарсан тогтоол энэнийхээ хэрэглэгчдийг л би асуугаад байгаа юм. Лаборатори хэзээ яг орж ирэх вэ гэдэг асуудал.

Хоёрдугаарх нь. Жишээ нь би асуугаад байгаа зүйл нь дахиад та бүхэнд үүрэг даалгавар болгочихсон зүйл маань юу вэ гэхээр генетикийн оношилгоо гений сангийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр холбогдох хуулийн төслүүдийг чинь боловсруулж орж ирээч гэсэн хэзээ орж ирэх вэ гэдэг асуудал байгаад байгаа юм.

Тэгэхээр одоо орж ирээгүй. 2022 онд орж ирэх ёстой байсан.

**Л.Мөнхбаатар:** Тэмүүлэн даргын асуултад Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд нэмж хариулъя. Лабораторитой холбоотой асуудлаар нь хариулт өгье гэж байна. Микрофон өгье.

**Л.Энх-Амгалан:** Тэмүүжин гишүүн ер нь сүүлийн жилүүдэд яг энэ цус ойртолттой холбоотой асуудлаар өөрөө гишүүнийхээ хувьд нэлээн ажлыг энэ салбарын эрдэмтэн мэргэдтэй нэлээн сууж судалгаан дээр нэлээн суусан. Тэгээд хамгийн гол асуудал бол энэ үндэсний лаборатори энэ Монгол хүний удмын сангийн лабораторитой болох л асуудал юм байна лээ. Энэ Монгол Монгол Улсын бараг цаашидаа оришихуй, эс оришихуйн тухай асуудал юм байгаа юм. Тэгээд энэ дээр үндэсний Анагаах ухааны Их сургууль дээр бас яг энэ лабораториудыг

түшиглэж байгуулах нь зүйтэй гэдэг бас нэг ийм шийдлүүдийг Засгийн газрын түвшинд бас бид нар ярилцаж, тэгээд бид нар энэ дээр бас нэлээн шийдлүүд дээр энэ Солонгос их сайн шийдэлтэй юм байна. Хүн амынхаа энэ удмын санг хамгаалж үлдсэн удмын сангийнхаа менежментийг их сайн хийдэг. Тэгээд энэ чиглэлээр бид нар нэг солонгосын мэргэжилтнүүдийг урьж ажиллуулаад тооцоо судалгаанууд хийгдээд 60-аас 80 сая орчим долларын хөрөнгө оруулалтууд шаардлагатай юм байна гэсэн ийм тооцоонууд гарч байгаа. Тэгээд бид нар шинжлэх ухаан технологийн нөгөө нэгдсэн хүрээлэнгүүдийн баригдаж байгаа л нэгдсэн лабораториуд баригдаж байгаа тэр цогцолбор дээр бас энэ удмын санг байгуулж болох юм гэдэг төслийг бид нар хийгээд үндсэндээ ТЭЗҮ-үүд энэ хийгээд дуусаж байна.

Ингээд удахгүй бид нар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хурал дээр бас энийг танилцуулахаар ажиллаж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Хуулийн төсөл дээр хэн хариулах вэ? Улсын Их Хурлын нөгөө тогтоолд заасан хуулийн төслүүдийг хэзээ оруулж ирэх вэ гэж байгаа юм байна. Ер нь бол ийм байгаа шүү дээ. Хүн амын удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр Улсын Их Хурлын бас томоохон тогтоолыг Тэмүүлэн гишүүн, Бат-Эрдэнэ гишүүн бид 3 санаачилж батлуулсан. Энэ нь батлагдсанаас хойш нэлээдгүй хугацаа өнгөрчихлөө. Тийм болохоор Засгийн газраас энэ тогтоолын хэрэгжилтийн талаар Тэмүүлэн гишүүн асуулга тавьчихмаар юм байна тиймээ. Тэгээд хэрэгжилтийг нь ер нь Их Хурал дээр сонсох нь зүйтэй байх гэж бодож байна.

Тогтоолд заасан хуулийн төслийн талаар хэн хариулт өгөх вэ? 81 дүгээр микрофоныг өгье. Солонгоо дэд сайд хариулъя.



**Б.Солонгоо:** Өнөөдрийн бас хэлэлцэж байгаа асуудал Гэр бүлийн тухай хуультай холбогдуулаад бас бид нарын зүгээс бол энэ тогтоолын хэрэгжилттэй холбогдуулаад бас гэрлэгчид гэрлэлтээ бүртгүүлэхээс өмнө ДНК-ийн шинжилгээ өгдөг байх боломжийг хуулийн заалтад тусгасан. Тэгэхдээ хэрэгжих хугацааг 2028 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжихээр тусгасан. Яах вэ энэ суурь судалгаа зайлшгүй шаардлагатай юм байна гэдэг бас асуудал байгаа. Тэгээд цаашидаа бас энэ чиглэлийн лабораторийн хүчин чадлыг сайжруулах дээр тодорхой төсөл судалгаанууд хийгдэж байна.

Шүүх шинжилгээний ерөнхий газар дээр ДНК-ийн шинжилгээг шинжилгээний чанарыг сайжруулахтай холбогдуулаад тоног төхөөрөмжийг бүрэн шинэчилсэн. Тогтоолд тусгасан хуулийн төсөлтэй холбогдуулаад бас ЭМЯ-ны эрхлэх асуудалтай холбоотой асуудал байна. Тэгээд бид нар бас цаашидаа үргэлжлүүлээд холбогдох салбарын яамдуудтай бас энэ асуудлыг үргэлжлүүлээд судлаад бас холбогдох хуулийн төсөл дээр ажиллана.

**Л.Мөнхбаатар:** Ганзоригийн Тэмүүлэн дарга тодруулж асууя.

**Г.Тэмүүлэн:** Энэ 2022 онд гарсан энэ хуулийн тогтоолын төслийг та хэд маань сайн үзээрэй. Засгийн газар энэ дээр хариуцлагатай хандаарай. Тэгээд бид нар энэ асуулга тавина аа. Би он дээр нь түрүүн андуурчихсан байна. Зорилтот хөтөлбөрийг та бүхэн оруулж ирэх ёстой болчхоод байгаа юм. Удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотой. Тэгэхээр энэ нь 2022 онд орж ирэх ёстой. Энэ хэрэгжилт байхгүй болчхоод байгаа юм. 2023 онд та бүхэн яах ёстой вэ гэхээр генетикийн холбогдох хуулиуд буюу генетикийн оношилгооны тухай хууль, Генетикийн судалгааны тухай хууль, Гений сангийн тухай

хуулиудыг оруулж ирэх хэрэгтэй болчхоод байгаа юм 23-нд заасан.

Дээрээс нь 2024 ондоо багтаж энэ судалгаанд сууриалаад ургийн овгийн нэршлийг шинэчлэх ажлыг хийх ёстой болчхоод байгаа юм. Яагаад вэ гэхээр нийт Монгол Улсын хүн амын чинь 700, 800 гаран мянган хүн ам чинь нэг овогтой болчхоод байгаа юм. Уг нь цус ойртолтоос сэргийлэх олон улсын нийгэмлэг чинь ургийн бичгээ хөтлөөд, хамаатан дотроо суудаггүй байх, овог нэршилээрээ нэг зохицуулалт хийдэг байх, техник дээрээ суурилуулъя гэхлээр генетикийн лабораторио зохицуулдаг байх асуудал болчхоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ 3 суурь ажлыг бид нар зайлшгүй хийж байж цаашидаа Монгол энэ гэр бүлийн үндэс болсон овог удам угшил цэвэр байх асуудал болох гээд байгаа юм.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн асуултаа асууя.

Баярлалаа.

**Ж.Чинбүрэн:** Чухал хууль орж ирж байгаа гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар олон ач холбогдол бүхий зохицуулалт орсон байна аа. Энэ бас дэвшилттэй тал байна. Сая Тэмүүлэн гишүүн бас хэллээ. Тэмүүлэн гишүүний өргөн барьсан энэ Монголын хүний удмын сангийн аюулгүй байдал хамгаалах, хүн амын өсөлтийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай энэ хуулийн төслийг би өөрөө ахалж ажилласан. Тэгээд энэ тогтоол гараад бид энэ тогтоолын дагуу 2 зүйл эхний зүйл дотроо 7 бүлэгтэй ийм шаардлага тавьсан. Тэгээд хугацаатай. 2022 онд хэрэгжих ёстой, 2023 онд хэрэгжих ёстой, 2024 оноос эхлэх ёстой. Эндээс бол одоо 2024 онд эхлэх ёстой юм энэ ургийн бичиг хөтлөх ургийн бичиг хөтлөх чухал байгаа.

Тэгэхээр энэ бас энэ ажлын тогтоолын хүрээнд та бүхэн энэ хуулийг өргөн барьж байгаа гэж харж байгаа. 2022 онд Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах хүн амын өсөлтийг дэмжих талаар тогтоолын төслийг батлаад бид энд туссан гол зүйлүүдийн нэг нь Монгол хүний удмын санг цус ойртолт, удамилын өвчлөөс сэргийлэх, угийн бичгийг айл өрх бүрд шинжлэх ухааны үндэстэйгээр хөтлүүлэн хэвшүүлэх ажлыг орон даяар 2024 он энд хаяанд тулчихлаа. Тийм ээ, багтаан хэрэгжүүлэх, мөн удмын санг хамгаалах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар асуудлыг чиглэл өгсөн. Үүнтэй холбоотойгоор угийн бичиг айл өрх бүрд шинжлэх ухааны үндэслэлтэй хөтлүүлэх, хэвшүүлэх тал дээр төрийн байгууллагууд ямар чиг үүрэгтэй оролцох гэж байна аа? Энийг нэг дэлгэрүүлж хэлээрэй. Тэр талаар нарийвчлан заасан зохицуулалтууд хуульд байна уу? Угийн бичгийг хөтөлж хэвшүүлэхэд түүнд тавих хяналт төрийн байгуулалтын оролцоо нэн чухал шаардлагатай. Энэ тал дээр хуульд тусгасан уу? Энэ эхний асуулт.

Хоёр дахь асуудал. Сая Тэмүүлэн гишүүний хэлдэг ДНК-ийн шинжилгээ авах асуудал байгаа тийм ээ. Тэгэхээр бол ямар ч байсан төслийн хэмжээнд та бүхэн лабораторийн хүчин чадлаа сайжруулчихсан юм байна гэж ойлголоо. Энх-Амгалан сайдын хэлж байгаагаар ер нь бол Үндэсний анагаах ухааны их сургуулиа түших нь их зөв өө. Энэ бас зөв байна. Тэгэхлээр энэ дээр боловсон хүчнийг бэлтгэх энэ ДНК шинжилгээг найдвартай хийдэг болох тал дээр онцгой анхаарах ёстой. Зүгээр энэнтэй уялдуулаад би бас Булгантуяа сайд энд байж байна. Энэ шүүх шинжилгээний ажилчдын төрийн албан хаагчдын нөгөө тэтгэмж нэмэгдлийн асуудлыг бас онцгой анхаараач ээ. Энэ байгууллага дотор чинь тогтвортой ажиллах нь

өөрөө чухал аа. Эдгээр улсуудыг тогтвортой ажиллаж, чадвартай энэ лабораторийн молекул генетик шинжилгээ хийж чаддаг улсууд нь ажилладаг байх нь өөрөө чухал.

Тийм учраас энэ чиглэл дээр энэ төрийн албан хаагчдынх нь тэтгэмж урамшууллын асуудал дээр бас онцгой анхаарч энэ ажлыг Хууль зүйн яамнаас би Солонгоо дэд сайд мэдэж байгаа байх. Хууль зүйн яамнаас бичиг очсон байна шүү дээ. Эдгээрийн тэтгэмжийг нэмье гэдэг. Тэгэхлээр энэ асуудал дээрээ онцгой анхаарч энийгээ урагшаа явуулна уу? Энэ дээр бас ямар хариулт байх бол оо?

Гурав дахь асуулт нь бас энэ Гэр бүлийн тухай хуулиар зохицуулагдаагүй байсан хамтран амьдрагчдын эрх зүйн байдлыг тодорхойлж өгсөн байна. Тийм энэ бол бас их дэвшил гэж харж байгаа. Тэгээд хуулиас харахад хамтран амьдрагчдын гэр бүлтэй адилтгах харилцаа байхаар зохицуулжээ. Тэгээд Монгол Улсад гэрлэлтээ бүртгүүлээгүй олон жил хамтран амьдарч дундаасаа хүүхэдтэй эд хөрөнгөтэй болсон хүмүүс олон байдаг. Тэдгээр улсууд салж сарних яахад хөрөнгийн маргаан их үүсдэг. Тэгэхлээр энэ өмчлөх эрхийн зохицуулалтыг хэрхэн зохицуулж байна вэ? Энэ хуульдаа. Энэ тал дээр бас хариулт өгөхийг хүсэж байна аа.

**Л.Мөнхбаатар:** Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Солонгоо хариулъя. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье.

**Б.Солонгоо:** Чинбүрэн гишүүний асуултад хариулъя.

Тэгээд угийн бичиг хөтлөх хүртэл өвлүүлэхтэй холбоотой бас тодорхой заалтыг бол Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан. Тэгэхлээр гэрлэгчидтэй гэр бүлийн харилцаанд хүлээх үүрэг гээд 6.3 дугаар



зүйлийн 6.3.4-д уг угийн бичиг хөтлөх өвлүүлэх гэсэн заалт тусгасан. Мөн хуулийн төслийн бас 9.5-д угийн бичиг хөтлөх журмыг соёлын болон хүн амын хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална гээд бас холбогдох угийн бичиг хөтлөхтэй холбоотой журмыг тусгасан. Мөн бас эцэг эхийн хүүхдийн өмнө хүлээх үүрэг дээр бас угийн бичигтэй холбоотой заалт байгаа. Мөн бас Гэр бүлийн тухай хуулийг яг хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн байгууллагын чиг үүргийг тусгасан 10 дугаар бүлэг дээр гэр бүл хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт бас энэ угийн бичигтэй холбоотой бас тодорхой заалтыг тусгасан байгаа.

Тэгэхлээр цаашидаа энэ гэр бүлийн үнэт зүйлийг хамгаалах, хөгжүүлэх, дэвшилтэт уламжлалт зан заншлыг өвлүүлэх угийн бичиг хөтлөхөд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас бас хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгасан. Тэгээд түрүүн дурдсан Улсын Их Хурлын 2022 оны тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор бас яг угийн бичигтэй холбоотойгоор Соёлын сайдаар ахлуулсан ажлын хэсэг Засгийн газар дээр ажиллаж байна аа.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн нэмж хариулах юм уу? Асуултад нэмж хариулья. Нэг минут. Солонгоо дэд сайдын микрофоныг өгье.

**Б.Солонгоо:** Чинбүрэн гишүүний хамтран амьдрагчтай холбоотой бас асуултад хариулья.

Үүнтэй холбогдуулаад хуульд заасан тодорхой нөхцөл шаардлага хангагдсан бол хамтран амьдарсан иргэдийг хамтын амьдралаас хүүхэд төрсөн 5-аас доошгүй жил хамтран амьдарсан дундын эд хөрөнгөтэй болсон гэх мэтчилэн бас энэ тодорхой бас хуульд заасан хүчин зүй зүйлийг харгалзаад

хамтын амьдралаас үүдэж байгаа үр дагаврыг бас зохицуулахаар хуулийн төсөлд тусгасан. Тэгэхлээр энэ бол өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Гэр бүлийн хуультай харьцуулахад шинэлэг зохицуулалт. Бид нар энэ зохицуулалтыг бас шүүхийн байгууллагын төлөөлөлтэй шүүгчтэй бас хэлэлцэх явцад бас нэлээн бас нухацтай бас хэлэлцсэн.

Тэгэхлээр цаашидаа бас хуульд заасан нөхцөл шаардлагыг харгалзан үзээд шүүхээс хамтран амьдарсан одоо иргэдийн хооронд хамтын амьдралд гэрлэлттэй адилтгах харилцаа үүссэн эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Үүнтэй холбогдуулаад бол

**Л.Мөнхбаатар:** Чинбүрэн гишүүн тодруулж асууя.

**Ж.Чинбүрэн:** Ойлголоо тэгээд ер нь дэвшилттэй хууль гарч байна гэж ойлгож байна.

Хоёрт бол ер нь гений сан байгуулах асуудал их чухал. Энэ дээр яг Энх-Амгалан сайд онцгой анхаараарай. Тэгээд энэ санг хаана байгуулах ёстой юм? Энэ бол ер нь манай анагаах ухааны хөгжлийн бас их том дата бааз болох ёстой. Эд эс, эрхтэн хадгалж тэдгээрийн гений санг хадгалдаг ийм тогтолцоог энийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлтэй хамтарч хийх ёстой юм уу? Хаана хийх ёстой юм энэ бол? Бид тогтоолоороо бол үүрэг өгчихсөн байгаа шүү дээ. Энэнийхээ хэрэгжилтийг анхаарна биз.

Хоёрт би бас дахин хэлье. Шүүх шинжилгээний байгууллагын ажилчдын тэтгэмжийн асуудал дээр онцгой анхаараарай. Энэ дээр бас Булгантуяа сайд байгаа учраас би зориуд бүүр энийг 2 удаа давтаж хэллээ шүү. Энэ дээр анхаарч эдгээр улсуудын тэтгэмжийн асуудлыг энд ажиллаж байгаа улсуудын тогтвортой байдлыг хангах чиглэлд энэ

маш том урам өгөх зүйл байгаа. Тэгэхлээр энэ хууль нь байна тогтоол нь байна энийг хэрэгжүүлэхэд та бас анхаарч өгөөрэй гэж хүсье баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа асуултаа асууя.

**Б.Жаргалмаа:** Баярлалаа. Та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Гэр бүлийн тухай хуулийг бас нэлээн хүлээж орж ирж байгаа. Хуулийг бол бүрэн дэмжиж байгаа гэдгийг нэн түрүүнд хэлье. Ер нь бол хуулийн үзэл баримтлал хуулийн зүйл заалт бүр Монгол хүнийг зөв хүн болгон төлөвшүүлэх гэр бүлийн тогтвортой байдлыг хамгаалах Монгол өрх бүр сайн сайхан амьдрах бүхий л боломжоор нь хангах заалтууд бас орж ирсэн байна аа. Тэгэхлээр хэд хэдэн бас асуултууд байна аа.

Ер нь сая Тэмүүлэн дарга ч ярилаа. Чинбүрэн гишүүн ч гэсэн бас хэллээ. Ер нь Монгол хүний удмын санг хамгаалах энэ тогтоолын төсөл бол яг л Гэр бүлийн тухай хуультай нийцэх энэ тогтоол гарсан байдаг. 2022 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр бид нар бас баталсан байгаа. Гишүүд маань тогтоолынхоо хэрэгжилтийг шаардаад байна л даа. Тэгэхлээр энэ тогтоолын хэрэгжилт дээр бол ер нь Монгол хүний удмын санг хамгаалах аюулгүй байдлыг хамгаалах гэсэн, хүн амын өсөлтийг дэмжих гэсэн энэ бодлогын хүрээнд энэ тогтоол батлагдсан байгаа юм. Тэгээд сая нэгэнт асуултуудад хариулчихсан учраас би эндээс нэг зүйлийг тодруулъя гэж бодож байна аа. Сая бас бид нар Улсын Их Хурлаар төсөв яригдаж байгаа энэ цаг мөчид шүүх шинжилгээний байгууллагын нөгөө ДНК-ийн шинжилгээнд ашиглагддаг урвалж бодис гээд бүүр тодорхой заасан төсвийг бид нар баталж байна л даа.

Энэ урвалж бодисынхоо чанар дээр та бүхэн бас нэг анхаараач. Яагаад

би энэ нэг зүйлийг хэлээд байна вэ гэвэл шинжилгээний хариу зөрөх ийм асуудал бас өмнө нь үүсэж байсан учраас энэ дээр ер нь яг ямар бодлогоор ярьж бодлого барьж ажилладаг юм болоо. Бид шууд худалдан авах энэ зохицуулалтыг бас хийж өгье өө гэдэг зүйлийг Шүүх шинжилгээний тухай хууль дээр ч гэсэн ярьж байсан. Яг энэ асуудал чанараас шалтгаалан бас маргаан үүсэх энэ асуудал бас үүссэн гэдгийг би бас хэлье. Нөгөөтээгүүр энэ хууль дээр тэтгэмжийг тодорхой хугацаанд шинэчлэх боломж бий юу үгүй юу гэдгийг асуумаар байна. Сая Учрал гишүүн маань ч хэллээ эмэгтэйчүүдийн бүлгээс ч гэсэн бас энэ тодорхой хуулийн төсөлд бас саналаа өгөхдөө ер нь бол энэ орлоготой тэнцүүлэн тэтгэмж олгодог байя гэдэг энэ саналыг тавьсан байгаа. Тэгэхлээр энэ дээр ер нь өөрөөр хэлэх юм бол 2-оос 3 жилийн хугацаанд олгогдсон тэтгэмжийг шинэчлэх тийм ээ, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулах нөгөө хүний орлоготой нь тэнцүүлэх ажиллаж байгаа нөхцөл байдлаас нь шалтгаалан нэмэх, нөгөөтэйгүүр хэрвээ тэтгэмжээ төлөхгүй бол албадан хөдөлмөр эрхлүүлж тэтгэмжийг төлүүлдэг байх улсын хилээр гаргадаггүй байх ийм зохицуулалтуудыг оруулъя гэдэг ийм санал явагдаж байсан. Яг орсон болов уу үгүй юу.

Нөгөөтээгүүр гэрлэлтийн гэрээ, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл өмчлөх эрх тэтгэмж гээд маш олон дэмжих саналууд бас байна. Энэ нэг зүйл байна.

13.12 болоод 36.3, 39.3 шүүхээс эцэг эх байх эрхийг нь түдгэлзүүлэх явцын үеэр хүүхдийг төрийн хамгаалалтад авна гэсэн нэг ийм зохицуулалтууд байгаад байгаа байхгүй юу. Өнөөдөр бид нар хүүхэд хамгааллын хуулиараа хүүхдээ хамгаалахдаа хүүхдийн эрхийг зөрчихгүй хамгаалж чаддаг билүү, үгүй билүү 36.3, 39.3 нэг ийм давхацсан заалт байгаад байгаа юм. Зүгээр энэ давхацсан заалт нь яах вэ мэдээж засагдах байх. Хамгийн гол

нь бид хүүхдийнхээ эрхийг зөрчихгүйгээр хамгаалж чадахгүй.

Өөрөөр хэлэх юм бол эцэг эхээс нь хамгаалах гээд төр хажуудаа авахдаа өөрсдөө бид нар хүүхдийнхээ эрхийг хангаж чадах уу, үгүй юү гэдэг нэг ийм асуулт байна аа. Энэ асуултууддаа хариулт авчхаад үргэлжлүүлээд асууя.

Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье.

**Б.Солонгоо:** Жаргалмаа гишүүний асуултад хариулъя.

Тэгээд юуны өмнө бас шүүх шинжилгээний байгууллагын бас чадавхыг сайжрахтай холбогдуулаад бас төсөл хэрэгжиж байгаа. Тэгээд бид нар бас бүгдээрээ Солонгос улсад бас шинжээчдийг сургах чадавхыг бэхжүүлэх ажлууд хийгдэж байна. Түүрүүн бас дурдсан ДНК-ийн лабораторийг бас тоног төхөөрөмжийг нь энэ онд бүрэн шинэчилсэн. Цаашидаа Хууль зүй, дотоод хэргийн яамны зүгээс бас шүүх шинжилгээний байгууллагынхаа чадавхыг бэхжүүлэх дээр анхаарч ажиллана. Урвалж бодисыг шууд худалдан авалтаар авдаг гэсэн мэдээлэл байна. Тэгээд цаашидаа мэдээж бол шинжилгээний чанарыг сайжруулах дээр мэдээж тухайн байгууллага анхаарч байна. Яамны зүгээс ч гэсэн бодлогын хувьд бол дэмжиж ажилладаг. Хүүхдийн тэтгэлэгтэй холбогдуулаад хуульд бас яг орлоготой уялдуулж тэтгэлгийн хэмжээг тогтоох зохицуулалт бол орсон. Энэ бол хүүхэд гэр бүл цуцалсан эсэхээс үл хамаараад амьдралын чанар нь өөрчлөгдөхгүй байх хүүхдийн эрх ашиг зөрчигдөхгүй байхад бол ач холбогдолтой. Бусад улсуудын бас жишигийг олон улсын бас гэрээ конвенцыг харахад ч гэсэн бас орлоготой уялдуулж хүүхдийн тэтгэлгийг тогтоодог жишиг бол байна.

Хэрвээ тэтгэлэг төлөгчийн эд хөрөнгө орлогод өөрчлөлт гарсан мөн бас тэтгэлэг авагчийн бас нөхцөл байдал өөрчлөгдсөн бусад бас холбогдох нөхцөл байдал өөрчлөгдсөн бол тэтгэлэг авагч тал маань тэтгэлгийн хэмжээг өөрчлүүлэхээр бас шүүхэд нэхэмжлэл гарах боломжтой. Тэгэхлээр энэ тэтгэлгийн хэмжээ нь шүүхээр тогтоолоо гээд огт өөрчлөгдөхгүй гэсэн үг биш. Нөгөө талаасаа гэр бүл цуцлах маргааныг шүүхээр шийдвэрлэж байхад өнөөдөр гарч байгаа нэг асуудал юу байдаг вэ гэхлээр гэрлэгч талууд хүүхдийн тэтгэлэг авах асуудлыг хэрвээ нэхэмжлэлийн шаардлагадаа тусгаагүй бол шүүхээр энэ асуудлыг тусгайлан бол шийдэхгүй байгаа.

Ингэснээрээ бас хүүхдийн эрх ашиг хохирдог. Тэгэхлээр Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд гэрлэгчид гэр бүл цуцлуулах нэхэмжлэл гаргахдаа хүүхдийн тэтгэлэг төлөх асуудлыг тусгасан эсэхээс үл хамаараад шүүх энэ асуудлыг заавал шүүхийн шийдвэртээ тусгаахаар бас заасан байгаа. Ингэснээрээ бас шүүгчид хүүхдийн яг энэ гэр бүл цуцалж байгаа энэ асуудалд хүүхдийн эрх ашигийг хамгаалах ялангуяа хүүхдийн тэтгэлгээс гадна хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг эх хүүхэдтэйгээ уулзах нөхцөл боломжийг шүүхийн шийдвэрт тусгаахаар заасан.

Тэгэхлээр бас гэр бүл цуцалсан ч гэсэн эцэг эх нь хүүхэдтэйгээ байнгын харилцаатай байх нь бас энэ хүүхдийн тэтгэлэг төлөхөд их дэм дэмжлэг болдог олон улсын судалгаанууд байдаг. Тэгэхлээр цаашидаа хүүхдийн эрхийг бид нар хамгаалахад яалт ч үгүй бас энэ гэр бүл цуцлах энэ шүүхийн шийдвэрийн процесс болон шүүхийн шийдвэрт хүүхдийн эрх ашигийг нэн түрүүн харгалзан үзэх шаардлага байна. Тэгээд ер нь бас Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үндсэн.

**Л.Мөнхбаатар:** Тодруулах юм уу? Хариулт хангалтгүй гэж үзвэл тодруулж асууж болно. Бадарчийн Жаргалмаа гишүүн тодруулж асууя.

**Б.Жаргалмаа:** Хуулийн төсөл дээр хэд хэдэн заалт дээр хүүхдийг төр хамгаалалтад авна гэсэн ийм зохицуулалт байгаа. Энэ дээр төр өөрөө хамгаалах тэр боломж нь ер нь хэр байгаа юм бэ? Хүүхэд хамгааллын байр чинь ер нь хэр боломж нөхцөлтэй юм бэ гэдэг зүйлийг асууя. Энэ дээр бас нэг хүүхэд хэрвээ 7 нас хүрсэн бол эцэг эхийнхээ хэнтэй нь амьдрахаа өөрөө шийдвэрлэж байгаа тийм ээ. 7-гоос өмнөх бол ямар зохицуулалтыг хийх юм бэ гэдэг дээр бас нэг тодруулга авъя.

Нөгөөтээгүүр энэ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас тодруулъя. Ахмадын хуультайгаа хэр нийцэж байгаа вэ? Хэдийгээр Гэр бүлийн тухай хуульд цөм гэр бүл буюу хүүхдийг насанд хүртэл нь энэ хууль хамааралтай боловчиг нөгөөд эцэг эх нь асрамжийн төвд байгаа эцэг эхчүүд хөгшичүүлтэй би хамааруулж асуугаад байна л даа. Тийм ээ, аав ээжийгээ асардаггүй, хамгаалдаггүй энэ хүүхдүүдийн асуудал. Энэ нэгэнт л гэр бүл байсан. Тэгээд энэ асуудал бусад хуультайгаа хэр нийцэх юм бэ гэдэг дээр бас хариултыг авмаар байна. Өөрөөр хэлэх юм бол эцэг эхээ нөгөө төрд ингээд хаячихдаг. Хүү асардаггүй энэ асуудлыг бусад хуультайгаа хэр дүйцүүлэх вэ гэдэг зүйлийг тодруулах гэсэн юм.

**Л.Мөнхбаатар:** Тодруулгад нэмж хариулъя. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье. Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Солонгоо хариулна аа.

**Б.Солонгоо:** Жаргалмаа гишүүний асуултад хариулъя.

Тэгээд ер нь шүүх гэр бүлийн маргааныг шийдвэрлэх явцад бас хүүхдийн эрх ашгийг харгалзаж үзэх хүүхдийн саналыг бас харгалзаж үзэх асуудал бол өнөөдөр хүчин төгөлдөр

мөрдөгдөж байгаа хуулийн төсөлд ч байгаа. 7 насаа хүрсэн хүүхдийн саналыг шүүхийн шийдвэр гаргахдаа шүүгч харгалзаж үзнэ гэсэн заалт байдаг. Энэ заалт хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөлд ч мөн тусгасан. Тэгэхдээ нэмэлтээр бид нар бас сэтгэл зүйч, нийгмийн ажилтныг бас шаардлагатай бол оролцуулах заалтыг тусгасан. Ер нь бас цаашидаа манай улсад гэр бүл хүүхдийн асуудлаар дагнасан шүүх байгуулах нь гэр бүлийн маргааныг оновчтой шийдвэрлэх, хүүхдийн эрх ашгийг хамгаалахад шаардлагатай юм байна гээд бас Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр шүүх байгуулах тухай хуулийн төслийн хүрээнд гэр бүлийн асуудал эрхэлсэн дагнасан шүүх байгуулах асуудал мөн судлагдаж байна.

Тэгэхээр бас бидний зүгээс бас шүүгчидтэй хийсэн хэлэлцүүлгийн үеэр ч гэсэн шүүгчдийн зүгээс тавьж байгаа бас нэг асуудал нь цаашидаа энэ чиглэлээр мэргэшсэн, дагнасан шүүх байгууллага шүүгчид бас гэр бүлийн маргааныг шийдвэрлэдэг болох нь ялангуяа хүүхдийн эрх ашгийг бас хамгаалах хүүхдийн эрхийг хамгаалахад нэн шаардлагатай юм байна гэдэг асуудлыг ярьж байгаа. Нөгөө талаасаа бас Гэр бүлийн тухай хуульд асран хамгаалалтгүй болсон хүүхдийн асуудалтай холбогдуулаад Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдуулж энэ холбогдох заалтуудыг хүүхэд хамгааллын тогтолцоог тусгасан. Тэгээд үүнтэй холбоотой нэмэлт мэдээллийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас өгнө өө.

**Л.Мөнхбаатар:** Нэмж хариулах уу? Ажлын хэсгийн 84 дүгээр микрофоныг өгье.

**Н.Баярмаа:** Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Баярмаа. Гэр бүлийн тухай хуулийн ажлын хэсэг, Хүүхэд хамгааллын тухай



хуулийн ажлын хэсэг 2 жилийн хугацаанд бид нар бас хуулийн төслүүдээ хийж ажилласан байгаа. Хүүхдийг үнэхээр гэр бүлээс нь тусгаарлах нөхцөлд гэр бүлээс нь тусгаарлах үндэслэлийг Хүүхэд хамгааллын хуульд зааж өгсөн. Тэгээд хүүхэд асрах хувилбарт үйлчилгээг хэрэгжүүлэх бол НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц болон НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд өгсөн удирдамжийн дагуу хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ байна аа. Гэр бүлтэй дүйцэхүйц орчинд үзүүлэх үйлчилгээ гээд үүндээ болохоороо төрөл садны асрамж. Асралт гэр бүлийн зохицуулалтын асуудлыг Гэр бүлийн хуулиар Ерөнхий зохицуулалт хүүхэд хамгааллын хуулиар хүүхэд хамгааллын үйлчилгээний хэлбэр гэдэг энэ байдлаар оруулж ирсэн. Дараагийн шат бол төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд бас хамруулах асуудал. Одоогийн байдлаар улсын хэмжээнд 28 байгууллагын 31 асрамж, халамжийн хүүхдийн төв үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 3 нь улсын төсвийг бусад нь Олон улсын байгууллага, хувь хүний дэмжлэгтэйгээр байгуулагдсан ийм төвүүд байна. Тэгээд яг энэ тохиолдолд үнэхээр эцэг эхийн үүргийг хязгаарласан хассан энэ тохиолдолд шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд бид нар үнэхээр хүүхэд асран хамгаалах хүсэлт гаргасан гэр бүлүүдэд бас энэ хүүхэд хамгааллын энэ үйлчилгээг гэрээ байгуулж сургаж шилжүүлнэ. Нөгөө зардал мөнгийг нь бас Засгийн газар тусгайлсан бус аргачлалын дагуу бас тогтоож шийдэхээр бас тусгасан байгаа. Нөгөө талаар бас энэ асран хамгаалах үйлчилгээ үзүүлж байгаа энэ төвүүдэд бас шилжүүлэх зардал мөнгийг нийгмийн халамжийн сан болон хүүхэд хамгааллын зардлаас шийдвэрлэх энэ асуудлыг Хүүхэд хамгааллын хуультай бас тусгайлан бас оруулж өгсөн байгаа.

**Л.Мөнхбаатар:** Нэмж хариулах юм уу? Хэн хариулах юм? Булгантуяа сайд нэмж хариулъя.

**Х.Булгантуяа:** Сая бас манай Баярмаа дарга хариуллаа.

Гэр бүлийн тухай хууль дээр бол яг гэр бүл гэдэг нь гээд хамгийн эхний тодорхойлолтоор гэр бүл гэж гэрлэлт, төрөлт, үрчлэлтийн үр дүнд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг яахаар оруулсан байж байгаа. Гэр бүлийн тухай хууль дээр яах вэ садангийн хүн төрлийн хүн гэдгийг тодорхойлсон.

Гэхдээ таны хэлж байгаа бас яг үнэн. Бид нар энүүнийг бас ахмад настны тухай хууль гээд бусад хуулиудад нэлээдгүй зааж өгөхгүй бол сүүлийн жилүүдэд манай ахмад настны эрх зөрчигдөж байгаа асуудлууд маш их байгаа. Үр хүүхдүүд нь эцэг эхчүүдээ хүчирхийлдэг, үл хайхардаг, тэтгэврийнх нь мөнгийг аваад бараг гудамжинд гаргачихдаг. Тэгээд ийм асуудлууд маш их байгаа учраас үүнийг бас Ахмад настны тухай хууль нь байдаг юм уу нэлээдгүй зааж өгөх нь бас зүйтэй юм байна гэж бодоод таны саналыг хүлээж авлаа.

**Л.Мөнхбаатар:** Боловсрол шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан асуултаа асууя. Би асуулт асуухгүй үг хэлэх гэж байгаа юм. Тэгэхээр энэ гэр бүлийн тухай хуулийн шинэ найруулгын хамгийн чухал асуудал бол энэ хүүхдийн эрх, хүүхдийн хууль, ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, эцэг эхийн үүрэг хариуцлагыг маш тодорхой түвшинд сайжруулах хариуцлага хариуцлагажуулах л асуудал талаас нь бас би хэлэхийг хүсэж байгаа юм.

Тэгэхээр өнөөдөр энэ хуулийн төсөл дээр бид нар ингээд уншаад сууж байхад чинь яах вэ энэ ковидын дараа л гэж байна л даа. Жилд 16 мянган залуучууд гэр бүлээ бүртгүүлчхээд тэгээд буцаагаад жилд 4 мянга орчим гэр бүлд гэрлэлтээ цуцлуулж байна гэдэг илүү их аймшигтай тоо шүү дээ. Гэрлэж байгаа



4 залуугийн нэг нь гэр бүлээ цуцлуулж байна гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр энэний цаана бол хэдэн мянган хүүхэд өнчирч хоцрох, эцэггүй болох, эхгүй болох ийм том эрсдэлүүд байнга дагаж байдаг. Тэгээд энэ судалгаагаар чинь одоо хэлээд байна шүү дээ. Салж болно салаад хүүхдийнхээ өмнө хүлээх хариуцлагаасаа бултчихдаг ийм бүхэл бүтэн ийм празит үе гарч ирсэн байна шүү дээ. 14 мянган хүүхдийнхээ тэтгэлэг төлөх ёстой шүүхийн шийдвэр гарчхаад байхад энэнээсээ бултаад явж байгаа 60 хувь нь хүүхдийнхээ төлбөрийг, хүүхдийнхээ тэтгэлгийг төлдөггүй ийм сэтгэлгүй ийм бүхэл бүтэн ийм үе үүсчихсэн. Тэгээд шалтгаан нь болохоор ажилгүй байна, ядуу байна, төлбөрийн бололцоогүй байна гэдэг ийм тайлбар хэлээд ингээд хуулийг завшаад хариуцлагаас бултаад явдаг ийм тогтолцоог бид нар дэмжиж байж ерөөсөө болохгүй.

Тийм учраас одоо ингээд яг энэ эцэг эхчүүдэд хүлээх хариуцлагуудыг бид нар нэг хуульчлаад хуульчлах нэг өөр. Хамгийн гол нь энийг хариуцлагажуулах ёстой.

Тэгээд яг ингээд хариуцлагаас бултвал өнөөдөр яг энэ хүнд ямар хариуцлага хүлээх юм бэ гэдэг асуудал байгаа юм. Ер нь манай энэ хууль тогтоомжууд чинь нэг амьдралд хэрэгждэггүй нэг гол зүйл бол өчнөөн хууль гаргадаг. Хуулийг хэрэгжүүлэхээр амьдрал дээрээ хүлээх хариуцлагууд байдаггүй. Төр нөгөө яг төмөр нүүрээ гаргах үедээ төмөр нүүрээ гаргаж болдоггүй, чаддаггүй, нөгөө шүдгүй арслан шиг ийм хуулиуд баталдаг. Тийм учраас бол яг энэ эцэг эхийг хүлээх хариуцлага тэр тусмаа энэ хүүхдээ өнчрүүлж байгаа энэ эцэг эхчүүд дээр бид нар үнэхээр төр яг төмөр нүүрээ гаргах ийм цаг нь болсон л гэж би ойлгож байгаа.

Тэгэхээр маш их аймшигтай тоонууд байгаа байхгүй юу. Одоо ингээд үндсэндээ энэ хүүхдийн хүчирхийллийн чинь үйлдэгдэж байгаа бараг 70 хувь нь

гэр бүлийн орчинд хүүхдийн хүчирхийлэл үйлдэгдэж байна. Энэ бодит тоо, бодит амьдрал. Тэгээд мөн одоо яг энэ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас гаргасан тоогоор болохоор 14 мянган хүүхэд эрсдэлтэй орчинд амьдарч байна гэдэг тоо байдаг. Гэтэл манай яамнаас гаргаж байгаа аргачлалаар энэ тоог үзэхээр 50 хэдэн мянган хүүхэд эрсдэлтэй орчинд амьдарч байна гэдэг. Тэгээд 50 хэдэн мянган хүүхэд эрсдэлтэй орчинд амьдарч байгаа хүүхдүүдийг ингээд судлаад ингээд үзэхээр яг л хөөрхий тэгээд гэр бүл нь салчихсан эс үгүй бол эцэг эх 2 нь тусдаа амьдардаг. Эс үгүй бол нэг нь гадаадаар амьдардаг яг ийм хүүхдүүд байгаад байгаа юм аа.

Тэгэхээр өнөөдөр яг энэ хүүхдүүдийн өмнө хүлээх хариуцлагуудыг яг бид нар Боловсролын хууль дээр бас нэлээн энэ хүүхдээ эрүүл болгох, эрүүл өсгөх, саруул бойжуулах, сургах, хүмүүжүүлэх, амьдралд хөл дадал хөл олгох энэ асуудлуудыг ганцхан сургуульд найдаж ерөөсөө орхиж болохгүй.

Тэгэхээр энийг бид нар Боловсролын хууль дээр бас энэ заалтуудыг хийж байсан. Энийг энэнтэй уялдуулж энэ заалтуудтай уялдуулж бас Гэр бүлийн тухай хууль дээр яг энэ хүүхдийн хууль ёсны эдлэх ёстой эрх үүрэг хариуцлагуудыг ингээж бүүр яаж өгсөн нь тусдаа 5 дугаар бүлэг болгож өгсөн нь бас давуу тал. Гэлээ гэхдээ ганцхан бид нар энэ заалтаар энийг ингээд хийгээд орхиж болохгүй. Энэ зөрчлүүд гарах юм бол энэ нөхдүүдэд ямар хариуцлага тооцох юм бэ? Ингээд толгойг нь илээд яваад байж болохгүй. Хариуцлага тооцох тооцохдоо нэлээн хатуу хариуцлага тооцдог ийм хуультай болж байж л бид нар энэ Гэр бүлийн хууль дээр тодорхой дэвшил гарах юм.

Улсын Их Хурлын гишүүн  
Цэрэнжамцын Мөнхцэцэг асуултаа асууя.

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр энэ Монгол Улсын үндсэн нэгж болж байгаа энэ Гэр бүлийн хууль оруулж ирж байгаа энэ заалтууд нэлээн дэвшилттэй зүйл байна аа. Тэгээд ер нь гэр бүл салалт гэр бүлийн салалтаас үүдэлтэйгээр тухайн гэр бүлийн гишүүд тэр дотор хүүхэд, ахмад настан хохирох асуудал удаа дараа нэмэгдэж байгаа. Энэ нөхцөлд энэ гэр бүлийн тухай хууль дахь энэ гэр бүл бологчдын эрх үүргийг нарийвчлан зохицуулсан тодорхой нөхцөлд гэр бүлийн гишүүдийн эрх зөрчигдсөн тохиолдолд хуулийн болон бусад хариуцлагыг нэлээн сайн оруулж өгсөн байна аа.

Тийм учраас энэ хуулийг бол концептууд дэмжиж байна. Тухайлбал энэ гэр бүл салах үед хүүхдийг хамтран амьдарсан гэр албан ёсны гэр бүл болсон эсэхээс үл хамаараад ерөөсөө эцэг эхийн үүргийг нарийвчлан зааж өгсөн байна. Мөн тэжээн тэтгэх үүрэг гэдгийг өмнөх хуультай харьцуулахад бас нэлээн хатуу зохицуулж өгчээ. Нөгөө түрүүн гишүүд маань хэлж байна. Маши олон ахмад настнууд тэтгэврийнхэн, эцэг эх нь үүргээ гүйцэтгэж ирсэн хэдий ч хүүхдүүд нь хайхрахгүй зөнд нь орхисон. Үүний улмаас өндөр настны асрамжийн газраар очих эсвэл бүүр хүнд өвчтэй гэртээ хаясан ийм асуудал зөндөө гарч байна аа. Тэгвэл хуулийн төсөл болон тэжээн тэжээн тэтгүүлэх эрхээ зөрчигдсөн тохиолдолд тухайн хүн маань нэхэмжлэх шүүхэд хандах энэ боломжийг оруулж ирсэн байна.

Тэгээд 2 асуулт байна. Энэ төсөлд бол удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах цус ойртсон гэрлэлтээс сэргийлэх тухайд бас нэлээн нэршилтэй заалтууд орсон байна. Тэгээд энэ гэрлэлтийг бүртгэх үед садан төрлийн гэрлэлтийг хориглох, цус ойртолтоос сэргийлэх үүднээс ДНК-ийн шинжилгээнд орох ёстой гэдэг ийм нөхцөлд оржээ. Тэгэхдээ энийг бас хуульчлаад заавал ДНК-ийн шинжилгээ хийлгэсэн байна гэж оруулаагүй байна.

Тэгэхээр ер нь энийг заавал нэг хуульчлаад оруулж болдоггүй юм уу? Хүн ам цөөтэй удмын сангийн хувьд бол бас бид нар төрийн үндэсний хэмжээнд хуулийн хэмжээнд хамгаалах ийм асуудал ер нь Монгол Улсад байдаг. Тийм учраас гэр бүл болж байгаа бүх хүмүүс энэ ДНК-ийн шинжилгээ буюу генетикийн шинжилгээнд заавал орсон байх ёстой гэдгийг хуульчлах ийм, хуульчилж орсон нь илүү дэвшилттэй юм биш үү? Тэгээд үүнтэй холбоотойгоор тэр нэг генетикийн шинжилгээ хийх боломж ер нь зөвхөн шүүх шинжилгээний үндсэн хүрээлэнгээс өөр газар байхгүй юу. Хэрэвзээ хуульчлаад оруулсан тохиолдолд бас генетикийн үндэсний лаборатори байгуулагдах хүртэл яг тухайн заалтыг цаг хугацааны хувьд бас нэлээн хойшлуулаад хэрэгжүүлэх боломж байна л даа.

Тэгэхгүй бол зүгээр гэрлэгчид ДНК-ийн шинжилгээ өгсөн байна гээд оруулчихаар яг өнөөдрийн энэ байдал маань ерөөсөө засагдахгүй юм биш үү гэдгийг асуумаар байна.

Хоёрдугаарт нь мөн гэрлэгчдийн эрх үүргийг гэрлэлтийн гэрээгээр зохицуулахаар бас хуульд оруулж өгсөн байгаа. Энэ бол олон улсын жишиг байдаг. Мөн энийг бас заавал биелүүлэх үүрэг болгож хуульчилж болохгүй юм уу? Яагаад вэ гэхээр энэ хуулийн маань төсөлд хэрэвзээ гэрлэлт цуцлах үед гэрлэгчдийн хооронд эд хөрөнгийн болон бусад маргаан байгаа тохиолдолд шүүх тухайн гэрлэгчдийн хоорондын гэрлэлтийн гэрээг үндэслэнэ гэсэн ийм заалт орж ирсэн байгаа. Хэрэв гэрлэлтийн гэрээ байхгүй тохиолдолд хуульд заасан бусад нөхцөлөөр шүүх энэ гэр бүлийн гишүүдийн хооронд хөрөнгө хуваарилна гэж байгаа.

Тэгэхээр ийм заалт байгаа учраас ерөөсөө энэ гэрлэлтийн гэрээг заавал

байхаар бас үүрэгчилж болдоггүй юм уу гэсэн ийм 2 асуулт байна аа.

**Л.Мөнхбаатар:** Асуултад хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Солонгоо хариулъя. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье.

**Б.Солонгоо:** Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Тэгээд ер нь бид нар бас энэ сая цус ойртолтоос урьдчилан сэргийлэхтэй холбогдуулаад яг энэ хуулийн төсөл дээрээ бол ДНК-ийн шинжилгээ өгдөг болох боломжийг нээсэн. Гэхдээ энийг бас мэдээж бид нарын хувьд хамрагдаж болно гэдэг бол ерөнхийдөө боломжтой гэдэг байдлаар оруулсан байгаа. Тэгээд ер нь бол гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ бүртгүүлэхээс өмнө хоорондоо садан төрлийн холбоотой эсэхээ мэдэх зорилгоор өөрийн хүсэлтээр эсвэл сонирхогч талын шаардлагаар энэ шинжилгээнд хамрагдаж болохоор тусгасан. Тэгэхлээр бас зөвхөн гэрлэгчид өөрсдөө биш тухайн яг хуульд заасан сонирхогч тал гэж заасан этгээд бас энэ шинжилгээнд хамрагдах асуудлыг тавих боломжтой.

Тэгэхлээр бас гэр бүлийн яг бусад гишүүд төрөл садны хүмүүс ч юм уу тэ эс үгүй бол албан тушаалтан яг тухайн хүүхдийн эрхийг хамгаалах ашиг сонирхол нь бас хөндөгдсөн этгээдүүд бас энэ асуудлыг гаргах боломжтой. Түрүүн бас дурдсан. Бид нар энэ генетикийн шинжилгээг бас хийдэг болоход тодорхой бэлэн байдал шаардлагатай. Тэгэхээр энэ хуулийн заалт маань 2028 он 8 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжихээр туссан. Цаашидаа бас энэ лаборатори бэлэн болоод холбогдох суурь судалгаанууд хийгдсэний дараа бас энэ хуулийн хэрэгжилтийг харгалзаж үзээд цаашидаа ямар байдлаар бас энэ асуудлыг хуулиар зохицуулах нь зүйтэй вэ гэдэг дээр бас судалгаа хийгдсэний дараа бас хууль хэрэгжилт дээр бас тодорхой

судалгаанууд хийгдсэний дараа бол дараа дараачийн асуудлуудыг бас хуулиар зохицуулах боломж бүрдэнэ.

Хоёр дахь асуулт.

Гэрлэлтийн гэрээтэй холбогдуулаад иргэний эрх зүйн суурь зарчим бол талуудын чөлөөт байдал. Тэгэхлээр талууд сайн дурын үндсэн дээр гэрээ байгуулах эсэхээ шийдвэрлэдэг. Тэгэхлээр энэ гэрлэлтийн гэрээг заавал байгуулах шаардлагатай гэдэг асуудлыг бас бид нар хувийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд хуулиар тусгах боломжгүй. Харин гэрлэгч талууд хүсэх юм бол эд хөрөнгийн харилцааг зохицуулах зорилгоор бас гэрлэлтийн гэрээг байгуулах боломжийг нээсэн.

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Иргэний хуульд бол гэрлэлтийн гэрээ байгуулах талаар боломжтой талаар дурдчихсан байдаг. Гэхдээ дэлгэрэнгүй зохицуулалт байдаггүй. Нөгөө талаасаа бид нар гэрлэлтийн гэрээгээр талууд бас асуудлаа зохицуулах нь эд хөрөнгийн асуудлаа зохицуулах нь маргаан үүсгэхээс урьдчилан сэргийлэх боловч нөгөө талаасаа гэрээ байгуулж байгаа талууд нийгмийн хэм хэмжээг зөрчсөн ёс суртахууны хэм хэмжээ зөрчсөн асуудлаар бас гэрээ байгуулж болохгүй.

Үүнтэй холбогдуулаад бас холбогдох бас хамгаалах зохицуулалтыг тусгасан. Тухайлбал гэрлэлтийн гэрээгээр эцэг эх байх эрхийг хязгаарласан заалт оруулж болохгүй. Хүүхдээ тэжээн тэтгэх сурах эрхийг бас хангах үүргээс чөлөөлсөн заалт тусгаж болохгүй гээд тэгэхлээр эд хөрөнгийн бус асуудлыг.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг асуултаа асууя.

**М.Оюунчимэг:** Энэ өнгөрсөн 4 жилд бас энэ Гэр бүлийн тухай хуулийг

маш яаралтай оруулж ирж батлах шаардлагатай байна гэдэг асуудлууд олон яригдсан. Тэгээд Хөдөлмөр, нийгмийн хамгаалал дээр байж байснаа энэ бол бас гэмт хэргийн юм уу, эрүүгийн олон тийм санкцтай учраас ганц Хөдөлмөр, нийгмийн хамгаалал биш Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр асуудал орох нь зайлиггүй хэрэгтэй байна гээд Хууль зүй, дотоод хэргийн яам руу шилжүүлж явсан. Өнөөдөр тэгээд сая нөгөө хүүхэдтэй холбоотой ноцтой асуудлууд гарсны дараа Хүүхэд хамгааллын хуультай ингээд нэгтгээд орж ирж байна. Энэ бол бүүр цаг алдаж байгаа хууль. Зайлиггүй орж ирэх шаардлагатай байсан. Одоо тэгээд орж ирж байна аа. Тэгээд сая бас Солонгоо дэд сайд тайлбарлаж байна. Хэд хэдэн чухал заалтууд энүүгээр бас орж байгаа нь зөв.

Яагаад гэвэл одоо мөрдөж байгаа хууль 1999 оны хууль. Энэнээс хойш улс орны нийгэм эдийн засгийн харьцаа ер нь тэгээд л бүх зүйл маш их өөрчлөлтүүд орсон. Энэтэй уялдаад гэр бүлийн маргаанд ч яг ийм нийгмийн тусгалууд маш их бий болчихсон байгаа шүү дээ. Одоо ингээд л харж байхад гэрлэлт түүнтэй харьцах цуцлалтын хэмжээ л гэхэд сүүлийн жилүүдэд асар их нэмэгдэж байна. 10 хүн гэр бүлээ цуцлуулж байхад 40 хүн нь хос болж байна гэхэд сүүлдээ энэ харьцаа чинь бараг бие бие рүүгээ дөхөж очих хэмжээнд гээд л. Тэгээд энэний шалтгаан юу байна гэхээр тааламжгүй харьцаа гээд байгаа юм. Тааламжгүй харьцаа гэж юуг хэлж байгаа юм гээд хэлэхээр одоо яг энэ насных нь хувьд аваад үзэхэд дандаа 25-аас 40 орчим насны 39 гэж гарсан байна лээ л дээ. Тэгэхээр энийг яах вэ сэтгэл зүйчид яг энэ шүүх дээр гэр бүлийн маргааныг шийдвэрлэж байгаа хүмүүсийн ихэнх нь бол хэт эрт гэрлэх, гэр бүл болох бэлэн биш байж байж болчихоод тэгээд хүүхдээ ч асарч чадахгүй, хүүхдийн тэтгэмж ч өгч чадахгүй тэгээд энэ нь өөрөө эргээд өөр харьцаа үүсгэхэд

хүрдэг гэсэн шалтгаануудыг тайлбарласан байна лээ л дээ.

Тэгэхээр одоо бас манай мэргэжлийн хүмүүс энэ тааламжгүй харьцаа гэдэг нь юунаас үүдэлтэй байна гээд. Тэр үүдлээс нь устгах асуудал бол өөрөө их чухал байгаа шүү гэдгийг хэлье. Тэгээд I дүгээрт гэр бүл салалтын хамгийн том хохирогч хүүхэд. Тэгэхээр энэ хууль дээр ялангуяа Иргэний хуулийн нэмэлт, өөрчлөлт энэ тэр дээр нэгдүгээрт хүүхэд хамгаалах хүүхдээ орхисон тохиолдолд сая тэтгэмжийн тухай ярьж байна. Тэгэхээр энэ бас арай доогуур байгаад байгаа юм аа. Доогуур байгаа хэр нь төлөхгүй байгаад байгаа шүү дээ.

Тэгэхээр сая Энхбаяр сайд түрүүн хэлж байх шиг байсан. Хилээр гарах хориг тавингуут хүмүүс зайлиггүй ажлаар явах хэрэгтэй болоод хүүхдэдээ тэтгэмжээ өгч эхэлж байна гэсэн нэг мэдээ хэлж байсан. Үнэхээр ийм бодитой зүйлүүд байгаа яг тэр эдийн засгийн хөшүүргийг нь хүчтэй чанга болгох нь энэ хуулийн бас нэг онцлог зүйл байх ёстой. Авч байгаа цалингийнх нь хэмжээтэй орлогынх нь хэмжээнд тохируулаад ер нь хүүхдэд олгох тэтгэмж, дээрээс нь тэтгэмжээ төлөхгүй бол оногдуулах хариуцлагыг маш өндөр чангатгах хэрэгтэй.

Тэгээд энэ тэтгэмжийг жишээлбэл хүүхдэд өөрөө хэлбэл яаж ашиглах вэ? Ирээдүйд тэрнээс авчхаад тэтгэмж төллөө гээд нөгөө хүүхдэд нь биш бусад улс оронд хүүхдийн тэтгэмжийг эцэг эх нь төлсөн энэ тэтгэмж зөвхөн хүүхдэд нь л зарцуулагдана гээд байдаг. Манайд одоогоор бас ийм заалтууд энд харагдахгүй байгаад байна л даа. Тэгэхээр энэ дээр нэгдүгээрт нь маш тодорхой заалтууд оруулж өгмөөр байна. Сая тэр Учрал гишүүний хэлээд байгаа бас үнэнч шүү дээ. Хүүхдийн тэтгэмж төлж чадахгүй байж баахан энд тэнд очоод л айл гэр үймүүлэх юм уу эсвэл ингээд



хүүхдээ өнчрүүлээд яваад байж болохгүй шүү дээ. Энэ бол асар том хариуцлагатай байх ёстой. Сүүлийн үед ганц эрэгтэйчүүд ч биш жишээ нь манай Чингэлтэй дүүргийн хувьд ярихад эх нь явчихсан, тэгээд хүүхдээ харж байгаа эрэгтэйчүүд ч байна.

Тэгэхээр бид нар асуудалд маш цогцоор нь хандах нь зөв болов уу гэсэн бодолтой байна.

Хоёр дахь зүйл нь эд хөрөнгийн маргаан бол хамгийн том бас шалтгаан болж байгаа гээд. Манайхан нөгөө гэрлэлтийн гэрээ хийж бараг байгуулж чаддаггүй. Нөгөө хайртай дуртай гээд суучаад дараа нь салах болоход ялангуяа эмэгтэйчүүд ямар ч эд хөрөнгийн баталгаагүй. Тэгээд л ёстой ядуурлын эгнээ рүү орж байна. Тэгэхээр бид нар энэ дээр гэрлэлтийн гэрээг зайлшгүй байгуулах хөшүүргийг нь суулгаж өгөх хэрэгтэй байна аа. Энд бол харилцан тохиролцсоны үндсэн дээр гээд байж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье.

**Б.Солонгоо:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Тэгэхлээр бас хүүхдийн тэтгэлэг төлөлттэй холбоотой бас тулгамдсан асуудлууд амьдралд байна. Нэгдүгээрт бол тэтгэлгийн хэмжээ хүрэлцэхүйц байх, хоёрдугаарт бас тэтгэлэг төлүүлэхтэй холбоотой бас албадлагын арга хэмжээг шүүгч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудаас бас шүүхийн шийдвэрийн шүүхээс гарсан шийдвэрийг хэрэгжилтийг хангуулах дээр бол ажлууд хийгддэг.

Нөгөө талаасаа бас хүүхдийн тэтгэлгийг зөвхөн хүүхдийн хэрэгцээнд зарцуулахтай холбогдоод хуулийн заалт Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн

найруулгын төсөлд тусгасан. Тэгэхлээр хэрвээ хүүхдийн тэтгэлгийг хүүхдийн хэрэгцээнд зарцуулаагүй нь тогтоогдсон бол тэтгэлэгт төлөгч 14 насанд хүрсэн хүүхэд өөрөө эс үгүй бо лтухайн сум, хорооны гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан шүүхэд бас нэхэмжлэл гаргаж болно гэсэн заалт орсон. Мөн бас хүүхдийн өөрийн хуваарьт эд хөрөнгөтэй холбоотой бас холбогдох хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Иргэний хуульд оруулахаар хуулийн төсөл дагаж өргөн мэдүүлсэн.

Цаашидаа бидний хувьд мэдээж энэ гэр бүлийн гишүүдийн эрх ашгийг хамгаалах гэр бүл цуцалсан тохиолдолд яг гэрлэгчдийн болон гэр бүлийн гишүүдийн дундын эд хөрөнгийг хуваарилах асуудал дээр яг Иргэний хуулийн зохицуулалтыг харгалзаж үзэж энэ хуульдаа тусгасан. Тэгээд шүүхийн практикт энэ асуудал нэлээн хөндөгдөж шүүхийн практикт Иргэний хуулийн холбогдох зохицуулалтуудыг хэрэгжүүлж ажиллаж байгаа. Тэгэхлээр бидний хувьд энэ Иргэний хуулиар зохицуулагдаж байгаа суурь асуудал дээр бол бас илүү энэ хуулийн зохицуулалтыг анхаарсан. Гэр бүлийн тухай хууль дээр хэрвээ эд хөрөнгөө нуун дарагдуулсан нь тодорхой хэмжээгээр гэрлэгчдийн хэн нэгний эрх ашиг хөндөгдсөн тохиолдолд бас шүүх өөрөөр шийдвэрлэж болно гэсэн Иргэний хуулийн заалтыг тусгайлж оруулсан. Тэгээд цаашидаа бол мэдээж шүүхийн практикт энэ асуудал бол одоо хууль хэрэгжих асуудал маань сайн шийдэгдэх ёстой. Мэдээж бид нар энэ гэр бүлийн тухай хуулийг сурталчлах гэрлэгчдэдээ бас эрх үүрэг хариуцлагыг нь сайн таниулж мэдүүлэх эрх зүйн боловсрол олгох ажлуудыг хийх шаардлагатай байгаа.

Залуу гэр бүлийн хувьд бас энэ талын сургалтад хамрагдах хүсэлтийг бас их илэрхийлдэг энэ асуудлыг бас бид нар хуулийн төсөлд тусгасан. Цаашидаа



мэдээж гэр бүл бол манай нийгмийн суурь институц. Тэгэхлээр бас гэр бүлийг тогтвортой байдлыг нь төрөөс хамгаалах чиглэлээр холбогдох заалтуудыг Гэр бүлийн тухай хуульд тусгасан байна. Тэгээд ШШГБ-аас энэ тэтгэлэг төлөхтэй холбоотой нэмэлт мэдээллийг өгөх нь зүйтэй.

**Л.Мөнхбаатар:** Яах юм тодруулах юм уу? Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

**М.Оюунчимэг:** Тэр гэр бүлийн хүчирхийллийг ингээд аваад үзэхэд дандаа л нөгөө ихэнх нь хүүхэд хохирчихсон эмэгтэйчүүд хохирчихсон байдаг. Яагаад ингээд хүчирхийлэл үйлдээд байхад та хамт амьдраад байдаг юм гэхээр би яах билээ. Орлого байхгүй болчихно байранд нь амьдардаг ч гэдэг юм уу байшин, гэр гээд ийм асуудал маш их байдаг юм байна лээ. Тэгэхээр энэ дээр л бид нар өнөөдрийн хуулиараа бас энийг нь эзэмших өмчлөх эрхэн дээр нь ч гэдэг юм уу бас тодорхой заагаад өгчихвөл их чухал. Түүрүн бас хэлж байна. Би 2018 онд Чингэлтэй дүүрэгт Гэр бүл хүүхэд залуучуудын газар байгуулсан юм. Өнөөдөр тэнд нөгөө эрэгтэйчүүдийн сэтгэлээ нээх булан гээд 2 өрөө болсон. Тэгсэн чинь эрэгтэйчүүд аягүй сайн ирж байна гэж байна. Тэгээд шалтгаан нь юу юм гэхээр нөгөө сэтгэл гутрал, тэгээд л архидалт, ажилгүйдэл. Тэгээд байнга чи ингэдэг ингэдэг гээд л нөгөө үглээд байхаар сүүлдээ надад хэцүү байдаг юм. Тэгээд л аргагүйн эрхэнд явах болдог ч гэдэг юм уу.

Тэгэхээр бид нар энэ нөгөө сая хэлж байна. Гэр бүлийн боловсролыг бүр ингээд боловсролын сургуулиудыг ингэж заана, цэцэрлэгт нь ингэнэ. Хүүхдийг багаас нь ингээд сургачихвал.

**Л.Мөнхбаатар:** Санал уу тэ. Санал хэллээ.

13 цаг өнгөрсөн байна яах уу гишүүд үргэлжлүүлэх үү, завсарлах уу үргэлжлүүлэх үү?

Өнөөдөр төрсөн өдөр нь тохиож буй Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир асуултаа асууя.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа дарга. Засгийн газраас энэ харин Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тэр дундаа бага насны хүүхдийн эсрэг үйлдэж байгаа гэмт хэргийн ялын бодлогыг чангалахаар мөн Гэр бүлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг ингэж цогц байдлаар нь оруулж ирж байгаа нь бас сайшаалтай байна аа. Энэ хуулиуд бүгд хоорондоо уялдаатай. Гэр бүлийн тухай хууль дээр нэгд манай хүн амын өсөлт, төрөлт ер нь ямар байна вэ? Ер нь сүүлийн үеийн залуучуудын гэрлэлтээ бүртгүүлж байгаа залуу хосуудын гэдэг юм уу дундаж наслалт ер нь ямар байна вэ? Сүүлийн үед ажиглаад байхад бас ер нь энэ Монгол залуучууд ер нь их хожуу гэрлэх ийм байдал түгээмэл болж байгаа гэж яригдаж байгаа.

Энэ нь өөрөө нийгмийн олон зүйлийн шалтаг шалтгаантай гэж ингэж яригдаж байгаа. Та бүхэн шалтаг шалтгааныг нь хэлбэл энэнээс юунаас болж ингэж гэрлэх дундаж наслалтад их оройтож байна гэж бид ингэж үзэж байна. Эцэг эх байх үүргээс, хариуцлагаас бас зайлсхийх энэ чиглэл рүүгээ хандаж байна уу гэж. Энэ дээр нэг та бүхэн ямар судалгаа тооцоо байна вэ? Гэр бүлийн тухай хуулиар эцэг, эх байх үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд эцэг эхчүүдэд оногдуулах хариуцлагыг Зөрчлийн тухай хуулиар албадлагын журмаар Эрүүгийн хуулиар эд нар ямар хариуцлага хүлээж байна вэ?

Өөрсдөө хариуцлагагүй байдлаас эцэг эхийнхээ үүргийг биелүүлээгүйн улмаасаа гаргасан, хүүхэд хохирсон эрүүл мэнд амь насаараа сэтгэл санааны энэ тохиолдолд хариуцлагыг хэрхэн яаж

чангаруулж байгаа юм бэ? Яг яаж чангаруулна л гэж яриад байна. Яг яаж чангаруулж байгаа юм гэдгийг нэг тодорхой хэлж өгөөч? Удмын сангийн асуудлаар чухал заалт орж ирж байгаа. Ургийн овог гэдэг нэг юм байна аа. Энэ иргэний үнэмлэх дээр нэг ургийн овог гээд 1990 онд ингээд бий болсон. Удмын сангаа хамгаалах талаар хамгийн их үүх түүхтэй улс бол манайх шүү дээ. Уг нь түүх яривал.

Гэтэл 1990 онд ургийн овогтой байна гээд нийтээрээ зүгээр ингээд нэг бэлэн бэлэг төдий хэлбэр төдий ингээд бүгдээрээ Боржигон гээд авчихсан. Бараг одоо дийлэнх олонх нь Боржигон овогтой явж байгаа байх. Цаашидаа энэ удмын санг хүн амын удмын санг хамгаалах цус ойртолтоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хамгийн чухал асуудал чинь энэ иргэний бүртгэл дээр байгаа энэ ургийн овгийн асуудал байгаа юм. Энийг цаашидаа нэг цэгцлэхгүй бол одоо энэ талаар хүмүүс ойлголттой болсон. Ураг төрлийн хүмүүс хоорондоо гэр бүл болохгүй байх ёстой юм байна. Ургийн овгоороо энийг мэдэх ёстой юм байна гээд ингээд. Тийм учраас энэ одоо Хууль зүйн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас цаашидаа энэ ургийн овгийн талаар бас тодруулаач. Асуудал оруулж ирээч.

Иргэний бүртгэл дээр байгаа энэ ургийн овгийг цаашидаа жинхэнэ утгаар нь амьдралд хэрэгжүүлж чадвал уг нь энэ нэг угийн бичиг хөтөлнө гээд л ингээд л байна. Одоо та нар хууль дээрээ ураг төрлийн хүмүүс гэрлэхийг хориглоно л гэж байна. Яг яаж хориглох юм. Суучихсан байгаа тохиолдлууд зөндөө байна шүү дээ. Алслагдсан бүс нутгуудад. Тэгээд энийг болиулах юм уу, салгах юм уу? Эсвэл одоо энэ чиглэлийг гэрлүүлэлтийг нь хориглоно гэхээр одоо тэгээд яах юм. Яг ямар арга хэмжээ авчихсан юм авах юм. Энэ дээр нэг та бүхэн хэлээч. Гэр бүл болохоосоо илүүтэй бас гэр бүл цуцлалт нь их байна гээд яриад байгаа, үнэн. Бид нар ингээд өнгөрсөн энэ

хугацаанд эмэгтэйчүүд, эмэгтэйчүүд гэж ярьсаар байгаад хүний эрх гэж ярьсаар байгаад эмэгтэйчүүдийн эзэмисэн боловсрол мэргэжил чинь эрчүүдээсээ давамгай болоод эхэлсэн байна шүү дээ.

Энэ гэр бүл цуцлах асуудалд чинь гол нөлөөлж байгаа зүйл би энэ гэж харж байгаа юм.

**Л.Мөнхбаатар:** Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Булгантуяа сайд хариулах уу? Булгантуяа сайд хариулъя.

**Х.Булгантуяа:** Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя аа.

Ер нь жилд нийтдээ нэг 20 орчим мянган гэр бүл бүртгүүлж байна. 2022 онд гэхэд нэг 17 мянга орчим гэр бүл бүртгүүлсэн салалт бол 4500 орчим. Ер нь гэр бүл болж байгаа хүмүүсийн бараг 4 гэр бүл тутмын бараг нэг нь ер нь ингээд салж байна гэсэн ийм тоо баримт байна гэсэн үг. Энэ гэр бүлийн байсан хугацаагаар нь аваад үзэх юм бол 10 жил орчим дотор л ингээд л салаад байгаа байдал нийтдээ 30 хувь нь байна. Тэгээд үлдсэн 70 хувь нь яах вэ? Түүнээс урт удаан хугацаагаар гэр бүл болж бас амьдарч байна гэсэн ийм тоон үзүүлэлтүүд ер нь байна аа.

Гэр бүлийн салалтын гол шалтгаануудыг аваад үзэхээр яах вэ ганцхан эмэгтэй нь өндөр боловсролтой ч байдаг юм уу байгаагаас гэхээсээ илүүтэйгээр дандаа эдийн засгийн асуудлууд байгаад байна. Гэр бүлийн тулгамдаж байгаа асуудал гэхэд залуу гэр бүлийн хувьд 50.8 хувь нь ажлын байр, 22.5 хувь нь орон сууц, 16.3 хувь нь орлого нэмэгдүүлэх боломж бололцоо хэрэгтэй байна аа. Амьдралынхаа наад захын хэрэгцээг хангаж чадахгүй байгаа хүмүүс аз жаргалтай хамтын амьдралыг үүсгэнэ гэдэг үнэхээр хэцүү байна аа. Ингээд 35-аас 49 насныхны хооронд гэхэд бас л

санхүү, эдийн засаг, боловсрол гэдэг энэ асуудлууд байнга яригддаг асуудлууд.

Гэхдээ манай гэр бүлийнхэн маань ер нь бол бас ч гэж 11.5 хувь нь гэр бүлийн уламжлалт угийн бичгийг хөтөлдөг, 13 хувь нь удам намтраа сайн мэднэ 64.8 хувь нь ерөнхий мэдлэгтэй, 22.2 хувь нь огт мэдэхгүй гэж хариулсан байна. 29.3 хувь нь төрөл садантайгаа байнгын ойр дотно харилцаатай, 36.3 хувь нь холбоотой, 21.8 хувь нь зөвхөн баяр ёслол, хурим, оршуулга гэсэн тэмдэглэлт үйлээр л бид нар холбогддог гээд. 5.1 хувь нь бид нар ямар ч холбоо байхгүй гэж ер нь хариулсан байна.

Гэр бүлийн бид нар ингээд эрхэмлэдэг зүйл дээр ач холбогдол өгдөг дээр ингээд харахад хосууд бол гэр бүл болохдоо удам гарлыг 57 хувь нь маш хардаг, харилцаа хандлагыг 49 хувь нь хардаг гэсэн байна. Тэгэхээр бас ч гэж энэ уламжлалт Монгол гэр бүлийн энэ асуудлуудыг гэр бүл болоход чухалчилж авч үздэг нь өнөөдрийг болтол бас харагдаж байна аа. Гэхдээ хүчирхийлэл гэр бүл дотор өндөр байна. Манай нийт хүүхдүүдийн хүчирхийлэлд өртөж байгаа байдлыг харахад 70 хувь нь гэр бүл дотроо байна.

Тэгэхээр Хүүхэд хамгааллын тухай хуулийг Төрийн Одонтуяа дарга бас асууж байсан. Хамтад нь хэлэлцэх ёстой юм биш үү гээд. Ерөөсөө л хүүхдийн эсрэг үйлдэгдээд байгаа гэмт хэргийн 70 хувь нь гэр бүл дотроо байгаад байгаа юм Гэр бүлийн тухай хуультай хамтад нь авч хэлэлцэхээс өөр аргагүй болчихоод байгаа юм аа. Тэгээд энэ хүчирхийллийн хувьд гэр бүлийн согтууруулах ундааны хэрэглээний байдал гэхэд гэр бүлийн бараг 32 хувь нь гэр бүлд нь дор хаяж нэг гишүүн согтууруулах ундаа хэрэглэдэг гэж хариулсан байна.

Тэгэхээр бид нар тогтвор суурьшилтай гэр бүлийг бий болгоё гэх юм бол охидуудын боловсролыг бууруулах биш

согтууруулах ундаатай л тэмцэх ёстой юм байна. Энэ бол бид нарын номер нэг асуудал, нэгдүгээрт.

Хоёрдугаарт тогтвор суурьшилтай гэр бүлүүдээ бид нар ипотек.

**Л.Мөнхбаатар:** Сандаг-Очир гишүүний асуултад нэмж хариулъя. Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 89 дүгээр микрофоныг өгье.

**Н.Өлзийхутаг:** Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Өлзийхутаг байна аа. Би энэ Сандаг-Очир гишүүн нөгөө гэрлэлтийн дундаж наслалтын талаар асуусан байгаа. Тэгэхээр анхны гэрлэлтийн дундаж наслалт бол одоо Үндэсний статистикийн хороогоор жил бүр энэ статистик тоо гардаг. Тэгэхээр эрэгтэй 26-наас эмэгтэй 24 насандаа бол бас хүмүүс гэр бүл болж байна гэсэн ийм статистик мэдээлэл байгаа.

Ургийн овогтой холбоотой хэн хариулах вэ? Дээр нь бас Сандаг-Очир гишүүн нэг ийм зүйл асуугаад байна шүү дээ тэ. Ургийн овгийн ихэнх нь боржигон байна гээд байна. Тэгэхээр Боржигон овогтой хэдэн хүн байна хүн амын хэдэн хувь нь байна тэрийг бас нэмээд хариулчих.

Солонгоо сайд хариулах юм уу? Ажлын хэсгийн 81 дүгээр микрофон. 81 дүгээр микрофоныг өгье.

**Б.Солонгоо:** Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Тэгээд бас хүүхэд төрөлттэй холбоотой статистик мэдээлэл болон ургийн овгийн бүртгэлтэй холбоотой мэдээллийг бас манай Иргэний улсын бүртгэлийн газрын төлөөлөл хариулна.

Эрүүгийн хууль дээр бас асран хамгаалах үүргээ зөрчсөн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх заалт өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. Тэгэхлээр хүүхдээ бас асран хамгаалах үүргээ биелүүлээгүй асран хамгаалагчид эрүүгийн хариуцлага хүлээх заалт байдаг. Мөн бас Зөрчлийн хууль дээр тодорхой бас заалтууд байдаг яг хариуцлагын тухайд бол.

**Л.Мөнхбаатар:** Иргэний бүртгэлээс хариулах уу? Хэддүгээр микрофон байна наадах чинь. Ажлын хэсгийн 95 дугаар микрофоныг өгье. Сандаг-Очир гишүүний асуултад нэмээд хариулчих.

**Н.Наранцэцэг:** УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газрын ахлах мэргэжилтэн Наранцэцэг байна. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Төрөлт ер нь бол жилийн нэг дундаж төрөлт бол ерөнхийдөө 70 мянга орчим бол байдаг. 2023 оны 10 сарын өссөн дүнгийн байдлаар бол нийтдээ 56639 хүүхэд төрсөн. Үүнээс эрэгтэй хүүхэд бол 29044, эмэгтэй бол 27595 хүүхэд төрсөн байж байгаа. Ер нь Тайланд сарын хугацаанд бол төрж байгаа төрөлт нийтдээ 5400 орчим хүүхэд бол төрөлт бүртгэгддэг. Ургийн овгийн хувьд ерөнхийдөө бас таны хэлдэг үнэн л дээ. Монголчуудын ихэнх нь Боржигон гэсэн ургийн овгийг бол авсан байдаг. Гэхдээ сүүлийн үед иргэд маань ургийн овгоо буруу тогтоосон байна энийгээ зөвтгөө өө гэсэн асуудлуудыг бол маш их тавьдаг.

Тэгэхээр зэрэг Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлээр бол иргэний овог эцэг эхийн нэрийг өөрчлөх ийм боломжийг нь бол зохицуулж өгсөн байдаг. Тухайлах юм бол иргэн үе уламжлан ирсэн овог эцэг эхийн нэрээ өөрчлөх хүсэлтээ гаргаад өөрийнхөө нөгөө бусад гэр бүлийн гишүүдтэйгээ бол адилтгаад овог, эцэг, эхийн нэрээ солих ийм боломж нь бол хуулиар бол тогтоогдсон байж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Наранцэцэг дарга тодорхой хариулчихлаа. Яах юм та тодруулах юм уу? Сандаг-Очир гишүүн тодруулж асууя.

**Ц.Сандаг-Очир:** Тэгэхээр энэ гэр бүлийн чиглэлээр Ерөнхий боловсролын сургууль сургалтын хөтөлбөрт ерөөсөө ганцхан иргэний ёс зүй гэдэг хичээл орж байгаа шүү. Булгаа сайд аа, Энх-Амгалан сайд аа. Ер нь цаашдаа энэ гэр бүл, үнэ цэнэ, эцэг эхийн үүрэг хариуцлага энэ чиглэлээр бас ерөнхий боловсролын хичээлийн сургалтын хөтөлбөрт энэ чиглэлийн сургалтуудыг оруулж байж багаас нь тэр ирээдүйд эцэг эх байх юм гэдгийг нь ойлгож ухамсарлуулж ямар үүрэг хүлээх юм гэдгийг нь ойлгуулах энэ чиглэлийн ажлыг нь үе шаттайгаа Ерөнхий боловсролын сургуулиас нь эхэлж явж байхгүй бол өнөөдрийн ганцхан Иргэний ёс зүй гэдэг хичээлээр энэ чиглэлийн асуудлыг ингээд даатгаад орхиж болохгүй шүү гэдгийг нэгд хэлье.

Нөгөө талаар би хэлэх гэж байсан санаа бол энэ. Эрчүүд маань өнөөдөр үндсэндээ орхигдож ирж байна шүү Булгаа сайд аа. Эмэгтэйчүүдээсээ болсоор байгаад эмэгтэйчүүдээ гээд аав ээж нь хүүхдүүдээ мэдлэг боловсрол сургуульд явсаар байгаад банди нараа орхигдуулсаар байгаад.

**Л.Мөнхбаатар:** Сандаг-Очир гишүүн байр сууриа илэрхийлж үг хэллээ.

Хүрэлбаатарын Булгантуяа сайд асуулт асууя.

**Х.Булгантуяа:** Би хэдэн санал хэлэх гэсэн юм. Нэгдүгээрт манай өрхийн тоо нийтдээ 942 мянга орчим өрх улсын хэмжээнд бүртгэгдэж байна. Түүрүүн хэлсэнчлэн хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэргийн 70 гаруй хувь нь гэр бүлдээ байна гэдэг бол бид нар гэр бүл болгонд л нэг нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын ажилтан, ажилтнууд дунд



бол манай өрх дотор үйлдэгдэж байгаа энэ хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй бид нар тэмцэхэд их хэцүү байна аа.

Тэгэхээр бид нар энэ Гэр бүлийн тухай хууль маш чухал ач холбогдолтой. Эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх ёстой гэдэгтэй бол санал нэг байна аа. Сайшаалтай тоо гэх юм бол өрх толгойлсон ганц бие эцэг эхийн тоо 2018 онд 92 мянга орчим байсан бол одоо 82 орчим мянга болж бас буурсан ийм тоон үзүүлэлттэй. Гэхдээ манай хүүхэд хамгааллын төвүүдэд байж байгаа хүүхдийн тоо эрсдэлд байгаа хүүхдийн тоо төдийлөн сайн буурч өгөхгүй байна аа. Тэгээд дээрээс нь нэмээд бид нар ингээд бодохдоо энэ эцэг эх байх энэ үүрэг хариуцлагыг зөвхөн энэ албан боловсролоор олгох биш, албан бус байдлаар эцэг эхчүүд бид нар, томчууд бид нар хүүхдүүдээ их үлгэрлэмээр байгаа юм.

Энэ чинь хүүхдүүд маань сургууль, цэцэрлэг дээрээ нэг 4-өөс 6, 7 цэцэрлэгт 8 цаг л байгаа. Бусад бүх цагийг эцэг эх бид нар хажууд байгаа. Бид нар үе тэнгийн дээрлэхэлтийн тухай сая том аян явуулахад хүүхдүүд тэгж хэлж байна шүү дээ. Урдаас нь та нар өөрсдийгөө бие биеийгээ хайр найргүй дээрлэхдэг юм байна лээ шүү дээ. Сошиалаар бие биеийгээ хэлэх хэлэхгүйгээр хэлдэг юм байна лээ шүү дээ. Тэгсэн мөртөө бид нарыг болохоороо бие биеийгээ битгий дээрлэх битгий муухай үг хэрэглэ, бие биеийгээ хайрла гэж хэлэх юм. Та нар өөрсдөө энүүнийгээ үлгэрлэх ёстой юм биш үү гэдэг шиг бид нар энэ гэр бүл доторх ялангуяа үүрэг хариуцлагыг бас нэмэгдүүлмээр байна аа.

Би түрүүн хэн Жаргалмаа гишүүний асуултад бас жоохон дутуу дулимаг хариулчих шиг боллоо. Энэ манай ахмад настнуудыг асран хамгаалах асуудал манай Гэр бүлийн тухай хууль дээр бас туссан. Тэгэхдээ үүнийг бас чангаруулах хэрэгтэй байгаа. Асран

хамгаалах үүргээ хөгжлийн бэрхиээлтэй иргэн хөгшин настай хүмүүс өөрөө өөрийгөө асран хамгаалах боломжгүй энэ хүмүүст гэр бүлийн гишүүд нь үзүүлэхгүй бол Зөрчлийн тухай хуулиар торгодог байж байгаа юм. Хувь хүнийг гэхэд 200 нэгжээр, ААН-ийг гэхэд 2 мянган нэгжээр гээд ингээд торгуулийн бас юунууд байгаа. Санциууд байгаа. Тэгэхдээ энэ бас төдийлөн сайн хэрэгжихгүй байна. Энхбаяр сайд өмнө нь ХЗБХ-ны дарга байхдаа хүний эрхийн тайланг хэлэлцэхэд ялангуяа ахмад настны эрх зөрчигдөж байгаа асуудлаар бас их тайлан мэдээлэл дээр дурдаж ярьж байсан.

Тэгэхээр энэ асуудлыг магадгүй ажлын хэсэг дээр нэлээн чангаруулж оруулж өгөх шаардлага бас байж магадгүй. Үнэнийг хэлэхэд манай асрамж хамгааллын төв дээр сүүлийн үед хүүхдийнхээ мөнгийг цуглахаар буцаж ирээд эцэг, эх байх эрхээ сэргээлэгчиддэг хүмүүс их байна аа. Энийг яах вэ? Нэгдүгээрт.

Ингээд л юу яангуут 4, 5 сая төгрөгтэй болонгуут нь ирээд хүүхдийнхээ мөнгийг эцэг эх байх эрхээ сэргээлэгчдэд хүүхдийнх нь мөнгийг ганц хоёрхон сарын дотор авч үрчхээд тэгээд буцаад хүүхдээ аваачаад өгчихдөг, нэгдүгээрт.

Хоёрдугаарт өмнөх эцэг эх гэр бүлтэй байхдаа эцэг эх байх эрхээ хасуулчхаад, дахиад эцэг эх болчихдог. Тэгээд өмнөх хүүхдүүдээ асран хамгаалах үүргээ биелүүлээгүй, хүүхдийнхээ мөнгөн тэтгэмжийг төлөхгүй байгаа хүмүүсийг яагаад дахиад эцэг эх байх гэрлэлтийг нь бүртгээд байдаг юм бэ? Энийг яах ёстой юм бэ энэ чинь хуулийнхаа өмнө эхлээд өөрийнхөө 2, 3 хүүхэд, 4, 5 хүүхдийн эрхийг нь бид нар үүрэг хариуцлагыг нь хүлээлгэх ёстой биз дээ? Энэ асуудлыг манайг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хууль дээр юу гэж оруулж өгсөн юм бол? Би сая асрамжийн төвийнхөнтэй уулзаж байхад энэ асуудлыг бүр тусгайлан асуугаарай



гээж та бүгдээс надад энэ хүсэлтийг уламжилсан юм асуултыг.

**Л.Мөнхбаатар:** Булгантуяа сайд санал хэллээ. Хэн хариулах юм? Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Солонгоо хариулъя.

**Б.Солонгоо:** Гэр бүлийн тухай хуулийн бас үндсэн зарчим үзэл баримтлал бид хүүхдийн эрхийг нэн тэргүүнд хамгаалах асуудал тавигдаж байгаа. Тэгээд Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын хүүхдийн эрхийн конвенцод бас хүүхдийн эрхийн бас суурь эрх нь гэр бүлийн орчинд өсөж хүмүүжих эрх байгаа. Тэгээд Гэр бүлийн тухай хуулийн төслийн маань 3.9-д шүүх хүүхдийн гэр бүлийн орчинд өсөн хүмүүжих эрхийг нэн тэргүүнд хамгаална. Тэгээд хүүхдийн эрх, хүүхдийн хууль, ёсны ашиг сонирхол, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор зөвхөн зайлиггүй тохиолдолд энэ эрхийг хязгаарлаж болно гэж заасан. Тэгэхлээр эцэг эх байх эрхийг хязгаарлах хасах асуудал маань бас бидний хувьд хамгийн сүүлчийн арга хэрэгсэл байхаар хуулийн төсөлд тусгасан байгаа.

Тэгээд үүнээс өмнө бас холбогдох нийгмийн үйлчилгээг төрөөс үзүүлдэг байх эцэг эхэд дэмжлэг үзүүлэх холбогдох асуудлууд болон нийгмийн бодлогын хүрээнд тодорхой дэмжлэгүүдийг төрөөс үзүүлэхээр тусгасан. Эцэг эх байх эрхийг хасах гэдэг маань хүний үндсэн эрхийг хасаж байгаа асуудал байгаа учраас бас Гэр бүлийн тухай хуульд энэнтэй холбоотой асуудлыг дэлгэрэнгүй тусгасан.

Ямар үндэслэлээр хасаж болох вэ? Ямар үндэслэлээр сэргээж болох вэ гээд. Тэгэхлээр ер нь бол хүүхэд эцэг эхтэйгээ байнгын харилцаатай байх эрхийг бол бид нар хамгаалах, баталгаажуулах нь бас нэн тэргүүний зорилт байх ёстой. Тэгэхээр энэ зорилтын хүрээнд бол Гэр бүлийн тухай хуульд бол хүүхэд гэр бүлийн орчинд өсөж хүмүүжиж, том болох

эрхийг хамгаалах үндсэн үзэл баримтлалтайгаар хуулийн төсөл маань боловсруулагдсан.

**Л.Мөнхбаатар:** Асуулт асууж, хариулт авлаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

**Б.Пүрэвдорж:** Гэр бүлийн тухай хуулийн 3.3-д Монгол Улсад эрэгтэй хүн нэг эхнэр, эмэгтэй хүн нэг нөхөртэй байна гэсэн ийм заалт байгаа. Дээрээс нь 9.3.7 дээр гэрлэгсэд нь бие биедээ үнэнч байна. Гэр бүлийн тогтвортой байдлыг тууштай байлгана гэсэн ийм л заалттай. Тэгэхээр энэ заалт нь юуг илэрхийлж байна вэ гэхээр нөгөө нууц амраг, араар тавиулалт энэ тэр чинь хуулиар хорьсон зүйл шүү гэдгийг, агуулгыг илэрхийлж байгаа байхгүй юу даа. Өөрөөр хэлбэл энэ хуулиар хориглосон зарчмыг илтгэж байгаа.

Гэтэл энэ нууц амраг, араар тавилтаас болоод жилд 6 мянган хүн гэр бүлээ цуцлуулахаар өргөдөл өгч байгаа. Тэгээд энэнээс 10 мянган хүүхэд хагас өнчин болж хоцорч байна. Тэгэхээр энэ араар тавилтын улмаас энэ гэмт хэрэг гэж үзэж байгаа учраас энэ гэмт хэргийн улмаас хүүхэд маш их хохирч гэмт хэргийн объект болж байна. Тэгэхээр энэ дээр би нэг зарчмыг хэлэх гээд байгаа юм. Ингээд эхнэр нөхөр 2 нэг нь араар тавилаа гээд нөгөөдөх нь хоёулаа ингээд салж байгаа. Тэгэнгүүт аль буруутай нь хохирол төлж байгаа ийм зарчим энэ хууль дээр орчхож. Гэтэл зүв зүгээр тогтвортой байсан тэр гэр бүлийг нэг нөхөр янз янзын уулзъя учиръя гэж байгаад нөгөө эхнэртэй нь ч юм уу, нөхөртэй нь ч юм уу асуудал үүсгээд тэгээд тэр гэр бүл салж байгаа байхгүй юу. Тэгэхээр нөгөө нэг асуудал үүсгэсэн тэр хүнийг нь хариуцлага тооц гэсэн механизм энэ дээр ерөөсөө байхгүй байна. Тэгээд энэ 92.1 дээр болохоор энэ хуулийг зөрчсөн хүнд зөрчлийн болон эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэж байгаа юм.

Тэгэхээр нөгөө нэг сайхан ингээд амьдраад явж байсан тэр гэр бүлийг гаднаас ирж бусниулж байгаа тэр нөгөө нэг нууц амрагт нь яаж хариуцлага тооцох вэ? Тэрийг Эрүүгийн хуулиар бас яллаж тэр гэмт хэргийн хохирогч тэр хүүхдүүдийг нийгэмд бий болгомооргүй байна шүү дээ. Энэ асуудлыг яаж шийдвэрлэх юм.

**Л.Мөнхбаатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Солонгоо хариулна аа.

**Б.Солонгоо:** Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя.

Тэгээд Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах явцад бид нар бас нийгмийн оролцогч талуудтай хэлэлцүүлгүүдийн өргөн хүрээнд зохион байгуулсан. Манай яамны цахим хуудсан дээр Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг энэ оны 6 сараас хойш байршуулж олон нийтэд санал авсан. Тэгээд ирүүлсэн 400 гаруй саналын 90 орчим хувь нь энэ гэр бүлийн тогтвортой байдлыг хамгаалах гэр бүлийн гадуурх харилцааг бас зохицуулах шаардлагатай байна гэсэн саналуудыг иргэдийн зүгээс өгсөн.

Тэгээд үүнтэй холбогдуулаад бас Гэр бүлийн тухай хуульд нэг заалт орсон нь тухайн хуулийн төслийн 9.4-д гэрлэгчдийн хэн нэгний буруутай үйлдлээс шалтгаалж гэрлэлт цуцалсан нь нөхөр эсхүл, эхнэрийн эрх нэр төр алдар хүндэд хохирол учруулсан бол иргэний хуульд заасны дагуу хохирогч тал гэм хорын хохирол нөхөн төлүүлэх нэхэмжлэл шүүхэд гаргах эрхтэй гэсэн бас тодорхой зохицуулалт тусгасан. Тэгэхээр Иргэний хуулийн 497-д гэм хор учруулснаас үүсэх хариуцлагыг бас тос тодорхой заасан байдаг.

Тэгэхлээр бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, сэтгэцэд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй гэсэн бас хуулийн заалт байна. Тэгэхээр энэ гэм хор учруулсантай холбоотой бас тодорхой бас шүүхийн шийдвэрүүд гарсан жишээ байдаг. Тэгээд энэ одоо зохицуулалттай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг манай ажлын хэсгийн судлаач доктор Амарсанаа бас дэлгэрүүлж хариулт өгөх боломжтой.

**Л.Мөнхбаатар:** Нэмж хариулъя. Ажлын хэсгийн 82 дугаар микрофоныг өгье.

**О.Амарсанаа:** Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн гишүүн Амарсанаа.

Гэр бүлээс гадуурх харилцаанаас болж гэр бүл цуцлагдсан нь буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага ялангуяа гуравдагч этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой юу гэж асуугаад байгаа. Тэгээд энэ гэр бүлээс гадуурх харилцаанд бол олон улсын туршилагаар эрүүгийн хариуцлага хүлээлгэж ирж байсан уламжлал бол байдаг. Гэхдээ энэ маань өөрөө эрүүгийн хариуцлага гэдэг бол ялангуяа төрийн эрүүгийн бодлого бол тэр гэмт хэрэг үйлдэл маань тодорхой, үйлдэл нь өөрөө гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэх зайлшгүй ийм хэлбэртэй байх ёстой тэгээд энэ үүднээсээ ялангуяа өнгөрсөн үед энэ эрүүгийн хариуцлага хүлээлгэж байсан улсууд бол тухайн хувь хүний эрхийг зөрчиж байна, суурь эрхэд нь халдаж байна гэдэг үндэслэлээр ерөнхийдөө татгалзсан байдаг.

Хамгийн сүүлд Бүгд Найрамдах Солонгос улс 2015 онд Үндсэн хуулийнхаа шүүхээр энэ эрүүгийн хариуцлага хүлээлгэж байсан асуудлыг Үндсэн хууль зөрчсөн буюу хувь хүний суурь эрхэд халдаж байна гэдэг үүднээс хүчингүй

болгосон байдаг. Гуравдагч этгээдэд тэгвэл ямар эрх зүйн хариуцлага ийм хүлээлгэх боломж байна вэ гэхээр өнөөгийн манай Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн дагуу эдийн бус гэм хорыг бас яах вэ хохирогч тал шүүхэд нэхэмжлээд түүнийгээ бас нөхөн төлүүлэх ийм боломж байгаа. Энэ дээр зөвхөн тэр буруутай гэрлэгчийн аль нэгнээс гадна нөгөө гэрлэгчдийг бол гэр бүлтэй эсэхийг нь бол мэдсээр байж байж мөн санаатайгаар энэ харилцаанд орж гэр бүл цуцлагдах үндэслэл болсон гэдгийг үзээд мөн хохирогч тал өөртөө тодорхой хэмжээний эдийн засаг, гэм хор учирсан гэж үзэх юм бол шүүхэд нэхэмжлэл гаргаад.

**Л.Мөнхбаатар:** Нэмж хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн сайд Энхбаяр нэмж хариулъя.

**Б.Энхбаяр:** Манай Пүрэвдорж гишүүн араар тавьсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг бас хөндөж байна. Тэгэхээр хайр сэтгэл хуульчлагддаггүй асуудал байгаа. Бид энэ ёс суртахууны үүрэг гэж хуульдаа бичсэн. Энэ цэвэр ёс суртахууны асуудал. Хуульчилж болдог, хуульчилж чаддаг, хуульчилж огт болдоггүй бас нэг харилцаа байна. Бид хайрыг харж мэдэрч чадахгүй. 2 гэр бүлийн хос нь 3 дахь хүн рүү харсныг бид хайр юм уу, шохоорхол юм уу, дурлал юм уу, бүү мэд шүү дээ. Энийг бол дотор нь орсон хүн бол би мэдэхгүй, харж болохгүй гэж хууль бичиж болохгүй. 3 дахь хүнийг чи харж болохгүй хазаж болохгүй эд нар гэж бичиж болохгүй шүү дээ энэ чинь, хууль чинь. Тийм учраас энийг эрхэм гишүүн маань бас ойлгож хүлээж авах байх гэж бодож байна аа.

**Л.Мөнхбаатар:** Энэ ч бас онолын асуудал болоод явлаа шүү. Дуламдоржийн Тогтохсүрэн төсвийн байгууллагын хуралтай байгаа тийм ээ. Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл асуултаа асууя.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа манай улс 1973 онд Гэр бүлийнхээ тухай хуулийг баталсан, 1999 онд шинэчилсэн найруулга хийсэн. Тэгэхээр энэ хугацаанд бол нийгмийн амьдрал, сэтгэл зүй олон зүйл өөрчлөгдсөн л дөө. Тэгээд энэ өөрчлөлтөө бол хуулиа уялдуулах шаардлага байгаа. Тийм ч учраас Улсын Их Хурал дахь 13 эмэгтэй гишүүн Гэр бүлийн тухай хуульд статистик судалгаанд үндэслэн нэг асуудлыг нэлээн бас барьж авч хөндөж хуулийн төсөл өргөн барьсан. Энэний үндэслэл нь юу байсан бэ гэвэл гэр бүлд салалт их байна. Тухайлбал жилдээ нэг 3-аас 4 мянган салалтын асуудал байна аа. Эмэгтэйчүүд эхчүүд гэр бүл салалтын үеэр бас хохирч байна. Ямар нэгэн өмч хөрөнгөгүй ер нь хоосон салж байгаа.

Тэгээд энэ нь бол цаашидаа амьдрах, амьжиргааны түвшний асуудал, ядуурал руу орох гээд олон асуудлыг дагуулж байгаа тухай статистик судалгаанд үндэслэн энэ хуулийн төслийг бид нар өргөн барьсан. Тухайлбал манай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар жил бүр хүүхдийн мөнгөн тэтгэмжийн төлөлтийн талаар судалгаа хийж олон нийтэд мэдээлдэг бас ийм сайн дэвшилттэй талтай юм билээ.

Тухайн үед бид нарыг хуулийн төслийг өргөн барьж байхад бол нийтдээ 34 тэрбум төгрөгийн тэтгэмж бол төлөгдөөгүй байсан. Одоо харин нэг тэтгэмж төлөлт нэлээн 30, 40 хувьтай өндөр байгаа тухай хэлж байна. Бид нарыг хуулийн төсөл өргөн барьж байхад бол ерөөсөө төлөлт 20 хувьтай, 80 хувь нь хүүхдийнхээ тэтгэмжийг төлөөгүй гэдэг ийм мэдээллийг ШШГЕГ-аас өгч байсан юм. Тэгээд энэ мэдээллүүдтэй уялдуулан бид нар тухайн иргэний орлоготой уялдуулан тэтгэмж тогтоох тухай асуудлыг хөндсөн.

Солонгоо сайд маань орлоготой уялдуулан тэтгэмж төлдөг байх заалтыг орууллаа гэж хэлж байна лээ. Би хувь

хэмжээгээ сонирхож байна, нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт бидний өргөн барьсан хуулийн төсөлд ямар санал байсан бэ гэвэл тэтгэмжээс гадна, хүүхэд хүндээр өвдөх, осол гэмтэлд өртсөн үед нэмэлтээр тэтгэмж өгөх тухай асуудлыг хөндсөн. Энэ асуудал маань хэрхэн яаж орсон бэ? Ер нь орлоготой уялдуулахгүй бол хүүхдийн тэтгэмжийн асуудал үнэн санаа зовмоор шүү дээ. Амьжиргааны баталгаажих түвшинтэй уялдуулдаг. Амьжиргааны баталгаажих түвшин гэж юуг хэлдэг вэ гэвэл Улаанбаатар хотод сардаа 277 мянга хавьцаа, хөдөө орон нутагт 238 мянган төгрөг сардаа авдаг тийм орлоготой бол амьжиргааны баталгаажих доод түвшний орлоготой байна гэж үздэг. Тэгээд энэ мөнгөнийхөө 50 хувийг хүүхдэд өгдөг байхгүй юу. Тэгэхээр ерөөсөө хөдөө орон нутагт 115 мянга Улаанбаатарт 277-ийн 50 хувь нь хэд байна тэр хэмжээний мөнгийг л тэтгэмж гэж өгч байгаа юм.

Тэгэхээр энэ хүүхдийн амьдрал, тэр ээжийн амьдрал юу болох вэ юу болж хувирах вэ гэдэг асуудал маш тулгамдсан асуудал байгаа учраас бид нар энэ асуудлыг тавьсан. Тэгээд би энэ хариултуудыг нэгдүгээрт авна.

Хоёрдугаарт, Жендерийн үндэсний хорооноос бас энэ Гэр бүлийн тухай хуульд нэлээн анхаарал хандуулж байгаа. Үндэсний хороо маань ямар асуудалд анхаарал хандуулж байгаа вэ гэвэл хүүхдийн тэтгэмжийн асуудлыг бол бид нар ярьчихлаа. Ингээд хуульчлах гэж байна. Харин эмэгтэйн хувьд, тэр ээжийн хувьд, эдийн засгийн хувьд ямар ч баталгаа байхгүй, орон байргүй, унаа малын асуудлыг бүүр орхиё. Үндсэндээ ингээд хов хоосон салж байгаа. Гэр бүлдээ хамгийн гол үүргийг гүйцэтгэсэн байдаг.

Тэгэхээр энэ эмэгтэйн асуудлыг ер нь хуульд ямар байдлаар тусгаж байгаа

вэ? Эдгээр асуултдаа эхлээд хариулт авъя. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Сарангэрэл гишүүний асуултад ажлын хэсэг хариулъя. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье.

**Б.Солонгоо:** Сарангэрэл гишүүний асуултад хариулъя.

Тэгээд бас тантай санал нэг байна. Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль дээр бас энэ тэтгэлгийн хэмжээг тухайн бүс нутгийн амьжиргааны доод түвшний хэмжээгээр тогтоосон нь бас хүүхдийн эрх зөрчигдөх хүүхдийн амьдрах нөхцөл чанар дордох сөрөг талуудтай. Тэгээд дэлхийн бусад улсуудын жишигийг дагаад хуулийн төслийн шинэчилсэн найруулга 47 дугаар зүйлд маань шүүх тэтгэлгийн хэмжээг тэтгэлэг төлөгчийн эд хөрөнгө орлого, тэтгэлэг авагчийн хэрэгцээ шаардлага зэрэг нөхцөл байдлыг харгалзан талуудын амьдралын чанарыг доордуулахгүйгээр тэтгэлэг тогтоох аргачлалын дагуу тогтооно гэсэн заалт орсон. Тэгэхээр энэ аргачлалыг бол гэр бүл, хүүхдийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг харгалзан Улсын дээд шүүхээс батлахаар заасан. Тэгэхлээр бас ХБНГУ болон бас Европын бусад улсуудын жишигээс харахад шүүхээс энэ аргачлалыг тогтоосон жишиг их байдаг.

Тэгэхээр бас тухайн орон нутгийн онцлог, талуудын орлого хэрэгцээ шаардлагаас үндэслээд энэ орлогоос хамааруулж аргачлалаар энэ тогтоодог болох жишиг хуулийн төсөлд туссан. Гэхдээ зөвхөн цалингийн орлоготой тэтгэлэг төлөгчийн хувьд бол энэ тэтгэлгийн хэмжээ яг сарын цалин хөлсний 50 хувиас хэтрэхгүй байна гэдэг заалтыг тусгасан. Мэдээж амьдралд бас олон нөхцөл өөрчлөгдөж болно. Тэгэхлээр бас гэнэтийн одоо тохиолдол гарсан. Ялангуяа тэтгэлэг авагч хүндээр өвдсөн,



хүүхэд одоо өвдсөн гэх мэтчилэн асаргаа шаардлагатай болсон сургуульд орсон зэрэг бас онцгой нөхцөл байвал нэмэлт тэтгэлэг гаргуулах асуудлыг шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдүүлж болохоор хуулийн төсөлд дурдсан.

Тэгэхлээр тэтгэлэг авагч хүндээр өвчилсөн эс үгүй бол хөгжлийн бэрхшээлтэй болсон эс үгүй бол байнгын асаргаа шаардлагатай, эсвэл сургуульд орсон зэрэг онцгой тохиолдолд тэтгэлэг төлөгчөөс нэмэлт тэтгэлэг эсвэл зардал хариуцуулахаар бас сонирхогч тал шүүхэд нэхэмжлэл гаргаж болно гэж заасан.

Сонирхогч талын маань тодорхойлолтыг бас хуулийн төсөлд дэлгэрэнгүй тусгасан байгаа. Нэмэлт тэтгэлэг одоо зардлын хэмжээ нь тухайн тэтгэлэг төлөгчийн эд хөрөнгө санхүүгийн нөхцөл байдал мөн бас тэтгэлэг авагчийн бодитой нөхцөл байдалд хэрэгцээ шаардлагад нийцэх ёстой гэсэн бас хуулийн заалтыг тусгасан. Тэгээд бас гэр бүл салсан тохиолдолд эмэгтэй тал нь бас хохирч үлдэж байна гэдэг бас асуудал сая хөндөгдлөө. Тэгэхлээр бас гэр гэр бүлийн маргаан шүүхээр шийдвэрлэж байгаа тохиолдолд шүүхээс бас шийдвэрлэж байгаа нэг асуудал бол гэрлэгчдийн дундын эд хөрөнгийг хуваарилах асуудал байдаг.

**Л.Мөнхбаатар:** Сарангэрэл гишүүн тодруулж асууя.

**Д.Сарангэрэл:** Тэгээд Солонгоо дэд сайдын хариултад бол би бас сэтгэл хангалуун байна аа. Яагаад гэвэл манай эмэгтэйчүүдийн өргөн барьсан хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яам маань Гэр бүлийн тухай хуульд нэлээн сайн тусгасан байна. Тэгэхдээ нөгөө орлоготой уялдуулж тэтгэмж өгнө гэдэг асуудлыг шүүх шийднэ. Өөрөөр хэлэх юм бол нэг аргачлал байх юм байна. Одоо бол хэлэлцэх эсэхийг нь ярьж байгаа учраас яг нэгдүгээр хэлэлцүүлэг дээр та бүхэн

маань аргачлалын талаар олон нийтэд бас нэлээн дэлгэрэнгүй мэдээлэх тал дээр анхаараарай гэж хүсэж байна.

Хоёрдугаарт яг эмэгтэй хүний тухайд та нар маань түрүүн мэдээллийг сонссон байх тиймээ. Өрх толгойлсон 79 мянган эмэгтэй 20 мянган эрэгтэй байгаа. Тэгээд 79 мянган эмэгтэйн тухайд асуудал нэлээн хэдийгээр хууль эрх зүйн орчноор бид нар өрх толгойлсон ээж аавууддаа тэтгэмж өгч байгаа ч гэсэн энэ бас л мөн их бага хэмжээтэй байгаа. Тэгээд Жендерийн үндэсний хорооноос энэ эмэгтэйчүүдтэй холбоотой 10 тодорхой санд олон улсын жишигт нийцүүлэн та бүхэнд өгөх юм байна лээ. Тэгээд энэ асуудлыг бас нэлээн сайн харж үзэж бид нарын өгсөн жишигээр хуулийнхаа төсөлдөө бас.

**Л.Мөнхбаатар:** Сарангэрэл гишүүн бас санал хэллээ. Пүрэв-Очирын Анужин гишүүн асуултаа асууя.

**П.Анужин:** Баярлалаа. Хуулийн төслийг бол үзэл баримтлалын хувьд дэмжиж байна. Гэр бүлийн тухай хууль бас сүүлийн он жилүүдэд 8 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон хэдий ч энэ нь яг уг хуулийг дагалдах хуулиудтай холбоотойгоор орсон. Ийм өөрчлөлтүүд. Яг утга чанарын гол өөрчлөлтүүд ороогүй ирсэн гэдгийг бол ойлгож байгаа. Тийм учраас Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг үзэл баримтлалынх нь хувьд дэмжиж байгаа юм аа. Тэгээд надаа 2 санал байна. Ялангуяа Их Хурлын дэд даргад хандаж хэлэхэд энэ Гэр бүлийн хууль маань өөрөө гэр бүлийн харилцаан дахь үүрэг хариуцлагыг хуульчилж байгаагаараа энэ талаасаа бол илүү Хууль зүйн байнгын хороо хийгээд тиймээ энэ холбогдох Байнгын хороогоор явж байгаа. Гэтэл гэр бүл гэдэг маань өөрөө нийгмийн бодлогын гол цөм тиймээ нийгмийн өөрөө үнэт зүйл, нийгмийн харилцааны гол асуудал гэдгээрээ Нийгэм бодлогын байнгын хороогоор энэ хууль заавал ч үгүй бас



хэлэлцэх ёстой юм биш үү гэсэн ийм саналтай байгаа.

Энэ саналыг ч гэсэн манай Байнгын хорооны гишүүд бас хэлж байгаа. Үүнийг би бас уламжлахыг хүсэж байна. Тэгэхээр бас энэ ажлын хэсэгт ч гэсэн зөвхөн Хууль зүйн байнгын хороо биш Нийгмийн бодлогын байнгын хорооноос хамтарсан ийм том хэмжээний ажлын хэсэг гаргаж байж бодлогын хувьд тийм гэр бүл маань хэдий үүрэг хариуцлагын асуудал ч гэсэн нөгөө талдаа саяын миний дурдсан нийгмийн цөм үнэт зүйл. Тийм гэр бүл гэдэг чинь өөрөө улс доторх жижиг улс жижиг, институц гэдэг утгаараа бид том хүрээнд нь авч харах ёстой юм аа. Ийм учраас энэ дээр цаашидаа анхаарч өгнө үү гэдгийг бас хэлэхийг хүсэж байна.

Хоёр дахь нь Улсын Их Хурлын эмэгтэй гишүүдийн өргөн барьсан төсөлд тэр орлогоос нь хамаарч хүүхдийн тэтгэмжийг тогтоох тухай бид нар маш тодорхой оруулж ирсэн. Энэ бид нарын оруулсан яг тодорхой санал маань энэхүү хуулийн Засгийн газраас өргөн барьсан хуулийн төсөл бол тийм өгүүлбэр төдий цаашидаа яг тодорхой хэрэгжинэ гэхэд тийм байдал харагдахгүйгээр ингэж орж ирсэн байна аа.

Тэгээд түрүүн Учрал гишүүн бас хэлж байна аа. Ерөөсөө гэр бүл гэдэг чинь хамтын үнэ цэнэ. Хамтдаа бүтээсэн үнэ цэн байхгүй юу. Тэгээд энэ нь ямар нэгэн шалтгаанаар байхгүй болсон тохиолдолд тэр хамтдаа бүтээсэн үнэ цэнийнхээ хаана нь ч хүрэхгүй зүгээр нэг жишиг мөнгө аваад тэрийгээ тэгээд өгсөн өгөөгүй явна гэдэг бол бид нар үнэхээр энэ хариуцлага хүлээлгэж чадахгүй байгаа. Энэ хуулийн бас нэг шийдэгдэх ёстой нийгэмд хүлээлттэй байгаа гол зүйлийг бид шийдэж чадахгүй юм аа. Тийм учраас ажлын хэсэг анхаарч энэ дээр бас тодорхой зүйл заалтуудыг оруулж ирнэ байх гэж ингэж бодож байна.

Баярлалаа асуулт байхгүй надад.

**Л.Мөнхбаатар:** Тодорхой саналууд хэллээ. Анужин даргын гаргаж байгаа саналууд бас тодорхой үндэслэлтэй байна. Тийм болохоор шинэчилсэн найруулгыг хэлэлцэх эсэхийг нь шийдсэний дараа ажлын хэсэг байгуулагдаж ажиллана. Тийм болохоор Хууль зүйн байнгын хорооноос гадна Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдийг оролцуулсан Ажлын хэсгийг байгуулж ажиллуулъя. Тэр ажлын хэсэг дээр шаардлагатай гэж үзэх юм бол Нийгмийн бодлогын байнгын хороогоор бас хэлэлцүүлэх боломжтой гэдгийг бас хэлье гэж бодож байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүн Наянтайн Ганибал асуултаа асууя.

**Н.Ганибал:** Сая манай МАН-ын бас нэлээдгүй гишүүд л асуугаад байна л даа. Энэ цус ойртолтын асуудал, энэ овгийн бичиг хөтлөх асуудал гээд. Энэ яагаад эд нар асуугаад байгаа юм бэ гэхээр одоо 2020 онд Улсын Их Хурлын гишүүн болохдоо мань хүмүүс яг ийм амлалт өгсөн байхгүй юу. Хүн бүр овгийн бичгээ хөтлөх, цус ойртолтоос урьдчилан урьдчилан сэргийлэх, удмын сангаа хамгаалах үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ гээд. Тэгээд харамсалтай нь 3 жил 5 сар боллоо. Энэ хөтөлбөр байхгүй. Энэ тухай ярьдаг яам хариуцсан салбар байхгүй болчихоод л энэ хүмүүс тэрийгээ нэхээд байх шиг байна л даа.

Тэгэхээр 7 сар үлдлээ. Тэгээд харамсалтай нь энэ хөтөлбөр хэрэгжүүлнэ гэдэг чинь бас тодорхой хэмжээнд санхүү мөнгө, төсөв мөнгөн дээр тавьж байгаад нэлээн компани т ажил болгож байгаад л хэрэгжүүлдэг байх. Тэгээд энэ удаа бол ямар ч байсан энэ тэр угийн бичгээ хөтлөх цус ойртолтоос урьдчилан сэргийлэх энэ үйл ажиллагаа хөтөлбөр бол хэрэгжихгүй нь бол тодорхой болчихлоо. Тэгэхээр энэ дээр гишүүд асуугаад байгаа нь угаасаа зөв л дөө зөв. Ер нь тэгээд өөрсдийнхөө

бас амласан амлалтаа одоо олон нийтдээ бас 7 сарын дараа тайлагнах гэж байгаа хүмүүс бас энэ асуудлаа яриад байгаа нь бас зөв байх.

Ер нь зүгээр гэр бүлийн асуудал дээр Монголчууд түүн дотроо ер нь Ази хүмүүс ер нь тийм гэр бүлийн үнэт зүйл дээр өөрсдийнхөө амьдралын философио тавьдаг. Тэрүүгээрээ дамжуулж нийгмийн харилцаанд ч ордог ийм асуудал бусад тивүүдийнхнээс ялгаатай. Нэн ялангуяа Европчуудаас ч гэдэг юм уу тэ. Тэгэхээр Монголчуудын хувьд бол энэ уламжлалт гэр бүлийн асуудал нь өнөөдөр яг бид бүхний амьдралын гол үнэт зүйл болоод явдаг. Энэнээс гажсан, энэнээс тодорхой хэмжээнд бидний уламжлалт тэр гэр бүлийн харьцаанаас өөр байдлаар асуудал гарч байгаа тохиолдолд тэр асуудлуудыг Гэр бүлийн тухай хуулиараа хэрхэн шийдэх вэ гэдэг гол асуудлууд энэ дотор явж байгаа байх. Тэр нэг хэд хэдэн асуулт байна л даа. 11.2 дээр эхнэр нь жирэмсэн эс үгүй бол 3 нас хүрээгүй хүүхэдтэй бол гээд. Ингээд нэг хэд хэдэн заалт. Ийм бол гэрлэлтээ цуцлуулахыг зөвшөөрөөгүй бол гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлийг шүүх хэрэгсэхгүй болгоно гээд. Энэ дээр бид бүхэн бас ер нь зүгээр Монголын энэ уламжлалт гэр бүлээс гадуурх маш олон сэтгэл эмзэглэм үйлдлүүд их болж байгаа.

Тэгээд хэрвээ 3 нас хүүхэд нь хүрээгүй л бол тэнд эцэг эхийнх нь нэг нь дарамталж байгаа тохиолдолд тэр гэр бүл ямар ч байдалд салахгүй байх ийм байдал харагдаад байна л даа. Энэ дээр та бүхэн нэг хариултаа өгөөрэй.

39.1 эцэг эх байх эрхийг дараах тохиолдолд хасна гэж байна. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн тохиолдол гээд. Хэрвээ эцэг хүн хүүхдээ алгадсан бол энийг хүчирхийлэлд тооцох уу, үгүй юу гээд энэ дээр нэг хариулт авчихъя.

46.4 дээр эцэг эхийн хэн нэг нь гэрлэлтээ цуцлуулах үедээ хүүхдийн

тэтгэлэг тогтоолгохоос татгалзсан хүсэлтийг шүүхэд гаргах эрхгүй гэж. Ямар нэгэн байдлаар авахыг тэтгэлэг авахыг хүсээгүй ч байсан эс хүссэн ч одоо автоматаар тэр тэтгэлэг хариуцагч бол тэтгэлэг төлөх ийм нөхцөл үүсэж байгаа гэсэн заалт мөн үү гэж ойлгож болох уу? Энэ бол бас сайн л заалт байна л даа. Тэгээд энэ 3 асуудал дээрээ ямар ч байсан эхлээд хариулт авчихъя.

**Л.Мөнхбаатар:** Ганибал гишүүний асуултад хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Солонгоо хариулъя.

**Б.Солонгоо:** Энэ хуулийн ажлын хэсгийг хэнээр ахлуулах юм бэ? Ганибал гишүүний асуултад хариулъя.

Тэгэхлээр Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд бол тодорхой нөхцөлүүд хуульд заасан нөхцөлүүд байгаа тохиолдолд гэрлэлт цуцлахгүй байх асуудлыг шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдэхээр заалт орсон. Энэ нь нөгөө гэр бүлийн гишүүний илүү сул талыг хамгаалах зорилготой. Тэгэхлээр эхнэр нь жирэмсэн эсвэл 3 насанд хүрээгүй хүүхэдтэй эсвэл хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй эсвэл, гэрлэгчдийн хэн нэг нь хүндээр өвчилсөн, хөдөлмөрийн чадвараа хагас эс үгүй бол бүрэн алдсан тохиолдолд бол хэрвээ хариуцагч нь гэрлэлтээ цуцлуулахыг зөвшөөрөөгүй бол нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгоно гэж заасан.

Тэгэхээр хамгийн гол нь бас гэрлэгчдийн хэн нэг нь гэрлэлтээ цуцлуулах хүсэлт өгөөд нэхэмжлэх талаар хүсэлт өгсөн ч гэсэн энэ нөхцөлүүд байгаад гэрлэгчдийн нөгөө талд нь зөвшөөрөөгүй тохиолдолд шүүх гэр бүл цуцлах асуудлыг шийдвэрлэхгүй гэдэг заалт. Тэгэхлээр энэ нь бас гэр бүлийн харилцаанд байгаа илүү сул талыг хамгаалах зорилготой. Гэхдээ энэ нөхцөл байдал арилсан тохиолдолд бас

нэхэмжлэл дахин гаргаж болохоор бол заасан. Тэгээд ер нь талууд хүсэлт гаргасан эсэхээс үл хамаараад гэр бүл цуцлах тухай шүүхийн шийдвэрт хүүхдийн тэтгэлгийн асуудлыг заавал тусгах тусдаа амьдарч байгаа эцэг эхтэйгээ хүүхэд байнгын харилцаатай байх, уулзах, нөхцөлийг тусгахаар бас хуулийн төсөлд заасан. Энэ нь бол хүүхдийн эрх ашгийг хамгаалах зорилготой байгаа.

Тэгээд цаашидаа бас бидний хувьд бол анхаарах зүйл маань гэрлэлтээ бүртгүүлж байгаа эцэг эх маань яг хүүхдийн өмнө хүлээсэн энэ хамтын үүрэг хариуцлагаа бас хэрэгжүүлдэг байх асуудлыг шүүх бас шүүхийн шийдвэр гаргахдаа анхаарч үзэхээр тусгасан.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүд танхимдаа орж ирье санал хураалт явагдана.

Ганибал гишүүн тодруулж асуух юм уу тэ? Асуултад сайд нэмээд хариулчихъя. Хууль зүй, дотоод хэргийн сайд Энхбаяр хариулъя.

Дараа нь тодруулаад асуучих.

**Б.Энхбаяр:** Ганибал гишүүний яг энэ хөндөж байгаа заалтыг хууль хэлэлцүүлгийн шатанд бол бас бодох ёстой. Хууль санаачлагчийн хувьд бас санал нэг байгаа. Өөрөөр хэлбэл гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн бол эцэг эх байх эрхийг хасна гэдэг нь Зөрчлийн хуулиар шийдэгдсэнийг хэлж байна уу эсвэл гэмт хэрэг үйлдэж шийдэгдсэнийг хэлж байна уу гэдэг дээр бас ньюанс зааг ялгаа байгаа.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэдэгт бол одоо тэр ганцхан бие махбодод зодуур зовуур үйлдэхээс гадна сэтгэл санааны хүчирхийлэл ч багтаж явдаг. Эд хөрөнгийн хувьд хараат байдалд оруулах үйлдэл ч бас багтаж явдаг их өргөн хүрээтэй ойлголт. Тэр байтугай гэр

бүлийн дундын хэрэгцээний машинаа хэн нэгэндээ унуулахгүй өөрөө унаад байх чинь өөрөө гэр бүлийн хүчирхийлэлд тооцогддог, эд хөрөнгийн хүчирхийлэлд тооцогддог.

Тийм учраас энэ асуудлыг Ганибал гишүүний ярьж байгаа энэ ньюансыг бол бид юу гэж ойлгож байгаа вэ гэхээр энэ илүү ноцтой үйлдлийг л ойлгоно. Тэрнээс биш одоо хөнгөн гэж хэлэх юм уу одоо тиймээ ийм үйлдлээр шууд эцэг эх байх эрхийг нь хасаад хасаад явчихна гэвэл ийм асуудал байж болохгүй.

Тийм учраас энийг бол хэлэлцүүлгийн шатанд бас хууль тогтоогчид ажлын хэсэгтэй бас сайн ярьж тодотгох шаардлагатай гэдэг Ганибал гишүүний асуулттай би санал нэг байгаа.

**Л.Мөнхбаатар:** Тодруулъя, Ганибал гишүүн тодруулъя. Тэгээд дараа нь санал хураалттай байгаа гишүүд суудлаа эзлээрэй.

**Н.Ганибал:** Тэгэхээр түрүүн хэлээд байгаа юм л даа. Монголын уламжлалт гэр бүлийн энэ харилцаанаас гадуурх зохицуулалтыг л энэ хуулиар хийх оролдлого явж байгаа байх. Тэгээд хэт шууд хүний эрхийн гэдэг ч юм уу энэ бусад улс орнуудаас шууд хуулбарлах нь Монголд буцаагаад яг нутагших энэ боломж хэр байдаг юм доо. Тэрэн дээр та бүхэн маань бас анхааран хэдүүлээ бас энэ хуулиа эцэслэн хэлэлцүүлгийн явцад бас анхаарах шаардлага байна.

Хоёр дахь нэг асуулт байгаад байгаа юм аа. Ингээд гэр бүл гэдэг харилцаанд ороод салсны дараах зохицуулалтуудыг л маш сайн хийж байна л даа. Тэтгэлэг өгнө энээ тэрээ гээд. Тэгээд энэ чинь эргээд нөгөө сөрөг үр дагавар авчрах магадлал бас харагдаад байгаа юм. Хүмүүс гэр бүл болохгүйгээр хүүхэдтэй болох, нэг эсвэл гэрлэлтийн батлах авахгүй байх цаг хугацаагаа

уртасгах хамтран амьдрах гэдэг нэр томъёолол маань гэр бүлээсээ давсан ийм нэр томъёолол болоод зохицуулалтад орох ийм шаардлага гарах вий дээ гэдэг энэ болгоомж бас байгаа юм уу? Энгийг хууль дээр ер нь яаж тусгасан байгаа бол?

**Л.Мөнхбаатар:** Хамтран амьдрагчийн эрх зүйн байдлыг тодруулж асуугаад байх шиг байна. Солонгоо сайд хариулъя.

**Б.Солонгоо:** Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд гэрлэлттэй адилтгах харилцаа гэсэн шинэлэг зохицуулалт орсон байгаа. Тэгэхлээр бас гол зорилго нь хэрвээ хамтран амьдрагчдын одоо хамтын амьдралаас хүүхэд төрсөн бол дундын эд хөрөнгөтэй болсон бол тодорхой бас хуульд заасан нөхцөл шаардлага хангагдсан бол шүүхээс тухайн хамтын амьдралыг гэрлэлттэй адилхан тооцож болно гээд энэ хамгийн гол нь бас эд хөрөнгийн маргааныг одоо энэ хамтын амьдралаас үүссэн одоо энэ хөрөнгийн маргааныг шийдвэрлэх, нөгөө талаасаа хүүхдийг тэжээн тэтгэх үүргээ одоо бас эцэг эхчүүд яаж хариуцах вэ гэдэг асуудлыг бас шийдвэрлэхэд дөхөмтэй.

Гэхдээ мэдээж бид нар бол гэрлэлт бүртгүүлж албан ёсны бас гэр бүл болж байж одоо хамтын амьдралаа авч явахыг илүү урамшуулах зорилгоор тодорхой хязгаарлалтуудыг хуулийн төсөлд тусгасан. Тэгэхлээр хамтран амьдрагчдын хамтын амьдрал дуусах дуусгавар болох тохиолдолд бие биеэ тэжээн тэтгэх өв залгамжлах эрх үүрэг үүсэхгүй гэж тодорхой заасан байгаа. Тэгэхлээр бас цаашидаа бас бидний хувьд анхаарах зүйл маань мэдээж гэрлэлтээ бүртгүүлж хамтран амьдрахыг илүү дэмжсэн гэр бүлийн бодлогыг тусгасан байдлаар Гэр бүлийн тухай хуулийн үндсэн үзэл баримтлал байгаа гэдгийг бас тодруулж хэлье.

**Л.Мөнхбаатар:** Хариулт болчихсон уу тэ? Хамтран амьдрагчийн хувьд гэрлэлттэй адилтгах нөхцөлийг шүүх л тогтоох юм байна шүү дээ тэ?. Шүүхээр шийднэ гэж байгаа юм байна. Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Дэмжсэн 3, дэмжээгүй 3 гишүүн үг хэлж болно алга уу?

Тогтохсүрэн гишүүнээр тасаллаа. Үг хэлэх гишүүн Тогтохсүрэн гишүүнээр тасаллаа. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн үг хэлье.

**Д.Тогтохсүрэн:** Хуулийн төслийг дэмжиж байна аа. Энэ бас олон жил хүлээгдэж байгаа ялангуяа энэ хүүхэд, гэр бүлийн хамгаалах асуудал ярьж байгаа энэ цаг үед бол заавал хэлэлцээд баталчих шаардлагатай хуулийн нэг байгаа юм.

Нэгдүгээрт би ингэж бодоод байна. Энэ хуулийг энэ Хүүхэд хамгааллын хуультай нэлээн уялдуулж ярих хэрэгтэй байгаа юм. Нэг ажлын хэсэг байгуулах юм уу яах юм. Гэр бүлийг нь яриад нөгөө хүүхэд нь тусдаа өөр хуулиар яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ 2-ыг яаж уялдуулж аятайхан авч явах вэ гэдгийг бол нэг авч үзэх ёстой гэж бодож байгаа юм.

Хоёрдугаарт нь манай Хууль зүйн хорооныхон бодно биз. Дараагийн хэлэлцүүлэг дээр Нийгмийн бодлогын байнгын хороогоор бид нар хэлэлцүүлж явах хэрэгтэй байна шүү. Энэ чинь 2 талтай. Нэг талаасаа хэлэхэд эрх зүйн зохицуулалт хийж байгаа боловчиг нөгөө талаасаа нийгмийн асар том асуудал байхгүй юу. Тэр агуулгаар нь хандаж би бол Нийгмийн бодлогын Байнгын хороогоор дараагийн хэлэлцүүлэг эд нарыг бас хийлгэж байж юм уу хамтарч хурал хийж явбал илүү үр дүнтэй болов уу гэж бодож байна. Ажлын хэсгийг бол Байнгын хорооныхоор биш Их Хурлын даргын шийдвэрээр захирамжаар ажлын хэсэг гаргаж өөр Байнгын хороонд байгаа энэ



чиглэлийн гишүүдийг бас түлхүү оруулж нэлээн өргөн хүрээнд хэлэлцэж ярих нь зөв болов уу гэж ингэж бодож байна.

Хоёр дахь саналын хувьд бол хамгийн санаа зовоож байгаа асуудал бол энэ гэр бүл салалт л байхгүй юу. Тэгээд гэр бүл салж байгаа орчин нөхцөлүүд ямар байна вэ? Энийг яаж эрх зүйн хүрээнд нь зохицуулах вэ гэдгийг л их сайн бодож энэ хуулийг хийх ёстой гэж бодож байна. Нөгөө талаас нь юу байна вэ гэхээр энэ үр хүүхдээ эцэг эх болгож бэлтгэх ёстой асуудал байгаа юм аа. Энэ дээр ерөөсөө манай энэ эцэг эхчүүдийн үүрэг мэдлэг чадвар бол үнэндээ байдаггүй. Тэгээд энэ нь бас холбоотой байгаад байгаа юм аа.

Тийм учраас энэ дээр их анхаарах хэрэгтэй гэдгийг би 2 дугаарт нь хэлье гэж бодож байна.

Гурав дахь нэг тулгамдсан асуудал юу байна вэ гэхээр гэр бүл салалттай холбоотойгоор үүсэж байгаа юм бол нөгөө дагавар хүүхдийн тухай асуудал байгаа юм аа. Өнөөдөр хамгийн хэлмэгдэж байгаа хүмүүс эд нар болж байгаа юм.

Тэгэхээр энэ хууль энэ хүүхэд хамгааллын хууль, Гэр бүлийн хууль 2-ыг хооронд нь уялдуулаад энэ хүрээндээ тэр салчихсан ч гэсэн тэр хүүхдээ хамгаалах, асрах өсгөж хүмүүжүүлэхэд нь оролцох оролцоог нь бий болгох чиглэлээр бол хуульд онцгой анхаарч тусгахад бол онцгой анхаарах хэрэгтэй байна гэдгийг хэлье. Тэгээд хуулийн төслийг бол дэмжиж байна.

**Л.Мөнхбаатар:** Тогтохсүрэн даргын үг хэлсэнтэй холбогдуулаад хэлэхэд түрүүн Анужин Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга бас санал гаргасан. Эдгээр хуулиудыг Гэр бүлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын хуулийг хоорондоо уялдаатай ийм хууль байгаа учраас нэгтгээд хамтад нь бас хэлэлцээд явъя. Ажлын хэсгийг Хууль зүйн

байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хорооны хамтарсан ажлын хэсэг байгуулъя. Уг асуудлыг Хууль зүйн болоод Нийгмийн бодлогын байнгын хороогоор аль аль дээр нь хэлэлцэх нь зүйтэй гэж үзэж байгаа. Ер нь Нийгмийн бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хүн амын хөгжлийн бодлогын асуудал өөрөө багтдаг. Тийм учраас энэ эрхлэх асуудлынх нь хүрээнд байгаа учраас 2 Байнгын хороогоор хэлэлцэх нь зүйтэй гэж үзэж байна.

Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явагдана.

Байнгын хорооны саналаар Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураая.

Санал хураалт.

58 хувиар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт



бэлтгүүлэхээр Хууль зүйн болон Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжжүүлээ.

*Дараагийнхаа асуудалд оръё.*

*Төсвийн байнгын хорооноос өмнө 32 санал хураалт байгаа шүү. Яах юм түр завсарлах юм уу? Юмаа хэлэлцээд явж байвал яасан юм бэ? Тэгье.*

#### 14.13 цагт

*Дараагийнхаа асуудалд оръё. Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.*

*Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна аа.*

*Таныг индэрт урьж байна.*

*Энэ хооронд Төсвийн байнгын хороо хуралдаж байна.*

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

*Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал*

*2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжжүүлсэн билээ.*

*Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны 2023 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 12 дугаар тогтоолоор дээрх хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэгт бэлтгэл ажил хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнээр ахлуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Б.Бейсен, Ц.Идэрбат, Ц.Туваан нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажилласан.*

*Байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна аа.*

Үүнд:

*Олон улсын худалдааны чөлөөт байдлыг дэмжих болон улс, бүс нутагт тархсан тархсан өвчнөөс хамгаалах тэмцэх зорилгоор хамгаалалттай аж ахуйд мөрдөх био хамгааллын нийтлэг зааврыг мал амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дарга өвчин тус бүрээр батлах хамгаалалттай аж ахуйн дээрх зааварт нийцүүлэн өөрийн үйл ажиллагаанд мөрдөж био хамгааллын зааврыг дагаж мөрдүүлэхээр тусгасан.*

*Гаалийн байгууллага улсын хилээр нэвтрүүлсэн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний талаарх мэдээллийг тогтоосон хугацаанд Хүнс хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар хүргүүлнэ.*

Эрсдэлийн үнэлгээг Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх бүхий ажилтан гүйцэтгэдэг байх зэрэг нийт 33 зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Ц.Туваан, Г.Ганболд, Ц.Батжаргал, Н.Наранбаатар Б.Бейсен, Ш.Адьяа нарын хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёололтой холбогдуулан асуулт асууж хариулт авсан болно. Байнгын хороо ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж санал хураалт явуулсан бөгөөд зарчмын зөрөөтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн

хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Энхбаатарын Цолмонжаргал, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Аюушжавын Нарантуяа байна уу? Мал эмнэлгийн ерөнхий газрын Хяналт баталгаажуулалтын газрын дарга Басангийн Батсүх, Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсийн дарга Гончигжавын Батмөнх, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал эмнэлгийн бодлогын асуудал эрхэлсэн ахлах шинжээч Хөхөөгийн Алтангэрэл, Гаалийн ерөнхий газрын хорио цээрийн хэлтсийн Гаалийн улсын байцаагч Гончигдоржийн Шүрэнчулуун нар оролцож байна аа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу? Байхгүй байна.

Цогтгэрэл гишүүнээр тасаллаа. Та Мөнхцэцэг гишүүн орох юм уу? Аубакир гишүүнээр тасаллаа. Мөнхцэцэг, Аубакир гишүүн хоёрыг нэмье. Ширнэнбандийн Адьяаа гишүүнийг нэмье. Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

**Т.Энхтүвшин:** Баярлалаа. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хууль гэж байдаг. Энэ хуульд одоо шинэчилсэн найруулгыг оруулж ирж байгаа юм байна гэж бодож байна. Хуучин бол энэ үүргийг Мэргэжлийн хяналтын байгууллага гүйцэтгэдэг байсан. Одоо бол мэргэжлийн хяналтын байгууллага бол гаальд шилжиж очоод гаалийн байгууллага энэ гишүүний шалгалтын гэрчилгээг олгоод явж байгаа. Тэгээд энэ хуулийн өөрчлөлтийг үзэхээр энэ мал

амьтны эмнэлгийн гэрчилгээ болон ургамал, хорио цээрийн гэрчилгээг Хөдөө аж ахуйн яам болон Мал эмнэлгийн ерөнхий газар л олгохоор ингээд ороод ирсэн байна л даа.

Тэгээд энэ юу гэдэг юм хуучин гааль дээр олгож байсан юмыг заавал энэ Хүнс, хөдөө аж ахуйн яам олгох гээд байгаа нь ямар учиртай байгаа юм бэ? Заавал Хүнс, хөдөө аж ахуйн яам руу энэ функцийг шилжүүлдэг нь ямар үүрэг ач холбогдолтой юм? Нөгөө Хүнс, хөдөө аж ахуйн яамны Мал эмнэлгийн ерөнхий газар нь боловсон хүчний нөөц хэр хангалттай юм. Хуучин бид нар мэргэжлийн хяналтыг татан буулгаад яам яам руу нь шилжүүлсэн. Эсрэгээрээ аж ахуйн нэгж байгууллагууд байгууллагуудад энэ давхардал шалгалтууд улам их болсон шүү. Тэгээд энийг шинэчлэхийн оронд заавал юу гэдэг юм ингээд Хүнс, хөдөө аж ахуйн яам руу шилжүүлэх, Мал эмнэлгийн ерөнхий газар руу шилжүүлэх ер нь ямар учир шалтгаан байж байгаа юм? Ер нь бид нар бодлогын байгууллага дээрээ хяналт шалгалтыг авдаг. Салбарын байгууллагууд дээрээ ингэж хяналт шалгалтыг авдаг бол буруу юм байгаа шүү дээ. Хөндлөнгийн хяналт байж л энэ хяналт шалгалт үнэн зөв л явах ёстой юм.

Тийм учраас би одоо Болорчулуун сайдаас юу гэж асуух гээд байна вэ гэхээр энэ Мал эмнэлгийн ерөнхий газар чинь ер нь хүний нөөцийн асуудал хэр байж байгаа юм? Энэ гаальд ажиллаж байгаа хилийн мэргэжлийн хяналтын, хилийн хяналт шалгалтыг зохион байгуулдаг энэ гаалийн ажилтныг бүхлээр нь бүтцээр нь шилжүүлж авах гэж байгаа юм уу? Өөрсдөө зохион байгуулах ийм хүний нөөц байгаа юм уу?

Хоёрдугаар асуудал нь энэ гаалийн байгууллага экспорт, импортын гэрчилгээ олгохдоо ер нь яаж хүлээж авч олгож байгаа юм. Тийм удааширалтай олгоод үнэхээр үйл ажиллагаа нь явахгүй болоод ингээд Хүнс, хөдөө аж ахуйн яам авна

гэдэг ийм саналыг тавиад байгаа юм уу? Энэ асуудал дээрээ нэг тодорхой хариултыг бас хэлж өгмөөр байна аа. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Үйлдвэржилтийн байнгын хорооны дарга Энхтүвшиний асуултад хариулъя. Ажлын хэсэг хариулах уу, хэн хариулах вэ? Ажлын хэсгийн ахлагч Жадамбын Бат-Эрдэнэ хариулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя аа. Энэ гол нь яах вэ Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа. Нөгөөдөх нь, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд гол хууль нь бол энэ байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ хуульдаа үг, үсгээр нь хөөгөөд харлаа. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалт гэж байгаа байхгүй юу. Хорио цээрийн хяналт шалгалт. Энэ үед юу яригдах вэ гэхээр ургамал амьтны эрүүл мэндтэй холбоотой асуудал. Амьтны эрүүл мэндтэй холбоотой асуудал. Ургамалтай холбоотой хорио цээрийн асуудлууд яригдах байхгүй юу даа. Ингэхээр энд мэргэжлийн байгууллага ажиллах хэрэгтэй болчхоод байгаа юм.

Мэргэжлийн байгууллагын дүгнэлт хэрэгтэй болчхоод байгаа юм. Тэгэхээр мэргэжлийн байгууллагын дүгнэлт нь хаанаас гарах вэ гэхээр энэ асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага буюу Хөдөө аж ахуйн яам болж хувираад байгаа юм. Тэгэхээр Хөдөө аж ахуйн яам мэргэжлийн үүднээс малынхаа эрүүл мэндтэй холбоотой асуудал дээр нь тодорхой дүгнэлт өгөөд ургамлын хорио цээртэй холбоотой асуудалд тодорхой дүгнэлт өгөөд энэ дүгнэлтийг үндэслэж хилээр нэвтрэх

үеийн хяналтыг бол гаалийн байгууллага хийгээд байгаа юм аа.

Өнөөдрийн байдлаар бол энэ гаалийн байгууллага бол энэ мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг давхар хийгээд байгаа байхгүй юу даа. Тийм болохоор мэргэжлийн байгууллагынхаа дүгнэлт цэгнэлтийг бол Хөдөө аж ахуйн яам өөрөөр хэлбэл Болорчулуун дарга өөрсдөө хийг. Хилээр нэвтрэх үеийн хорио цээр нь бол яг тэр эдний гаргасан дүгнэлт бусад зарчмын дагуу бодлогын гаргасан бичиг баримтыг үндэслэж тэнд нь бол хяналт шалгалтаа хийг гээд. Өөрөөр хэлбэл нэг гар дээр бол хүргэж өгч байгаа юм л даа. Нэг гар дээр л очиж байгаа юм.

Өөрөөр хэлбэл мэргэжлийн байгууллага нь мэргэжлийнхээ үйл ажиллагааг л явуулах. Тэр тусмаа бид нарын өнөөдөр Монгол Улсад хамгийн нэн тэргүүнд хэрэгцээтэй байгаа проблем болоод хүндрэл болоод байгаа асуудал бол ерөөсөө махны экспорт шүү дээ. Одоо Монгол Улсын мах бол гадагшаага бол экспортод гаргахгүй байгаа. Ер нь бол хорио цээр нь бол тавигдсан Монгол мал өвчтэй гэсэн тодорхойлолт байж байгаа. Энэнээс үндэслээд маш тийм олон төрлийн хорио цээрийн асуудлууд дээр нь бол шийдвэр гаргаж байж ингэж байж мал болон түүхий эд мах бол гадагшаа гарч байгаа шүү дээ.

Тэгэхээр энэний ганц дүгнэлтийг ерөөсөө одоо энэ Монгол мал ерөөсөө жишээ нь мал ингээд төрснөөс хойш тэжээгдээд тэгээд нядалгаанд орон ортол энэ эрүүл мэндийн асуудал жишээ нь энэ мэргэжлийн байгууллага буюу мал эмнэлгийн асуудал хариуцсан энэ байгууллага л хариуцах ёстой болчихоод байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дүгнэлтийг мэргэжлийн байгууллага нь бол хийдэг байя. Яг жинхэнэ хилийн гарах нэвтрэх үеийнх нь хяналт шалгалтыг бол гаалийн байгууллага тухайн мэргэжлийн байгууллагын бичиг баримт дээр үндэслээд, тэр дүгнэлт дээр үндэслээд

хорио цээрийнхээ шалгалтыг хийгээд явдаг байя гэж ажлыг нь бол ингэж ангилж өгч байгаа юм аа.

**Л.Мөнхбаатар:** Гааль хариулъя. Хэд байна? Ажлын хэсгийн 82 дугаар микрофоныг өгье. Нэр албан тушаалаа хэлээд асуултад хариулаарай.

**Батмөнх:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Гаалийн ерөнхий газар Хорио цээрийн хэлтсийн дарга Батмөнх. Тийм энэ сүүлийн 3 жил Мэргэжлийн хяналтад байхаас авхуулаад энэ гаалийн хорио цээрийн үйл ажиллагааг хариуцаж байгаа нэгж бол саяын хэлж байгаа энэ импортын мэдэгдэл, экспортын гэрчилгээ юу бол ургамал амьтны гаралтай бүтээгдэхүүн дээр эдгээрийг олгож ажиллаж байгаа. Энэ сүүлийн 3 жил цахимаар материалыг хүлээж аваад шийдвэрлэж байгаа. Одоо ер нь бол нийт олгогдож байгаа гэрчилгээ, мэдэгдлийн хугацааг нь сүүлийн нэг жилийн байдлаар авч үзэхлээр 4 цагаас 8 цагийн хооронд бол үндсэндээ 93 хувийг нь бол олгосон байгаа. Ингээд цахимаар материаллаг ААН-ээс авч байгаа учраас цаг хугацаа болон газар нөхцөлөөс бол хамаарахгүй. Мөн гаалийн байгууллага өөрөө 18 газар хороотой. Энэ 18 газар хороогоороо энэ саяын импортын мэдэгдлүүдийг бол мөн цахимаар авч шийдвэрлэж байгаа учраас аж ахуйн нэгж, иргэдэд бол тухайн бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэдэд тухайн орж ирүүлж байгаа боомтоороо тэр гэрчилгээ мэдэгдлээ авах нөхцөл нь бүрдсэн энүүгээрээ хийгдэж байгаа учраас аж ахуйн нэгждээ бол чирэгдэлгүй явагдаж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Үйлдвэржилтийн байнгын хорооны дарга Энхтүвшин тодруулж асууя.

**Т.Энхтүвшин:** Гааль дээр олгож байгаа энэ ургамал хорио цээрийн гэрчилгээ болон малын экспортын



гэрчилгээ саадгүй олгогдоод явж байгаа. Цаг хугацаандаа цахимаар заавал энийг Хүнс, хөдөө аж ахуйн яам болон мал үржлийн газар руу шилжүүлэх шаардлага байхгүй гэж миний хувьд үзэж байгаа. Яагаад гэхээр гааль дээр юу гэдэг юм иж бүрэн ХАА-н лаборатори нь байж байна. Гааль дээр ажиллаж байгаа ажилтнууд нь дандаа мэргэжлийн олон жил ажилласан ийм гаалийн байцаагч нар байж байгаа. Мэргэжлийн хяналтын салбарт олон жил ажилласан хүмүүс шилжээд очсон байж байгаа шүү дээ. Харин эсрэгээрээ юу гэдэг юм энэ ХАА-н газар Хөдөө аж ахуйн яам болон энэ мал эмнэлгийн газарт бол яг боловсон хүчин бол энийг шийдээд явчих цахим ийм технологиуд нь байхгүй байгаа шүү.

Тийм учраас энэ асуудлыг юу гэдэг юм хуулиа нэгмөсөн нарийвчилж шинэчлэх нь л зүйтэй зүйтэй байх. Энийг заавал Хүнс, хөдөө аж ахуйн яам бол.

**Л.Мөнхбаатар:** Тодруулгад нэмж хариулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Болорчулуун хариулъя.

**Х.Болорчулуун:** Энхтүвшин гишүүний асуултад хариу хариулъя.

Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдаж салбар салбарын яамандаа салбарын хяналт ирсэн. Энэ нь ч ер нь ер нь зөв зүйтэй асуудал. Өмнө нь бол тийм байсан. Харин Мэргэжлийн хяналтын газар татан буулгагдахын өмнөх жил нь хилийн хяналт гээд хилийн хяналтыг нь зөвхөн салгаад гааль руу аваачсан. Энэ дээр гааль дээр тийм тусгайлан манай яамны харьяа мал эмнэлгийн лаборатори шиг ийм төвлөрсөн ийм лабораториуд байхгүй. Ер нь мэргэжлийн байгууллага хилээр гарч орох энэ ургамал амьтны гаралтай зүйл дээр хяналт тавих ийм эрхтэй хуульчлагдсан байдаг. Энэ нь бол Мал эмнэлгийн ерөнхий газар.

**Л.Мөнхбаатар:** Тодруулж асууя. Түүнд нь гүйцээгээд дараа нь хариулчхаарай. Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

**Т.Энхтүвшин:** Энэ ургамал хорио цээрийн гэрчилгээг яг хэн олгохоор энэ хуульчилсан байгаа юм? Яг хуулийг нь үзээд байхад энэ ургамал хорио цээрийн гэрчилгээг олгох газар нь бас тодорхойгүй юм шиг харагдаад байх юм. Тэгээд энэ дээр бас нэг тодорхой хариултыг хэлээд өгөөч.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсгийн ахлагч Жадамбын Бат-Эрдэнэ хариулъя. Шаардлагатай нэмж ажлын хэсэгт нэмж оруулж болно. Олон улсын энэ ургамал хорио цээртэй холбоотой энэ бичиг баримтуудыг мэргэжлийн байгууллагад шилжүүлж гээж байгаа шүү дээ. Тэгээд энэ 25.2 дээр олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ, ургамал, хорио цээрийн гэрчилгээг гээж байгаа юм. Хорио цээрийн хяналт эрүүл мэндийн үзлэг шинжилгээний дүн энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг харгалзан Хөдөө, аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төв байгууллага, яам. Нөгөөдөх нь мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус олгоно гэж байгаа юм.

Нөгөөтээгүүр бас тодруулаад хэлэхэд ер нь бол олон улсын байгууллагын хүрээнд энэ мал эмнэлгийнхээ асуудлыг бол мал эмнэлгийн мэргэжсэн байгууллагууд нь хариуцаад яв аа. Тэр хөндлөнгөөс мэргэжлийн бус хяналтын байгууллага энд гэрчилгээ өгөөд байдаг юм энэ чинь хаанаасаа ямар учиртай юм бэ гэсэн ийм л зүйлийг яриад байгаа байхгүй юу даа. Энэ Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийг хэлэлцэх явцад.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсэг нэмж хариулах юм уу? Хариулт хангалттай юу?



Одоо Чинбүрэн гишүүн асуултаа асууя.

**Ж.Чинбүрэн:** Надад бас хэд хэдэн асуулт байна аа. Нийгмийн эрүүл мэндийн салбарын шийдвэрлэх ёстой нэг асуудал энэ нянгийн тэсвэртэй чанар, антибиотикт тэсвэртэй чанар түүнчлэн мал амьтанд антибиотик хэрэглэснээс хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө чухал юм аа. Тэгэхлээр хамаа замбараагүй антибиотик хэрэглэдэг болсонтой холбоотой. Хүн ч ялгаагүй мал ч ялгаагүй энэ антибиотикийн хэрэглээ үнэхээр замбараагүй болсон. Энэнтэй холбоотойгоор антибиотикт тэсвэртэй нянгийн тоо ихэссэн. Энэ бол зөвхөн одоо хүний эрүүл мэндийн асуудал биш бас мал амьтанд хүртэл энэ том асуудал болж байна.

Энэтэй холбоотой замбараагүй хэрэглэж байгаа энэ антибиотикнуудыг нөгөө хэрэглэсний дараагаар биед нь үлдэц нөгөө антибиотик эмийн үлдэц тэгээд хүнсний бүтээгдэхүүн болоод хэрэглэх гэхээр баахан эм тан хэрэглэчихсэн малын мах идэж байгаа нь одоо худлаа биш. Үнэн болчихоод байна. Тэгэхлээр энэ асуудлыг энэ хуульд зохицуулж чадаж байна уу?

Хоёрт энэ мал амьтны эм бүртгэлтэй бүртгэлгүй, дураараа хэрэглэдэг энэ байдлыг энэ хуулиар зохицуулах зохицуулалт орсон уу? Энэ тал дээр хэлж өгөөч.

Хоёр дахь асуудал энэ вакцинжуулалтын асуудал байгаа. Тэгээд хамаа замбараагүй вакцинжуулалт антибиотикжуулалт нь мал аж ахуйг эдийн засгийн эргэлтэд оруулах, экспортыг нэмэгдүүлэх бодлогыг дэмжсэн арга мөн эсэхэд анхаарах цаг болсон. Тэгэхлээр бас зарим нэг судалгаа байна. Малын сүргийг бүгдийг нь вакцинжуулах нь зөв юм уу эсвэл тодорхой тоог нь вакцинжуулж өвчнөөс

сэргийлдэг байх нь зөв юм уу? Энэ тал дээр бас яг мэргэжлийн улсуудаас судалгаа байна уу? Энэ чиглэлийн зохицуулалтууд бас анхаарч байгаа зүйл байгаа юу?

Гурав дахь чухал асуудал бол бас энэ бид чинь энэ 70 сая малтай тэгээд малын эмчийн асуудлыг хувийн салбар руу ингээд хаячихсан. Энэтэй холбоотой бараг 80-аас 300 мянган малд нэг эмчтэй байна шүү дээ. Энэ маань өөрөө малыг эрүүлжүүлэх малыг эмчлэх энэ бодлого өөрөө алдагдаж байгаагийн нэг том жишээ. Ер нь нэг судалгаагаар бол 50 мянган малд нэг эмч байх шаардлагатай гэсэн тооцоо байдаг юм байна шүү дээ.

Тэгэхээр энэ чиглэлд энэ хууль маань энийг зохицуулах чиглэлд бас заалтууд орж малын эмчийг бэлтгэх тоог хангалттай байлгах чиглэлд анхаарсан зүйлүүд байна уу, энийг нэг ярьж өгөөч гэж.

**Л.Мөнхбаатар:** Чинбүрэн гишүүн асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 87 дугаар микрофон өгье.

**Х.Алтангэрэл:** Чинбүрэн гишүүний асуултад хариулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын Мал эмнэлгийн бодлогын асуудал хариуцсан ахлах шинжээч Алтангэрэл. Ерөнхийдөө Мал амьтны эрүүл мэндийн хуулиар бол ер нь эм бэлдмэлтэй холбоотой асуудал бол эм эмнэлгийн хэрэгслээр хүн эмнэлгийн хуультай нэг хуулиар ингээд зохицуулж явдаг. Одоогоор Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг мал амьтны эмийн хуулийн зохицуулалтыг тусад нь хуулийн төсөл бас боловсруулаад явж байгаа. Ерөнхийдөө Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 24, 25, 26 дугаар зүйл дээр бол эмийн үлдэгдэл бичил биетийн энэ тэсвэржилттэй холбоотой асуудлыг

зохицуулчихсан. Өмнө нь зохицуулаад ингээд тусгагдаад энийг хэрэгжүүлээд явж байгаа.

Дараа нь 2 дугаар асуудал нь вакцинжуулалттай холбоотой асуудал болохоор ер нь бол тархвар зүйн мал амьтны эрүүл мэндийн тухай хууль 2017 оноос хойш батлагдаад хэрэгжиж байгаа. Энэтэй холбогдуулаад бол ерөнхийдөө тархвар зүй евмологийн судалгаанд үндэслэж дархлаажуулалтыг хийгээд явж байна. Гоц халдварт шүлхий өвчний хувьд бол өнгөрсөн 2020 оноос хойш бид зөвхөн үхэр сүрэг дээрээ дархлаажуулалтын ажлыг зохион байгуулаад явж байгаа. Малын эмчийн нийтдээ улсын хэмжээнд 980 нэгж үйл ажиллагаа явуулж байна. Энд нийтдээ 1575 эмч ажиллаж байгаа. Нэг малын эмчид 60 мянган мал ноогдож байгаа. Цаашидаа энийг бас 40 мянга хүртэл стандартад бариулах бодлого зохицуулалтын арга хэмжээг бас авч хэрэгжүүлж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Хариулах юм уу? Нэмж хариулах юм уу? Ажлын хэсгийн ахлагч Жадамбын Бат-Эрдэнэ хариулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Чинбүрэн гишүүн асууж байгаа дээр бас нэг жоохон тодруулаад явчихъя гэж байгаа юм аа. Яг мэргэжлийн байгууллага эрүүл мэндийн асуудал хариуцаж явж байсны хувьд бол арай илүү ойлгох болов уу гэж бодоод байгаа юм. Түрүүний асуугаад байсан. Жишээ нь хилээр гарч байгаа Монгол Улсын иргэний эрүүл эсэхийг Гаалийн байгууллага тодорхойлох юм? Энэ хүн эрүүл гээд тодорхойлох эсвэл эрүүл мэндийн байгууллага тодорхойлох уу? Яг үүнтэй ижилхэн олон улсын байгууллагаас нэг юм асуудаг байхгүй юу бид нар. Гадагшаага гарч байгаа малын чинь эрүүл эсэхийг гаалийн байгууллага тодорхойлоод байдаг нь ямар учиртай юм бэ? Яг энэ эрүүл мэндийн асуудлыг хариуцсан мэргэжлийн байгууллага мэргэжлийн яам Болорчулуун гишүүн,

сайд тодорхойлох бус гаалийн байгууллага өмнөөс нь энэ мал эрүүл шүү энэ мал хүнсэнд хэрэглэж болно шүү гэдгийг чинь тайлбарлаад ийм магадалгаа өгөөд байдаг гэрчилгээ өгөөд байдаг чинь ямар учиртай юм бэ гээд гаднынхан чинь бас ойлгодоггүй байхгүй юу даа.

Тийм болохоор энэ энэний асуудлыг үнэхээр малынхаа эрүүл мэндийг хариуцаж байгаа яам бол энэ малаа гадагшаага экспортод гаргаж байгаа мах маань эрүүл юм шүү гэдгийг энэ мэргэжлийн байгууллага өөрсдөө тодорхойл гээд гаалийн байгууллагаас энэ зөвхөн тодорхойлох асуудлыг нь л авч мэргэжлийн байгууллагад нь өгч байгаа юм шүү. Хил дээр мэдээж хяналт шалгалтын асуудал хийх нь бол мэдээж гаалийн байгууллагадаа бол үлдэж байгаа шүү дээ.

**Л.Мөнхбаатар:** Та яах юм тодруулах юм уу? Чинбүрэн гишүүн тодруулж асууя.

**Ж.Чинбүрэн:** Би нэмэлт санал бас хэлэх гэж байна. Яг сая Бат-Эрдэнэ гишүүний хэлсэнтэй адилхан. Ер нь энэ үлдэгдлийн хяналтын тогтолцоог бий болгох явдал бол энэ сонголтын асуудал биш энэ бол зайлиггүй хийх ёстой. Энэ Хүнс, хөдөө аж ахуйн яамны харьяанд тухайн малын бүтээгдэхүүн өөрөө эрүүл юм. Энэ янз бүрийн антибиотик эмийн хэрэглээний үлдэгдэлтэй ийм бүтээгдэхүүн биш юм гэдгийг бүүр анхан шатан дээр нь тодорхойлдог байх. Энэ тогтолцоог бий болгохын тулд анхан шатны малын эмч нар хүртэл оролцдог байх. Ингэж байж бид ямар мал идэж байгаа, ямар мах, ямар хүнсний бүтээгдэхүүн идэж байгаа гэдгээ бид мэддэг байх хэрэгтэй. Жишээлэх юм бол ургамал ч гэсэн ялгаагүй шүү дээ.

Бордооных нь агууламж нь азотынх нь хэмжээ ихсэх нь өөрөө хавдар хүртэл үүсгэх нөлөөтэй шүү дээ. Тийм учраас ерөөсөө бид энэ хүнсний

бүтээгдэхүүнүүдийг үлдэгдлийг нь хянадаг энэ тогтолцоог яаралтай Монгол Улсад олон улсын стандарт нийцээнийг байгуулах бол энэ Болорчулуун сайдын хийх ёстой хамгийн том ажил гэж ойлгож байна. Ингэснээрээ бид ард иргэдээ эрүүл.

**Л.Мөнхбаатар:** Чинбүрэн гишүүн санал хэллээ шүү дээ сая. Болорчулуун сайд дэмжиж хариулъя.

**Х.Болорчулуун:** Чинбүрэн гишүүн түрүүнд ингэж асуусан. Энэ хууль дээр чинь хууль орсноороо ямар чанарын өөрчлөлт гарч байна аа. Энэ Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт орсноороо энэ хэлэлцэж байгаа асуудлаар бол энэ эрүүл бүс гэж ямар бүс вэ? Хамгаалагдсан аж ахуй гэж ямар аж ахуй вэ? Энийг тодорхой зааж өгсөн. Энэ эрүүл бүс хамгаалагдсан аж ахуй байж байж бүх өөрийн чинь хэлдгээр яг тэнд байгаа мал сүрэг махны хяналт яг мэргэжлийн байгууллагын хяналтад орно оо. Малын эмчийн хяналтад орно. Ингэснээрээ баталгаат мал мах гадагшаа экспортод гарах боломж бүрдэж байгаа юм гэдгийг бас нэмж хэлье. Ийм өөрчлөлт орж байгаа хуульд.

**Л.Мөнхбаатар:** Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Дашидондогийн Ганбат, Амгалангийн Адьяасүрэн нарын удирдлагаар Баянхонгор аймгийн Баянговь сумын ЕБС-ийн багш, ажилтан, Соёлын төвийн ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил амьдралд нь хамгийн сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе.

Наянтайн Ганибал гишүүн асуултаа асууя.

**Н.Ганибал:** Өнөөдрийн энэ хуулийн өөрчлөлтүүд маань арай цаг хугацаа хоцроод байна. Энэ чинь нөгөө мэргэжлийн хяналтаа байхгүй болгоод мал эмнэлэг маань хяналтаа бүрэн авах энэ боломжоор хангагдаад 2 жил болчихлоо. Харамсалтай нь өнөөдөр ингээд 2 жилийн дараа энэ хуулийг ингээд хэлэлцээд сууж байна гэдэг чинь. Засгийн газар тухайн үедээ хамгийн чухал асуудлыг шийдлээ хяналтыг салбар салбарт нь өглөө ингээд үйл ажиллагаанд ямар нэгэн хүнд сурталгүй явуулна гээд л ингээд л зарлаад л байсан. Эндээс ингээд эргээд харах юм бол махныхаа экспортыг тэр улаан буудай юуныхаа ургамлын экспортын асуудалдаа бид нар чинь ингээд хойрго хандаад эндээ жоохон дургүй ч байгаа юм уу ингээд байж байгаа юм шиг ийм л асуудал үүсээд байна л даа.

Ер нь зүгээр мал эмнэлгийн байгууллага маань бас босоо тогтолцоотой. Хуулиараа ингээд болсноос хойш хамгийн сүүлчийнхээ энэ өөр хууль дээр байсан хяналтынхаа тогтолцоог энэ хуулиараа бүрэн авах ийм боломжоор хангагдаж байна. Энэ маань өөрөө олон улсын нөгөө мал амьтны эрүүл мэндийн байгууллага буюу оуа-гийн тавьж байгаа хамгийн том шаардлагыг өнөөдөр бид нар ингээд биелүүлэх гээд өнөөдөр ингээд хэлэлцээд сууж байгаа нь зөв л дөө. Тэгээд энийгээ гаргачих юм бол бид нарт зөвхөн нэг 2 улсад мах экспортлох бусад бүтээгдэхүүнийг яг экспортод гаргах энэ боломжоо нэг 2 улсаар хязгаарлагдахгүй дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх энэ боломж л нээгдэнэ гэж харж байгаа. Цаашилаад бид нар хувийн мал эмнэлгийн энэ тогтолцооныхоо асуудал дээр бид нар энэ жоохон төрд байгаа юм шиг хайр халамжаа үзүүлмээр байна.

Зөвхөн хувийнх гээд л хаячих биш. Одоо ямар ч байсан нэг тарифыг нь нэмсэн юм байна. Тэнд одоо техникийн хүчин чадал боломжууд байвал тэрэн дээр яаж тусалж болох юм. Тэрүүгээр нь

тусалмаар байна аа. Тэгэхгүй бол хувийн мал эмнэлгүүд маань өнөөдөр бол ерөнхийдөө үйл ажиллагаа нь сайжраад хүн тэнд орон тоо нэмэгдээд мал эмнэлгүүд илүү олноор байгуулагдаж байвал тэнд яаж байгаа юм боломж байна гэсэн үг. Одоо бид нарт юу харагдаж байна вэ гэхээрээ мал эмнэлгүүд маань тоо нь цөөрөөд хөдөө очдог тэр малын эмч нар чинь байхгүй болоод байгаа нь энэ салбар чинь болохгүй байна л гэсэн дохио шүү дээ тэ. Тэгэхээр энэ асуудлуудаа хэдүүлээ ингээд бодитоор нь хараад яг тэр хувийнхаа мал эмнэлгүүдийг чадавхжуулах, сайжруулах энэ боломжийг төрийн юм шиг тэр анхаарлаа хандуулмаар байна. Тэгж байж өнөөдөр бид нарын Монгол Улсын хамгийн чухал бүтээгдэхүүн болох мал махныхаа асуудлыг бид нар шийдэх ийм боломж гарч ирж байгаа юм аа.

Хоёр дахь асуудал нь үнэхээр махны экспортоо бид нар сайн хийе гэж байгаа бол Монгол Улсаас мах авч байгаа тэр улс орнуудынхаа тэр вакциныг эм бэлдмэлийг ашигладаг болъё л доо. Яагаад заавал нэг ч килограмм мал мах авдаггүй тэр улс орны вакциныг хүчээр авчирч бид нар тариад байгаа юм бэ. Энийгээ бүүр анхаармаар байна. Энэ чинь 2 улсын мал эмнэлгийн протокол бие биеийнхээ хүлээн зөвшөөрөх энэ асуудал дээр давуу тал болно шүү энийг ер нь манай үе үеийн сайд нар маань энэ дээр бүүр хатуу байр суурь илэрхийлж байж бид нар харилцан ашигтай хамтын ажиллагаа гэдэг чинь энэ үгийг л хэлдэг байлгүй дээ бодвол. Тэгэхээр энэ дээрээ бас анхаармаар байна аа. Тэгээд энэ жилийн хувьд бас дулаанаас хүйтэн рүү шилжих огцом шилжилт эргээд өнгөрсөн жилийнхтэй адилхан боллоо.

Тэгэхээр малчдын маань хувьд маш хүндрэлтэй нөхцөл байдал бий боллоо. Тэгэхээр одоо энэ жилийн энэ мал мах бэлтгэлийн асуудлаа бид нар шуурхайлаад энэ хуулиа хурдан гаргаад энэ хүнд суртлуудаа улам хурдан байхгүй болгож

байж л бид нар цаашаа явах байх. Тэгээд ер нь зүгээр одоогийн байдлаар өглөө болгон хялмаалж байна. Хялмаалж хялмаалж зуд гэдэг. Өнөөдрийн энэ жилийн цасны эхний оролт бол энэ өвлийн нөхцөл байдлыг харуулдаг аа. Тэгэхээр малчид маань мал махаа бэлдэх, экспортод гаргах, үнэ цэнтэй байлгах асуудал дээр энэ хууль бас чухал ач холбогдолтой гэж бодож байна.

**Л.Мөнхбаатар:** Хариулъя. Ажлын хэсгийн ахлагч Жадамбын Бат-Эрдэнэ хариулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ хуулийн өөрчлөлт маань үндсэндээ бол Монгол Улсын эдийн засагт нэлээн том өөрчлөлт оруулах тэр тусмаа малчдын маань одоо мал мах нь зарагддаг байх үнэд орох энэ боломж бололцоог нээсэн ийм том хууль орж ирж байгаа юм шүү. Гишүүд маань бас энийг нэлээн зарим талаас нь бол бас ойлгож байх шиг байна. Ганибал гишүүн бас үнэнийг хэллээ. Яагаад гэхээр бас энэ салбарт ажиллаж байсан Хөдөө аж ахуйн яаманд ажиллаж байсны хувьд зовлон жаргал мэдэж байх шиг байна.

2018 онд Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийг миний бие ажлын хэсгийг нь ахлаад ингээд батлуулж байсан. Одоо энэ бүрэлдэхүүн баг бүрэлдэхүүн бүгдээрээ л бид ажиллаж байсан. Тухайн үед олон улсын мал эмнэлгийн газар байгууллагаас буюу оёогоос тавьсан шаардлага юу вэ гэхээр энэ малынхаа бүхэл бүтэн нядалгаанд орох хүртэлхийг эрүүл мэндийн асуудлыг энэ мэргэжлийн байгууллага нэгдүгээрт хариуцна.

Хоёрдугаарт гадагшаа экспортолохдоо та нар мэргэжлийн байгууллага эрүүл гэсэн баталгааг нь та нар өөрсдөө өг өө гэсэн ийм шаардлагыг тавьсан юм л даа. Ийм шаардлага угаасаа олон улсад тавигддаг. Гэтэл тухайн үед яг энэ 2018 оны батлаад бид нар батлуулж байсан хууль дээр мэргэжлийн



хяналтын байгууллагын лобби дэндүү явагдаад ерөөсөө тэр сертификат өгч байгаа импортын сертификат мэдэгдэл өгч байгаа энэ зүйлээ бол бид нарт одоо өөрөөр хэлбэл мал эмнэлгийн байгууллага яаманд өгөөгүй тухайн үед нь аваад л үлдчихсэн юм л даа. Тэгээд сүүлд бол мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдаад тэгээд бид нарт энэ асуудлууд нь нээлттэй болоод тэр лобби нь тасраад зогсоод одоо бол жинхэнэ эдийн засгийн бодит байдлууд бий болж байгаа байхгүй юу. Бодит хаалга үүд нээгдэж байгаа энэнээс.

Түүнээс биш хэн нэгэн эрх мэдлийг булаацалдаад нэгнээсээ нөгөө рүү авч байгаа асуудал биш юм аа. Энэ бол цаанаа эдийн засгийн маш том олон улстай харилцах хаалгыг нээж байгаа олон улсын оёо буюу тэр олон улсын мал амьтны эрүүл мэндийн асуудлыг хариуцсан байгууллага бол ерөөсөө зарчмууд тавьдаг. Та бүхэн хэрвээ малынхаа эрүүлийг баталж байгаа бол мэргэжлийн байгууллагууд энийгээ батал, тэр вакцинжуулалт, бүх зүйлүүдээ бол хий. Тэгээд энэнийхээ эрүүл гэдэг баталгааг мэргэжлийн байгууллага та нар өг гэсэн энэ том зарчим бол олон улсын хэмжээнд явагддаг. Тийм болохоор энэ олон зарчмуудыг бид нар Мал амьтны эрүүл мэндийнхээ тухай хуульд бол бүгдийг нь суулгачихсан байгаа. Нэг л зүйл дутуу байсан энэ бол энэ зөвхөн хорио цээрийн мал амьтантай холбоотой энэ бүтээгдэхүүн гадагшаа гарах, хил гаалиар гарах хорио цээрийн асуудал дээр л бид нар өнөөдөр энэ асуудлыг нь авч байгаа болохоос биш гаалийн эрхийг бол авчаж байгаа асуудал биш. Гаалийнхан бол тодорхой хэмжээний энэ мэдэгдлүүдээр энэ гэрчилгээжүүлэлтийг хараад энэ дээр үндэслээд л хяналт шалгалтаа хийгээд явах бүтэц бүрэлдэхүүнүүдээрээ бол цаашаа бол ажиллаад явах юм гэдгийг хэлье.

**Л.Мөнхбаатар:** АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл асуултаа асууя.

**О.Цогтгэрэл:** Энэ хуулийн утга агуулга, нэр бол бас их чухал хууль байна л даа. Мал амьтны гаралтай түүхий эдийг хилээр нэвтрүүлэх оруулах, гаргах тухай, тэгээд энэ хуулийн агуулгыг бас ингээд эргүүлээд харахлаар явсаар явсаар байгаад энэ хорио цээрийн зөвшөөрлийг хэн нь өгөх юм бэ гэдэг нэг ийм асуудал руу яваад нэг захиргааны ажил руу яваад л орчих шиг болох юм. Энэ гааль нь авах юм уу, Хөдөө аж ахуйн яам нь энэ зөвшөөрлийг авах юм уу? Яг л манай бүх хуулиуд л нэг ийм л юм болдог л доо. Гоё ганган нэртэй явсаар утга агуулга гэж нэг лаг лаг юм явж байгаад сүүлд нь хэн нь илүү эрх мэдлээ, хэн нь илүү зөвшөөрөл өгдөг эрх мэдлийг хэн нь авах юм бэ гэдэг нэг ийм л зүйл рүү л очоод орчихдог. Хэн дарга нь илүү эрх мэдэлтэй байх юм бэ гэдэг. Яг одоо энэний цаана хөдөө аж ахуйгаас өнөөдрийн бодит байдал Монголын хөдөө аж ахуй хүнстэй бүүр нийлүүлээд гэвэл магадгүй би нарийн тоо мэдэхгүй байна. Үсрээд 100 сая долларын л экспорт хийж байгаа байх. 70 сая малтай, 5 сая үхэр юу юу ч гэлээ ингээд баахан юм тоолбол 100 сая долларын л экспорт бүүр өсгөөд хэлэхэд.

Дэлхийн бусад улс орнуудад эрчимжсэн энэ аж ахуй энийг хэрвээ эдийн засгийн бүтэц гээд үзэх юм бол эндээс хэдэн 10 тэрбум долларын экспорт тэрийг дагасан орлого ашгийн тухай яриа энд явагдах ёстой. Тэгэхээр бид нарын тэр төвлөрөх ёстой гол зүйл маань бас яг хаана байгаад байна аа? Тэр мал махны экспорт, малын экспорт, махны экспорт гэж байна. Энэ чинь явсаар байгаад нэг халдвар Монголын мал өвчтэй халдвартай гэдэг энэ зүйлээс л бүх зүйлийн үндэс язгуур. Тэрнээс биш энэ гаалийн зөвшөөрлийг хэн өгөх бол тийм ч их чухал асуудал өнөөдөр тулчихсан асуудал биш л байх. Аль нэг нь авна л биз. Тэгэхдээ эндээс тийм их дэвшил, хөгжил



дэвшилийн юм гарахгүй. Яг тэр мал эрүүлжүүлэх гэдэг ажил яг тэр маань яг хаана явна аа? Монголын махыг эрүүл гэж үзэх харин нэг харьцангуй нэг сайн мэдээ байдаг. Тэр элдэв янзын квот тавьдаг байсан үхрийн махны квот энэ тэр гэдэг зүйлүүд байхгүй болж байгаа юм гэж сонссон. Тэр маш сайн хэрэг. Тэр яг үндсэн гол асуудал руугаа төвлөрсөн маань бараг Монгол Улсад Хөдөө аж ахуйн яам гэж байдаг бол тэр Мал аж ахуйн салбарын бодлого гэж байдаг бол бүхий л хүчээ зөвхөн энэ түүхий эд тэр мал махаа эрүүлжүүлэх гэдэг ганцхан зүйл рүү л бүх юмаа л төвлөрүүлээд тэр бусад элдэв янзын бодлого бусад элдэв янзын татаас дэмжлэг олон янзын зүйл энийгээ бүрмөсөн нольломоор л байна. Ганцхан халдварт өвчнөөс л хамгаалах, халдварт өвчнөөс сэргийлэх, эрүүл гэдгээ олон улсад яаж батлах юм? Бүүр цорын ганц бодлого бараг энэ л шийдэгдчихвэл бусад нь олон янзын бодлого, олон янзын ажлын байр олон янзын зүйл Монгол Улсад өнөөдөр яг үнэндээ хэрэггүй л байна шүү дээ.

Ер нь тэр тусмаа яг хөдөө аж ахуйн малчид мал дагасан эдийн засгийн тогтолцоо гэхэд одоо нэг анхны цас ороход баахан мал нь байтугай хүн нь тэрийгээ дагаж явсан малчин нь эндчихдэг нэг ийм харгис тогтолцоог л үндсэндээ бид нар улам л энд ямарваа нэгэн өөрчлөлтгүй ямар ч нэгэн бодлогын болоод бодит өөрчлөлт байхгүй нэг ийм л салбар л болчихлоо. Үнэхээр харамсалтай нь энэ дээр. Тэгэхээр энэ хууль болоод энэ олон тал дээр яг энэ талын бодлого үнэхээр би тийм онцлог зүйл бол эндээс харсангүй. Захиргааны байгууллагыг зөвшөөрөл өгдөг байгууллагыг хэн нь авах гэж байгаа юм бэ гэдэг л зүйл л энэ хуулийн өөрчлөлтийн гол зүйл юм байна. Яг л манай уламжлалд байдаг хуулиуд хэлэлцэгддэг хуулиудын л олон л жишээний нэг ийм л зүйл харагдаж байна. Тэгээд гол яг одоо тэр мал эрүүлжүүлэх гэдэг зүйл дээр энэ бодлогын яг ямар шинэчилсэн өөрчлөлтүүд гарсан бэ?

Тэр хамгаалалтын бүс гээд л бид нар баахан л юм ярьдаг, хамгаалалтын зооно, тэгээд л баахан юм ярьдаг. Үнэндээ ямар ч бодит хөгжил дэвшил, бодит өөрчлөлт, үр дүн байхгүй л байгаад байгаа шүү дээ. Яг эцсийн үр дүн байхгүй ахиц дэвшил байхгүй л ийм л нөхцөл байдалтай байгаад байгаа.

**Л.Мөнхбаатар:** Ерөнхийдөө санал хэллээ. Хариулах юм уу? Ажлын хэсгийн ахлагч Жадамбын Бат-Эрдэнэ хариулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Их Хурлын гишүүд энэ малын эрүүл мэндтэй холбоотой асуудлыг ярьж байгаад санаа зовж байгаад бас ойлгож байгаа. Бид харин эсрэгээр ахиц дэвшил гаргах гэж энэ нэг процессын алдаануудыг л засаад байгаа юм шүү дээ Цогтгэрэл гишүүн. Одоо Тэсо компаниас гаргаж байгаа бараа бүтээгдэхүүнүүд байж байна. Өөрөөр хэлбэл яг энэ гадаа бид нар үүдэнд ууж байгаа аарц байна. Энэ аарцан дотор орсон амин дэмүүд ашигтай бактери юу байдаг юм энэ бүтээгдэхүүний чанарыг хэн хамгийн сайн тодорхойлж чадах вэ? Танай компани танайх л тодорхойлж чадна шүү дээ. Түүнээс хөндлөнгөөс би эндээс тодорхойлж чадахгүй шүү дээ. Та нар орц найрлага нь ямар байх юм, яаж бүтээсэн юм, ямар гарал үүсэлтэй юм, хаанаас ямар бүтээгдэхүүнийг ямар юмтай нь холиод хийсэн юм гэдэг энэ бүх магадлал энэ бүх гэрчилгээг бол та нар хамгийн сайн гаргаж өгөх байхгүй юу даа. Энийг л яриад байгаа юм.

Түүнээс биш таны өмнөөс хэн нэгэн очоод хийгээд байна уу, хэн нэгэн гэрчилгээ гаргаж өгөөд байна уу гэдэг асуудал бол энэ чинь чанарын хувьд бол өөр асуудал байхгүй юу даа. Яг энэнтэй холбоотойгоор тэр малын өвчин ямар вакцин хийсэн юм, ямар үржүүлэг хийсэн юм, ямар нөхцөлд үржүүлсэн юм ямар нөхцөлд маллагаа хийсэн юм энэ чинь ингээд бүр нядалгаанд орон ортлоо бүх асуудалд чинь мал амьтны эрүүл мэндийн

асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага буюу босоо удирдлагаараа доошоогоо суман дээр байгаа малын эмч хүртлээ энэ босоо удирдлага чинь энэ бүх хариуцлагыг хариуцаж байгаа шүү дээ.

Тэгчхээд яг энэ мах нь гадагшаагаа экспортод гарах гэхээр шал ондоо байгууллага хүрч ирээд гэрчилгээ өгчхөж байгаа байхгүй юу. Энэ одоо мал эрүүл юм гээд гэрчилгээ өгчхөж байгаа байхгүй юу. Тэгэхээр гаднынхан чинь гайхаад байна шүү дээ. Яагаад энэ тэгвэл Болорчулууны гарын үсэгтэй гэрчилгээ байхгүй байгаа юм бэ? Энэ асуудлыг эрүүл байгаа, малынх нь эрүүл мэндийг хариуцаж байгаа Болорчулуун болон Болорчулууны удирдлагад ажиллаж байгаа энийг хариуцсан хүмүүсийн гарын үсэгтэй гэрчилгээ байх ёстой болчихоод байгаа байхгүй юу даа. Энэ л асуудал юм.

Ганцхан гааль дээр бол тэр хянадаг шалгадаг асуудал нь бол саяын тэр гэрчилгээ болон бусад сертификат бүх зүйлүүдийг үндэслээд үзлэг шинжилгээгээ хийгээд яв гэж байна. Цаашидаа ч явна. Түүнээс биш Болорчулууны энэ яамныхан гүйж очоод хил, гааль дээр очоод зогсоод байх асуудал биш л юм л даа.

**Л.Мөнхбаатар:** Одоо 2 гишүүн асуулт асуусны дараа санал хураалт явагдана.

Нийтдээ 32 зарчмын зөрөөтэй санал байна. Гомшилдоогийн Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя.

Гишүүд танхимдаа орж ирээрэй санал хураалт явуулна шүү.

**Г.Мөнхцэцэг:** 2018 онд Тэмүүлэн, Бат-Эрдэнэ, Мөнхбаатар нарын зэрэг бидний хэдэн гишүүд энэ Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийг санаачлан батлуулж байсан. Энэ хуулийн гол онцлог ерөөсөө Мал эмнэлгийн ерөнхий газар

агентлагтай болгосон явдал нь энэ хуулийн онцлог байсан. Тэгээд саяынхаа Бат-Эрдэнэ ажлын хэсгийн ахлагчийн хэлж байгаагаар бол яг энэ хууль дотор бид бас яг энэ хилээр гарах малын гаралтай түүхийн эдийн бүтээгдэхүүний гаргах энэ эрүүл яг тэр чиглэлийнх нь асуудлуудыг бид нар бас шийдэж өгч чадаагүйгээрээ бас ингээд учир дутагдалтай байсан гэж. Өнөөдөр асуудлыг ингээд шийдэж байна л даа. Гэхдээ яг бүгдийг нь энэ Мал эмнэлгийн ерөнхий газарт ингээд шилжүүлснээрээ магадгүй салбар хоорондын уялдаа холбоо нь бас зөрчигдөх вий. Ялангуяа бас энэ хил, гааль, хорио цээрийн гээд ингээд энэ чиг үүргийн мэргэжсэн мэргэжилтнүүд нь өөрөө бүтцийнхээ хувьд бас хаана нь харьяалагдаж явах юм гэдэг ийм бас нэг эрх зүйн зохицуулалтууд хэр туссан юм бэ гэдэг асуух асуулт байгаад байна.

Дээр нь Мал аж ахуйн итгэмжилсэн лаборатори гэж байгаа. Энэ лабораторийн маань үйл ажиллагаа өнөөдөр бас ямаршухан байдалтай явагдаж байна вэ? Энэ хуулийн байна шүү дээ 31.5.3 дээр байж байгаа юм л даа олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ олгох ажлыг Мал эмнэлгийн ерөнхий газарт ингээд олгохоор заачихсан байж байгаа юм. Тэгэхээр энэ бололцоо нөхцөлүүд маань хэр байгаад байгаа билээ. Энэ олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ олгох ажил шүү дээ. Тэгээд энэ ажлыг энэ хуулиар ингээд хуульчлаад хийгээд өгчихсөн байгаа юм. Энэ асуудлууд маань манай Мал эмнэлгийн ерөнхий газарт хэрхэн харьяалагдаж байгаа юм бэ гэж энэ зүйлийг асууя. Дээр нь өнөөдөр ингээд малын гаралтай түүхий эд тэр чигтээ үнэгүйдэж байна.

Тэгэхээр энэ цагаан идээ экспортлох зөвшөөрлийг хөнгөвчлөх талаар энэ хуульд бас ямар нэгэн заалт байна уу үгүй юу? Бид зөвхөн махаа гаргана, арьс ширээ гаргана л гэж ингэж үзээд байдаг. Гэтэл энэ цагаан идээ дээр нь яах вэ? Энд өнөөдрийн байдлаар яах вэ

энэ ургамал амьтан гээд л ингээд л ороод ирж байна л даа. Тэгэхээр энэ цагаан идээг бид нар бас яг экспортлох тал дээр манай Хөдөө аж ахуйн яам ер нь бас яг бодлого болгож байгаа юмнууд юу байгаад байгаа юм? Яг энэ хууль дотор тодорхой хэмжээгээр хөнгөвчилсөн заалт, туссан заалт ер нь юу байна вэ гэж.

**Л.Мөнхбаатар:** Мөнхцэцэг даргын асуултад хариулъя.

Ажлын хэсгийн ахлагч Жадамбын Бат-Эрдэнэ хариулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Мөнхцэцэг гишүүн бид хэд Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль боловсруулах ажлын хэсэгт хамт ажиллаж байсан. Зовлон жаргалыг бас сайн мэднэ л дээ. Тэгээд тэр талаасаа асуугаад байх шиг байна. Ямар ч байсан бид нарын үед хийж байсан хууль дотор мал эмнэлгийн газар болоод энэ малын эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн байгууллагууд маань өөрсдийнхөө дүгнэлтийг хорио цээрийн дүгнэлтийг гаргах энэ боломж бололцоо нь бол хаагдмал болчхоод өөрөөр хэлбэл Мэргэжлийн хяналтын газар өгчхөөд байсан шүү дээ. Тэгээд энийгээ бид нар бол одоо засаад үндсэндээ бол түрүүний миний хэлсэнчлэн малыг төрснөөсөө авхуулаад тэгээд нядалгаанд хүртэл энэ бүх эрүүл мэндийнх нь асуудлуудыг хариуцаад тэгээд тэнд нь бол үнэлэх гэрчилгээг нь өгөөд хилээр гаргах тодорхойлолтыг нь бол өгч байгаа. Өгч байгаагаараа энэ хуулийн бол өөрчлөлт онцлог болчхоод байгаа юм.

Хоёрдугаарт, ер нь бол хариуцлагыг бол нэгэнт эрүүл мэндийнхээ асуудлыг малын эрүүл мэндийн асуудлыг хариуцаж байгаа бол энэ талынхаа хариуцлагыг бүгдийг нь даана гэж байгаа юм. Ерөөсөө Болорчулуун сайд болон мал амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, төрийн

захиргааны төв байгууллага бол ерөөсөө хариуцлагаа бүрэн даана гэж байгаа юм.

Тийм болохоор энэ талаар тэгээд жишээ нь наад зах нь гэхэд магадлан гаргах асуудлууд байж байна. Хилийн цаана магадгүй зүгээр мал амьтны эрүүл мэндийн байгууллагын хоорондын хэлэлцээрийн дагуу асуудлууд байж байна. Энэ дээр жишээ нь урьд нь бол баг ажиллана гэдэг байсан нэг ийм заалт байсныг бол болиод зөвхөн энэ хариуцлагынхаа дагуу өөрсдөө тэр мэргэжилтнийхээ дагуу мэргэжилтнүүдээ томилж ажиллуулаад эндээ дүгнэлт гаргуулъя энэ тэр гэсэн ийм зүйлүүд ингээд ороод явчхаж байгаа юм.

Нөгөөтээгүүр цааш цаашидаа энэ хуулийн логик бол мал ингээд төрснөөсөө хойш яг нядалгаанд ороод мах комбинатаар ороод тэгээд тэнд бол улаан тамгаа дараад энэ мах бол энэ мал эрүүл байж байгаад нядалгаанд ороод эрүүл мах бид нар хүнсэнд нийлүүлж байгаа шүү, худалдаа нийлүүлж байгаа гэсэн тамгаа улаан тамгаа дарах хүртэл бол мал эмнэлгийн асуудал. Өөрөөр хэлбэл мал эмнэлэгтэй холбоотой асуудал. Түүнээс цааших нь бүтээгдэхүүн нь бол хүнсний эрүүл мэндтэй холбоотой асуудлууд гэж энэ ангилах ийм юу руу орох юм, цаашидаа бол.

Нөгөөтээгүүр энийг дагаад бас Ургамлын хорио цээрийн тухай хууль бас боловсруулагдаад яаман дээр явж байгаа. Энэ дээр бас та бүхэнд тодруулаад хэлчихнэ биз. Энэ хууль батлагдаад ирэхээр яг нэг талдаа бол малтай холбоотой малын эрүүл мэндтэй холбоотой, хорио цээртэй холбоотой асуудал нөгөөдүүл нь ургамлын хорио цээртэй холбоотой асуудал. Тэгээд тэнд нь бас мэргэжлийн байгууллагууд энийгээ хариуцаад ингээд явах, үндсэндээ бол мэргэжлийн байгууллагууд бүх тодорхойлолтоо нэг талаасаа ургамал талдаа, нөгөө талдаа амьтан талдаа ингээд тодорхойлолтоо өгөөд явдаг. Мал

болон ургамал гэсэн ийм 2 хүрээнд бол ажиллах ийм боломж бололцоо нөхцөл биелэгдээд явах юм гэж. Тэгээд тэр утгаараа бол цагаан идээтэй холбоотой асуудлыг Хөдөө аж ахуйн яамныхан бас ажлын хэсэг тодруулаад явчихъя гэж баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсэг нэмж хариулъя.

Ажлын хэсгийн 82 дугаар микрофоныг өгье.

**Г.Батмөнх:** Гаалийн ерөнхий газрын хорио цээрийн хэлтсийн дарга Батмөнх. Түрүүн Мөнхцэцэг гишүүний асуултаас тэр 3 дахь асуултад нь хариулъя.

Тийм яг энэ нь үнэн манай энэ бас Мал аж ахуйн бүтээгдэхүүн дагаж гарч байгаа. Тэгээд бас энэ бол төлждөг эргээд ургадаг тийм нэмэгддэг ургамалтай адил бүтээгдэхүүн бол сүү цагаан идээний асуудал байгаа. Тэгээд энэ сүү цагаан идээний асуудлаар бол сүүлийн 3 жил хөрш орон хамгийн том зах зээлийг импортлогч зах зээл улс болох Хятад улстай хорио цээрийн энэ асуудлыг протоколыг бол сүүлийн 3 жил ажиллаж байгаад энэ протоколыг бол байгуулсан. Мөн тэгээд түүнийгээ дагалдуулаад Хятад улстайгаа энэ цагаан идээгээ экспортлохдоо солилцох гэрчилгээнийхээ загварыг ч бас энэ хорио цээрийн хэлтсээс тохиролцоод болчихсон байж байгаа. Тэгэхлээр одоо Хятад улс руу бол бас ийм экспорт явах боломж нээгдсэн гэж хариулах байна аа. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд танхимдаа ирье. Санал хураалт явагдах гэж байна.

Байнгын хорооны дарга Гомтилдоогийн Мөнхцэцэг тодруулж асууя.

**Г.Мөнхцэцэг:** Батмөнх дарга аа. Энэ нөгөө зөвхөн тэгэхээр бид нарын хувьд бол зөвхөн Хятадтай л яг ийм гэрээний дагуу түүхий эдийг түүхий эдээс гадна энэ цагаан идээг экспортолж байгаа гэж ингэж ойлгож болох юм байна. Өөр орнуудтай ингэж яг гэрээ хэлэлцээр хийгээд ингээд цагаан идээг гаргаж байгаа ийм зөвшөөрлийг манайх олгож байгаа, өөр зохицуулалт байхгүй байгаа юм байна гэж ойлгож болох уу?

Хоёрт гэвэл тэр 31.5.3 дээр байхгүй юу. Хуулийн төслийн олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ олгох ажлыг Мал эмнэлгийн ерөнхий газар хариуцна гэж байгаа юм. Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ олгоно оо гэдэг маань өөрөө ямар гэрчилгээг хэлээд байгаа юм бэ тэ? Тэгэхээр энийг манай Монгол Улсын Мал эмнэлгийн ерөнхий газар хааш нь яаж олгож ирсэн юм энэ ингээд сайжирч байгаа юм уу? Шинэ заалт орж ирж байгаа юм уу? Энэ дээр манай Хөдөө аж ахуйн яамныхан нэг тодорхой хариулт өгнө үү?

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсэг нэмж хариулъя. Эхлээд гааль хариулах уу? 82 дугаар микрофоныг өгье. Дараа нь бас нэмж хариулаарай.

**Г.Батмөнх:** Мөнхцэцэг гишүүний тодруулга асуултад хариулъя. Тийм Япон Солонгос, Америк руу бол бас цагаан идээнээс бас гарч байгаа. Яг хэлэлцэн тохиролцсон протокол хэлэлцээрийг байгуулсан нь бол хорио цээрийн протоколоор байгуулсан нь Хятад улс сая 2022 оны 6 сард байгуулагдсан байж байгаа. Бусад 3 улс руу бол тодорхой хэмжээний бол цагаан идээ бүтээгдэхүүн бол бас гарч байгаа.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсгийн 88 уу? 88 дугаар микрофоныг өгье. 86 юм уу 86 дугаар микрофон өгье.

**А.Нарантуяа:** Мал эмнэлгийн Ерөнхий газрын дарга Нарантуяа байна.



Ингээд гишүүний асуултад хариулъя. Олон улсын гэрчилгээний талаар тодруулга өгье. Олон улсын гэрчилгээ гэдэг бол 2 орны хооронд мал эмнэлгийн 2 талаасаа тавигдсан шаардлагыг хүлээн зөвшөөрсөн Дэлхийн мал амьтан, эрүүл мэндийн байгууллагын кодексын дагуу тийм батлагдсан тийм стандарт шаардлага байдаг. Тэгээд өнөөдөр бол Монгол Улс 2018 оноос хойш өнөөдөр олон улсын гэрчилгээг мал эмнэлгийн гэрчилгээг олгож байна. Яг өнөөдрийн байдлаар 2200 олон улсын гэрчилгээг цахимаар олгоод байж байна. Тэгээд Мал эмнэлгийн ерөнхий газраас энэ гэрчилгээг олгоод үйл ажиллагаа явагдаад явж байна. Үүний нэг тод жишээ бол саяхан БНСВУ-тай 2 талын хөлдөөсөн мах, махан бүтээгдэхүүн, малын гаралтай бүтээгдэхүүн дээр яг энэ протоколын дагуу мал эмнэлгийн олон улсын гэрчилгээгээр тохирсон хамгийн сүүлийн энэ тохиолдол энэ байлаа.

**Л.Мөнхбаатар:** Өөр нэмж хариулах уу? Болчихсон уу? Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Гишүүд суудлаа эзлээрэй. Төсвийн байнгын хороо хуралдаад дуусаж байна.

Гишүүд ороод ирэх байх. Бүлгийн дарга нар ирцээ бүрдүүлье.

Зочин танилцуулъя аа. Амгалан айл ТББ-ын хөтөлбөрийн оролцогч ЕБС-ийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа.

Хүүхдүүд та бүхэндээ сурлага хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе өө.

Төсвийн байнгын хороо хуралдаж дууссан байна. Гишүүд байраа эзэлье. Санал хураалт явагдана.

Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан саналыг хураая.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 14.9, 14.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 14.9, 14.10, 14.11 дэх хэсэг болгох:

“14.9.Энэ хуулийн 11.1.1-д заасан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалттай аж ахуйд мөрдөх био хамгааллын нийтлэг зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга өвчин тус бүрээр баталж хэрэгжилтэд хяналт тавина.

14.10.Хамгаалалттай аж ахуй нь энэ хуулийн 14.9-д заасан нийтлэг зааварт нийцүүлэн өөрийн үйл ажиллагаанд мөрдөх био хамгааллын зааврыг баталж мөрдүүлнэ.

14.11.Энэ хуулийн 14.2, 14.9, 14.10-т заасан журам, био хамгааллын зааврын хэрэгжилтэд үнэлгээ хийх үйл ажиллагааг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцан хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ, Аубакир, Бейсен, Идэрбат, Туваан цаашид ажлын хэсэг гэнэ.

Санал хураалт.

Дамдины Цогтбаатар гишүүн горимын санал гаргая.

**Д.Цогтбаатар:** Би сая дэмжсэн санал өгсөн боловч гарсангүй. Тэгэхлээр саяын саналыг хүчингүй болгож санал хураалгаж өгөөч тэгээд дахиж санал хураалт явуулахыг хүсэж байна. Дамдины Цогтбаатар гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.



Санал хураалт.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Амгалангийн Адьяасүрэн горимын санал гаргая.

Адьяасүрэн гишүүний микрофоныг өгье.

**А.Адьяасүрэн:** Дарга аа горимын санал гаргах гэсэн юм. Энэ аппарат ажилласангүй учраас дахин санал хураалт явуулж өгнө үү? Улсын Их Хурлын гишүүн Амгалангийн Адьяасүрэнгийн гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

Санал хураалт.

54.8 хувиар санал дэмжигдлээ.  
Санал хураалт хүчингүйд тооцсон.

Үндсэн санал хураалтын саналын томъёоллыг уншиж танилцуулсан.

Санал хураалт.

54.8 хувиар санал дэмжигдлээ.

Зочин танилцуулъя. Баянхонгор аймгийн Галуут Заг сумын ЕБС-ийн багш, ажилтан, Соёлын төвийн ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил амьдралд нь хамгийн сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе өө.

Санал хураалтыг үргэлжлүүлъя.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 4.1.18 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4.1.20 дахь заалтын “эсхүл үе хөлтний шимэгчлэл” гэснийг хасах:

“4.1.18. “хамгаалалттай аж ахуй” гэж олон улсын худалдааны чөлөөт

байдлыг дэмжих болон улс, бүс, нутагт тархсан өвчнөөс хамгаалах, тэмцэх зорилгоор тандалт, хяналт, эрсдэлийн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ, био хамгааллын нийтлэг зааврыг хэрэгжүүлэхээр бусад мал, амьтнаас тусгаарлан маллаж байгаа эрүүл мал, амьтан бүхий байгууламжийг;”

Санал гаргасан ажлын хэсэг.

56.8 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн “7.4.2 дахь заалт” гэснийг “7.4.2 дахь заалтын “улсын байцаагчаас” гэсний өмнө” гэж, “9.7 дахь хэсэг” гэснийг “9.7 дахь хэсгийн “улсын байцаагч,” гэсний өмнө” гэж өөрчилж, “, 34 дүгээр зүйлийн 34.2.4, 34.3.3 дахь заалтын “дэвсгэрийн” гэсний дараа “мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, төрийн өмчийн мал эмнэлгийн лабораторийн оношилгоо, хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулах,” гэж” гэснийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт 57.8 хувиар санал дэмжигдлээ.

4. Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.4.2, 31.4.4, 31.4.5 дахь заалтыг тус тус хасах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүн Батсуурь горимын санал гараагаарай. Улсын Их Хурлын гишүүн Наянтайн Ганибал Горимын санал гаргаарай.

**Н.Ганибал:** Төхөөрөмж дэмжсэн санал өгсөн боловч ажилласангүй. Тэгээд дахин санал хураалт өгнө үү гэж хүсээж байна аа.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Наянтайн Ганибалын саналаар тус санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай саналаа өгөөрэй.

60.9 хувиар санал дэмжигдлээ. Хүчингүйд тооцсон. Одоо үндсэн саналын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа.

Санал хураалт гишүүд.

58.7 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.5.2 дахь заалтын “мал эмнэлгийн” гэснийг “мал эмнэлэг, эрүүл ахуй, ариун цэврийн” гэж, 31.5.4 дэх заалтын “худалдаа, үйлчилгээний” гэснийг “худалдаанд мөрдөх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

56.5 хувиар санал дэмжигдлээ.

6 Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.6.4 дэх заалтын “таслан зогсоох” гэсний дараа “талаар хугацаатай үүрэг даалгавар өгөх, хэрэгжилтэд хяналт тавих” гэж нэмж, 31.6.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“31.6.1.мал, амьтан, тэдгээрийн хашаа, байр, ус, бэлчээр, өвс, тэжээлд болон мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэх, хадгалах, тээвэрлэх, худалдах явцад мал эмнэлэг, эрүүл ахуй, ариун цэврийн үзлэг, шинжилгээ хийлгэсэн эсэхэд хяналт тавих;” санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

58.7 хувиар санал дэмжигдлээ.

7. Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.6.2, 31.6.3 дахь заалтыг

нэгтгэж доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“31.6.2.мал, амьтны халдварт өвчин тараах, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах эрсдэлтэй мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхийг хориглох, шаардлагатай тохиолдолд устгах;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

8. Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.6.6 дахь заалтын “мал, амьтны тэжээлийн нэмэлтийг улсын бүртгэлд бүртгэх,” гэснийг хасаж, 31.6.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“31.6.7.Мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн сангийн хөтлөлтөд хяналт тавих;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.6 хувиар санал дэмжигдлээ.

9. Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 15.13 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.13.Энэ хуулийн 28.2-т зааснаас бусад албан тушаалтан мал, амьтны гоц халдварт өвчний талаарх баталгаажуулахгүй мэдээллийг тараахыг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 3 дугаар зүйлийн 3, 4 дэх заалт буюу 34.2.4, 34.3.3 дахь заалтын “баталгаажуулах” гэсний дараах “, мал, амьтны эрүүл мэндийг

хамгаалах” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

57.8 хувиар санал дэмжигдлээ.

11. Төслийн 4 дүгээр зүйлийн “хамгаалалттай аж ахуйд мөрдөх био хамгааллын нийтлэг” гэснийг “хамгаалалттай аж ахуйг баталгаажуулах, хяналт тавих” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

57.8 хувиар санал дэмжигдлээ. Гишүүд суудалдаа суугаарай.

12.Төслийн 6 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал байна.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.5.2 дахь заалтын “тэдгээрийн гаралтай” гэсний дараа “түүхий эд,” гэж, 31.6.5 дахь заалтын “эмнэлгийн хэрэгсэл,” гэсний дараа “тэжээлийн нэмэлт,” гэж нэмэх.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 4.1.21 дэх заалтын “төлөвлөгөөтэйгээр” гэснийг “төлөвлөгөөний дагуу” гэж, “шаардагдах арга хэмжээ” гэснийг “шаардлагатай арга хэмжээг” гэж өөрчилж, 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.5.4 дэх заалтын “амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус” гэснийг “амьтан, тэдгээрийн гаралтай” гэж, 31.6.4 дэх заалтын “борлуулах” гэснийг “худалдах” гэж, 31.6.5 дахь заалтын “гаралтай” гэсний өмнөх “амьтны” гэснийг “амьтан, тэдгээрийн”

гэж, 31.6.6 дахь заалтын “малын” гэснийг “мал, амьтны” гэж өөрчлөх.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 4.1.20 дахь заалтын “бүлгийн” гэснийг, 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.6.4 дэх заалтын “хүнсний болон хүнсний бус” гэснийг, 31.6.5 дахь заалтын “тэжээл, тэжээлийн нэмэлт, мал” гэснийг, 31.5.4, 31.6.5, 31.6.12 дахь заалтын “мал эмнэлгийн” гэсний дараах “ажил,” гэснийг тус тус хасах.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг 1 дэх заалт, 4 дэх заалтыг 3 дахь заалт, 1 дэх заалтыг 4 дэх заалт, 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг 1 дэх заалт болгон өөрчлөх санал гаргасан. Ажлын хэсэг.

Санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Адьшаа, Пүрэвдорж, Бямбацогт нарын урилгаар Ховд аймгийн Үенч сумын ЕБС-ийн багш албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүгдэд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил амьдралд нь хамгийн сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе.

Санал хураалтыг үргэлжлүүлэн явуулъя.

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн санал хураалтуудыг явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 5.4 дэх хэсгийн 5.4.2 дахь заалтын “гадаад орны” гэсний өмнө “хуульд өөрөөр заагаагүй бол” гэж, 5.4.3 дахь заалтын “экспортлох” гэсний өмнө “шаардлагатай бол” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

60.9 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 3.1.11 дэх заалтын “мал, амьтан,” гэсний дараа “ургамал,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

59.6 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн “26.1 дэх хэсэг,” гэснийг “26.1 дэх хэсгийн “эрүүл мэндийг хамгаалах” гэсний өмнө болон” гэж өөрчилж, “8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтын “байгууллагад” гэсний дараа “цахимаар” гэж,” гэснийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

62.5 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.2 дахь хэсэг нэмж, төслийн 4 дүгээр зүйлийн “25.2,” гэснийг хасах:

“25.2.Хорио цээрийн хяналт, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүн, энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг харгалзан ургамлын хорио цээрийн гэрчилгээг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус олгоно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ.

Санал хураалт.

60.4 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 27.1 дэх хэсгийн “мэргэжлийн баг” гэснийг “эрх бүхий албан тушаалтан” гэж, 27.2 дахь хэсгийн “мэргэжлийн багийн” гэснийг “эрх бүхий албан тушаалтны” гэж өөрчилж, төслийн 2 дахь заалт буюу 26.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 26.4, 26.5 дахь хэсэг болгох:

“26.4.Эрсдэлийн үнэлгээг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон эрх бүхий албан тушаалтан гүйцэтгэнэ.

26.5.Энэ хуулийн 26.4-т заасан эрсдэлийн үнэлгээ хийх журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

58.3 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.7 дахь заалт нэмж, төслийн 6 дугаар зүйлийн “7.1.7,” гэснийг хасах:

“7.1.7.гадаад орны мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн байгууллагатай хяналт, шалгалтын ажлыг уялдуулан хамтран ажиллах, улсын хилээр нэвтрүүлсэн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний талаарх мэдээллийг тогтоосон хугацаанд хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар хүргүүлэх;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

60.4 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 4 дүгээр зүйлийн “тус тус, 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтын” гэсний өмнө “, 25 дугаар зүйлийн гарчгийг “Импортын, олон улсын мал эмнэлгийн,

ургамлын хорио цээрийн гэрчилгээ” гэж” нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

61.2 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 4 дүгээр зүйлийн ““мэдээг тогтоосон хугацаанд” гэснийг “тухай бүр”” гэснийг ““хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий” гэснийг “дээд шатны”” гэж өөрчилж, “, 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтын” гэснийг болон “27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

63.3 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл.Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

57.1 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал

1.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 1.1 дэх хэсгийн “хангах, худалдааг хөнгөвчлөх” гэснийг “дэмжих” гэж өөрчлөх.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 5.4 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 27.2 дахь хэсэг болон 4 дүгээр зүйлийн “хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн” гэсний өмнө “хүнс,” гэж нэмэх.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг 1 дэх заалт болгон өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

57.1 хувиар санал дэмжигдлээ.

Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу “9.13, 9.14 дэх хэсэг” гэснийг “9.14, 9.15 дахь хэсэг” гэж, төслийн 3 дахь заалт буюу 9.2.3 дахь заалтын “3-аас” гэснийг “гурваас” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

59.6 хувиар санал дэмжигдлээ.

2. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу “16 дугаар зүйлийн 16.12” гэсний дараа “, 16.13” гэж нэмж, 16.13.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.13.4.малын тэжээл, шимт чанар, хүрэлцээ, бэлчээрийн менежмент болон усан хангамж, аймаг дундын отрын бэлчээрийн ашиглалт, хамгаалалт,



холбогдох журмын хэрэгжилт, малын гаралтай түүхий эд бэлтгэл;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Үг хэлэх гэж байгаа юм уу? Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлье. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн микрофоныг өгье.

**Б.Пүрэвдорж:** Би нэг ажил хийдэг Засгийн газар Ардын намынх л даа. Ажил хийдэг Засгийн газар ажил хийдэггүй Засгийн газар 2-ын ялгааг хэлж өгье. Энэ малын тэжээл гэдэгтэй холбоотойгоор. 2017-гоос 2018 онд шилжих жил өвөлжилт хүндэрсэн. Өвөлжилт 8 аймагт хүндэрнэ гэж үзээд Хүрэлсүхийн Засгийн газар 40 тэрбум төгрөгийг Засгийн газрынхаа нөөц хөрөнгөөс гаргаад тэндээсээ малын тэжээл бас аймаг болгонд 5 тэрбум төгрөг өгөөд тэндээсээ малын тэжээл худалдаж ав, гадаадаас оруулж ир. Тэгээд энэ жишээ нь Ховд аймагт 14 мянган төгрөгийн үнэтэй хивгэн тэжээл байсан юм. Тэгэнгүүт 13 мянган төгрөгөөр та нар тэжээлээ нийлүүлэх юм бол энэ зээлээс хүүгүй аваад ашигла гэсэн.

Дараа нь нөгөө хорголжин тэжээл 24 мянган төгрөг байсан. 24 мянган төгрөгийн тэжээлийг 23 мянган төгрөгөөр та нар энэ өвөл хавар нийлүүлэх юм бол энэ мөнгөнөөс хүүгүй зээл аваад хэрэглэсэн. Тэрний дагуу тэр өвөлжингөө хаваржингаа тэжээл яг энэ үнэтэй байгаад хүмүүст олдоцтой байгаад тэгээд тэр өвөлжилтийг маш амжилттай давсан юм. Тэгсэн яасан гэхээр энэ жилийн хаваржилт хүндрээд ажил хийдэггүй Засгийн газар яасан бэ гэх дээр энэ улсын нөөцийн хэдэн тонн тэжээлийг Амарсайхан Шадар сайд Ховд аймагт очоод нэг буянтны дүрээр 20, 30 тэжээл, тонн тэжээл нэг суман дээр өгөөд тэгээд тэр сумд нь тэр 20 тонн тэжээл нь нэг сум дээр нэ бүх айлд бүгдэд

нь хүрэхгүй очсон нэг ганц шуудай нь тэр айлдаа өдөртөө ч хүрэхгүй ийм л юм болсон юм л даа. Тэгээд ерөөсөө бэлтгэл ажил хийгээгүй нөөц хангаагүй. Тэрний үр дүнд яасан бэ гэхээр нөгөө гу 30 мянга орчим үнэтэй байсан тэжээл 70 мянган төгрөгийн үнэтэй болсон байхгүй юу даа. Тэгээд тэжээл нь олдохгүй. Манай тэр Дуут сум руу 40 ширхэг үлдсэн тэжээлээ ачиж яваад 2 машин яваад цасанд суучихсан ийм тохиолдол гарч байгаа юм. Гэтэл энэ сая цаснаар бас нэлээн өвөлжилт нэлээн хүндрэх тийм төлөв харагдаж байна шүү дээ.

Тийм учраас энэ ялангуяа энэ ААН-үүдээ дэмжээд тэр өвс тэжээлийн бэлтгэлийг нөөц хангалт борлуулалтын хамгийн гол нь зах зээлийн шугамаар борлуулах тэр нөхцөлийг нь хангах талаар бас Засгийн газар ажиллаарай. Тэгэхгүй бол бас яг ингээд өнгөрсөн хаврынх шиг баахан тэжээл 70 мянган төгрөгөөр малчид аваад тэрнээсээ болж санхүүгээр хохироод тэгээд 1 ийм нэг дүр зураг харагдаад байгаа шүү. Тэрэн дээрээ Болорчулуун сайд өвөлжилтийн бэлтгэл ажил хангах талаар тэр Засгийн газрынхаа нөөц хөрөнгөөс гаргаж тэр тэжээлийн борлуулалтыг хамгийн гол нь зах зээлийн жсамаар тэжээлийн борлуулалтыг нь сайн хийж өгөх талаар ажиллах хэрэгтэй шүү гэж хэлмээр байна.

**Л.Мөнхбаатар:** Зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулж Пүрэвдорж гишүүн үг хэллээ. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан.

Санал хураалт.

63.8 хувиар санал дэмжигдлээ.

3. Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл. Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

61.7 хувиар санал дэмжигдлээ.

4. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг 1 дэх заалт, 3 дугаар зүйлийн 3 дахь заалтыг 1 дэх заалт болгон өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. Үг хэлэх юм уу?  
Санал хураалтыг хүчингүйд тооцъё.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлье. Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

**Б.Пүрэвдорж:** Би яг энэ гурилын тооцооллыг нарийн хэлж өгье.

Өнөөдөр Ховд аймагт гурил алтан тариа болон бусад Монголын гурил 120 мянган төгрөг байгаа. 120 мянган төгрөгөөр 50 кг-ын гурил 120 мянган төгрөг байгаа. 120 мянган төгрөгийн үнэтэй гурилыг тэр ахмадууд ядарсан ахмадууд хэдэн төгрөгийнхөө тэтгэврээр авч байна. Гэтэл яг өнөөдрийн байдлаар Горна-Алтайск хотод 1 кг алейкагийн 1 дүгээр гурил 20 рубль байна. Тэгээд 1 кг гэж байна. Тэгээд тэр 1 кг гурилаа наашаа тээвэрлэхэд 5 рублиэр орос машин шууд Ховдод буулгаж байна. Тэгэх дээр 20 рубль дээр нэмэх нь тээврийн зардал 5 рубль 25 рубль, 25 рублийг өнөөдрийн байдлаар юу рубль 35 төгрөг байна тэгэх дээр 875 төгрөг болж байна. Дээрээс нь гурил 15 хувийн татвартай 5 хувь биш 15 хувийн татвартай дээрээс нь НӨАТ-ын татвар 10 хувь нэмээд 26.5 хувиар татвар бодоход 231 төгрөг нэмэгдэж байна.

Ингээд 1106 төгрөгөөр Ховд аймагт гурил ирэх боломжтой байна. Энэ бол 55 мянган төгрөг гэсэн үг байхгүй юу даа. 55 мянган төгрөгөөр энэ иргэд маань

гурил идэх ийм боломж байж байхад гурилын импортоо хааж байгаад зөвхөн дотоодын гурил ид гэдэг. Тэр нь тэгээд хэдхэн буудайны компаниуд дээрээс нь тэр гурилын компаниудын ашгийг нь нэмэгдүүлдэг. Ийм байж болохгүй. Тийм учраас энэ хүмүүс орлогогүй ядарсан байж байхад тэр гурилыг нь хямдхан өгөх тэр боломж нь байж байхад тэрийг нь нээж өг л дөө.

Засгийн газар энэ дээр ажилла л даа. Жавхлан сайд аа. Ядаж тэр чинь импорт орж ирвэл НӨАТ, татвар, гаалийн татвар чинь нэмэгдээд тэндээс чинь орлого орж ирнэ шүү дээ тийм биз дээ? Энэ асуудлаа би бол яг тодорхой нарийн тоог нь би бичээд өгч болно. Засгийн газар руу асуулга явуулж болно. Ингээд хүмүүс чинь ингээд хямдхан гурилаар сайхан амьдрах хоол ундтай байх тэр боломж нь байж байхад чинь тэрнийг нь хаагаад байдаг ийм байж болохгүй шүү дээ. Энэ дээрээ анхааралтай ажилла л даа.

**Л.Мөнхбаатар:** Пүрэвдорж гишүүн үг хэллээ.

Саналын томъёоллыг уншиж танилцуулсан.

Санал хураалт.

55.3 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн санал хураалтуудыг явуулъя.

Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.3 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн санал хураалтуудыг явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн “6.63 дахь хэсэг” гэснийг “6.64 дэх хэсэг” гэж, “6.63.” гэснийг “6.64.” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

51.1 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “, 8, 9, 10, 11” гэсний дараа “, 12” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

61.7 хувиар санал дэмжигдлээ.

3. Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл. Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Байнгын хорооны дарга Бямбасүрэнгийн Энх-Амгалан горимын санал гаргая. Горимын санал гаргая.

**Б.Энх-Амгалан:** Өнөөдрийн нөгөө төхөөрөмжүүд их гацаад байна аа. Сая би дэмжсэн санал өгсөн. Тэгээд энэ эсрэг гарчихлаа. Энэ саналыг хүчингүй болгож өгөх горимын санал гаргаж байна.

Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалангийн гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

Санал хураалт.

59.2 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн талаарх зарчмын зөрүүтэй байгаа юу?

Сая нөгөөдөх горимын саналаар хүчингүй болгочихсон байгаа.

Үндсэн саналын томъёоллыг уншиж танилцуулсан.

Санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр, томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

52 хувиар санал дэмжигдсэн.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлээ.

### 16.16 цагт

Дараагийнхаа асуудлыг хэлэлцэнэ.

Төсвийн асуудал хэлэлцсэн шүү гишүүд.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн танилцуулна.

**Д.Тогтохсүрэн:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа явуулж төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдаанаараа дээрх хууль, Монгол Улсын Их Хурлын дотоодын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу явууллаа.

Нэгдсэн хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийн анхны

хэлэлцүүлгийг явуулах үед төслийг гүйцээн боловсруулах чиглэлийн хуралдаан дарлагчаар өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх нэг зарчмын зөрөөтэй санал Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу хуулийн төслийн зарим заалтаар дахин санал хураалгах шаардлага гэж үзсэн тул Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх нэг зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг бэлтгэн санал хураалгахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно оо.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хувилбарын төсөл эцсийн хэлэлцүүлэг бэлтгэгдсэн тухай Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Тогтохсүрэн даргад баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.



Сангийн сайд Болдын Жавхлан, Сангийн дэд сайд Санжаагийн Мөнгөнчимэг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Цогтын Баярбат, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Цэдэнбалын Батзул, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Анандын Энхманлай, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын дарга Чойгүнсэнгийн Чимэдсүрэн, Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга Зоригтбаатарын Энхболд, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Энхтөрийн Батмөнх, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Лувсанвандангийн Ичинноров нар оролцож байна аа.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Багаагийн Баттөмөр гишүүнээр тасаллаа. Байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр асуултаа асууя.

**Б.Баттөмөр:** Монгол Улсын 2024 оны төсөв ингээд батлагдах шатандаа ороод явж байна. 74 их наяд төгрөгийн ДНБ болж өссөн байгаа. Эдийн засгийн өсөлт 7 хувь тэгээд дээрээсээ инфляц 8.5 хувь гээд ингээд явж байна л даа. Зүгээр цааш цаашидаа бол төсөвтөө баригдахгүйгээр энэ Монгол Улсын хөгжлийн потенциалыг ашиглаж

төсвийн орлогыг нэмэгдүүлэх шаардлагатай.

Төсвийн орлого бол асар их боломжууд байгаа. Дайчлагдахгүй л байгаа. Төсвийн орлогыг бол зарлагыг ард иргэдийн амьдралыг дээшлүүлэх ядуурлыг бууруулах чиглэлд зарцуулах ёстой. Монголын ард түмний 42.5 хувь нь ядуурчихсан байгаа шүү дээ. Ийм ядууралтай ардчилсан улс гэж дэлхийд байхгүй шүү дээ.

Тийм учраас энэ төсвийн бодлогоо орлогоо дайчлах чиглэлд ажиллах ёстой. Монгол улсын энэ хулгай, авлигалаас шалтгаалсан хөгжлийн алдагдсан боломж бол асар их байгаа. Энийг төсөвт төвлөрүүлэх ёстой. Энэ Оюу Толгой төслийн далд уурхай ашиглалтад оронгуут л Монголчуудын амьдралд их том өөрчлөлт гарна гээд асар их том хүлээлт байсан. Тэгээд энэ төслөөс орж ирэх өгөөж хэр зэрэг байх юм? Тэр эхний асуулт энэ 74 их наяд төгрөгийн ДНБ-ий хэдэн хувь нь Оюу Толгойд ноогдож байгаа вэ? 25 их наяд төгрөгийн төсвийн орлогод Оюу Толгойгоос орох орлого хэд байна аа? Алтны агууламж, зэсийн агууламж 4 дахин нэмэгдэнэ гэж. Яах вэ тэр далд уурхай ашиглалтад орсноор зэсийн тэр агууламжийн хэмжээ бол 4 дахин нэмэгдэнэ гэсэн.

Тэгэхээр энэ маань энэ төсөвт ерөөсөө тодорхой бүрхэг л яваад байгаа юм. Нийт тоогоороо яваад байгаа болохоос биш яг задаргаа байхгүй байгаад байгаа юм. Эхний 8 сарын байдлаар 1 сая тонн зэс экспортод гаргачихсан байна. 5 хувиар нэмэгдэж. Гэтэл зэсийн орлого 5 хувиар буурчихсан байгаа байхгүй юу. Яасан гэхээр алтны агууламж буурсан гэж.

Тэгэхээр энэ алтаа алтны агууламжаа Монголчууд хил дээрээ юм уу, хаана ч юм тогтоодог тийм лаборатори тогтоож чадаж байгаа юм уу? Эсвэл Оюу Толгойнхны амаар яваад байгаа юм



уу? Энэ бол маш чухал асуудал шүү дээ та бүгд энд би хариулт авах гээд байхгүй байгаа.

Дараагийн асуудал энэ бүтээмж гэдэг асуудал.

Байнгын хороон дээр асуугаад бүтээмжид хэн ч хариулт өгөөгүй. Энэ бүтээмжээ дээшлүүлэх ёстой. Энэ ядуурал 42.5 хувь хүрчихсэн байгаа. Энэ хөгжлийн баримт бичиг дотор ядуурлыг бууруулах ямар хэмжээгээр бууруулах юм бэ гэж байгаа. Тийм тоо баримт алга байна. Тиймээс ядуурлыг бууруулах чиглэлд юу хийх вэ гэж.

Халамжид 1.4 сая хүн эхний 8 сарын байдлаар 1.4 сая хүн хамрагдаж байгаа. 56.8 хувиар өссөн. Халамжийг бууруулж тэр хөдөлмөр рүү шилжүүлнэ гээд ингээд л бид яриад яваад байна. Энэ маань хэр зэрэг тэр бодлоготойгоо хэр зэрэг нийцэж байна аа?

Халамж 2024 онд яаж буурах вэ? 2023 оныхоос ийм асуултуудад хариулт авъя.

**Л.Мөнхбаатар:** Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Хэн хариулах вэ? Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

**Л.Мөнхбаатар:** Гишүүний асуултад хариулъя. 2024 оны төсөв бол орлого зарлагаа маш бодитойгоор төсөвлөж чадсан, Засгийн газрын дунд урт хугацааны гол бодлогын суурь бичиг баримт шинэ сэргэлтийн бодлого 2030 он хүртэл алсын хараа 2050 он хүртэлх энэ төлөвлөгөөний эдийн засгийн зангилааг тайлсан ийм төлөвлөлтийнхөө зорилгыг хангаж байгаа ийм төсөв болж байгаа гэж үзэж байгаа.

Ирэх оны төсвийг хөрөнгө оруулалтуудаар нь салбараар нь харах юм бол яг гол баялаг бүтээгч нарыг дэмждэг

хөрөнгө оруулагч нарыг дэмждэг гол дэд бүтцийн суурь асуудлуудаа нэлээн дорвитой шийдсэн ийм төсөв болж байгаа.

Тухайлбал эрчим хүчний салбарт бид анх удаа 1 их наяд гаран буюу 1.1 их наядын ийм хөрөнгө оруулалт хийж байна. Зам дээр 2 их наяд гаран төсөвт өртөгтэй 790 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт санхүүжилт хийж байна.

Барилга, хот байгуулалтын салбарт 750 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтууд хийж байна. Ингээд яг топ 3 салбар нь дэд бүтцийн 3 салбар юм байгаа юм. Хүмүүс харахдаа зөвхөн төсвийн ном дээрээс харж байгаад яг цэвэр төсвийн санхүүжилт хараад байдаг юм. Энэ төсвийн санхүүжилтээс гадна гадаадын зээл тусламж төр хувийн хэвшлийн түншлэл гээд яг төсвийн харилцаанаар бүхэлд нь харах юм бол ийм байгаа.

Төсвийн орлого талд нь бас ярьдаг. Гишүүн маань орлогоо бага төлөвлөсөн байна гэж байна. Ихэнх гишүүд болохоор хэтэрхий өөдрөг төсөөлчихсөн байна гээд байдаг юм. Тэгвэл бид өмнөх 10, 20, 30 жилийн хугацаанд гарч байсан яг төсвийн төлөвлөлтийн алдааг харах юм бол зарлага тавихын тулд орлого төлөвлөд байдаг. Бид сүүлийн жилүүдэд энэ хандлагыг эрс өөрчилсөн. Бид хуулиараа ч энэ энэ алдаануудыг хааж өгсөн байгаа. Боломжит бодит орлогоо төлөвлөд эндээ шаардлагатай багтаах зардлуудаа эрэмбэлээд ингээд багтаадаг. Орлогыг бид хэт бас өндөр төлөвлөх нь маш эрсдэлтэй.

Өндөр орлого төлөвлөж байгаад зардлуудаа тавьчихдаг зардал болгоны цаана төрийн үйл ажиллагаа байдаг. Орлого биелэгдэхгүй бол эргээд төрийн үйл ажиллагаа саатах доголдох ийм өндөр эрсдэлтэй.

Тийм учраас ирэх жилийн орлогыг бол бид бодитой төсөвлөсөн гэж харж

байгаа. Яагаад тэгж байна вэ гэхээр өнгөрсөн жилүүдийн жишээ байна.

Жишээ нь 2023 оны төсвийг бид 2022 онд ярьж байхдаа мөн л бас ийм шүүмжлэлүүд байдаг байсан. Гэхдээ энэ жил бид орлогоо ямар ч эрсдэлгүй төсөвлөж чадсан байна аа. Яагаад гэвэл энэ жилийн орлогын төлөвлөлт татвар хураалт татварын орлого бүрдүүлэлт сайн явж байна. Би төсвийн тодотгол хийж байх үеэр бас орлого маань яадаг бол гэж санаа зовж байсан. Одоо 3 дугаар улирлын байдлыг харахад бол санаа зовох зүйлгүй байна. Эрсдэл бол байхгүй болж харагдаж байна.

Тийм учраас ирэх жилийн орлогын бүрдүүлэлтийг би дутуу гэхээсээ илүү энэ тавьсан орлогоо бүрэн биелүүлээд зардлаа бүрэн хангаад төсөвлөсөн Засгийн газрын бүхий л үйл ажиллагаа төрийн үйл ажиллагаануудыг тасалдалгүй, доголдолгүй явуулахыг Засгийн газар хичээж ажиллана.

**Л.Мөнхбаатар:** Та яах юм тодруулж асуух юм уу? Байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр тодруулж асууя.

**Б.Баттөмөр:** Яах вэ тэгээд тэр шууд бас хариулах боломжгүй байгаа бол дараа нь хариулт өгөөрэй. Энэ Оюу Толгойтой холбогдсон асуудал би ярьсан шүү дээ. Алтны хэмжээ, зэсийн үнийн хэмжээ тэрийг хариулчихна биз дээ. Тэгээд гадаад өр 33.8 тэрбум доллар байгаа нийт өр. Тэгээд уг нь өсөлт бий болгож хуримтлал бий болгож энэ өрийг л төлөх ёстой шүү дээ. Одоо бол яах вэ өрийг өрөөр. Сая 500 сая долларын өрийг Хөгжлийн банк энэ тэртэйгээ нийлээд төлчих шиг боллоо. Ийм менежментүүдийг л цаашидаа хийх ёстой. Өрийн хэмжээгээ багасгах бол шаардлага зайлиггүй л байна л даа. Тэгээд эдийн засгийн яг цэвэр өсөлт бий болгодог ийм салбар руугаа бид нар их анхаарах ёстой гэдэг утгаар л яриад байгаа юм.

Монгол Улсын хөгжлийн өөрийнх нь потенциал асар өндөр шүү дээ.

**Л.Мөнхбаатар:** Зочин танилцуулъя.

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эрин сургуулийн 9-ийн Б ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа.

Та бүхэндээ хичээл сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Тодруулгад хариулъя. Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

**Б.Жавхлан:** Гишүүний асуултад гүйцээж хариулъя.

2024 онд манай зэсийн биет экспортын 1.5 сая тонн байх гэж бид ингэж төлөвлөсөн. Үүнээс 700 биет хэмжээгээр 870 мянган тонн Оюу Толгойгоос хийнэ. Эндээс бид 760.5 тэрбум төгрөг орж ирнэ гэж ингэж төлөвлөж байгаа. Ирэх жил бол энэ жил бид далд уурхай эхлүүлсэн байгаа. Далд уурхайн яг оргил бүтээн байгуулалтын экспортын биет хэмжээний нэмэгдэх хэмжээ нь 2025 оноос эхлэх юм байгаа юм. 2023 онд эхэлсэн 2024 онд ингээд шат дараатай бага хэмжээгээр нэмэгдэнэ ийм байгаа. Оюу Толгойн яг уулын ажлынх нь төлөвлөлтөөр бол энэ жил өнгөрсөн жил ч тэр, өнгөрсөн жил, энэ жил, ирэх жил онуудад бол алтны агууламж нь ийм багасаж байгаа ийм жилүүд байгаа.

**Л.Мөнхбаатар:** Хариулт болсон уу? Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана.

2 зарчмын зөрөөтэй 2 санал байна. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

Монгол Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу хураалгах санал байна.

1. Төслийн 2 дугаар зүйлийн 23.2.23 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.2.23.төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил, ашиглалтад байгаа газар дээр хууль бусаар барилга, байгууламж баригдсан талаар шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бол хураан авах ажлыг зохион байгуулах.” Санал гаргасан Төсвийн байнгын хороо.

Санал хураалт.

56.2 хувиар санал дэмжигдлээ.

Энэ Раднаасэд гишүүний гаргасан саналын томъёоллыг өөрчлөөд юу яасан юм байна шүү дээ тэ? Найруулсан юм байна. Дараагийнхаа санал хураалтыг явуулъя.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг танилцуулъя. Төсвийн байнгын хороо дэмжсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал байна.

1. Төслийн 4 дэх заалтыг 2 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/-д тус тус даалгасгай:

1/орон сууцны ипотекийн зээлийн эрэлт болон төвлөрлийг сааруулах бодлоготой уялдуулан ипотекийн хөтөлбөрийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, нийслэл, орон нутагт тэгш хүртээмжтэй хуваарилах;

2/агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах зорилгоор инженерийн дэд бүтцийн шийдэлтэй, нийт талбай нь 100 м<sup>2</sup>-аас ихгүй хэмжээтэй амины орон сууцыг орон сууцны ипотекийн зээлд хамруулах.” Санал гаргасан Төсвийн байнгын хороо.

Санал хураалт.

Санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж үг хэлье.

**Б.Пүрэвдорж:** Энэ ипотекийн зээлтэй холбоотой асуудлаар ерөнхийдөө нэг 700 орчим тэрбум төгрөгийг Монгол банк гаргах ийм төлөвтэй байгаа. Энийг аваад үзэхээр ойролцоогоор 17 мянган орон сууцыг ипотекийн зээлд хамруулж зээл өгөх боломж нь бүрдэх юм. Энэ бол өнөөдөр өгч байгаа тооноос хэд дахин илүү.

Дээрээс нь орон сууц ипотекийн зээлийн авлигал хаана явж байна гэхээр Монголбанкнаас арилжааны банк руу очдог арилжааны банкна дээр тэндхийн албан тушаалтнууд, хувийн, банкны тэр нөхдүүд тодорхой хувь авч байгаад бүүр 10 хувь энэ тэр авч байгаад ипотекийн зээлийг нь өгдөг ийм зүйл рүү орчихсон

байгаа. Тэгэхээр нэг зүйлийг сануулахад 98 мянган айлын орон сууцыг 2012-2016 онд оруулсан. Тэрэнд хамгийн гол хөшүүрэг болсон зүйл бол хэнд ч хэнээс ч гуйлгүйгээр очоод авдаг байсан тэр ипотекийн зээлийн хүрэлцээ байхгүй юу даа.

Тийм учраас энэ саналыг би дэмжиж байгаа. Өөрөөр хэлбэл 17 мянган айл энэ жилийн ирэх жил ипотекийн зээлээр болох байртай болох ийм боломж нь бүрдэж байгаа.

Тэгэхээр зарим нэг хүмүүс ярьдаг. Ипотекийн зээл бид нарыг шулаад хаячихлаа гэж ярьдаг.

Гэтэл 10 жилийн өмнө авсан, авч байсан, юуны байр хотын төвд байсан байр 2 сая орчим төгрөг байж байхад өнөөдөр тэр байр зарим нь 4 дахин өсчихсөн, 3 дахин өсчихсөн байж байна. Тэгэхээр 10 жилийн өмнө авсан тэр байраа ипотекийн зээлээр төлөөд явна гэдэг чинь бол тэр хувь хүнд их ашигтай байхгүй юу даа. Өөрөөр хэлбэл 2 дахин өссөн, 3 дахин өссөн байна шүү дээ. Гэтэл төлбөр одоо өндөр гараад байгаа гэсэн. Өөрөөр хэлбэл зээлийн хүүтэй явсаар байгаад үндсэн төлбөр нь төлөгдөхгүй байна гэдэг ийм зүйлийг бас манай ард иргэд ярьдаг. Энэ бол тэр байрны чинь үнэ асар их өндөр үнэтэй болж байгаа. Хэд дахин ашигтай тийм хөрөнгө оруулалт хийсэн гэсэн үг байхгүй юу даа. Тэгэхээр энэ ипотекийн зээлийн хэрэгжилт дээр хамгийн гол нь анхаарах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл сурчихсан нөхдүүд. Тэр арилжааны банкн дээр байгаа зээлийн эдийн засагч нар болон албан тушаалтнууд ингээд өнөөдрийн энэ бага цөөхөн байгаа тэр очер дараалал үүсгэж байгаад хүнд суртал бий болгож байгаад, ипотекийн зээл өгч байгаад тэрэн дээр авлигал аваад сурчихсан нөхдүүд, дахиад авлигал аваад байх вий.

Энэний хэрэгжилт дээр Засгийн газар Монголбанк хариуцлагатай ажиллаарай л гэж би хэлмээр байна.

**Л.Мөнхбаатар:** Тэгээрэй дэмжсэн болон дэмжээгүй гишүүн бас үндэслэлээ тайлбарлаж үг хэлж болно. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн саяын заалтыг дэмжиж үг хэллээ.

Гишүүд үг хэлж дууслаа.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураая.

Саналын томъёоллыг уншиж танилцуулсан.

Санал хураалт явуулъя.

72 хувиар санал дэмжигдлээ.

Зочин танилцуулъя.

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын “Эрдэм” сургуулийн багш ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил амьдралд нь хамгийн сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд илгэжүүлж байна.

Одоо Төсвийн хууль.

16.16 цагт

Дараагийнхаа асуудалд оръё.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн



*тухай хуулийн төслүүдийн 3 дахь хэлэлцүүлгийг явуулъя.*

*Төслүүдийн 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн танилцуулна.*

**Д.Тогтохсүрэн:** Эрхэм Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

*Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы 2023 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж 3 дахь хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.*

*Төсвийн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаар дээрх асуудал хуулийн төслүүдийг 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгэх асуудлыг хэлэлцлээ. Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг хийх үед дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллын дагуу холбогдох өөрчлөлтийг төсвийн төсөл болон холбогдох хавсралтуудад тусгаж Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцлээ.*

*Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийн 3 дахь хэлэлцүүлгийг хийх үед Улсын Их Хурлын гишүүдээс Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсэгт заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг өөрчлөхгүй, агуулга зарчим алдагдуулахгүйгээр арга хэмжээний нэр төрөл, хүчин чадал, байршилтай*

*холбоотой залруулга хийх санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн утга дэмжсэн болно оо.*

*Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд дараах өөрчлөлт тусгасан болно оо.*

*Улсын төсвийн орлогыг 565.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ 25 тэрбум 855.2 тэрбум төгрөг, нийт зарлагын хэмжээ 27 тэрбум 360.5 сая төгрөг болж нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 тэрбум 505.3 сая төгрөг буюу ДНБ-ний 2 хувьтай тэнцэх хэмжээний төсвийн алдагдалтай байхаар тооцлоо.*

*Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг нэмэгдүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцыг нийгмийн хамгааллын санд олгох татаасыг 140.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүллээ.*

*3.Төрийн хэмнэлтийн хууль болон эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан зарим шаардлагагүй төсөвт хөтөлбөр, урсгал зардлыг хэмнэж төсвийн зардлыг 320.4 тэрбум төгрөгөөр бууруулсан эх үүсвэрээр зохицуулалт хийлээ.*

*4.Улсын төсөв, хөрөнгө оруулалт, хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим хөрөнгө оруулалтыг нэмж тусгах мөн 2024 оны төсвийн жилд улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгагдсан хөрөнгө оруулалтыг гүйцээн ашиглалтад оруулах шаардлагыг үндэслэн зарим төсөл арга хэмжээний төсөвт өртөг санхүүжих дүнг нэмэгдүүлэх, зохицуулалтын хүрээнд 2024 оны хөрөнгө оруулалтын нийт зардлын санхүүжих дүнг 118.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүллээ.*

*5. 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн*



тухай хуулийн төслийн Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны 2 дахь хэлэлцүүлгээр орлого нэмэгдүүлэх урсгал зардал болон хөрөнгийн зардалд өөрчлөлт оруулалт орж байгаатай холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нарын төвлөрүүлэх орлого, зарцуулах зардалд болон орон нутгаас улсын төсөвт төвлөрүүлэх орлого, орон нутагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг саналын томъёололтой уялдуулан тооцоолол хийж хуулийн дагуу холбогдох өөрчлөлтийг хийх гэж өгсөн чиглэлийн дагуу холбогдох тооцооллын өөрчлөлтийг тусгалаа.

Монгол Улсад 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд холбогдох өөрчлөлтүүдийг тусгахдаа Монгол Улсын үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын хэмжээг нэмэгдүүлээгүй харин төсвийн орлогын хэмжээг нэмэгдүүлж төсвийн тэнцлийг сайжруулсан болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд өөрчлөлт оруулсан төслийн хувилбарыг нэгдсэн хуралдаанд танилцуулж төслүүдийг батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн өөрчлөлт оруулсан хувилбар болон холбогдох хавсралт тооцооллыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024

оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Тогтохсүрэн даргад баярлалаа.

Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэгийн урилгаар Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 140 дүгээр сургуулийн багш, ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа.

Та бүгдийнхээ ажил амьдралд Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе.

Ажлын хэсгийн гишүүдийн хувьд өмнө өмнөх хуралдаанд оролцсон гишүүд яг хэвэндээ байгаа юм байна.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу? Байхгүй байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг 4 дэх хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар өнөөдөр хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг өндөрлөснийг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

*ДУУНЫ  
ХУРАЛДААНЫ*

*БИЧЛЭГЭЭС*

*ДЭЛГЭРЭНГҮЙ  
БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ  
П.МЯДАГМАА*

*ТЭМДЭГЛЭЛ*